

**ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ,  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА**

*(Нөхцөл байдлын дүн шинжилгээ,  
нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээ)*

**БОДЛОГЫН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН**

*Тайлан бичиж, нэгтгэсэн: Т.Энэбиш*

**УЛААНБААТАР ХОТ  
2018**

Бодлогын шинжилгээний тайланг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын захиалгаар хийж гүйцэтгэв.  
Энэхүү тайлангийн эх хувь Үндэсний хөгжлийн газарт хадгалагдана.

Хаяг:

Үндэсний хөгжлийн газар 15160

Засгийн газрын II байр

Нэгдсэн үндэсний гудамж - 5/1

Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг.

Монгол Улс

Цахим шуудан: [www.nda.gov.mn](http://www.nda.gov.mn)

**Факс:** .....

ТОВЧИЛСОН ЗАРИМ ҮГ:

ҮХГ- Үндэсний хөгжлийн газар

ҮСХ- Үндэсний статистикийн хороо

НҮБХХ – Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр

ОУБ - Олон Улсын Байгууллага

БХҮБ – Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

БХУЗТХ –Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль

ЭЗБХТСБ – Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлого

ДБ- Дэлхийн банк

АХБ- Азийн хөгжлийн банк

ЭЗБӨЧСТ –Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

МННФ –Монголын Нээлттэй Нийгмийн Форум

ЭЗЧУ –Эдийн засгийн чуулга уулзалт

УБ – Улаанбаатар хот

ОХУ – Оросын холбооны улс

БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард улс

**Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага,  
өнөөгийн байдал, цаашдын зорилт**

**АГУУЛГА**

**ХУРААНГУЙ – 5**

**НЭГ. ОРШИЛ - 9**

- 1.1. Бодлогын судалгааны үндэслэл, шаардлага - 10
- 1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт - 12
- 1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ - 13
- 1.4. Судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө - 13

**ХОЁР. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ**

- 2.1. Олон улсын бүсчилсэн хөгжлийн онолын чиг хандлага - 14
- 2.2. Бүсчилсэн хөгжлийн судалгааны арга зүй, аргачлал - 16

**ГУРАВ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ**

- 3.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хоорондын уялдаанд хийсэн үнэлгээ - 19
- 3.2. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн талаар төр, улс төр, иргэд, олон улс, гадаад орны байгууллагын хийсэн үнэлгээ, санал, бодол, мэдээлэл - 46
- 3.3. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ - 57
- 3.4. Эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн чадавх, гарц /SWOT үнэлгээ/ - 76
- 3.5. Монголын эдийн засгийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн арга зүйн шинэлэг хандлагууд – 86
- 3.6. Бүлгийн дүгнэлт, санал, зөвлөмж - 90

**ДӨРӨВ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

- 4.1. Бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудал, шалтгаан, шийдвэрлэх арга замууд - 92
- 4.2. Бодлогын асуудлын зураглал /зохиомж - сценари/ - 96
- 4.3. Бүлгийн дүгнэлт, санал, зөвлөмж - 105

## **ТАВ. МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД**

- 5.1. Монголын бүсчилсэн хөгжлийн бодлого /2030 он хүртэлх/ -ын зорилго, зорилтуудыг тодорхойлох үндэслэл санал - 106
- 5.2. Бодлогын хувилбаруудын SWOT шинжилгээ - 112
- 5.3. Бүлгийн дүгнэлт, санал, зөвлөмж - 130

## **ЗУРГАА. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН НӨЛӨӨЛЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ**

- 6.1. Бүсчилсэн хөгжлийн одоогийн бодлогын тойм - 133
- 6.2. Бүсчилсэн хөгжлийг дэмжих макро эдийн засгийн бодлогын орчин - 136
- 6.3. Бүсчилсэн хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг сонгосон үндэслэл /матриц 1; 2/ - 139
- 6.4. Бодлогын хувилбаруудад хийсэн нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээ /PEST анализ/ - 144
- 6.5. Бүлгийн зөвлөмжүүд - 152

## **ДОЛОО. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ СХЕМ, ХАВСРАЛТУУД**

- 7.1. Ашигласан материалын жагсаалт - 155

## **НАЙМ. ШИНЖЛЭХ УХААНЫ ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ, САНАЛ - 174**

- 6.1. Үндэсний хөгжлийн газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн санал, дүгнэлт
- 6.2. Сангийн яамны дүгнэлт, санал
- 6.3. ШУА-ийн газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн дүгнэлт, санал

## ХУРААНГУЙ

### Бодлогын баримт бичиг (БББ):

“Монгол улсын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, өнөөгийн байдал, цаашдын зорилт” сэдэвт судалгааны энэ ажил нь эдийн засгийг бүсчлэн хөгжүүлж төвлөрлийг сааруулах талаар хөгжлийн газраас явуулж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж цаашид бодлого боловсруулахад туслах чиг зорилготой юм.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчилж, хэрэгжилтийг сайжруулахыг хэн сонирхож болно вэ?

- Хот, хөдөөгийн иргэд
- Аймаг, сумын ИТХ, Засаг дарга, түүний тамгын газар
- Төрийн байгууллага – УИХ, Засгийн газар
- Жижиг дунд бизнес эрхлэгчид, мэргэжлийн холбоод

### Судалгааны гол дүгнэлтийн агуулга:

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (УИХ-аас 2001 онд баталсан, БХҮБ), түүнийг дагалдан гарсан эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, аж үйлдвэрийн парк байгуулах үндсэн чиглэл, хэрэгжилтийн хугацаа дууссан байна. Бүсчилсэн хөгжлийн зорилтыг тусгасан аймаг, салбаруудын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, олонх нь хүчингүй болсон байна. БХҮБ үр дүнтэй хэрэгжээгүй, үндсэндээ зогсонги байдалтай болсон нь бодлого төлөвлөлтийн залгамж чанар алдсантай холбоотой.

1. Сүүлийн 40 жилд хот хөдөөгийн хүн амын ажил эрхлэлт багасч, ядуурал ихсэн, хүн ам томоохон хот суурин газар руу олноор шилжин явах хөдөлгөөн үргэлжилсээр байна. Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэлийн бөөгнөрөл ихсэж, нийслэлийн үйлчилгээний ачаалал, нэмэгдсэн экологийн даац хэтэрсэн байна. Үүнтэй зэрэгцэн олонхи аймаг сум, ялангуяа алслагдсан бүс нутгийг хөгжил олон талаар хоцорч, газар нутаг эзэнгүйдэх хандлага бий болж байна.
2. БХҮБ-ыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, тогтвортой хөгжлийн 2030 оныг үзэл баримтлалтай уялдуулан тодотгон боловсруулж түүний хэрэгжилтийг сайжруулах эрх зүй, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн шинэ орчин бүрдүүлэх шаардлагатай байна.
3. Бүсчилсэн хөгжлийн ойрын ирээдүй стратеги нь улсын нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын харилцааг зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд хөгжүүлэхэд оршино. Энэ нь төр, хувийн хэвшлийн түншлэл, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааг эн түрүүнд үр ашигаа өгөх байгал, түүний эдийн чадавхи байрлал сайтай бүс нутгуудад төвлөрүүлж зах зээлд өрсөлдөх чадвартай, өртөг шингэсэн нэмүү бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний сүлжээг буй болгоход чиглэх ёстой гэж

үзсэн болно. Үүний тулд, эдийн үасгийн орон зайн менежментийг бүрдүүлэх, бодлогын хувилбаруудыг сонгон авахад анхаарах ёстой.

### **Бодлогын хувилбарууд:**

- А. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн одоогийн хуваарь, орон нутгийн удирдлагын тогтолцоог хэвээр үргэлжлүүлэх
- Б. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд (аймаг, сум)-ыг томсгон шинэчиллийг бие даан, хамтран шийдвэрлэх
- В. Эдийн бүсчилсэн хөгжил, бүсийн удирдлага зохицуулалтыг бүх түвшин, хүрээнд уялдаатай хэрэгжүүлэх эдийн засгийн макро, мезо, микро (буюу бичил) бүсчлэл, салбарын бүсчиллын хүрээнд

### **Зөвлөмжийн агуулга:**

- Бодлогын хувилбарууд дотроос “Б”, “В”-г харьцуулан авч үзэж, одоогийн нөхцөлд аль хэрэгжих боломжтойг нт сонголт хийж, түүнд тохирсон удирдлага зохион байгуулалт, эрх зүйн өөрчлөлт хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Судалгааны хувьд бодлогын “В” хувилбарыг түлхүү авч үзэх боломжтой гэж үзсэн болно.
- Бодлогын “В” хувилбарыг сонгон авбал, түүнийг хэрэгжүүлэхэд бүс нутгийн хүрээнд төр, иргэн, аж ахуйн нэгжүүдийн харилцан уялдуулах, тогтвортой, үр ашигтай хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх явдлыг бүсчилсэн хөгжлийн үр дүнтэй хэрэгжүүлэх гол арга зам болгон дэвшүүлж байна.

2030 он хүртэлх ойрын 10 жилд, Монголын нийгмийн орон зайд эдийн засгийн өсөлтийн туйлууд, тэдгээрийг дотоод, гадаад зах зээлтэй холбосон худалдаа, тээвэр, эдийн тэнхлэгүүд(коридор)-ийг дэмжсэн бүсчилсэн хөгжлийн дараахь 5 тогтолцоо (буюу загвар)-г бүрдүүлэх явдлыг бодлогын гол зорилтууд болгохыг санал болгосон болно. Үүнд:

### **Нэгдэх загвар нь:**

- Монголын эдийн засгийн бүсчилсэн хөгжил – хүн амын байршил, хот байгуулалтын нэгдсэн тогтолцоо;

### **Агуулга нь:**

- Хот, хөдөөгийн хүн амын ажил эрхлэлт, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, залуучуудын орон нутгийн бүтээн байгуулалтад оруулах хувь нэмэрийг өндөржүүлэх, хот хөдөөгийн нэгдмэл хөгжлийн үндсийг хангах үйлдвэрлэл, үйлчилгээний орон зайн зохистой төвлөрөл, бөөгнөрлийг бий болгох, тус орны Баруун, Зүүн жигүүрт Улаанбаатартай адил таталцлын тулгуур төв, тэнхлэгүүдийг байгуулах;

#### Хоёрдахь загвар нь:

- Монголын газар нутгийг тэлж ашиглах, хамгаалах тогтвортой хөгжлийн бүсчилсэн тогтолцоо;

#### Агуулга нь:

- Монгол орон нутаг дэвсгэрээ Баруун, Зүүн гар, Төв хэсэг болгон зохион байгуулж ирсэн түүхэн хандлага, нүүдэлчдийн аж ахуй (мал аж ахуй), соёл, ёс зүйн дэвшилтэт өв уламжлалыг хадгалан, тусгай хамгаалалттай газар нутаг, экосистем – аялал жуулчлалын үйлчилгээний сүлжээнд үндэслэн газар нутгаа тэлж ашиглах, хамгаалах хамтын менежментийг бүрдүүлэх;

#### Гуравдахь загвар нь:

- Монголын эдийн засгийн орон зайг экологичлох, мэдлэгжүүлэх хандлагаар үйлдвэржүүлэх, кластержуулах бүсчилсэн тогтолцоо;

#### Агуулга нь:

- Байгаль орчинд ээлтэй техник технологи бүхий төр, хувийн хэвшлийн томоохон компанийг ЖДҮҮ-тэй хоршиж, төрөлжсөн хамтын сонирхлын бүс нутгуудыг үүсгэж, тэдгээрийг дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн хөгжих нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлэх;

#### Дөрөвдэх загвар нь:

- Монголын дотогшоо харсан эдийн засгийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын бүсчилсэн зохицуулалт;

#### Агуулга нь:

- Газар, түүний баялгийг бүрэн өгөөжтэй ашиглуулах зарчимд тулгуурлан хөгжлингүй орнуудын үндэстэн дамнасан компани, пүүсийн салбарын бүсүүдэд нээж, Монголын аж ахуйн нэгж, байгууллагатай хоршин, өртөг шингэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, дэлхийн зах зээлд борлуулах, Монголын бизнес эрхлэгчид хөрш ба бүс нутгийн орнуудын зах зээлд ажиллаж, гаднаас орох дэвшилтэт технологи, ноу – хау, шилдэг мэдлэг туршлага, хөрөнгө мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх;

#### Тавдахь загвар нь:

- Монголын гадагшаа чиглэсэн худалдаа – эдийн засгийн хамтын ажиллагааны бүсчилсэн зохицуулалт;

Агуулга нь:

- Монгол Улс гео-улс төр, гео-эдийн засгийн бүсчлэлээ нягтлан тогтоож, Төв Ази, ЗХА, Ази Номхон далайн орнуудын бүсийн болон олон улсын бусад байгууллагатай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн хамт, Зүүн Хойт Азийн бүс нутгийн орнуудтай худалдаа – эдийн засгийн тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлэх улс төр – эрх зүйн нөхцлийг хангах, эдгээр орны хөгжлийн чадавх боломжийг шингээх таталцлын төв, тэнхлэгийг улс орондоо байгуулах;

Эдгээр 5 загварыг үндэсний (гадаад харилцааг оруулаад), бүс нутгийн, салбаруудын хөгжлийн аль ч түвшинд уян хатан харгалзах бүсчилсэн (бодлогын орчин, тавил өөрчлөгдөхөд зохицох чадвар) хөгжлийн тийм эрх зүйн болон ёс зүйн зохицуулалтын үндсийг бүрдүүлж, тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй юм.



## НЭГ. ОРШИЛ

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хандлага судалгаа нь Үндэсний хөгжлийн газрын 2018 оны 04 –р сарын 18-ны өдөр батлагдсан ажлын даалгавар/ дугаар: С- ҮХГ/201802008/ -ын дагуу хийгдсэн бодлогын судалгаа юм. Судалгааны зорилго нь Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал/БХҮБ/ -ыг шинэчилж, “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах” талаар боловсруулж байгаа бодлогод тусган, хэрэгжилтийг нь сайжруулах үндэслэл, шаардлага, боломж, арга замыг тодорхойлоход чиглэгдэж байгаа болно. Судалгааг бодлогын судалгаа хийх ерөнхий аргачлал, зохион байгуулалтыг баримтлан, эдийн засгийн бүсчлэл, бүс нутгийн хөгжлийн судалгааны онцлог арга зүй, арга барилыг ашиглан, 2018 оны 8-р сарын 01-ээс 11-р сарын 02 -ны дотор хийж гүйцэтгэлээ. Судалгааны эхлэлтийн тайланг 08-р сарын 29-нд, дунд шатны тайланг 9-р сарын 27-нд, эцсийн буюу төгсгөлийн тайланг 10-р сарын 29-нд тус тус захиалагч- ҮХГ-т хүлээлгэн өгсөн болно.

Эдгээр тайланг хэлэлцүүлэх явцад захиалагчийн талаас өгсөн үнэлэлт, тавьсан саналыг дараа, дараагийн шатны судалгаанд тусган шийдвэрлэхийг хичээж ирсэн. ҮХГ-аас зөвшөөрсний дагуу “Бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдал, цаашдын хандлага”-ын талаарх бодлогын хэрэгжилтийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, цаашид шинэчлэх нөлөөллийн үнэлгээний урьдчилсан үнэлгээг багтаасан нэгдсэн тайланг 2018 оны 11-р сарын 01-нд Сангийн яам, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгээс санал авахаар холбогдох газар хэлтэст өгч танилцуулж байна. Энэхүү судалгаа бүсчилсэн хөгжлийн асуудлаар анхлан хийгдсэн бодлогын дүн шинжилгээний ажил гэж үзнэ. Үүнд, Монгол орон газар нутгаа орон зайн хувьд хэрхэн зохион байгуулж байсан түүхэн хандлагыг мөшгиж, тэр нь өмнөх нийгэм/социализм байгуулах үе/ -д хэрхэн ямар үзэл, номлолоор хэрэгжиж байсан, 1990 оноос Монгол Улс ардчилал зах зээлд шилжсэн үеийн бүсчилсэн хөгжлийн бодлогын шинэчлэл ба тасалдал, хэрэгжилтийн үр дагавар, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг судалж, тэдгээрийн өнөө ба цаашдын бодлого, чиглэлд үзүүлж болзошгүй туршлага, сургамжуудыг нэгтгэн дүгнэх оролдлого хийсэн болно. Ингэхдээ, нүүдэлчдийн түүх соёлыг хадгалан хөгжүүлсэн, өргөн удам газар нутагтай, хүн ам бага, таруу сийрэг нутагшсан, бэлчээрийн мал аж ахуй зонхилсон зэрэг Монголын нөхцөлд нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын тулгамдсан асуудлыг ийнхүү түүхэн логикийн үүднээс өчигдөр, өнөөдөр, ирээдүйн 3 цагийн хэлхээнд авч үзэж, чухам өнөөдрийн цаг үед нь дүгнэлт өгөхийг хичээсэн болно. Энэ нь тус улсын бүсчилсэн хөгжлийн онол арга зүй, нийгмийн сэтгэлгээний онцлог талыг илрүүлж, хөгжлийн бодлого үйл ажиллагааны залгамж чанар, тотвортой байдлыг хадгалж, цаашид тавих бодлого чиглэлээ зөв төсөөлж, илүү үр дүнтэй хэрэгжүүлэх орчин нөхцлийг одооноос эхлэн бүрдүүлэхэд тустай байж болох юм гэж үзлээ. Чухам ийм хандлагаар бүсчилсэн хөгжлийн асуудлаар цаашид явуулах бодлогын

зорилго зорилтууд, хэрэгжүүлэх бодлогын хувилбарууд, тэдгээрийн нөлөөллийн орчинг тодорхойлох санал, зөвлөмжийг тус тайланд тусгалаа.

Эдгээрийг төр засаг, иргэний нийгмийн байгууллын түвшинд бүсчилсэн хөгжлийн асуудлаар бодлого боловсруулагч, төлөвлөгч, шийдвэр гаргагчид, түүнийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, уг асуудлыг судалдаг, сургалт, мэдээлэл хийдэг бүх хүмүүст сонирхон үзэж, өөрсдийн саналаа солилцоно гэдэгт итгэж байна. Энэхүү нэгдсэн тайлангийн бүтцийг ҮХГ-аас ирүүлсэн “Бодлогын судалгааны агуулга” –ыг үндсэнд нь баримтлан хийлээ. Тус агуулгад тодорхойлсон “Тав. Хөгжил, байршлын орон зайн анализ, төлөвлөлтийн зураглал” гэсэн хэсэг нь салбаруудын бодлогын судалгааны ажилд хамааралтай байх тул үүний оронд “ Бодлогын хувилбаруудад хийсэн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ”-ний үр дүнг нэгтгэн тайланд тусгалаа. Мөн ирүүлсэн бүтцийн “Гурав. Бодлогын судалгаа, шинжилгээ” хэсгийн 3.3-ын салбарын хөгжлийн цаашдын чиг хандлага, 3.4-ийн бодлогын залгамж байдал зэргийг БХҮБ хэрэгжиж ирсэнтэй холбон тус тайлангийн 3.1, 3.2 –т нэгтгэн үнэлж, дүгнэсэн тул тусгайлсан гарчиг өгөөгүй болно. Харин “3.3-ын салбарын хөгжлийн чиг хандлага”-ын оронд бүсчилсэн хөгжлийн бодлогыг үндэсний, бүс нутгийн, салбарын түвшинд шинэчлэхэд нийтлэг ач холбогдолтой гэж үзсэн **“Монголын эдийн засгийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн арга зүйн шинэлэг хандлагууд”** –ыг орууллаа. Монголын бүсчилсэн хөгжлийн цаашдын бодлогыг зөв, оновчтой тодорхойлоход төр, улс төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоо, монгол дахь олон улсын байгууллага, гадаад орны судалгааны байгууллагын дэмжлэг, харилцан ойлголцол чухал байгааг харгалзан, бүсчилсэн хөгжлийн холбогдолтой баримт материалыг интернет болон сусад эх үүсвэрээр аль болох бүрэн түүвэрлэн гаргахыг хичээж, гол гэж үзсэнийг нь судалж, нэгтгэн тус тайлангийн 3.2 гэсэн хэсэг болгон тусад нь бичиж орууллаа. Энэ бүхнийг анхаарна уу.

### **1.1. Бодлогын судалгааны үндэслэл, шаардлага**

Бүсчилсэн хөгжил зохицуулалтын асуудлаар монголын эдийн засгийн орон зайн хүрээнд бодлогын судалгаа явуулах үндэслэлийг дор дурдсан нөхцөлөөр тодорхойлж байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, байршилт нь эдийн засгийн үр ашгийг тогтвортой нэмэгдүүдэх өсөлтийн хүчин зүйл болж чадаагүй харин ч хүрээлэх орчны даац, чанарыг муутгаж, оршин суугчдын аж байдал, эрүүл мэндэд ноцтой нөлөөлсөн олон тооны сөрөг үр дагаварыг бий болгосоор байна. Өнөөдөр энэ асуудал үндэсний аюулгүй байдлын түвшинд дэвшигдэж байна.
2. Тус улсын өргөн уудам газар нутаг, түүний байгалийн баялаг, үзэсгэлэнт газар, түүх соёлын их өв, мал аж ахуйн түүхий эдийн нөөцийг дотоод, гадаад зах зээлд бүрэн, зохистой ашиглаж, үр өгөөжийг нь тэгш шударга хуваарьлаж ирээгүйгээс хүн амын аж байдлын түвшин жигд дээшилж чадаагүй, ажилгүйдэл, ядуурал ихсэж, хүн ам нийслэл, Дархан, Эрдэнэт хот, уул уурхайн

- цөөн тооны төвүүд рүү шилжин суурьшиж, гадаад оронд гарч ажиллах явдал үргэлжилсээр байна.
3. Эдийн засгийн бүсүүд , аймаг, орон нутаг, хот сууринг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах талаар өнөөг хүртэл баримталж ирсэн бодлого, хөтөлбөрүүд, чөлөөт бүсүүд ба хот суурингийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүд өөр хоорондоо болон бүсчилсэн хөгжлийн нэгдсэн үзэл баримтлал, үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, жил бүрийн төсөв санхүүгийн хөөц, хуваарьлалт, аж ахуйн салбарууд, гадаадын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй тухай бүр уялдаж чадаагүйгээс үр дүн нь хангалтгүй байгаа юм. Тэдгээр нь мөн даян дэлхийн болон Монгол улсын тогтвортой хөгжлийн стратеги, байгаль орчны хамгаалах шаардлагыг хангах нийтлэг зорилгод
  4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн болон хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай, Чөлөөт бүсийн тухай хуулиудын боловсруулалт, хэрэгжилтийн шатны уялдаа хангалтгүй, тэдгээрт тодорхойлогдсон эрх зүйн хэм хэмжээ, заалтууд тус улсын нутаг дэвсгэрийн нийгмийн харилцаа, орон зайн зохион байгуулалтыг оновчтой зохицуулдаг хуулийн нэгдмэл мехаиизм болж үйлчлээгүй, хүмүүсийн нийтээр дагаж мөрддөг ёс зүй, үзэл санаа, дадал, заншлыг ч бүрэн тусгаж чадаагүй байгаа юм. Үүнээс шалтгаалж, бүс нутгийн үндэсний хэмжээний хөгжлийн нийтлэг асуудлыг гол төлөв орон нутаг – салбарын бодлогоор зохицуулахыг эрмэлзэж ирэв.
  5. Даяаршлын нөхцөлд. дэлхийн улсууд, түүний дотор манай хөрш хоёр орон ОХУ, БНХАУ –ын геополитик, геоэдийн засгийн чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж байна. Тухайлбал, ОХУ Сибир, алс Дорнод руу чиглэсэн хөгжлийн бодлогоо шинэчилж, Зүүн хойт Ази, Номхон далайн оруудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ ч Ази, Европыг холбож байсан торгоны замын худалдаа – эдийн засгийн харилцааг үндэслэн “Нэг бүс – нэг зам” –ын шинэлэг бодлогыг тодорхойлж, энэ чиглэлд татагдаж байсан бүх орон, түүний дотор Хятад-Орос- Монгол гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг батламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.
  6. Дээр дурдсан дотоод нөхцөл байдал, гадаад орчны өөрчлөлт нь бүс нутгийг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах талаар өнөөдрийг хүртэл баримталж байгаа үзэл бодлыг нягтлан өөрчилж, амьдралд хэрэгжих боломжтой, ирээдүйг угтан харсан бүсчилсэн хөгжлийн шинэчилсэн бодлогыг тодорхойлоход хүргэж байна. Ийм бодлого тодорхойлж, уялдаатай хэрэгжүүлэх эрх зүйн орчин, бодлогын үндэс тавигдлаа. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай Монгол Улсын хууль батлагдаж, энэ дагуу Монгол Улсын Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх үзэл баримтлалыг боловсруулан мөрдөж байна. Эдгээр бодлого, үзэл баримтлалд эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын мөн чанарыг шинэчлэн ойлгох хуулийн нэр томъёо, түүнийг үндэсний болон орон нутаг, салбарын бодлоготой уялдаатай боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн болон зохион байгуулалтын нийтлэг хэм хэмжээ тусгагдсан болно.

## 1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эдийн засгийг бүсчлэн зохицуулах бодлогын хэрэгжилтийн явцад үүссэн тулгамдсан асуудлыг тодорхойлж, тэдгээрийн тавигдах болсон шалтгаан, бэрхшээл, цар хүрээ, нөхцөл байдлыг зураглаж, шийдвэрлэх арга зам, боломжийн талаар таамаглал дэвшүүлэхэд оршино. Энэ үндсэн дээр эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг төвлөрлийгн сааруулах зорилттой холбон шинэчилэн боловсруулах үндэслэл шаардлагыг тусгасан нэдсэн санал, зөвлөмж гаргана.

Судалгаа нь бүхэлдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “**Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам**”-ын дөрөвт заасанчлан бүсчилсэн хөгжлийн урт хугацааны бодлогын төслийн “**нөхцөл байдлын дүн шинжилгээ**”, мөн “**нөлөөллийн урьдчилсан үнэлгээ**” өгөх ажилд зориулагдаж байна.

Судалгааны үр дүнг Засгийн газраас боловсруулах “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлого”-ын баримт бичгийг боловсруулахад шинжлэх ухаан арга зүйн нэг үндэслэл болгон ашиглуулахаар бодлого, боловсруулагч, төлөвлөгч нарт зориулж байна. Бодлогын энэхүү дүн шинжилгээний гарц нь мөн макро эдийн засгийн болон аймаг, нийслэл, салбарын бусад судалгааны үр дүнтэй нэгтгэн дүгнэж, Үндэсний хөгжлийн бүс нутгийн мэдээллийн санд оруулж, олон нийтэд мэдээлж санал авах, сургалт, сурталчилгаа явуулах зэргээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн оролцоог хангахад ашиглах боломжтой юм. Энэ зорилгын хүрээнд дор дурдсан гурван үндсэн зорилт тавьж байгаа юм. Үүнд:

- **нийгмийн амьдралыг орон зайн зохион байгуулалт, байгаль, эдийн засгийг мужлалтын талаар монголчуудын баримталж ирсэн түүхэн үзэл хандлага, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, судалгааны арга барилыг бусад улс орны судлаачдын орчин үеийн нийтлэг жишигтэй харьцуулан судалж, өөрийн онцлогийг тусгасан шинжлэх ухаан -танин мэдэхүйн нэгдмэл ойлголтыг бүрдүүлэх;**

- **бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, түүнтэй холбогдсон бодлого, хөтөлбөр, зохицуулалтын гол зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бодит баримт материал дээр тодорхой жишээгээр судлан, учир шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийг илрүүлэн гаргах, бүсчилсэн хөгжлийн өнөөгийн байдалд СВОТ шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлох;**

- **бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах талаар бодлогын шинэчлэл хийх үзэл бодлын үндсийг тодорхойлох, зах зээлийн нөхцөлд аймаг, орон нутаг, хот, тосгоны эдийн засгийн бүтэц, төрөлжилт, хоршилтыг бий болгох, үйлдвэр, үйлчилгээний орон зайн хөгжил, байршилтын үр өгөөжийг цаашид сайжруулах боломжит хандлага, ирээдүйн зураглалын талаар таамнал боловсруулж, асуудал шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг дэвшүүлж, сонголт хийх талаар санал, зөвлөмж боловсруулах**

### 1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ

Бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах асуудлыг эдийн засгийн макро түвшинд болон Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн хэмжээнд судалж, аймгуудын бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдалд ерөнхий үнэлгээ хийв. Бүсчилсэн хөгжлийн асуудлаар иргэдийн үзэл бодол, улс төрийн гол хүчнүүдийн байр суурийг тандан судалсан болно. Мөн Монголын бүсчилсэн хөгжлийн асуудлаар тус улсад ажиллаж байгаа олон улсын байгууллага, гадаадын зарим улсын хийж байгаа ажил, гаргасан санал, зөвлөмжийг баримт материалаар хураангуйлан харуулахыг хичээлээ.

### 1.4. Судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө

Бүсчилсэн хөгжлийн асуудлаар нэгдсэн судалгаа хийх зорилт тавьсан энэ ажлын дизайныг боловсруулахдаа, захиалагчаас баталсан ажлын даалгаварын 8 болон 10 –р зүйлд заасан гарах үр дүн, тайлангийн үе шатыг тусгасан дараах төлөвлөгөөг баримтлалаа.

Бодлогын судалгааны гарах үр дүн, үе шат	Судалгааны ажил	Хугацаа
Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт. <b>/Эхлэлтийн тайлан/</b>	Монгол улсын БХҮБ, хууль бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдсан байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж гаргах	2018.08.28.
Бүсчилсэн хөгжлийн одоогийн байдлын үнэлгээ,, цаашид хэрэгжүүлэх шаардлага, зорилго, зорилт, бодлогын хувилбарууд <b>/ явцын тайлан/</b>	Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, туршлага, сургамжид үндэслэн бүсчилсэн хөгжлийн одоогийн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлж, бодлогыг шинэчлэх орчин нөхцөл байдлыг дүгнэн шинжлэх	2018. 09. 27

<p>Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудын харьцуулсан үнэлгээ, сонголтын талаарх санал, зөвлөмж <b>/Төгсгөлийн тайлан/</b></p>	<p>1. Нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах стратегийн бодлогын хувилбаруудад нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээ өгөх 2. Нэгдсэн тайлан бичих</p>	<p>2018.10.29.  11.05</p>
<p>Тайланг хэлэлцүүлэх</p>	<p>ҮХГ-ын Аргазүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн гарсан санал зөвлөмжийг тусгаж, эцэслэн хүлээлгэж өгөх</p>	<p>2018 оны 11 сар</p>

## **ХОЁР. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ**

### **2.1. Олон улсын бүсчилсэн хөгжлийн онолын чиг хандлага**

Дэлхийн улс орнуудын туршлагаас үзвэл, монголын нөхцөлд, бүс нутгийн онолын орчин үеийн хөгжлийн дор дурдсан 4 үндсэн чиг хандлагыг аль нь илүүтэй тохирохыг судлан тогтоох нь зүйтэй байгаа юм.на. Үүнд:

1./ Бүсийн байршилтын онолын хандлага. Энэхүү хандлага нь хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний хүрээнд байршилтыг тогтоох (байршилтын сонголт) эсвэл тодорхой бүсийн хүрээнд тэдгээрийг оновчтой байршуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг ажээ.

2./ Бүс нутгийн эдийн засгийн бүтцийн хөрвөх чадварын онолын хандлага. Уг хандлага нь бүсийн үйлдвэрлэлийн хүчин зүйлс ( байгалийн нөөцөөс илүүгээр хүний хөдөлмөрийн бүтээмж, нийгмийн капитал, технологи, мэдлэг чадвар ) болон бараа бүтээгдэхүүний хөрвөх чадвар, тэдгээрийн идэвхжилт болон үзүүлэх нөлөөллийг, өөрөөр хэлбэл бүс нутаг хоорондын бараа бүтээгдэхүүн ба үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн/байршилтын/ хөдөлгөөн, тэдгээрийн нэг нэгнээ нөхөхчадвар, үр дагаварыг авч үздэг бөгөөд харин хөрвөх чадварыг улсын болон бүсийн эдийн засгийн өсөлтийн хэрэгцээтэй уялдуулдагаараа онцлогтой байна.

3./ Эдийн засгийн өсөлтийн туйлуудад үндэслэсэн бүсийн тогтвортой өсөлт, хөгжлийн онолын хандлага. Энэ хүрээнд өөр хоорондоо зарчмын ялгаатай онол, үзэл баримтлалууд хамрагддаг. Энэ онолын цаад санаа нь капитал бүрдүүлэлт, ажил эрхлэлтийн өсөлт, байгалийн нөөц баялгийн ашиглалтын эрчимжүүлэлтээр эн түрүүнд зах зээлд ашигтай байрласан дотоод чадавхи сайтай бүс нутгийг түрүүлэнгүй хөгжүүлж, энэ үндсэн дээр улс орон, бусад бүс нутгийн хөгжлийг дэмжих эдийн засгийн өсөлт, хуримтлал, нийгмийн бүтээмжийн чадавхийг дээшлүүлж болно гэж үзэж байна.

4./ Эдийн засгийн газар зүйн ба бүс нутгийн хөгжлийн шинэ онолын хандлага. Энэ нь нэлээд өргөн хүрээтэй бөгөөд дотроо хэд хэдэн томоохон чиглэлтэй.

Гэхдээ байршилт, төрөлжилтийн болон бүсийн өсөлт, хөгжлийн онолд тулгуурлах бөгөөд бүсийн өвөрмөц онцлогийг харгалзан үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг оновчтой ашиглах замаар аж үйлдвэржсэн нийгмээс мэдлэг оюун, соёлын үнэ цэнийг шингээсэн нийгэмд шилжих нөхцөл боломжийг голлон авч үзэж байна.


Дээр дурдсан онолын нийтлэг чиг хандлагууд нь улс орнуудын бүс нутгийг хөгжүүлэх практик үйл ажиллагаанд харилцан адилгүй ялгаатай байдлаар тусгагдан хэрэглэгдэж ирсэн байна. Энэ нь тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эдийн засаг, аж ахуй, түүх, соёлын уламжлал, газарзүйн байрлал, байгаль, эдийн засгийн нөөц чадавхийн хүрэлцээ, хангамж зэрэгтэй холбоотой юм.

Тэдгээрийг арга зүйн талаас нь дор дурдсан гурван гол хандлагаар тоймлон авч үзэж болох байна:

- Төвлөрч хөгжүүлэх хандлага
- Хослуулан хөгжүүлэх хандлага
- Жигд хөгжүүлэх хандлага


1. Төвлөрч хөгжүүлэх хандлага. Энэ нь нэг буюу хоёр төв/хот суурин/ - д төвлөрөн хөгжүүлэх чиглэлийг баримталдаг бөгөөд эдийн засгийн чадавхи султай буурай хөгжилтэй орнууд зонхилон баримталж иржээ. Учир нь эдгээр орнуудад бүс нутаг бүрийг нэгэн зэрэг хөгжүүлэх боломж хомс байдагтай холбоотой юм.

Зураг 1.1




Энэхүү хандлагад бүсийн төвлөрөл ба төвийн онол, өсөлтийн ба гадаад худалдааны шинэ онолууд багтана.

2. Хослуулан хөгжүүлэх хандлага. Энэхүү хандлагаар хэд хэдэн томоохон төвийг бий болгон тэдгээрт хүн ам, үйлдвэрлэлээ төвлөрүүлж бүс нутгийг хөгжүүлдэг. Сул, буурай хөгжилтэй улс орнууд нэг төвд чиглэсэн хөгжлийн үзэл баримтлалаас хэд хэдэн төвүүдэд төвлөрөн хөгжих арга замыг сонгож ирсэн байна. Уг хандлага нь жигдрүүлэн хөгжүүлэх ба төвлөрүүлэн хөгжүүлэх хандлагуудын тодорхой шинжүүдийг агуулдаг бөгөөд завсрын үе шат гэж үзэж болох талтай.



3. Жигдрүүлэн хөгжүүлэх хандлага. Энэхүү хандлагаар улс орнууд өөрийн бүс нутгуудыг жигд, тэнцвэртэй хөгжүүлэх чиглэл, бодпогыг баримтатдаг бөгөөд өнөөгийн өндөр хөгжилтэй, жижиг газар нутагтай /бид заримыг нь хот улс ч гэдэг/ улс орнууд гол төлөв баримталж байна. Учир нь тэдгээр орон бүсүүдийнхээ нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлуудыг жигд анхааран шийдвэрлэх эдийн засгийн чадамж бүрдсэн байдагтай холбоотой.



Энэхүү хандлагад бүсийн байршилтын онолын хандлагууд болон шинэ сонгодог, посткейнс, зкспортын суурь онолууд хамаарч байна. Эдүгээ томоохон газар нутагтай хөгжингүй орнууд байгаль, түүхий эдийн нөөц, хатуу дэд бүтцэд түшиглэж ирсэн харьцангуйн онолоос илүү зах зээлийн өрсөлдөөнд үндэсний болон бүс нутаг бүрийн давуу тал, түүнийг тодорхойлогч хүчин зүйлүүдийг илрүүлэх, бүрдүүлэх, ашиглах зах зээлийн эрэлт хэрэгцээ, тэдгээрийн өөрчлөлт, чиг хандлага, банк, санхүү, зээл, даатгал, хөрөнгийн бирж зэрэг уян дэд бүтцийн өөрчлөлтийг соргог мэдэрч тусгах нь бүс нутгуудыг эдийн засгийн хувьд бие даалган хөгжүүлэхэд бизнесийн оролцоо, дэмжлэгийг хангаж, төрийн оролцоо, зохицуулалтыг аль болох бага байлгаснаар амжилт олох нэг гол нөхцөл гэж үздэг болсон байна. Бүс нутгуудын хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, төрөлжилтийг хөгжүүлж, нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүнийг боловсруулж, борлуулах зах зээлийн сувгуудыг бий болгох төр, хувийн хэвшлийн аль аль талын ашиг сонирхолыг хослох нэг гол үндэс ч чухам үүнд оршиж болохоор байна.



## 2.2. Бүсчилсэн хөгжлийн судалгааны арга зүй, аргачлал

Энэхүү судалгааг “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухй хууль” тогтоомжид үндэслэн бодлогын судалгаа явуулдаг арга зохин байгуулалтаар явуулсан. Бүсчилсэн хөгжлийн судалгаа хийх жишээгээр ийм арга зүйн төслийг эхлэн боловсруулж, ҮХГ-т танилцуулан, гол санааг нь “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн нөхцөл, байдлын шинжилгээ, судалгаа”-ны ажлын даалгаварт тусгуулан ашигласан болно. “Бодлогын судалгаа хийх арга зүй”-н төслийг тайланд хавсаргав.

Бодлогын судалгааг явуулахдаа, баримт бичигт анализ хийдэг судалгааны аргыг түлхүү ашиглав. Үүнд, Монгол улсын эдийн засгийн төрөл бүрийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн талаар дотоод, гадаадын эрдэмтэд, судлаачдын гаргасан бүтээл, эдийн засгийн бүсүүд, аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, байгаль, түүхий эдийн нөөц чадавхи, хөгжлийн давуу ба сул тал, боломжууд, өрсөлдөх чадварын талаар ҮСХ, ЭЗБӨЧСТ-ийн жил бүр гаргасан тайлан, яам, газруудаас гаргадаг албан ёсны тоо, чанарын үзүүлэлтүүд, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт – шинжилгээ, үнэлгээний материалууд, хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд хийсэн дүн шинжилгээ, монголын бүсчилсэн хөгжлийн одоо байдал, ирээдүйн хандлагын талаар монгол дахь ОУБ, гадаад орны мэргэжилтэн, судлаачдын гаргасан тайлан, өгсөн, санал зөвлөмж, Интернетэд байгаа бүсчилсэн хөгжлийн асуудлаарх санал, шүүмж зэрэг баримт материалыг оруулж байна.

Эдийн засгийн бүсчлэлийн зорилго, чиг үүрэг, хөгжлийг бүсчлэн( **бүсээр, бүс нутгаар** ) зохицуулах арга механизм, бүсчилсэн хөгжлийн өвөрмөц шалгуур үзүүлэлтүүд, зах зээлийн нөхцөлд эдгээр ойлголт, ухагдахууны өөрчлөгдөж буй чиг хандлагатай харьцуулан судалж, нэгдсэн дүн шинжилгээ хийх арга зүйг баримталсан болно. Баримт бичгийн харьцуулсан түүвэр судалгаа, нөхцөл байдлын ерөнхий дүн шинжилгээний энэхүү арга зүйгээр судалгаанаас гарсан зөвлөмж, дүгнэлтүүдийг хураангуйлах, онцлог, анхаарал татсан асуудлуудыг тодотгон харуулж зураглах, өнөөдөр манай нийгэмд буй эдийн засаг ба байгаль газарзүйн бүсчлэл, мужлалт, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, эдгээрийн шинэчлэлийн талаарх ойлголт, үзэл бодлын зөрүүтэй байдлыг нэг мөр болгож, цаашид нийтээр баримтлах боломжтой нэгдмэл үзэл хандлагыг тодорхойлоход тус дөхөм үзүүлэх оролдлого хийлээ. Бодлогын судалгаа явуулахдаа, **“онол – таамаглал – ажиглалт – дүн шинжилгээ – баталгаа”** гэсэн тоо чанар хосолсон **дедуктив аргыг** голлон баримталсан болно. Үүний зэрэгцээ, түүхийн шинжилгээний логик, харьцуулалтын аргууд, хамаарлын корреляц, SWOT шинжилгээ, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, төрөлжилт, хоршилтын индексүүд, бүсчлэлийн төрөл бүрийн схемийг нэг масштабын зураглалаар давхацуулан шинжлэх, зураглах, таамаглал,төсөөлөл/прогноз/ хийх аргуудыг хослон ашигласан. Энд тус судалгааг иж бүрэн явуулах хугацаа бага байсныг хэлэхийн хамт, зарим хязгаарлагдмал нөхцөл байдал байсныг тэмдэглэж байна.

Орон нутагт ажиллах, ярилцлага зохиох, асуулга авах цаг хугацаа, зардал хүрэлцэхгүй, холбогдох санхүүжилтийг цаг тухайд нь авч чадаагүйгээс шалтгаалан уг судалгааг нарийвчлан хийхэд дор дурдсан зарим бэрхшээл тулгарч байсныг Захиалагч байгууллагын зүгээс анхааралдаа авахыг хүсч байна. Үүнд:

- Нэгдүгээрт, энэхүү судалгаанд нэг тодорхой аймаг, салбарыг жишээ болгосон юмуу иргэд, аж ахуйн байгууллагын сонирхлын үүднээс бүсчилсэн зохицуулалтын хүрээнд хамтарч хорших, төрөлжин хослох /кластер/ боломж, түүхий эд татан авах, бараа бүтээгдэхүүн борлуулах, нэмүү өртөгийн бүс нутгийн сүлжээ байгуулах эрэлт, нийлүүлэлтийн сувгуудыг зураглах, байршилтын хүчин зүйлсийг шинжлэх талаар тооцоо, дүгнэлт хийгээгүй, тиймээс аналитик задлан шинжилгээ, түлхүүр судалгааны хүрээ гэх тодорхой зүйлс байхгүй юм. Үүнийг аймаг, салбарын хөгжил, байршилтын бусад судалгаанаас тодруулж харах нь зүйтэй болов уу/,

- Хоёрдугаарт, уг тайланд олон нийтэд аль хэдийн танил болсон Монголын Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн эдийн засгийн дөрвөн бүсийн тодорхойлолт, эдгээр бүсийн хөгжлийн нөөц, чадавхийн судалгаа, төлөвлөлт, хяналт - шинжилгээний ажлуудын тайлан, тоон мэдээллүүдийг харьцуулан гаргаж авсан дүгнэлт, зөвлөмжүүд багтсан. Иймд судлаачдын санал болгож, зурагласан хөгжлийн бүсүүд/дунд болон бичил масштабын бүсчлэл/, чөлөөт бүс, ШУҮТ-ийн паркууд, кластер, тээвэр, логистикийн коридоруудын талаар мэдээ, баримт дутмаг орсон тул, энэ хэсгүүдийн тухайд бодлого боловсруулах явцад дахин тодотгож, нэмэлт боловсруулалт хийх шаардлагатайг анхаарна уу;

- Гуравдугаарт, эдийн засгийг бүсчлэн зохицуулах, бүс нутаг, салбар хоорондын арга хэмжээг уялдаатай боловсруулах Шинэ **Үндсэн хуулийн** заалт гарсанаас хойших сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд, УИХ, Засгийн газар, яам газар, янз бүрийн байгууллага, төслийн шугамаар аймаг, бүс нутгийн хүрээнд хэрэгжсэн бүсчлэл, хот байгуулалтын холбогдолтой хөгжлийн бүх төсөл, хөтөлбөр, судалгаа, тэдгээрийн хоорондын уялдааг дэлгэрэнгүй үнэлж, нэгтгэн бүртгэж, бүрэн жагсаалт гаргах нь энэ ажлын хамрах хүрээ, нөөц бололцоо, цаг хугацаанаас давсан ажил гэж үзэж байна.

## ГУРАВ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

**3.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хоорондын уялдаанд хийсэн үнэлгээ /БХҮБ, Бүсүүд, аймаг, нийслэлийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр, бусад баримт бичгүүд/**

### 1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ  
/төрийн байгуулалтын хүрээнд/

№	БХҮБ-ын төрийн байгуулалтын хүрээнд дэвшүүлсэн бодлогын Зорилтууд	Арга хэмжээ/зохицуулалт/, үе шатаар		Хэрэгжилтийг үнэлсэн чанарын тодорхойлолт, тайлбар
		2001 - 2010	2010 - 2020	
д/д	1	2	3	4
1	Бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;	УИХ-аас баталсан Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль/БХУЗ/, Чөлөөт бүсийн тухай хууль/ЧБ/, мөн Алтанбулаг, Замын –үүд, Цагаан-нуурын чөлөөт бүсүүдийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг баталсан.Эдгээрийг	БХУЗ-ын тухай хуульд УИХ 2015 оны 11-р сарын 26 –нд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Гол өөрчлөлт нь бүс нутгийн хөгжлийг дэмжих санг аймаг, сум бүрд байгуулах болсонтой холбогдуулан Бүсийн хөгжлийн сан байгуулах журмыг хүчингүйд тооцсон байна. Мөн ЧБ-ийн	2010 оноос бүсчилсэн хөгжлийг дэмжин зохицуулах эрх зүйн зохицуулалтын үйлчлэлт суларч, эдүгээ үндсэндээ тодорхойгүй, бүрхэг болсон байна. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа зогссон, цаашид үргэлжлүүлэх эсэхийг УИХ, засгийн газрын түвшинд нэг

		<p>хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны дүрэм, Бүсийн хөгжлийн сан, Бүсийн зөвлөлүүдийг байгуулах, Бүсийн хэлэлцээр байгуулах дүрэм журмыг батлан мөрдүүлжээ.</p>	<p>хөгжлийг нэгдсэн нэг хуулиар зохицуулах бодлого баримталж, Алтан булаг, Замын-үүд, Цагаан-нуурын чөлөөт бүсүүдийн хуулийг хүчингүй болгож, ЧБ-ийн тухай хуулийг шинэчлэн баталж мөрдүүлсэн байна. Бусад дүрэм, журам хүчингүй болоогүй боловч амьрал дээр үйлчлээгүй хэвээр, олон нийтэд энэ талаар мэдлэг мэдээлэл байхгүй байна.</p>	<p>мөр шийдэх шаардлагатай.</p>
--	--	--	---	---------------------------------

2	<p>бүсийн болон бүс нутгийн хөгжлийн стратегийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох;</p>	<p>УИХ 2003 он/24-р тогтоол/ -д “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацаа/2010 он хүртэлх/ -ны /ДХС/ стратегийг баталсан. Засгийн газар БХҮБ, ДХС –ийг хэрэгжүүлэх зорилгоор бүсүүдийн зөвлөлтэй хамтран 2003-2006 онд Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатар/2006/-ын бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж батлан мөрдүүлсэн. Бүсчилсэн хөгжлийн эдгээр бодлого, хөтөлбөрийг салбар яамд, аймгуудын хөгжлийн бодлого, чиглэлд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна. Бүх аймаг бүсчилсэн хөгжлийн зорилтыг тусгасан орон нутгаа 2010 - 2016 он хүртэл хөгжүүлэн цогц хөтөлбөрүүдийг батлан мөрдүүлсэн/Хавсралт жагсаалтыг үз/. Дээр дурдсан бүсчлэн хөгжлийн удирдлагын зохион байгуулалтын бүтцийн</p>	<p>Засгийн газар/Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо/ “Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц/эхний үе шатны/ -ыг Баруун, Хагайн бүсийн жишгээр 2011 онд хяналт-шинжилгээ хийжээ. Мөн Ховд аймаг дахь Бүсийн зөвлөл Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар 2005-2011 онд авсан арга хэмжээ, оруулсан хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг гаргаж ЗГ-т тайлагнасан байна. Зарим аймаг/Өмнө –говь, Завхан, Хөвсгөл, Дорнод, Орхон, Дархан-уул, Төв, Ховд г.м/ хөгжлийн хөтөлбөрт тусгасан бүс нутгийн хөгжлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн нийтлэг арга хэмжээний хэрэгжилтийн байдал, тэдгээрийг цаашид үргэлжлүүлэх шаардлагыг 2015 2016 оны байдлаар</p>	<p>2013 оноос бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийгзо хэрэгжүүлэх арга хэмжээг Засгийн газрын хэмжээнд албан ёсоор тусгайлан төлөвлөх, тайлагнахаа больсон байна. Хариуцан хянаж, зохицуулдаг байгууллага, мэргэжлийн хүмүүсийн идэвхтэй үйл ажиллагаа зогссон. Хэрэгжилт хангалтгүй, цаашид үргэлжлүүлэх эсэх нь хүлээгдэж байна.</p>
---	--	---	--	---

		<p>нэгжүүдийг ЗГ-ын шадар сайдын хариуцах асуудлын хүрээнд болон Эдийн засгийн 5 бүсийн тулгуур төвд эмхлэн байгуулсан</p>	<p>нэгтгэн дүгнэж, Аудитын газруудад тайлагнасан мэдээ байна.Засгийн газар 2014 оноос Бүсийн зөвлөлүүдийг үндсэнд нь татан буулгасан боловч 2005 -2012 он хүртэл жил бүр, 2015 -2018 он хүртэл боломжтой үед бүсчилсэн уулзалт, зөвлөлгөөний Засгийн газрын болон ОУ-ын байгууллага, ААН ба ТББ-тай хамтран зохион байгуулж иржээ.</p>	

3	<p>бүсийн хөгжлийг төсөв, татвар, хөрөнгө оруулалт, мөнгө зээлийн бодлогоор дэмжих;</p>	<p>Бүс нутгийн хөгжлийг дэмжих төсөв, санхүүгийн эх үүсвэрийг төрийн сангийн дансанд Засгийн газрын шийдвэр, Бүсийн хэлэлцээрийн дагуу төвлөрүүлэн зарцуулж, байгалийн баялгийн нөөц ашигласны орлогын татварын тодорхой хэсгийг орон нутгийн мэдэлд үлдээх, дэд бүтцийг хөгжүүлэх нийтлэг арга хэмжээнд улсын болон гадаад орны хөрөнгө санхүүгийн дэмжлэгийг Бүсийн зөвлөлтэй зөвшин зарцуулж байх эрхзүйн боломжуудыг дээр дурдсан хуулиудад тусгасан боловч амьдралд хэрэгжээгүй буюу юунд зарцуулсан нь тодорхойгүй болсон байна. Харин мөнгө, зээлийн бодлогоор дэмжих асуудал шийдэгдээгүй судалгааны түвшинд байна.</p>	<p>УИХ-аас 2011 онд баталсан Төсвийн тухай хуулиар төвийн ерөнхийлөн захирагч Аймаг, сумдын хөгжлийг дэмжих “Орон нутгийн хөгжлийн сан” байгуулж, иргэдийн оролцоотой төсвийн менежментийг хэрэгжүүлэх бодлого тодорхойлжээ. Энэ сангийн хөрөнгийг , нэг сум-нэг компани, шинэ сум-шинэ тосгон хөгжүүлэх арга хэмжээнд зарцуулж эхэлсэн боловч, 2013 оноос Засгийн газар солигдмогц/ЕС нь Сайханбилэг/ цаашид шатлан үргэлжлүүлж чадаагүй байна. Орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн хөрөнгө бага, дутагдалтай байсны улмаас зөвхөн орон нутгийн жижиг өргө хэмжээнд зарцуулж, аймаг, сум, хот, тосгоныг хоршин хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бололцоогүй байлаа. Харин</p>	<p>2012 оноос бүс нутгийн хөгжлийг төрөөс дэмжин зохицуулах бодлого, менежмент өөрчлөгдсөний улмаас БХҮБ, БХУЗХ-д тавьсан энэ зорилтыг хэрэгжүүлэх шаардлага, санаачлага үндсэндээ суларсан байна.Цаашид бодлогын шинэ тавил, арга зам, шийдвэр, хэрэгжилтийн байнгын мониторинг хүлээгдэж байна.</p>
---	---	---	---	---

			<p>бүсийн ач холбогдолтой гэж үзвэл Оюу толгой, Таван толгой, Эрдэнэт, мөн тээвэр хөгжлийн коридор/төмөр зам/ зэрэг макро төслүүдийг хэрэгжүүлэх асуудал анхаарал татах болсон байна.. Тухайлбал, 2010 оноос Дэлхийн банкны дэмжлэг, оролцоотой Өмнөд /Говийн/бүсийн дэд бүтцийн стратегийг шинээр тодорхойлж, Говийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийг төвлөрүүлж, Талуудын гэрээ, хэлэлцээрийн дагуу зарцуулж байх асуудал дэвшигдсэн боловч, хэрхэн шийдэгдсэн нь одоогоор нийтэд тодорхой биш байна.</p>	
4	<p>бүс нутагт банк, санхүү, даатгалын тогтолцоог бүрдүүлэх;</p>	<p>БХҮБ-ын энэ зорилт, БХУЗ-ын тухай ЧБ-ийн тухай хуульд тусгагдсан боловч, орон нутаг, компаниудын хүрээнээс хэтрээгүй, судалгаа, мэдээллийн</p>	<p>Энэ талаар бүсчилсэн хөгжлийг дэмжихтэй холбогдсон арга хэмжээ, алхам хийглээгүй байна.</p>	<p>Хэрэгжээгүй. Асуудлыг үргэлжлүүлэн судалж, нэгдсэн үзэл хандлага, хэрэгжүүлэх арга замыг шинээр тодорхойлох хэрэгтэй</p>



		түвшинд байна.		байна_.
5	бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжин урамшуулах;	Энэ талаар бодитой, тодорхой ажил хийгдээгүй, зарим нэг судалгаа, санал, хүсэлтийн /Мэргэжлийн холбоод, ЖДҮҮД, Баялаг бүтээгчид/ шатанд байна	БХ-ийг дэмжих хүрээнд судалгаа, төлөвлөлтийн тодорной ажил хийгдээгүй.	Хэрэгжээгүй. Хэрэгжүүлэх арга зам, төр, иргэн, ААНБ-ын харилцан ойлголцол, дэмлэг үгүйлэгдэж байна.
6	бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд аймаг, нийслэл, хот, тосгоны хамтын ажиллагааг өргөжүүлэх;	БХ –ийн үндэсний хороо, Бүсийн зөвлөлгөөн, уулзалтаар байнга яригдаж ирсэн. Бүсүүдийн болон, аймаг, нийслэлийн хөгжлийн хөтөлбөр, хот тосгоны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан	Шинэ сум, шинэ тосгоныг хөгжүүлэх төсөлд тусгагдсан. УБ хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн хандлагын баримт бичигт орон зайн нэгдсэн төлөвлөлтийн зарчим, бүс нутаг, хот, тосгоны нэгдмэл хөгжлийг хангах санал, зураглал тусгагджээ.	Бодлого, төлөвлөлт, зураг төсөл, судалгааны ажлын шатанд байна. Цаашид БХҮБ –д заасны дагуу салбар хоорондын, бүс нутаг, хот байгуулалтын орон зайн нэгдсэн төлөвлөлтийн арга хэмжээгээр хэрэгжүүлэх шаардлагатай.
7	бүсчилсэн хөгжлийн асуудлаар төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллага	Засгийн газар, яамдын санаачлагаар бүсчилсэн зөвлөлгөөн, уулзалтыг жил бүр/зарим жил 2 удаа/ зохион байгуулж/ШУ-ны болон	Засгийн газрын оролцоотой Бүсчилсэн зөвлөлгөөн цөөрч, ШУ-ны байгууллага, Мэргэжлийн холбоодын санаачлагаар орон нутгийн	Хэрэгжилт мэдлэг, мэдээлэл солилцох арга зүй, зохион байгуулалтын чанартай, цаашид хөгжлийн бодлого хөтөлбөрт тусган бодит ажил

	<p>хоорондын ажлын уялдаа, харилцан мэдээлэл, зохицуулалтыг хангах</p>	<p>ААНБ,ТББ-ын төлөөллийг оролцуулан/, бүсчилсэн хөгжлийн хүрээнд хамтран ажиллах боломж, арга замын талаар санал солилцож, салбар, аймаг, нийслэлийн бодлого, төлөвлөгөөнд тусгах мэдээ, баримт бүрдүүлж ирсэн</p>	<p>чанартай зарим асуудлаар уулзал, ярилцлага зохион байгуулагдах болсон байна. 2018 оноос Засгийн газрын шийдвэр, Үндэсний хөгжлийн газрын санаачлагаар “Бүсчилсэн хөгжлийн асуудал”-аар Иргэд, байгууллагын өргөн оролцоотой хурал, зөвлөлгөөн, ОУ-ын бага хурал зохион байгуулагдаж эхэллээ. ҮХГ-т бүс нутгийн хөгжлийн асуудлаар улс орны хэмжээнд ашиглах цахим мэдээллийн сан бүрдүүлж байгаа юм байна.</p>	<p>болгон хэрэгжүүлэх шаардлагатай.</p>
--	--	---	---	---

8	. бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажлыг хөхүүлэн дэмжих;	Бүсчилсэн хөгжлийн асуудлаар судалгаа, сургалтын ажил өргөн хийгдэж, төрөлжсөн сургалт-мэдээллийн байгууллагууд бий болж, Их дээд сургуульд “Бүс нутаг, хот төлөвлөлт”-ийн тодорхой хөтөлбөр, мэдээллийн сан бүрдэж эхэлсэн.	Бодлогын залгамж байдал алдагдсанаас сургалт, сурталчилгаа хийж байсан байгууллага, хүмүүсийн санаачлага, идэвхжилт, хамтын ажиллагаа илт сулрах хандлагатай болсон байна.	Нийгмийн сэтгэлгээнд нөлөөлсөн үр дүн нь хангалтгүй, Ойлголт, мэдлэгийн зөрүү их байгаа нь ажиглагдаж байна. Цаашид бүсчлэн хөгжих үзэл санааг төр, иргэн, ААНБ, хот, хөдөөгийн түвшинд хүмүүсийн харилцан хэгнээ дэмжиж, хоршин хөгжих, хамтдаа өсөн дэвжих бодлогоор Засаг, төр, компаны зүгээс хөхиүлэн дэмжих нэгдсэн менежментийг бүрдүүлэх хэрэгтэй нь харагдаж байна.
9	БХҮБ-ын 3.15 зүйлд:..эдийн засгийн бүсчлэлийн хүрээнд эдийн засгийн бүс, бүс нутаг-хот байгуулалтын нэгдмэл тогтолцоо бүрэлдэж, улс үндэсний хөгжлийг түргэтгэх нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын дотоод, гадаад орчин	Засгийн газрын санаачлагаар БХҮБ хэрэгжих орчин нөхцөлтэй 33, НД-ийн нэгжүүдийн хуваарь, тэдгээрийн хоорондын уялдааг сайжруулах санал, үндэслэлийг судлаачид, эрдэмтэдийн оролцоотой боловсруулж, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо, Ажлын хэсгүүдээр хэлэцүүлж байсан боловч, тууштай ажил хэрэг болгон хэрэгжүүлж чадаагүй байна.	Засгийн газар, зарим улс төрч-судлаачид / Жишээ нь:УИХ-ын гишүүн Д. Эрдэнэбатын бичсэн “хагаэрхай цонх шиг эх орон минь” эмхэтгэл., 2012/ аймгуудыг эдийн засагт суурилсан 6-7 чөлөөт бүс, сумдыг 330 компани болгон зохион байгуулах бүтцийн өөрчлөлт хийх санал гаргаж байсан ч төрийн бодлого,	БХҮБ-д тодорхойлсон “..эдийн засгийн бүсчлэлийн хүрээнд бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоо бүрэлдэх, тодорхой орчин нөхцөлтэй уялдуулан...”гэсэн бодлогын гол баримтлал, зорилтыг сайтар харгалзаагүй байна. Үүнээс үүдэж,33НД-ийн хуваарийг эдийн засгийн бүсчлэл, бүсийн хөгжлийн

<p>сайжрахын хирээр аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгон хоорондын харилцаа холбоо бэхжиж Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн одоогийн байгууламжийг ардчилал, зах зээлийн нөхцөлд зохицуулан боловсронгуй болгож эхэлнэ. Энэхүү үзэл санааг төрийн байгуулалтын хүрээнд / 4.7.1.и/. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хэрэгжих орчинтой уялдуулан засаг захиргаа нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох гэж тодотгон томъёолсон байна;</p>		<p>олон нийтийн мэдээллийн системд тусгагдаагүй байна.</p>	<p>тулгуур төв-хот, орон нутгийн хөгжлийн төвүүдтэй эдийн засгийн бүсийг ЗЗ-ны нэгжтэй тус тус адилтган ойлгох үзэл хандлага гарсан байна.Эдгээр асуудлын уялдаа, заагийг цаашид нарийвчлан судалж, нэгдмэл нэг үзэл бодол, зөвшилцлийг нийгэмд төлөвшүүлэх хэрэгтэй байна. Мөн эдийн засгийн дунд хэмжээний болон бичил бүсүүд/бүлэг суурин/-ийн сүлжээ бүрэлдэх цаашдын хандлагыг тооцож, олон жилийн туршид хадгалж ирсэн ЗЗНД хуваарийг орон нутгийн иргэний нийгмийн удирдлага, зах зээлийн орон зайн сүлжээ бүрдэх ирээдүйн тогтвортой хандлагатай уялдуулан нэг мөр бүхэлд нь юмуу, эсвэл хэсэгчлэн өөрчилж шинэчлэх асуудлыг бүсчилсэн хөгжлийн дунд хугацааны бодлогод тусгах нь зүйтэй байна.</p>
--	--	--	---

## 2. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль

Хавсралт -хүснэгт

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай  
хуулийн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээ  
/төрийн удирдлага зохицуулалтын хүрээнд/

№	БХУЗ –ын хууль заагдсан бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжин зохицуулах удирдлагын зохион байгуулалтын бүтэц	Удирдлагын зохион байгуулалт / үе шатаар/ын бүтцийг бүрдүүлэх		Хэрэгжилтийг үнэлсэн чанарын тодорхойлолт, тайлбар
		2001 - 2010	2010 - 2020	
д/д	1	2	3	4
1	БХУЗ-ын хуулийн Хоёр дугаар бүлгийн 6-р зүйлд зааснаар Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хороо / БХҮХ/ байгуулж ажиллуулах. Энэ хороо нь хуульд зааснаар Бүсчилсэн	Хуульд заасны дагуу Засгийн газар БХҮХ-г 2002 онд ЗГХЭГ-ын бүрэлдэхүүнд, 2005 оноос Шадар сайдын хариуцах асуудлын хүрээнд ажлын албыг байгуулж, түүний ажиллах журмыг батлан	БХҮХ –ны хууль дүрэмд заасан эрх хэмжээнд 2012 оны 8-р сарын 17 –ны хуулиар өөрчлөлт оруулснаар хариуцах чиг үүрэг, албаны орон тоо нь багасч, бүсчилсэн зөвлөлгөөн, уулзалтад оролцож, санал солилцох,	БХҮХ ялангуяа 2013 оноос хуулийн дагуу ажиллах боломжгүй болж, ЗГ-ын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн стратегийг тодорхойлж,хэрэгжүүлэхэд салбар хоорондын, аймаг, нийслэлийн хоорондын хамтын

	<p>хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлэх;</p>	<p>мөрдүүлсэн байна. Гэвч БХҮХ-нь бүр эхнээсээ хуульд заасан хугацаа, бүрэлдэхүүнээр тогтмол хуралдаж чадаагүй, гол төлөв ажлын албаны хүрээнд ажиллаж, бүсийн зөвлөлгөөн зохион байгуулах, зарим судалгаа хийлгэж, Шадар сайдад мэдээлэл өгөх хэмжээнд ажиллаж байв</p>	<p>мэдээлэл бэлтгэх хэмжээнд ажиллах болж, эдүгээ хэлбэрийн төдий /3-4 хүний орон тоотой/ нэгж болжээ.</p>	<p>оролцоог хангах асуудал орхигдож ирсэн байна. Бодлогын өөрчлөлт, шинэчлэл хүлээгдэж байна.</p>
2	<p>БХУЗХ-ийн 7 дугаар зүйлд Бүсийн зөвлөл байгуулж, Түүнийг /цаашид “Зөвлөл” гэх/ нь бүс нутгийн хөгжлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг зохицуулах чиг үүрэгтэй ажиллуулах /</p>	<p>Бүсийн зөвлөлийг 2002 онд Эдийн засгийн 5 бүсийн хүрээнд зохион байгуулж,ууль заасан чиг үүргийг нь дэлгэрүүлэн, түүнийг тухайн бүсийн аймгуудын Засаг дарга/Нийслэлийн Засаг дарга/ нар ээлжлэн хариуцаж байхаар журамласан байна. Зөвлөлүүд нь 2013 оныг хүртэл нарьцангуй тогтвортой ажиллаж, аймаг</p>	<p>Хэрэг дээрээ 2013 оноос, 2015 онд албан шийдвэрээр Зөвлөлүүд татан буугдсанаар, аймгууд өөрсдөө санаачлан/Зарим газар бүсийн зөвлөл гэсэн ойлголт хэвшиж ирсэн байна./ бүсчилсэн уулзалт, ажил хэргийн уулзалт зохион байгуулж, санал, мэдээлэл соилцож иржээ.</p>	<p>Зөвлөлүүд амьдралд хэрэгтэйгээ харуулсан ч төр засгийн зохион байгуулалтын болон төсөв санхүүгийн дэмжлэг дутагдсанаас чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж ирсэн. Бодлогын өөрчлөлт, шинэчлэл хүлээгдэж байна</p>

	орон тооны бус /	орон нутгийн хөгжлийн асуудлын уялдааг хангах, шаардлагатай асуудлыг Бүсийн хөгжлийн сан, Бүсийн хэлэлцээрийн дагуу холбогдох яам, агентлагт улсын болон салбарын хөгжлийн дунд хугацааны үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулахаар саналаа ирүүлж ажиллаж эхэлсэн байна.		
3	БХУЗХ-ийн УИХ-д танилцуулсан үзэл баримтлалд бусад орны жишгээр “Бүсийн хөгжлийг дэмжих сан” байгуулах санал тусгагдсан/ БХУЗХ-ийг хэлэлцүүлж, батлуулах үед дэмжигдээгүй болно/	Санхүү-эдийн засгийн яамны ажлын хэсэг “Бүсийн хөгжлийг дэмжих сан”-гийн төслийг судалгааны үндсэн дээр хэд хэдэн удаа нягтлан боловсруулж, Сайдын зөвлөл, ЗГХЭГ-ын ажлын хэсгээр хоёр ч удаа хэлцүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй	Улсын төсвийн 2011 оны хуулиар аймаг, сумын хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэрт хөгжлийг хангах чиг зорилготой “орон нутгийн хөгжлийн сан байгуулах” эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид өгч, олонх аймаг сумдад байгуулсан . Гэвч аймаг, сумдын чадавхиас хамаараад санд төвлөрүүлэх эх үүсвэр бага, улсын төсвөөс дэмжих боломж	Хэрэгжээгүй. Үе үеийн Засгийн газраас хийж ирсэн алхамуудыг одоогийн боломж, гадны туршлагатай харьцуулан судалж, аймаг, салбар, цаашилбал улс хоорондын нийтлэг асуудлыг шийдвэрлэх иргэний нийгмийн бүх талын оролцоо, зөвшилцлийг хангасан санхүүжилтийн үр дүнтэй механизм, оновчтой менежментийг тогтоож хэрэгжүүлэх явдал Монголын бүсчилсэн хөгжлийн бодлогын

			хязгаарлагдмал зэргээс хамаарч, тэдгээр сан өнөөг хүртэл бодитой үр дүн өгөхөөр ажиллаж чадахгүй байдалтай байна..	шинэчлэлийн гол асуудал болж байна.
4	БХУЗ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлд улсын болон бүсчилсэн хөгжлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор”Бүсийн хэлэлцээр байгуулах” заалт, хэлэлцээр байгуулах үндсэн зарчмуудыг тодорхойлсон	Засгийн газар 2010 онд, Бүсийн хэлэлцээр байгуулах нийтлэг журмыг баталж, улсын хэмжээнд Засгийн газар, түүнийг төлөөлж төрийн захиргааны холбогдох төв байгууллага, бүсийн хэмжээнд Зөвлөл нь бүсийн хэлэлцээрийг байгуулан ажиллуулахшийдвэр гаргасан. Зарим бүсийн зөвлөлүүд /жишээ нь Баруун бүсийн зөвлөл ОХУ-ын Алтайн БНУ, Алтайн хязгаартай хамтран ажиллах хэлцээрийн талаар санал ирүүлсэн боловч Засгийн газрын зүгээс албан ёсны тодорхой шийд өгөөгүй байна.	Бүсийн хэлэлцээр байгуулах талаар тодорхой алхам хийгдээгүй байна.	Засгийн газрын төв байгууллагуудын зүгээс Бүсийн хэлэлцээр байгуулах талаар дотоод, гадаадын байгууллага, хуулийн этгээдэд хандсан тодорхой санал, санаачлага тавиагүйгээс хуулийн энэ чухал механизм хэрэгжээгүй байна. Цаашид судалж, олон нийтэд мэдээлж, тодорхой арга зам, шийдэлд хүрч бодлогод тусгах шаардлагатай.



### **3. Чөлөөт бүсийн тухай үзэл баримтлал, хууль**

Хавсралт –тайлбар

Монголд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал, хуулийн хэрэгжилтийн явц байдлын талаарх Зөвлөхийн үзэл бодол /тайлбар/

Энэ тайлбарыг хийгч миний бие 1992 –оос 2010 онд тэр үеийн ҮХГ, Санхүү-эдийн засгийн яаманд ажиллаж байхдаа, бүс нутаг, чөлөөт бүсийн бодлогын асуудлыг хариуцаж, УИХ –аас 1996 онд баталсан Монгол улсад ЭЗЧБ байгуулах үзэл баримтлал, 2002 онд анх баталсан Чөлөөт бүсийн тухай /ерөнхий/ хууль, 2003-2005 онд баталсан Алтанбулаг, Замын-үүд, Цагаан-нуурын чөлөөт бүсүүдийн тухай хуулийн Ажлын хэсэгт орж ажилласны хувьд энэ талаар өөрийн үзэл бодлоо тайлбар маягаар хэлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

#### **Чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал, хууль бүрэн мөрдөгдөөгүй байна.**

1./ Монгол Улсын УИХ-ын 1995 оны 87 дугаар тогтоолоор баталсан эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалд чөлөөт бүс байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг бодит хүчин зүйл, угтвар нөхцөл, шалгуурыг үндэслэн сонгож авсан тодорхой бүсүүдийн статусыг тухай бүрт нь хуулиар тогтоон мөрдүүлэх замаар хэрэгжүүлнэ гэж заасан байна. Гэтэл 2015 онд Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан/анх 2002 онд баталсан/Алтанбулаг, Замын –үүд, Цагаан-нуурын чөлөөт бүсүүдийн тухай тусгайлсан хуулиудыг хүчингүйд тооцсон байна.

2./ Дээрх үзэл баримтлалын тулгуур зарчим болсон “Чөлөөт бүсүүдийг зохих дэд бүтцийг эхлэн бүрдүүлэх үндсэн дээр олон улсын шилдэг ололтыг харгалзан, харьцангуй бага зардлаар байгуулах, эхний элжинд Худалдааны чөлөөт бүс”-ийг энгийн хэлбэрээр бий болгож, зохих туршлага хуримтлуулсны үндсэн дээр эдийн засгийн буюу технологийн чөлөөт бүсд шилжих зарчмуудыг бүрэн харгалзаагүй байна. Тухайлбал дээрх бүсүүдийг “эдийн засгийн чөлөөт бүс гэж зарлан, зөвхөн дэд бүтцийн болон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнд ын удаан хугацааны туршид ихээхэн урсгал хөрөнгө зарцуулж ирсэн байна.

Чөлөөт бүсүүдэд 2003 оноос хойш хөрөнгө оруулалтын болон урсгал зардалд нийт 19.8 тэрбум төгрөг зарцуулсан боловч чөлөөт бүсүүд улсын болон бүс нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, далайд гарцгүй манай орны хувьд

эдийн засгийн өсөлтийг түргэтгэж, хуримтлалыг нэмэгдүүлэх хүчин зүйл өнөөг хүртэл болж чадаагүй хэвээр байна. Тухайлбал, чөлөөт бүсүүдийн урсгал зардал Засгийн газраас тогтвортой анхаарсан зардал 2003 аас 2011 он хүртэлх 9 жилд нийт хөрөнгө оруулалтынх нь 1/3-тэй тэнцэж байгааг Засгийн газрын төсвийн мэдээ харуулж бапиа.

Хүснэгт 1.

*Бүсүүдийн хөрөнгө оруулалтын болон урсгал зардал*

<i>№</i>	<i>Чөлөөт бүсийн нэр</i>	<i>Хугацаа</i>	<i>Урсгал төсөв /сая төг/</i>	<i>Хөрөнгө оруулалт /сая төг/</i>	<i>Нийт дүн /сая төг/</i>
1	Алтанбулаг ХЧБ	2003-2011 оны эхний хагас жил	1 821,8	11 205,4	13 027,2
2	Замын-Үүд ЭЗЧБ	2004-2011 оны эхний хагас жил	905,5	3 184,6	4 091,1
3	Цагааннуур ХЧБ	2005-2011 оны эхний хагас жил	594,4	1 482,6	2 077,0
4	Чойр ЭЗЧБ	2007-2011 оны эхний хагас жил	189,6	249,9	439,5
5	Чөлөөт бүсийн зөвлөлийн ажлын алба	2009-2011 оны эхний хагас жил	188,9		188,9
Нийт			3 700,2	16 122,5	19 822,7

**Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зорилтыг хангахад зайлшгүй шаардлагатай эдийн засаг, зохион байгуулалтын дараах угтвар нөхцөлийг бүрдүүлээгүй хэвээр байна /Дэлхийн банкнаас 2005 онд гаргасан илтгэлд үүнтэй адилхан дүгнэлт хийсэн байна./:**

- ❖ Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн холбоо, эрчим хүч, зам тээвэр зэрэг үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтэц шинээр бүрдүүлэх буюу сайжруулах;
- ❖ Чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж. Байгууллага чөлөөтэй ажиллах таатай орчин бий болгох;
- ❖ Гадаадын хөрөнгө оруулагчндган харилцаа тогтоосон чөлөөт бүсэд хөрөнгө оруулах баталгаатай бизнесийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах чадварлаг компанийг бий болгох;
- ❖ Худалдаа бизнесийн үйл ажиллагаанд мэргэшсэн, мэргэжлийн ур чадвар сантай. Үйлчилгээний өндөр соёл эзэмшсэн ажиллах хүч бий болгох;
- ❖ Чөлөөт бүсэд худалдааны төв, гаалийн баталгаат агуулах, хил гаалийн шалган нэвгрүүлэх цогцолбор, үйлдвэрлэлийн барилга байгууламж, банк, зочид буудал, үйлчилгээний бусад цэг салбар байгуулах талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ хэлцэл хийсэн байх
- ❖ Монголын хувьд газар, түүний баялгийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад үр дүнтэй ашиглуулах татвар, төлбөрийн таатай нөхцлийг бий болгох зэрэг болно.

*Эдгээр нөхцлийг чөлөөт бүс нэг бүрээр тоймлон зураглавал:*

Чөлөөт бүс байгуулах угтвар нөхцөл хангагдсан байдал /бүсүүдээр/

Бүрдүүлсэн байх угтвар нөхцөл	Алтанбулаг ХЧБ	Замын-Үүд ЭЗЧБ	Цагааннуур ХЧБ
Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн холбоо, эрчим хүч, зам тээвэр зэрэг үйлдвэрлэлийн болон	Хэрэгжээгүй	Хэрэгжээгүй	Хэрэгжээгүй

нийгмийн дэд бүтэц шинээр бүрдүүлэх буюу сайжруулах			
Чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, байгууллага чөлөөтэй, итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин нөхцөл бий болгох;	Бүрэн хангагдаагүй	Бүрэн хангагдаагүй	Бүрэн хангагдаагүй
Гадаадын хөрөнгө оруулагчидтай харилцаа тогтоосон, чөлөөт бүсэд хөрөнгө оруулах баталгаатай, бизнесийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах чадвартай компаниуд бий болгох	Хэрэгжиж байгаа	Хэрэгжиж байгаа	Хэрэгжиж байгаа
Худалдаа, бизнесийн үйл ажиллагаанд мэргэшсэн буюу энэ төрлийн ажил хийх сонирхол, мэргэжлийн ур чадвар сайтай, үйлчилгээний өндөр соёл эзэмшсэн ажиллах хүч бий болгох	Хэрэгжээгүй	Хэрэгжээгүй	Хэрэгжээгүй
Чөлөөт худалдааны төв, гаалийн баталгаат агуулах, хил, гаалийн шалган нэвтрүүлэх цогцолбор,	Хэрэгжээгүй	Хэрэгжиж байгаа	Хэрэгжээгүй

үйлдвэрлэлийн барилга, байгууламж, банк, зочид буудал, үйлчилгээний бусад цэг, салбар байгуулах талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ, хэлцэл хийсэн байх			
---	--	--	--

Бүхэлд нь үнэлж хэлбэл, тус улсад чөлөөт бүс байгуулах үйл ажиллагаа хөгжлийн эхний буюу бэлтгэл үе шатандаа явж байна. Гэтэл манай өмнөд хил залгаа БНХАУ-ын Эрээн хотод саяхан/2018/ онд байгуулсан чөлөөт бүсийн үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаа бид харж байна. Иймд, бүсчилсэн хөгжлийн нэгмэл бодлогоор байнга дэмжин зохицуулах ёстой чөлөөт бүс байгуулах үндэсний аюулгүй байдал, геоэдийн засгийн энэ чухал асуудлыг олон талаас нь нягтлан үзэж, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай гэж тогтвол, хөрш болон хөгжингүй орнууд, мөн ААНБ-ын шууд оролцоотой хэрэгжүүлж, үр дүнг нь богино хугацаанд авах хамтын менежмент хэрэгтэй гэж үзэж байна.

#### **4. Бүсийн хөгжлийн тулгуур төв-хотуудын талаар**

Хавсралт –тайлбар

Бүсийн хөгжлийн тулгуур төвийн талаарх  
Зөвлөхийн санал, дүгнэлт

“Бүсийн хөгжлийн тулгуур төв”/цаашид БХТТ гэнэ/ –ийн талаар нийгэмд өнөөг хүртэл үзэл бодлын ихээхэн зөрүү байгаа бөгөөд нэгдсэн нэг ойлголт, бодлого, төлөвлөлтийн арга зарчим, хэрэгжилтийн мониторинг бүрдээгүй байна. Уг чанартаа энэ асуудал, бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх үүднээс анх дэвшигдсэн юм. 2000 онд Санхүү-эдийн засгийн яам, Хууль зүйн яам, ШУА-ийн ажилтнуудаас бүрдсэн Ажлын хэсэг энд дор дурдсан хоёр үндэслэл шаардлагыг юуны өмнө харгалзан үзсэнийг хэлэх хэрэгтэй. Үүнд:

1./ Тус орны эдийн засгийн байгуулалтыг нутаг дэвгэрийн тэнцвэрт, харилцан уялдсан байдлыг хангах шалгуураар дотоод, гадаад зах зээлд зүй зохистой холбох таталцлын тулгуур тэнхлэг, цэгүүдийг тогтоох. Тухайлбал, доктор С.Нямзагд, Д.Базаргүр нарын дэвшүүлсэн тэнлэгээр хөгжих, тус орны газарзүйн байрлал, өргөрөгийн дагуу сунасан өргөн уудам

нутгийн дотоод болон гадаад хүчний таталцлын уулзвар цэгийг Баруун, Зүүн, Төв гэсэн гурван хэсэгт төв байршлын онолоор тогтоох саналыг тодотгож, БХҮБ-д тусгах,

2./ Архитектор Д.Дандарбаатар, Д. Сайн-эр нарын “Бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын бодлогыг уялдуулж, Улаанбаатар гэсэн нэг төвтэй орчноос нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийн олон төвтэй нэгдсэн загварт шилжих. Энэ нь эдийн засаг, хүн амын нутагшилтын 4-өөс 5 бүстэй тогтолцоо бүрдүүлэх санаа бөгөөд түүнийг БХҮБ-ын төсөлтэй ЗГ, УИХ-д хамтад нь оруулж хэлэцүүлэх . Б ХҮБ-ыг батлуулахдаа, дээр дурдсан үндэслэлийг харгалзан, бүсийн хөгжлийн таталцлын тулгуур төвүүдэд түшиглэн улсын хэмжээнд, эдийн засгийн бүс, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харилцан уялдсан нэгдмэл тогтолцоо, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэх замаар нутаг дэвсгэрийн хэсэг бүрийн тэнцвэрт, харилцан уялдсан байдлыг хангаж байх бүсчилсэн зохицуулалт, хот байгуулалтын нэгдмэл орчинг бүрдүүлэх стратегийг дэвшүүлсэн. Үүнийг хууль эрхзүйн талаас нь баталгаажуулахын тулд, БХУЗ-ын тухай хуулийн 3-р зүйлийн: 3.1.1-д “бүсийн хөгжлийн тулгуур төв” гэж тухайн бүсийг гадаад, дотоод зах зээлтэй холбоход байгаль, эдийн засгийн нөхцөлийн хувьд тохиромжтой байрласан улсын зэрэглэлтэй хот”; 3.1.2-т. “орон нутгийн хөгжлийн төв” гэж тухайн бүс нутгийн хүн амын нийгэм, эдийн засгийн хөгжилд голлох үүрэгтэй, үйлдвэрлэл, үйлчилгээний дэд бүтэц бүхий аймгийн зэрэглэлтэй хот” байхаар зохицуулах заалтыг тусгасан байна. Энэ заалтыг хот байгуулалтын бодлогод туган хэрэгжүүлэх зорилгоор Хот байгуулалтын тухай хууль/УИХ-аас 2008 онд батлан одоо мөрдөж байгаа/-ийн **6 дугаар зүйлээр тогтоосон Засгийн газрын бүрэн эрхэд**: “бүсийн хөгжлийн тулгуур төв хот, түүнчлэн томоохон уул уурхайн орд газар, үйлдвэр, нисэх онгоцны буудлыг даган бий болсон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах; мөн нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төв хотыг хөгжүүлэх арга хэмжээний дөрвөн жилийн төлөвлөгөөг батлах заалтыг тусгаж өгчээ. Гэвч БХТТ –ийн асуудал бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хуульд заагдсан яг дээрх утга агуулгаар хөгжлийн төлөвлөлт, зураг төсвийн баримт бичигт тусгагдаж хэрэгжээгүй байна. Энэ чиглэлээр 2003 аас 2016 он хүртэл хэрэгжүүлсэн ажлын явц, гарч буй үр дүнд дараах ерөнхий үнэлэлт, дүгнэлт өгч болохоор байна. Үүнд:

- Засгийн газрын 2006 оны тогтоолоор Баруун бүсийн тулгуур төв -хотоор Ховд, Улиастайг, Хангайн бүсийн тулгуур төв-хотоор, Хар-хорин, Эрдэнэтийг, Төвийн бүсийн тулгуур төв-хотоор Дархан, Зуун-модыг, Зүүн бүсийн тулгуур төв-хотоор Чойбалсан, Өндөрхаан /Одоогийн Чингэс/-ыг тогтоож, тус бүрийнх нь хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн бүрдэл хэсгийг баталсан байна. Энэ нь нутаг дэвсгэрийн тэнцлийг хангах таталцлын төвүүдийг хэт олшруулж, бүсчилсэн хөгжлийн үзэл санаа, хот байгуулалтын зарчмыг зөрчилдүүлэхэд хүргэсэн байна. Олон төвийг зах зээлийн эрэлт, бодит хандлагыг харгалзалгүйгээр төрөөс шууд дээрээс тогтоосон өгсөн нь нэгд, төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ашиг сонирхол хослох нэгдмэл зарчмыг алдагдуулжээ. Мөн улсын хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг олон чиглэлд тараан, үр ашиггүй зарцуулах нөхцлийг бүрдүүлсэн байна. Тийм учраас дээрх тогтоолоор баталсан “бүсийн тулгуур төв-хот”

байгуулах зураг төслийн ерөнхий шийдлийг хэсэгчилсэн төлөвлөгөө болон дараачийн үе шатны ажлаар нарийвчлан зураглаж төсөвлөх ажил цаашид хийгдэх боломжгүй болсон байна. Сүүлийн 10 жилд эдгээрийн хот төлөвлөлт, орон зайн архитектур зохион байгуулалтын ажил аймгийн төв гэсэн өмнөх ерөнхий төлөвлөгөөний аргачлал, барилгын норм дүрмээр хийгдэж иржээ. БХБЯ-наас 2017 оны 12-р сард шинэчлэн хийж батлуулсан Баруун бүсийн тулгуур төв Ховд , Зүүн бүсийн тулгуур төв- Чойбалсан, Улаанбаатарын дагуул хот болсон Бага – нуурын ерөнхий төлөвлөгөөнд хотын хөгжлийн дэд бүтэц, даац, ачаалал, орон зайн зохион байгуулалтыг тэдгээр таталцан хөгжих боломжтой ойролцоо хот тосгон, хөдөө орон нутагтай нь уялдаатай шийдэх зарчим чиглэлийг барьсан боловч, бүсчилсэн хөгжил, хот байгуулалт/ зах зээлийн нөхцөлд төвлөрлийг сааруулах бүсчилсэн хөгжлийн таалцлын төв тэнхлэгүүд ямар хэлбэрээр хаана үүсэх, тэдгээр нь ямар үүрэг функц, бүтэцтэй байх г.м олон асуудал/- ын цаашдын нэгдмэл бодлого,хэтийн чиглэл гараагүй тул хэрэгжих үндэслэл багатай болж болзошгүй бана.

- Эдгээр анхаарах зүйлс бий болсоны уг шалтгааныг Бүсчилсэн хөгжил хот байгуулалт хүн амын нутагшилтын асуудлыг бүр эхнээс нь уялдаатай авч үзэж, нэгдсэн нэг үзэл баримтлалд тулгуурлан шийдвэрлэж ирээгүйтэй холбоотой гэж үзэж байна. БХҮБ гараагүй байх үед тэр үеийн барилгын яам бүс нутгийн тулгуур төвүүдийг олноор байгуулах, тэдгээрийг төлөвлөх ажлыг урьдаас шийдсэн байдал ажигдагдаж байгаа юм. Тэр үеийн Дэд бүтцийн хөгжлийн яам сайдын 2000 оны 95 дугаар тушаалаар баталсан барилгын норм дүрэмдээ “Нийслэл Улаанбаатар хот болон бүс нутгийн хөгжлийн тулгуур төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Улсын хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан тэдгээрийн улсын хэмжээнд болон бүсийн түвшинд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг харгалзан боловсруулна” гэж заасан байх жишээтэй.Зүй энэ асуудлыг бүс нутгийн хөгжлийн бодлогын асуудал хариуцаж байсан Санхүү эдийн засгийн яамтай зөвшилцөх ёстой байсан болов уу.
- Засгийн газраар 2013 онд хэлэлцэж батлагдсан нийслэл Улаанбаатар хотыг 2020 онд хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол хотын хөгжлийн 2030 он хүртэлх чиглэлд энэхүү таталцлын төв тэнхлэг үүсэх асуудлыг, хотын цаашдын чиг үүрэг бүтэц, орон зайн зохион байгуулалтыг шинэчлэх арга зам, боломжит хувилбаруудыг Төвийн бүс, бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжих ирээдүйн орчинтой холбон нилээд үндэслэл сайтай авч үзсэнийг тэмдэглэж байна.
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн шинэ хууль гарсан өнөөгийн нөхцөлд бүс нутгийн хөгжил, хот байгуулалтын асуудлыг нэгдсэн/хосолсон/ загвар/томоохон газар нутагтай бусад орны жишгээр/-ын үндсэн дээр боловсруулж, эдийн засгийн бүсчлэл, төвлөрлийг сааруулах шинэчилсэн бодлогын төсөлд тусган баталгаажуулах, энэ үндсэн

дээр хүн амын нутагшилтын төсөл, хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зохиож, мөрдүүлэх тогтолцоонд шилжих нь төр, иргэний нийгмийн түвшинд бодлого үйл ажиллагааг төлөвлөх шатнаас нь, хэрэгжүүлэх шатанд уялдуулах нэгдсэн үнэлгээ, мониторингийг бүрдүүлэх шаардлагатай болж байна гэж ойлгож байна.

- Цаашид бүсийн хөгжлийн тулгуур төв гэсэн ойлголт, ухагдахууныг таталцлын төв, тэнхлэг, эдийн засгийн өсөлтийн туйлууд, хөгжлийн бүсүүдтэй холбон харьцуулан судалж, нийгэмд нэг мөр баримтлах нэгдмэл үзэл хандлага болгон хэвшүүлэх нь шинэ бодлогыг нийтээр хүлээн авч, хамтдаа хэрэгжүүлэх сэтгэлзүйн чухал нөхцөл болно гэж үзэж байна.

## **5. Төвлөрлийг сааруулах бодлого, хэрэгжилтийн талаарх санал бодол**

Төвлөрлийг сааруулах бодлого, хэрэгжилтийн талаарх үнэлэлт, дүгнэлт “Төвлөрлийг сааруулах” ойлголтын хүрээнд судлаачид дараах асуудлыг хамруулан үздэг. Үүнд:

- бүс (аймаг, сум)-ийн эдийн засгийн бие даасан байдлыг хангах;
- төв, орон нутгийн төрийн байгууллагын хооронд эрх, чиг үүргийн хуваарилалт хийх;
- төр боломжтой чиг үүргээ хувийн хэвшлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, шаардлагатай хөрөнгө төсвийг хуваарилах;
- ардчилал, зах зээлийн нөхцөлд төрийн төвлөрсөн удирдлагыг халж, иргэний нийгмийн эрх, үүрэг, хариуцлагын тэнцвэрийг хангах;
- хүн амын хэт бөөгнөрлийг багасгах, шилжих хөдөлгөөн, сууршилтыг зохистой болгох.

БХҮБ, хуульд бүс нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хангах, том хот суурингийн хүн ам, үйлдвэрлэл үйлчилгээний хэт бөөгнөрлийг багасгах зорилтуудыг тодорхойлжээ. Тухайлбал, БХҮБ-ын 4.1-д: ” Бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих бодлогын гол чиглэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын нутгийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатай дээшлүүлэх, 4.7.1-ийн ж –д, “бүсчилсэн хөгжлийн асуудлаар төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллага хоорондын ажлын уялдаа, харилцан мэдээлэл, зохицуулалтыг хангах”; 2.1-д, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах”; БХУЗ-ын тухай хуулийн 4.1.4-т, “бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг



дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, тэдгээрийн бие даан хөгжих боломжийг хангах” зэрэг зорилтуудыг тус тус дэвшүүлжээ.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх арга замууд нь бүс нутгийн эдийн засгийг экологийн даац, байгалийн баялгийн чадавх, хүн ам, зах зээлийн эрэлтэд нь нийцүүлэн төрөлжүүлэх, эдийн засгийн бүсийн хэмжээнд, аймаг, сум, хот, хөдөөгийн хөгжлийн уялдааг хангах, бүс нутаг, хот, тосгоны харилцан уялдсан тогтолцоонд тулгуурлан хүн амын суурьшил, шилжих хөдөлгөөнийг зохистой харьцааг тогтоох явдал гэж үзсэн байна. 2001 – 2015 он хүртэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийн зорилтууд бодитой үр дүн өгөхөөр хэрэгжээгүй учраас хүн ам хөдөөнөөс хот руу олноор шилжих үйл явц байнга үргэлжилж, хот, хөдөөгийн хүн амын аж байдлын түвшний ялгаа (олон үзүүлэлтээр: ажил эрхлэлт, орлогын ядуурал, нийгмийн үйлчилгээний хүртээмж, хангамж г.м) ихсэх хандлагатай байгааг 2016 оны ҮСХ-ны статистикийн мэдээ харуулж байна.

2016 онд, төвлөрлийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор Засгийн газар (2016 350-р тогтоол) “Төрөөс төвлөрлийг сааруулах бодлого”-ын бие даасан баримт бичгийг батлан мөрдүүлсэн байна. Энэ бодлогыг 2020 он хүртэл 2 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Бодлогын хүрээнд дор дурдсан зорилтуудыг тавьж хэрэгжүүлэх ба, тэдгээрийн үр дүнг үе шат бүрийн эцэст тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнэх юм байна. Үүнд,

- төв, орон нутгийн удирдах болон захиргааны байгууллагын зарим чиг үүргийг дахин хуваарилах;
- орон нутгийн эдийн засаг, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн төвлөрлийг сааруулах,
- татварын болон хөрөнгө оруулалтын уян хатан бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн тогтолцоог боловсронгуй болгох;
- төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд болон иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх хууль тогтоомжоор тогтоосон төрийн зарим чиг үүргийг гагцхүү шударга өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулсны үндсэн дээр шилжүүлэх;
- засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх санал боловсруулна;

Нэгдүгээр үе шатанд, төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, захиргаа, төсвийн төвлөрлийг сааруулах ажлыг эхлүүлэх бөгөөд дараах үр дүнд хүрсэн байна: Шалгуур үзүүлэлт:

1. нэгдсэн төсвийн нийт зарлагад орон нутгийн зарлагын эзлэх хувь 32 хувиас доошгүй болсон байна.
2. төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чиг үүргийн 20-иос доошгүй хувийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж эхэлсэн байна;

Хоёрдугаар үе шатанд, төвлөрлийг сааруулах бодлогыг бүрэн хэрэгжүүлэн Засгийн газар, орон нутгийн түвшинд чиг үүргийн оновчтой хуваарилалт бий болж, захиргааны болон төсвийн төвлөрөл саарсан байна.

Хүрэх үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтийг яам, Засгийн газрын агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чиг үүргийг ангилж, зайлшгүй шаардлагатайгаас бусад чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж нийтийн албаны чиг үүргийг оновчтой болгосон байна гэж тодорхойлсон байна.

Нэг дэх үе шат шувтарч байгаа ч бас л бодитой үр дүн гараагүй хэвээр байна. Үүнд, төрийн бодлогын залгамж чанар, төр, иргэн, ААНБ-ын харилцан зөвшилцөл, хамтын ажиллагаа хангалтгүй байгаа явдал нөлөөлсөөр байна. Энэ бодлогын мөн чанар, нийгэмд үзүүлэх үр нөлөөг Засгийн газрын байгууллагууд өөрсдөө санаачлан олон түмэнд сурталчлан ойлгуулах ажил дутмаг байна. Хүмүүс төвлөрлийг сааруулах гэхээр хөдөөгийн хүн ам нийслэл Улаанбаатарт олноор шилжин суурьшсаар байгааг голлон ойлгож байна. Мөн нийслэлийн ИТХ, ЗД-ын Тамгын газар “хүн амын шилжих хөдөлгөөнийг 2020 он хүртэл түр зогсооё” гэсэн захиргааны шийдвэр гаргасан нь оновчтой механизм болж чадахгүй байна.

Ийм нөхцөлд, Үндсэн хуульд заасанчлан, хүн ам, ялангуяа залуу үе эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд тав тухтай ажиллаж амьдрах газраа чөлөөтэй сонгох эрхийг бодитой хэрэгжүүлэх орон зайн эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй байна. Энэ бол “Бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлого”-ыг шинэчлэн тодорхойлж, гол нь үр дүнтэй хэрэгжүүлэх өмнөхөөс илүү ирээдүйтэй арга механизмыг олж тогтоох ажил хүлээгдэж байна. Ийм нэг эхний цогц механизм нь нийслэлийн ЗД-аас дэвшүүлж байгаа үр ашигтай “агломерац” буюу УБ, Дархан, Эрдэнэтийн бүс нутагт “Хөгжлийн гурвалжин”-г байж болох юм гэсэн асуудал олон нийтийн анхаарлыг татаж байгаа учир нягтлан судалж, төлөвлөх хэрэгтэй байна.

## **6. Аймаг, нийслэлийн хөгжлийн хөтөлбөрийн баримт бичгүүд**

№	Аймаг нийслэл	Хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр	Хамрах хугацаа	Батлагдсан он
---	---------------	--------------------------------------	----------------	---------------

1	Архангай	Архангай аймгийн 2006-2015 оны хөгжлийн хөтөлбөр	2006-2015	2006
2	Баян-Өлгий	Баян Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөр	2010-2020	2009
3	Баянхонгор	Баянхонгор аймгийн хөгжлийн хөтөлбөр	2006-2020	2006
4	Булган	Булган аймгийн эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр	2006-2020	2005
		Булган аймгийн хөгжлийн 2010-2021 оны цогц бодлого	2010-2021	2010
5	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого	2008-2021	2008
6	Говьсүмбэр	Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр	2003-2020	2003
		Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2010-2021 оны цогц бодлого /төсөл/		
7	Дархан-Уул	Дархан-Уул аймгийн 2009-2021 он хүртлэх хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009
8	Дорноговь	Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө	2011-2021	2011
		Дорноговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр	2002-2020	2002
9	Дорнод	Дорнод аймгийн хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009
10	Дундговь	Дундговь аймгийн 2020 он хүртэлх хөгжлийн бодлого	2003-2020	2003
11	Завхан	Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009

12	Орхон	Орхон аймгийн хөгжлийн цогц бодлого	2009-2021	2009
13	Өвөрхангай	Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлого	2007-2015	2006
14	Өмнөговь	“Байгалийн баялаг – Сайн засаглал – Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр	2010-2020	2009
15	Сүхбаатар	Сүхбаатар аймгийн хөгжлийн хөтөлбөр	2007-2015	2007
16	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн 2007-2021 оны хөгжлийн хөтөлбөр	2007-2021	2007
17	Төв	Төв аймгийн хөгжлийн хөтөлбөр	2008-2023	2008
18	Увс	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр	2008-2021	2008
19	Ховд	Ховд аймгийн хөгжлийн хөтөлбөр	2007-2015	2007
20	Хөвсгөл	Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр	2008-2015	2008
21	Хэнтий	Хэнтий аймгийн хөгжлийн 2009-2021 оны цогц бодлого /төсөл/		
22	Нийслэл	Улаанбаатар бүсийн хөгжлийн хөтөлбөр	2006-2015	2006
		Улаанбаатар хотын “Мянганы хөгжлийн зорилтууд”	2009-2015	2009
		Улаанбаатар хотыг 2020 оны хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн хандлага	2013	

Олонхи аймгийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд албан ёсны/ Зарим нь Аудитын хяналт хийлгэжээ/ болон хөнлөнгийн үнэлгээ хийлгээгүй, хугацаа нь дууссан байгаа тул бодитой дүгнэлт өгөх боломжгүй байгаа юм. Харин ажиглалт

хийж үзэхэд БХҮБ, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрүүдийн нэг адил аймаг, сум, баг хоорондын ЖДҮҮ-г хорших, орон нутгийн имижийг харуулсан шилмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын ажил эрхлэлтийг сайжруулах, шилжих хөдөлгөөний, сааруулах, ядуурлыг бууруулах, хот, хөдөөгийн суурийнгуудын уялдаа, холбоо, тохижилтийг сайжруулах бүсчилсэн хөгжлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон асуудал цаг тухайдаа шийдэгдээгүй Явж иржээ. Гол шалтгаан хөрөнгө санхүүгийн чадавхи, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр, улсын төсөвийн дэмжлэг, эрх мэдлийн болон татварын зохицуулалт дутсантай холбоотой байна. Орон нутгийн хөгжлийн санд өгч байсан ашигт ААНБ-ын ашигт малтмал ашигласны ашгийн татварын тодорхой хувь/сумдад 10%, аймагт 20 %-ийг нь/-ийг улсын төсөвт эргүүлэн авч төвлөрүүлэх болсон явдал нэлээд нөлөөлсөн байх жишээтэй.

Бүсчилсэн хөгжлийн бодлогоо шинэчлэн тодорхойлоод байгаа дээр дурдсан аймгууд ЖДҮҮ-г хоршин, зах зээлд нэмүү өртөг олох нутгийн бренд бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, байгаль орчин, нөөц баялгийг ашиглаж, хамгаалах орон зайн хамтын менежментийг бүрдүүлэх бүлэг суурингийн таталцал бий болгох зэрэг үндэслэлээр сум, багаа бүсчлэн/бичил бүсүүд/ хөгжүүлэх зураглал, схемүүдийг дэвшүүлсэн нь зүйтэй болжээ

## **7. Улаанбаатарын бүсчилсэн хөгжил**

Монгол улсын Их Хурлын 2001 оны 57-р тогтоолоор батлагдсан Монгол орны бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол улсын нутаг дэвсгэрийг эдийн засгийн Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэхээр тусгасан, Бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, эдийн засаг, нийгэм, оюуны чадавхийг харгапзан хөгжлийн тэргүүлэх чиглэлийг оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг улс хоорондын тээвэр – эдийн засаг, аялал жуулчлалын төв байхаар тогтоосон байна. Энэ дагуу Засгийн газраас 2006 онд /197-р тогтоол/ Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрийг батлан мөрдүүлжээ.. Бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдүгээр үе шат 2010 онд, хоёрдугаар үе шат 2016 онд дууссан байна. УБ хотын СВОТ шинжилгээний тайлан/ Нийслэлийн эдийн засгийн хөгжлийн газар. АХБ., 2014 он/-д хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалтгүй, үр дүн багатай болсон гэж дүгнэжээ. Энэ нь Улаанбаатар хотыг хөгжүүлэх бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн зорилтууд гол төлөв хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний арга хэмжээгээр хязгаарлагдаж ирсэнтэй холбоотой байна.

Нийслэл хотын хөгжлийн асуудлыг Төв аймаг, Төвийн бүсийн эдийн засаг, нийгмийн орон зайн таталцлын хүрээнд харилцан уялдаатай авч үзэхээр төлөвлөсөн 2020 он хүртэл хөгжүүлэхээр 2014 онд баталсан 5 дахь удаагийн Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжих хугацаа бас дуусах дөхөж байгаа ч хэрэгжилтийн явц хангалтгүй, 10 –аад жилийн өмнө

дэвшүүлсэн хотын хөгжлийн асуудлууд цаг тухайдаа шийдвэрлэгдэж чадаагүй, хуримтлагдсаар ирсэн байна. Ялангуяа хотын хүрээлэн буй орчин, оршин суугчдын амьдрах нөхцөл сайжраагүй нь хүн амын төвлөрөл саарахгүй, механик өсөлтийг хотын дагуул болон хаяа хот, тосгон төв аймгийн тосгон сумд руу чиглүүлэх бодлого хэрэгжээгүй байна. Хөдөөнөөс шилжин ирэгсэд олширч, ажилгүй хүмүүс, түүний дотод залуучууд олноор бий болж, ядуу өрх айлын тоо ихсэж, ажилтай гэгдэж байгаа хүмүүсийн амьдрал ч хангалттай биш, тэдний хөдөлмөрийн бүтээмж олон шалтгаан, түүний дотор авто машины түгжрэлийн улмаас доогуур байгаа юм. Улаанбаатар хотод оршин суугчдын 3 хүн тутмын нэг нь 1990-2015 оны хооронд шилжиж ирсэн дүр зураг гарч, хүн ам жилд дунджаар 6 хувиар өссөн нь улсын дундаж өсөлт болох 1.83 хувиас өндөр байна.

Улаанбаатар хотын хүн амын улсын дүнд эзлэх хувь 1990 онд 26 хувь байсан бол 2017 онд 47 хувь болж өсчээ. Нийслэлийн Засаг даргын захирамжаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг 2017 оноос хязгаарлаж зарим үр дүн гарч байна гэж хэлж байгаа ч нийслэлийн хүн амын өсөлтийн 56 хувийг хүн амын шилжилт хөдөлгөөн эзэлсэн хэвээрээ, хүн амын нягтрал 286 байгаа нь улсын дунджаас 150 дахин өндөр үзүүлэлт гарч байгаа бөгөөд энэ төвлөрлөөс үүдэлтэй агаар, орчны бохирдол, авто замын түгжрэл үүсэх, дэд бүтцийн ачаалал ихсэх, нийгмийн үйлчилгээний хүчин чадал зэрэг асуудлууд зохистой хэмжээнээсээ 2-3 дахин хэтэрсэнийг мэргэжлийн байгууллага, хүмүүсийн судалгаа харуулж байна. Энэ бүхний цаад хотын ерөнхий төлөвлөгөөтэй биш, харин, нийслэлийн хөгжлийн асуудлыг улс орон, бусад бүс нутгийг хөгжүүлэх эдийн засаг, нийгэм, хот байгуулалт, байгаль орчны бодлоготой уялдуулж, Монголын нийгмийн орон зайн нэгдмэл, харилцан уялдсан зохион байгуулалтыг бий болгох шаардлагыг дутуу харгалзаж байгаатай холбож үзэх нь зүйтэй байна.

БХҮБ-д тодорхойлсоны дагуу эдийн засгийн 5 макро бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, харилцан хамааралд тупгуурлан, нийслэлийн оновчтой бүтэц, чиг үүрэг, таталцлын тогтолцоог бүрдүүлж, нийгмийн ямар үйлдвэрлэл үйлчилгээг аль бүс нутаг, хот, тосгодод хэрхэн шилжүүлж, УБ хотын хэт төвлөрөл, ачааллыг дэс дараатай сааруулж болох вэ гэсэн төрийн алсын хараатай, бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах нэгдмэл бодлого, эрх мэдэл, чиг үүргийн хуваарьлалт, бүтэц, төрөлжилтийн өөрчлөлт, эдийн засгийн урамшуулал, аймаг бүс нутгийн өргөн зөвшилцөл, татвар, төлбөр, хөрөнгө санхүүгийн зохицуулалт зэрэг цогц арга хэмжээг дэс дараатай, тасралтгүй явуулах шаардлага тулгамдаж байна. Үүнтэй уялдуулан УБ хотыг 2030 он хүртэлх хугацаанд хөгжүүлэхээр зурагласан төсөөллийг дээрх бодлогоор баталгаажуулж, нийслэлийн хөгжлийн зохистой хэмжээ, бүтэц, чиг үүргийг Монгол орны нийгмийн орон зайн зохион байгуулалтын хүрээнд бусад аймаг, хот, бүс нутаг, юуны өмнө Төвийн бүсийн хөгжил, үйлдвэрлэл, үйлчилгээний байршилт, хоршилттой холбон шинээр авч үзэх хэрэгтэй байна.

Төвийн бус нутаг нь Ази – Европыг холбосон авто болон төмөр замын тэнхлэгт татагдан хөгжсөн нэгдмэл нэг нутаг дэвсгэрийн систем учир нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүс буюу Төв аймгийн нутагшил, суурьшилтын тогтолцоо, хөгжлийн хэтийн төлөвийг Төвийн бүс болон Улаанбаатарын бүсийн хөгжлийн чиг хандлагатай нягт уялдуулах шаардлагатай байгаа юм. Үүнд:

1. Дархан-Сэлэнгийн газар тариалан, аж үйлдвэрийн бүс,
2. Нийслэл Улаанбаатар хотын эрчимтэй таталцап нөлөөллийн бүс
3. Говийн уул уурхай, аж үйлдвэр, байгаль хамгаалах бүс эдгээр болно.

21 дүгээр зууны хотын хөгжлийн онолд томоохон хотын газар нутгийг “хотын үндсэн нутаг дэвсгэр”, “хотын агломераци буюу төвлөрлийн орон зай”, “хотын мегаполис” гэсэн гурван хэсэгт хуваан авч үзэж байна. Дэлхийн улс орнуудын хотжилтын жишгээр, хотын нутаг дэвсгэрт нийт хүн амын 35 хувь нь, хотын агломерацийн орон зайд 55 хувь нь, мегаполист 10 хувь нь тус тус оршин сууж байгаа юм байна. Энэ жишгээр Улаанбаатар хотын орон зайн зохион байгуулалтын бүсчлэлийг 4 бүсэд хуваан авч үзэж болох юм. Улаанбаатар хотын хойд хэсгээр эрчимжсэн мал аж ахуй, сүүний чиглэлээр, баруун хэсгийг хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр, зүүн хэсгийг хүнс, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр, урд хэсгийг инноваци, өндөр технологи, аялал жуулчлал, санхүү, бизнесийн үйлчилгээний чиглэлээр хөгжүүлэх боломжийг судлан цаашдын бодлого төлөвлөлтөд харгалзах нь зүйтэй байна,

Түүнчлэн төвийн бус нутагт төвлөрч буй хүн амын суурьшлын зохистой тогтолцоог бий болгоход аймаг, орон нутгийг эдийн засгийн хувьд төрөлжүүлэн хөгжүүлэх, нийслэлийн таталцал, нөлөөллийн бүсийг шинээр тодорхойлж, Улаанбаатар хотын төвлөрлийг задлах, дагуул хот, бусад хот, суурин газрууд руу түлхэх хүчийг үүсгэх зэрэг бодлогыг авч хэрэгжүүлэх боломжийг нарийвчлан судалж, холбогдох зураг төслийг боловсруулж болох байна. Энэ бүхнийг төвийн бүс, түүний дэд бүсүүд /мезо/-ийг ландшафт –экологийн болон газрын менежментийн бүсчлэл дээр тулгуурлан авч үзэх нь зүйтэй юм. Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн аль шийдэлд, УБ-ын ус цаг уурын өөрчлөлт, усны нөөцийн бчанар, байршилт, газар хөдлөлтийн хотын амьдралд үзүүлж болзошгүй аюул эрсдлийг бодолцох нь зайлшгүй болно. Дээр дурдсан олон асуудал, тулгамдсан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатарын бүсчилсэн хөгжлийн стратегийн чиглэл, арга замыг цаашид шинэчлэн тодорхойлж, түүнийг Монгол улсын эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болгон баталж, мөрдүүлэх нь зүйтэй байна. Эдгээр санал, дүгнэлтийг Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрт тусгасан “Улаанбаатар хотын хөгжлийн зохицуулалтын тухай хууль”-ийн үзэл баримтлалыг тодорхойлж, хэрэгжүүлэхэд харгалзуулах саналтай байна.

### 3.2. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн талаар төр, улс төр, иргэд, олон улс, гадаад орны байгууллагын хийсэн үнэлгээ, санал, бодол, мэдээлэл

#### 1. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн талаар төрийн байгууллагуудаас хийсэн хяналт шинжилгээ /ҮХШХ-ны мэдээ, хуучин нэрээр/

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод бүсийн хөгжлийн талаар дараах зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэх,
- Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн эдийн засгийн өсөлтийг хөгжлийн хүчин зүйл болгож, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх,
- “Хөдөөгийн хөгжил” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх,
- Бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавих,

#### Хэрэгжилтийн явц

- ❖ Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийг 2005 онд баталсан байна.
- ❖ Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө түүний бүрдлийг 2002 онд, Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2004 онд баталжээ.
- ❖ Бүсийн тулгуур төв хотуудыг 2020 он хүртэл хөгжүүлэх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2005 онд баталсан.

Эдгээр зорилтын хэрэгжилтийн үр дүнг ҮХШХ (тэр үеийн нэрээр)-ноос үнэлснийг дараах хүснэгтээр харуулав.

<b>2015 онд хүрэх зорилт</b>	<b>Өнөөгийн байдал</b>
------------------------------	------------------------



<p>Баруун бүсийн хөгжлийн төслийг ЗГ-аар батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхлэх;</p> <p>(ШҮ-Шинээр боловсруулсан бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр) Хангайн, Төвийн, Зүүн бүсийн хөгжлийн төслийг боловсруулж, ЗГ-аар батлуулах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж</p>	<p>Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо 2010 онд хөндлөнгийн байгууллагаар Баруун ба Хангайн бүсийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ хийлгэж тайланг хорооны Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Монгол Улсын Шадар сайдад хүргүүлсэн (“Бүс нутгийн эдийн засгийг дэмжих” хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгээр). Энэ мониторингоос үзэхэд:</p>			
	Бүсийн хөтөлбөр		<b>Баруун</b>	<b>Хангайн</b>
	Тэргүүлэх зорилтын тоо		46	32
	Бодлогын зорилтын тоо		377	402
	Хэрэгжилтийн /Зорилтын тоо ба хувь/	100 хувь	14 / 3.7	16 / 4
		90 хувь	36 / 9.5	33 / 8.2
		70 хувь	99 / 26.1	87 / 21.6
		50 хувь	78 / 20.6	99 / 24.6
30 хувь		55 / 14.5	79 / 19.7	
	10 хувь	42 / 11.1	40 / 10	

	0 хувь	42	37 / 9.2
	Дүгнэх боломжгүй	13	11 / 2.7
<b>Хэрэгжилтийн явцын дүн</b>		<b>52.06</b>	<b>47.0 хувь</b>
<b>Хүрсэн түвшний үнэлгээ</b>		<b>15.3</b>	<b>21 хувь</b>
<b>Хэрэгжих магадлал</b>		<b>60 хувь</b>	<b>60 хувь</b>
<b>Үр өгөөж</b>		<b>40 хувь</b>	<b>31.5 хувь</b>

Төвийн ба Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын мониторинг, үнэлгээг хугацаа болон санхүүгийн боломжгүй байдлаас 2011 онд хийхээр төлөвлөж байсан ч өмнөх хоёр бүсийн үнэлгээний тайланд үндэслэн мониторинг үнэлгээ хийлгэх шаардлагагүй гэж үзсэн.

"Баруун бүсийн хөгжлийн төсөл"-ийг 5 аймгийн ИТХ, "Баруун бүсийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлж, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд танилцуулсан. Салбарын ШУТЗ, ба сайдын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлсэн.

Төвийн бүсийн Тавантолгой, Оюутолгой, Цагаансуваргын орд газруудыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөө, Арвайхээр, Даланзадгад, Цэцэрлэг хотууд, Өмнөговь аймгийн зарим сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан.

	Баруун болон Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг, үнэлгээний тайлан буюу үнэлгээний багийнхны өгсөн зөвлөмжид: “Баруун ба Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд өнөөгийн хөгжлийн цаг үеэс хоцрогдож, цаашид хөтөлбөрийг үргэлжлүүлэх шаардлагагүй, харин шинээр боловсруулах хэрэгтэй болсныг харуулж байна” гэж заажээ.
Бүсийн тулгуур төв болох Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. (ШҮ-Шинээр боловсруулсан бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр)	Ховд, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Замын-Үүд, Сүхбаатар хотуудын хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулах хөрөнгө 2009, 2010 оны төсөвт тусгагдаагүй байна. Арвайхээр, Даланзадгад, Цэцэрлэг, Улиастай хот, Өмнөговь аймгийн зарим сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Төв, Өмнөговь, Булган аймгийн зарим сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна. Ховд, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Замын-Үүд, Сүхбаатар хотуудыг улсын зэрэглэлтэй хотын статустай болгож, хотын хөгжлийн цогц арга хэмжээ авах зорилгоор орон нутгаас ирсэн материалуудыг судлан, товч танилцуулга, тогтоолын төслийг боловсруулж байна.
Бүс нутгуудын удирдлагын	Төсвийн тухай хуулийн төсөлд орон нутгаас

<p>оновчтой тогтолцоо, бүтцийг бүрдүүлж ажиллуулах нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэн, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж шилжих хөдөлгөөнийг сааруулах</p>	<p>төсөвт төвлөрүүлдэг орлогыг төсөвт төвлөрүүлэхгүйгээр орон нутаг нь өөрсдөө захиран зарцуулах эрхийг тусгаж өгсөн.</p> <p>Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн хүрээнд орон нутгийн түүхий эд, ажиллах хүч, зээлийн багтаамж, нөөц боломжид тулгүүрлан ЖДҮ-дэмжих чиглэлээр улсын төсвөөс хуваарилсан 30 төгрөгийг олгосон байна.</p> <p>Хөдөө орон нутгийн хүн амын өсөлт 2010 оны 0.71 хувь байхад Улаанбаатар хотын хүн амын 2010 оны байдлаар 11.87 хувь байна.</p> <p>Хөгжлийн хөтөлбөрүүдийн биелэлт хангалтгүй нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэмжээ, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг жил үндсэн чиглэл, төсөвт төдийлөн тусгаагүй, талаар хөтөлбөрийн хэрэгжилтийг зүхицүүлалтаар ханган хяналт тавих үүрэгтэй зөвлөл. Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны албаны эрхзүйн чадамж, хүний нөөц хүрэлцээ удирдлага, зохион байгуулалтын бүтэц оновчгүй байгаатай холбоотой.</p>
<p>“Хөдөөгийн хөгжил” хөтөлбөр боловсруулж</p>	<p>“Хөдөөгийн хөгжил” хөтөлбөрийг боловсруулж 2009 онд “Малчдын талаар төрөөс баримтлах ын баримт бичгийг УИХ-аас баталж уялдуулан уг хөтөлбөрийг боловсруулж байна.</p>
<p>Бүсийн тулгуур төвүүдэд үйлдвэр, үйлчилгээний байгуулна. (ШҮ- Бүсийн төвүүдэд аж үйлдвэр, цогцолборын тооны өсөлт)</p>	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн тухай хууль 2009 онд батлагдсан. технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн тухай” журмын төсөл боловсруулсан. Улаанбаатар, Налайх, Эрдэнэт, Дарханд технологийн парк байгуулах асуудлыг Монгол</p>

<p>Тухайн паркийн үндсэн ажиллагаа жигдэрч, импорт болон экспортын үйлдвэрлэл явагдана. Багануурт нано сүүрилсэн үйлдвэр. парк байгуулагдсан байна)</p>	<p>үйлдвэржүүлэх хөтөлбөрийн 2010-2016 онд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. Хан Уул дүүрэгт үйлдвэрийн технологийн хаягдал цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, Ховд хотын байгууламжийн ТЭЗҮ 144.0 сая төгрөгөөр хийгдсэн. "Сайншанд аж үйлдвэрийн парк" төсөл "Төрийн концессын зүйлийн жагсаалт"-д тусгагдсан.</p>				
<p>Нэмэгдсэн өртгийн үндэслэсэн цогцолборуудын үйл жигдэрч үр ашгаа өгч эхэлнэ УИХ-аас баталсан үндсэн нэр заасан ҮТП-үүд</p>	<p>Жилд 30000 л наноантисептик тосон түрхлэг, 15000 гар халдваргүйжүүлэгч гель, 100000 наноантисепток шархны боолт бинт үйлдвэрлэх чадалтай Багануур дүүргийн "Монхимо" ХХК ЖДҮ-хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна.</p> <p>Үр ашгаа өгч эхлээгүй байна.</p>				
<p>Улаанбаатарын дагуул хот, Үүд, Алтанбулаг, Цагааннуур суурин газруудад эдийн болон худалдааны чөлөөт байгуулан ажиллуулж технологи нутагшуулах</p>	<p>"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн ажлын байдалд 2009 онд дүгнэлт өгсөн. "Цагааннуур", "Замын-Үүд" эдийн засгийн бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дүүссэн. БНХАУ-ын 50 сая ам.долларын хөнгөлөлттэй "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн дэд барихаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгчийн шалгаруулалт явагдсан.</p>				
<p>Бүс нутгийн хэмжээнд хүчний эх үүсвэрүүд (ШҮ- Бүс нутгийн хэмжээнд хүчний найдвартай эх хангана)</p>	<p>Уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа говийн бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах нэгдсэн хараахан гараагүй. Тус тусдаа хийгдэж буй ажлыг нэгдсэн бодлогоор зохицуулах шаардлагатай. Зүүн бүстэй холбох талаар зарим эхлэл тавигдаж Харин баруун бүстэй холбох талаар одоогоор ажил байхгүй байна.</p> <p>Улаанбаатарын цахилгаан, дулааны 5 дахь эх барьж байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулж байна.</p>				
<p>Хатуу хучилттай авто замын</p>		<p>2006</p>	<p>2007</p>	<p>2008</p>	<p>2009</p>

сүлжээ 6000 км болно (ШҮ-Хатуу хучилттай авто замын урт)	Хатуу <u>авто зам /км/</u>	2392.8	2597.2	2671.2	2824.0
--	-------------------------------	--------	--------	--------	--------

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах үүрэгтэй бүсийн зөвлөлийн дарга, холбогдох аймгуудын Засаг дарга нар, хяналт тавих үүрэгтэй ИТХ-ын

Тэргүүлэгчид тус тусын үүргийг төдийлөн сайн гүйцэтгэж чадахгүй байна.

Бүсүүдийн чуулга уулзалтыг жилд хэд хэдэн удаа зохион байгуулж, тэр үеэр тавьсан илтгэлд хийсэн дүгнэлт, дэвшүүлсэн зорилтууд болон иргэдийн гаргасан санал, хүсэлтийг тусган бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх талаар удаа дараа зөвлөмж гаргадаг хэдий ч хэрэгжилт, үр дүн хангалтгүй байсаар байна.

ҮХЦБ-д тусгагдсан стратегийн зорилт, арга хэмжээнүүд нь 2006 оноос өмнө эхэлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байсан бөгөөд үнэлгээний хамрах хугацаанд бодитой өөрчлөлт гараагүй байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын дараачийн үе шатны хэрэгжилтийн тайланд /2014 – 2015 он/ бүсчилсэн хөгжлийн асуудлыг тусгайлан тусгаагүй байгаа нь харагдаж байна.

## **2. Монголын бүсчилсэн хөгжлийн бодлого, хэрэгжилтийн талаар ОУБ–ын хийсэн судалгааны зарим дүгнэлт, санал**

БХҮБ, хууль тогтоомж батлагдсан 2004 оноос эхлэн Монгол дахь ОУБ, гадаад орны хамтын ажиллагааны байгууллагуудын зүгээс тодорхой судалгаа хийж, зарим үнэлэлт, санал зөвлөмж гаргасан байна. Зарим байгууллагын БХ-ийн бодлого, түүний талаар 2004 оноос өнөөг хүртэл хийж ирсэн судалгаа, тайлангийн ажил, тэдгээрт хийсэн гол дүгнэлт, санал зөвлөмжийг авч үзье.

ОУБ, гадаад орны хамтын ажиллагааны байгууллагаас Монголын бүсчилсэн хөгжлийн бодлого, хэрэгжилтийн явцын талаар хийсэн дүгнэлт санал

Д/д	Байгууллагын хийсэн судалгааны ажлын нэр	Гарсан он	Хийсэн гол дүгнэлт, санал /Зөвлөхийн тайлбар/
0	1	2	3
1	Азийн хөгжлийн банк (Австралийн компани) “Монголын бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх” МОН. 3948	2004	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн 5 макро бүс, бүсийн тулгуур төвүүдийг дээрээс тогтоож (төвлөрсөн төлөвлөлтийн аргаар) зах зээлийн нөхцөлд бүрэн нийцээгүй байна.</li> <li>• Бүсүүдийн хөгжлийг үнэлж дүгнэх төрөлжилт, хоршилт хөгжлийн индекс зэрэг шалгуур үзүүлэлтийг тооцож ашиглах,</li> <li>• Нутаг дэвсгэрийн хөгжлийг кластер (хамтдаа хөгжих)-ын зарчмаар зохион байгуулах зарчмыг судалж нэвтрүүлэх,</li> <li>• Төр, иргэн, ААНБ-ын хамтын сонирхол нийцсэн бүс нутаг, таталцлын төвүүдийг үүсгэн хөгжүүлэх боломжийг төрөөс дэмжин зохицуулах,</li> <li>• Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын хууль хэрэгжих боломжтой, гол нь төрөөс дэмжих арга механизмыг нь нарийвчлан тодорхойлж, бусад хуульд тусган тогтвортой хэрэгжүүлэх,</li> </ul>



2	Дэлхийн банк “Монголын бүсчилсэн хөгжлийн тайлан”	2005	<ul style="list-style-type: none"> <li>• БХҮБ-д тодорхойлсон хот, хөдөөгийн ялгаа багсгах, тэнцвэрт хөгжлийг хангах зорилтууд хэрэгжээгүй, харин ч төвлөрөл нэмэгдэх хандлагатай байна.</li> <li>• Төрийн чиг үүргийг орон нутагт шилжүүлэх, аймаг, суманд татварын орлогыг үлдээх, төсөв санхүүгийн эрх мэдлийг өргөжүүлэх,</li> <li>• Чөлөөт бүсүүд нь дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах хатуу болон зөөлөн дэд бүтэц хөгжөөгүй учир олонх зорилтууд хэрэгжээгүй байгаа.</li> <li>• Уул уурхайн бүс нутгийг байгаль орчинд ээлтэй хөгжүүлэх, хот суурин байгуулах, орон нутгийн хөгжлийг дэмжих талаар Засгийн газар, компани, олон улсын байгууллагын төлөөлөл оролцсон Гэрээ хэлэлцээр байгуулж ажиллах,</li> </ul>
3	Дэлхийн банк “Өмнөд бүсийн дэд бүтцийн стратеги” – тайлан судалгаа	2009	<ul style="list-style-type: none"> <li>• “Говийн хөгжлийн сан” байгуулж ажиллуулах</li> <li>• Усан хангамж, цахилгаан эрчим хүчний асуудлыг судалж, ирээдүйтэй арга технологийг тогтоон хэрэгжүүлэх,</li> <li>• Хот суурин байгуулах асуудлыг Засгийн газрын түвшинд, хэлэлцээрийн үндсэн дээр судалж, хамтран шийдэх,</li> </ul>
4	ХБНГУ-ын ГТХА-ны бүс нутгийн хөгжлийг дэмжих төсөл /хөтөлбөр/ - (Дархан-Уул,	2008 - 2015	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн асуудлыг зах зээлийн харилцааны зохицуулалтын механизмтай сайтар</li> </ul>

	Орхон, Завхан аймагт хийсэн орон нутгийн зах зээлийн судалгааны төсөл)		<p>холбох,</p> <ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газар, бүсийн болон мэргэжлийн байгууллага (бүсийн зөвлөлүүд, Худалдаа аж үйлдвэрийн танхим)-ын ажлын уялдаа, харилцан дэмжлэгийг хангах,</li> <li>• Бүс нутгийн хөгжлийн асуудалд иргэний нийгмийн идэвхтэй оролцоог хангах,</li> <li>• Бүсийн хэмжээнд аймаг, тулгуур төв бүрийн хоорондын хоршилт, төрөлжилтийг хөгжүүлэх,</li> <li>• Дотоод, гадаад зах зээлийн солилцоо, нэмүү өртгийн сүлжээ, сувгийг тогтоон зүгшрүүлэх,</li> </ul>
5	Дэ Нэйче Консерванси (TNC) “Экологийн бүс нутгийн үнэлгээ, тайлан” - /Монголын хээр талын жишээгээр/	2011	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засаг, нийгмийн хөгжлийг байгаль орчинд хал багатай төлөвлөх,</li> <li>• Экологи – ландшафтын бүсчлэл тогтоож, бүс бүрийн онцлогт тохирсон аж ахуй эрхлэлт, байгаль хамгаалалтын арга хэмжээг төлөвлөж, хөгжлийн бодлогод тусгах,</li> <li>• Энэхүү тайлан судалгааны жишгээр Монголын уулархаг ба говь цөл нутгийн экологийн үнэлгээг хийж, хөгжлийн төлөвлөлтөнд нэвтрүүлэх,</li> </ul>
6	Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага (JICA) “Монголын бүсчилсэн хөгжлийн судалгааны нэгдсэн тайлан”	2015 - 2016	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийг аймаг, салбар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хийх,</li> <li>• Яам газар, аймаг, орон нутгийн удирдлагын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэгийг хангах,</li> <li>• Бүсчилсэн хөгжил хот байгуулалт, дэд бүтцийн асуудлыг цогцоор нь авч үзэх,</li> <li>• Хөгжлийн таталцлын төвүүд, эдийн засгийн өсөлтийн туйлуудыг “эдийн засгийн болон ногоон</li> </ul>

			<p>хөгжлийн коридорын хүрээнд зохион байгуулах”,</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн бүсүүд (5 макро бүсийг оруулаад)-ийн төлөвлөлтийн системийг цаашид нарийвчлан авч үзэх,</li> <li>• Тайлбанд салбар бүрээр хийсэн тооцоо, хэтийн төлөвийн зураглалыг “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ыг цаашид шинэчлэх явцад дахин нягтлах ,</li> <li>• БХҮБ-ыг хүн амын нягтшилт, хот байгуулалтын асуудалтай уялдуулах,</li> </ul>
--	--	--	---

Тайлбар: БХҮБ-талаар иргэдийн бичсэн санаа бодол, нийтлэлийн түүврийн жагсаалтыг Хавсаргав.

### **3. Улс төрийн намуудын байр суурь**

1990 оноос хойш Монгол улс төрийн гол хүчнүүд аймаг, орон нутгийн болон бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын бодлого, хууль тогтоомжийг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны залгамж чанар, төлөвлөлт, зохион байгуулалтын тогтвортой, тасралтгүй байдлыг хангахад гол төлөв өөрсдийн намын үзэл баримтлалын үүднээс хандаж, таагүй нөлөөлж ирсэнийг тэдгээрийн гүйцэтгэлийн үр дүнд хийсэн албан ёсны болон хөндлөнгийн үнэлгээнүүд харуулж байгаа юм. Бодлого тодорхойлж, хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн идэвх оролцоо ч хангалтгүй байгаа нь бас үүнтэй холбоотой байна. Ерөнхийдөө, 2001 оноос 2012 он хүртэл МАН/одоо МАХН –тай нэг нам байсан/ УИХ –д олонх байсан үед макро эдийн засаг, дунд хугацааны төсвийн нэгдсэн бодлогод үндэслэн, аймаг, орон нутаг, салбар хоорондын уялдааг харгалзсан бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохицуулах, үр дүнд нь хяналт – шинжилгээ, үнэлгээ өгөх, бүсчилсэн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, олон түмэнд мэдээлж, тэдний саналыг авах ажлыг жил бүр хийж ирсэн байна. Харин 2012 оноос АН УИХ, Засгийн газарт олонх болж, ардчилал, зах зээлийг цаашид гүнзгийрүүлж, аймаг, сумдыг одоогийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн чадавхийн хүрээнд нь бие даалгах бодлого баримталж, аймгуудын дэд бүтцийг сайжруулах, шинэ тохижсон сум, шинэ тосгон хөдөлгөөн өрнүүлэх, эдгээр зорилгоор орон нутгийн хөгжлийн сан байгуулж, хөрөнгө хуримтлуулах, иргэдийн оролцоотой төсвийн менежментийг буй болгох төлөвлөлтийн зарчмыг хэрэгжүүлэх чиг хандлагыг түлхүү барьж эхэлсэн боловч түүнийгээ тууштай явуулж, бүсчилсэн хөгжлийн бодлоготой холбож чадалгүй , засаг нь солигдоход хүрсэн байна. Ийм учраас бүсчилсэн хөгжил төдийгүй, ер нь аливаа бодлогыг олон нийтийн оролцоотой, алсын хараатай тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэх бодлогын залгамж чанар, үйл ажиллагааны тууштай

байдлыг хангахад намуудын улс үндэстнийхээ эрх ашгийг дээдэлсэн харилцан ойлголцол, уян хатан зөвшилцөл зайлшгүй чухал байгаа юм. УИХ-д суудалтай улс төрийн одоогийн хүчнүүдийн мөрийн хөтөлбөрийг харьцуулан үзэхэд, МАН, АН, МАХН –ын бодлого, баримтлалд бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын асуудал ямар нэг байдлаар бүгдэд нь тусгагдсан байгаа юм. Харин тэдгээр асуудлыг шийдвэрлэх арга зам, дэс дарааллын асуудлаар голлон зөвшилцөх нь зүйтэйг байгааг бодлого тодорхойлох ажилд цаашид харгалзаж болох байна. /Хүснэгтээр харуулав/

№	Эдийн засгийн бүсчлэл, хот байгуулалттай шууд холбогдсон заалтууд	МАН	АН	МАХН
1	Макро эдийн засгийн бодлогын хүрээнд бүсчилсэн хөгжлийг дэмжих	++		
2	Бүсүүдийн эдийн засгийн өсөлтийг хангах	+	++	
3	Төвлөрлийг сааруулах, тогтвортой хөгжлийг хангах	++	+	++
4	Хүн амын нутагшил, хот байгуулалт	++	+	+
5	Бүс нутгийг холбосон хатуу дэд бүтэц, тээвэр ложистикийн сүлжээ	++	++	++
6	Газар эзэмшилт, газар зохион байгуулалт	++	++	+
7	Чөлөөт бүс, аж үйлдвэрийн паркууд	++	+	

8	Улс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн коридор, тээвэр ложистикийн сүлжээ	++	+	
9	Төр, иргэний нийгмийн харилцан түншлэл	+=	++	+
10	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд түшиглэсэн аялал жуулчлалын цогцолборууд	++	++	
11	Байгаль орчны хамгаалал, нөөц ашиглалтын хамтын менежмент	++	+	++

Тайлбар: 1./ 2016 оны УИХ-ын сонгуульд оролцсон, одоогийн УИХ-д суудалтай МАН, АН, МАХН гурваас бусад улс төрийн хүчний мөрийн хөтөлбөрт бүсчилсэн хөгжлийн асуудал бие даасан байдлаар тусгагдаагүй тул дээрх гурван намын байр суурийг харьцуулан авч үзлээ.

2./ Хүснэгтийн нүдэнд “++” тэмдгээр тухайн асуудлыг бүрэн тусгасан, “+” тэмдгээр зарим талаар тусгасан, мөн хоосон байвал тусгагдаагүй гэж үнэлсэн болно.

3./ Дээрх намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан бүсчилсэн хөгжлийн талаарх заалтуудыг хавсаргав. Ингэхдээ, МАН-ын байр суурийг өнөөгийн ЗГ-ын үйл ажиллагааны 2016 – 2020 он хүртэлх хөтөлбөрт тусгасан заалтуудтай нь хамт тусгалаа.

### **3.3. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ**

#### **1. Монголын бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн түүхэн хандлага /туршлага, сургамж/**

Монголын нутаг дэвсгэрийн хуваарилалтын түүхэн хандлага, зохион байгуулалтын хэлбэрүүд:

- Баруун, Зүүн гар, Төв хэсэг/дотроо түмт, мянгат, аравт/ Хүннү МЭ - IV-V зуунаас, цэрэг – улс төр –засаг захиргааны хэлбэр/
- Улс -түмт, мянгат, отог-аравт/ Их Монгол улс XIII, XIV, цэрэг – улс төр –засаг захиргааны хэлбэр/
- Түшээт хан, Засагт хан, Сэцэн Хан, Сайн ноён хан аймаг /дотроо... хошуу/, Манж чин улсын нөлөөн доорх вассаль улс/ XVII зуунаас X IX зууны эхэн, ЗЗНД –ийн хуваарийн түгжигдмэл хэлбэр/
- Богд хан-уул, Хан-Хэнтий уул, Цэцэрлэг мандал уул, Хан Тайшир-уул, Чандмань уулын аймаг /110 хошуу байгаль -бэлчээр, нүүдлийн аж ахуйг харгалзсан
- Аймаг/ 18 – 21/, сум /335/, баг/1600 гаруй/, нийслэл/УБ/- дүүрэг –хороо/ Нэг төвөөс төвлөрүүлэн удирдахад зохицсон ЗЗНД –ийн хуваарь /1931 оноос /

Монголын байгаль – эдийн засаг – газарзүйн мужлалтын туршлага, төрлүүд:

- Экологи –эдийн засгийн газарзүйн мужлалт/  
Дотроо /Ш. Цэгмэд.... нар., Судар бичгийн хүрээлэн 1923 он/
- ХАА-н газарзүйн мужлалт /4-өөс 6 их муж, дэд мужууд/ Н.И. Денисов, Г.Ширнэн 1950-аас 1970 -аад он/
- Тээвэр – газарзүйн мужлалт /5 –аас 6 муж/ М.Бадамбазар 1960-1970 –аад он
- Хэрэглээний уур амьсгалын мужууд /уртрагийн дагуух 3 том бүс/ Н.Намхайжанцан 1980, 1990 –ээд он
- Монгол орны Геокрилогийн /цэвдэгийн тархалтын /мужууд/ 1980–аас 2000 он / ШУА –ийн Газарзүйн хүрээлэн
- Монгол орны газар хөдлөлтийн мужлалт
- Монгол орны ландшафтын бүсчлэл
- Монгол орны металлоген- тектоникийн бүсчлэл - Монгол орны ашигт малтмалын мужлалт

Монголын эдийн засаг /нийгмийн/-ийн нэгдсэн болон салбрын мужлалт, бүсчлэл, төлөвлөлтөд ашиглагдаж ирсэн байдал:

- Баруун, Төвийн, Зүүн бүс / макро-эдийн засгийн 1961оноос Орос –Монголын хамтарсан судалгаа /
- Өрнөд, Төв, Дорнодын муж/ нэгдсэн, дунд масштабын бүсчлэл дотроо 7 дэд мужтай/ШУА-ийн ГЗЦСХ , ак. Б. Гунгаадаш. 1964 -1970 он /

- Авто тээврийн эдийн засгийн бүсүүд /6 том бүс, ак. Т. Намжим. 1965-1970 он/
- Эдийн засгийн Баруун, Төвийн, Өмнөд, Зүүн, Хойт бүсүүд /Эрдэнэт – Сэлэнгийн нутаг дэвсгэр – үйлдвэрлэлийн цогцолбор нэртэй/, 1975 -1990 он. Улсын Төлөвлөгөөний комиссийн ҮХХБХ, хэтийн төлөвлөгөө, Ерөнхий схемд ашиглагдсан/
- Нийгэм-эдийн засгийн тэнхлэгт таталцсан бүсчлэлийн схем /Өрнөд, Дундад, Төв, Дорнод, Хойт /Архангай, Хөвсгөл аймаг/ тэнхлэгийн бүсүүд/ШУА-ийн ГЗХ, док., Б. Базаргүр, С. Шийрэв-Адъяа., 2000 – 2005 он. Монгол Улсыг Тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал/

Монголын эдийн засаг /нийгмийн/-ийн мужлал, бүсчлэлийн үүсэл, хөгжил, төрлүүд:

- Хүн амын нутагшилт, хот байгуулалт /тулгуур төвүүд/-д суурилсан нийгэм-эдийн засаг –хотжилтийн бүсчлэл/Өрнөд, Хангайн, Төвийн,Хэнтийн, Дорнодын бүс, УБ –ын дэд бүстэй/ БЗУИ. Д.Дандарбаатар нарын хот байгуулалтын “Нэг төвтэй зогсонг орчноос олон төв (гурамсан: Улиастай, УБ, Хар хорин тулгууртай)-тэй эрчимтэй хөгжлийн загвар шилжих баримтлал”
- Зам тээврийн босоо тэнхлэг”дэд бүтцэд” суурилсан хүн амын нутагшилт- бүсчилсэн хөгжлийн хавсарсан бүсчлэл /Баруун,Завхан- Хөвсгөлийн, Орхон –Хархорины, Төвийн, Дорнодын 5 бүс/ Д. Сайн –эр нарын 1990 –ээс 2005 он
- Ашигт малтмалын тархалтын онцлог, хөгжлийн бүсүүдүүд үүсэх хандлагад суурилсан хэвтээ тэнхлэгийн бүсчлэл /Оюунбат нарын бүсчилсэн хөгжлийн шинэ концепц 2010 –он/

Монголын улсын эдийн засаг /нийгмийн/-ийн бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн одоогийн түвшин/үндэсний болон бүсүүдийн хэмжээнд/:

- Монгол улсын бүсчилсэн хөгжлийн 2020 он хүртэлх үзэл баримтлал /Эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн , Зүүн бүсүүд, тэдгээрийн дотоод аймгуудын хуваарь / УИХ –ын 2001. 57-р тогтоол
- Монгол улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль /УИХ –ын
- Чөлөөт бүсийн тухай Монгол улсын хууль /Алтанбулаг, Замын-үүд, Цагаан-нуурын чөлөөт бүс/
- Мянганы замын төсөл /2001 он
- Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги /2016 он хүртэлх/
- Баруун, Хангайн, Төвийн, Улаанбаатарын, Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд/2016 он хүртэлх

- Бүсүүдийн тулгуур – төв хотууд /Ховд, Улиастай, Хархорин, Эрдэнэт, Дархан, Зуун-мод, Өндөрхаан /Чингис/, Чойбалсан/ -ын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Монголын улсын эдийн засаг /нийгмийн/-ийн бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн одоогийн түвшин/аймаг, хот, бүс нутгийн хэмжээнд/:

- Аймгууд/18/-ын хөгжлийн/ эдийн засгийг бүсчлэх зарчмыг тусгасан/ хөтөлбөрүүд / Засаг даргын тамгын газрууд, 2015, 2020 хүртэлх/
- Баруун бүсийн хөгжлийн зорилтот /2020 он хүртэлх/төсөл /Зураг төслийн ИГХХК 20 он
- Галбын говь/Таван толгой, Оюу толгой, Цагаан суваргын бүс нутаг/-ийн бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын төсөл/2020 он хүртэлх/ Зураг төслийн ИГХХК 20 он
- Монголын Өмнөд бүсийн дэд бүтцийн стратеги/Өөрчлөн байгуулалт ба хөгжил, дэвшлийн олон улсын банк, Дэлхийн банк/2010 он
- Говийн бүсийн Таван толгой, Оюутолгой, Цагаан суваргын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги ба хот байгуулалтын төлөвлөгөө /БХБЯ, Шинэ хотжилт ХХК, 2008 он/

## **2. Монголын бүсчилсэн хөгжлийн өнөөгийн байдлын дүн шинжилгээ**

Монголын нийгмийн орон зай өнөөдөр эдийн засгийн хувьд Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн таван том бүсээр хүн амын 50 орчим хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 64.6 хувь, аж ахуйн нэгж байгууллагын 60 гаруй хувь нь нийслэл Улаанбаатар хотод бөөгнөрсөн, үлдсэн хувь нь газар нутгийн 90 гаруй хувийг эзэлж буй байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын үнэт өв, эрдсийн олон төрлийн баялаг бүхий 21 аймаг, 334 сумаас бүрдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд дэх хөдөө орон нутагт тархан байршиж байна. Орон зай нь үндсэндээ отор бэлчээрийн хагас нүүдлийн мал аж ахуй, тусгай хамгаалалт, зохицуулалт бүхий газар нутгийн сүлжээгээр зохион байгуулагдсан байна.

Нийгмийн орон зайн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцаа нь сумдыг аймагтай, аймгийг нийслэлтэй холбосон засмал ба сайжруулсан зам, мэдээлэл холбоо, эрчим хүчний шугам сүлжээгээр хэрэгжиж байна. Хоёр хөрш орон ба тэдгээрээр дамжин дэлхийн бусад улстай Улаанбаатар - Алтанбулаг, Улаанбаатар – Замын-үүдийн чиглэлийн төмөр ба хатуу хучилттай авто зам, эдийн засгийн дээрх бүсүүд дэх хилийн 40 гаруй боомтоор холбогдож байна. Аймгууд, бүсүүдийн



хооронд аж үйлдвэрийн, аж ахуйн салбар хоорондын чанартай боловсруулах үйлдвэрлэлийн байнгын хоршилт холбоо хөгжөөгүй, гол төлөв түүхий эд татан авалт, нийлүүлэлт, худалдаа наймаа, эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээ авах хүн амын шилжих хөдөлгөөн зонхилж байгаа юм. Энэ нь аймаг, сумд аж ахуйн адил төрлийн бүтэц, чиглэлтэй, нэг нэгнээ нөхөн хангадаг эдийн засгийн бүтэц, төрөлжилт хөгжөөгүй байгаатай холбоотой байна. Бүс нутаг хоорондын, салбар хоорондын худалдаа, түүний эд татан авалт, нийлүүлэлтийн уялдаа холбоо нь гол төлөв сум – аймаг, аймаг – Улаанбаатар, Улаанбаатар – аймаг, аймаг – сум гэсэн чиглэл, эрчимээр явагдаж байна. Сүүлийн жилд /2014 оноос/ Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв/ ТББ 2014 оноос/, Үндэсний статистикийн хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн Танхим зэрэг газрууд аймаг, бүсүүдийн өрсөлдөх чадварыг тооцох үзүүлэлтүүдийг тооцон гаргаж, албан ёсны болон хараат бус судалгаа хийж, мэдээлэл солилцон хөрьцуулсан үнэлгээ хийж байна. Энэ нь аймаг, сумдын хөгжлийн түвшин, түүнийг цаашид ахиулах чадавх боломжийг бодитой үнэлж, орон нутгийн засаглалын санаачлагыг идэвхжүүлж, дайчилахад түлхэц өгч байгаа нь сайшаалтай байна.

Гэвч байгаль газарзүйн бүс бүслүүрийн дотоод ялгаа ихтэй, нутаг, нутгийн хүн амын аж ахуй, соёлын онцлог зэрэгтэй холбоотой тус орны нөхцөлд эрдсийн баялаг, түүхий эдийн чадавх, түүний ашиглах дэд бүтэц сайтай, дотоод, гадаад зах зээлд ойр дөт байрласан аймаг орон нутаг түлхүү хөгжиж, өрсөлдөх чадвараар илүү байх боломжтой. Мөн экологийн эмзэг орчинтой учир байгалийн баялаг ашиглахад хаяагүй нэмэлт зардал гардаг манй улсад уул уурхай хөгжиж байгаа газар /аймаг, сумд / байгаль орчны шалгуур үзүүлэлтээр доогуур гарах магадлалтай юм. Иймд өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг орон нутгийн засаглал ба ААНБ /мөн тэнд үйл ажиллагаа явуулж буй толгойлогч компаниудын/ -ын хооронд ялган зааглаж, дүгнэх нь зүйтэй байна. Тухайлбал, аймгуудын тухайд тухайн байгаль, эдийн засгийн байгаа нөөц боломжоо тухайн бүс дотроо хоорондоо хоршин ашиглах, эдийн засгаа төрөлжүүлж бие даалгах, орон нутгийн хүн амын аж байдлыг дээшлүүлэхэд иргэд, ААНБ хамтын оролцоог хангаж гаргасан ахиц өөрчлөлтүүд, энэ талаар хэрэгжүүлсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ, хөтөлбөр төслүүдийн үр дүнг гол үндэс болгож болох юм.

Хөдөлмөрийн нутаг дэвсгэрийн хуваарь нарийн хөгжөөгүй, аж ахуй эрхлэлт, байршилтын ерөнхий нэг хэв шинжийн загвартай байгаа манай өнөөгийн нөхцөлд, бүс нутгийн эдийн засгийн бие даасан байдал, хоршилт, төрөлжилтийг нарийвчлан тооцож, задлан шинжилгээ хийх бодит нөхцөл, шаардлага хараахан бүрдээгүй байгаа гэж хэлж болно. Иймд цаашид энэхүү өргөн уудам орон зайд хүн амынхаа аж байдлыг дээшлүүлэх, тэдэнд аль ч аймаг, бүс нутагт очиж тав тухтай ажиллаж, амьдрах чөлөөт сонголтыг хаана, хэдийд, хэрхэн бүрдүүлж болох вэ гэдэг үүднээс бий болсон нөхцөл байдал, гарах арга замыг чанарын талаас нь харьцуулан үнэлж, дүгнэж болох байна. Дээр дурдсаныг харгалзан тус улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтийг бүс аймгуудаар гаргаж, ямар нөхцөл боломж байгааг харьцуулан үзлээ.

### Баруун бүс

Тус бүс нь хойд өргөрөгийн  $44^{\circ}$ - $50^{\circ}$ , зүүн уртрагийн  $88^{\circ}$ - $96^{\circ}$ -ийн хооронд хойноосоо урагш сунаж тогтсон, далайн түвшнээс дээш 800-3500 метр өндөрт өргөгдсөн, Монгол улсын томоохон нутаг дэвсгэр бүхий Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Увсаймгийн нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд эдгээр 5 аймаг нийт сумтай, 415.7 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 26.6 хувийг эзэлж оршдог. Үүнээс бэлчээр 28833.3 мян.га, тариалан 57.8 мян.га талбайг эзэлдэг байна.

Баруун бүс 2010 оны байдлаар 402.7 мян.хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 187.9 мянга, ажиллагчдын тоо 169.0 мянга бол ажилгүйдлийн түвшин 10.1 хувь байна.

Улсын хэмжээний нийт малын 22.7 хувь буюу 7418.5 мян. толгой нь тус бүс нутагт ногдож байна. Нийт тариалсан талбайн 4 хувь буюу 12525.9 га талбайд үр тариа, төмс хүнсний ногоо тариалчээ. Ерөнхий боловсролын 152 сургууль, 144 цэцэрлэгтэй, 3394 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Баруун бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд оны үнээр 388964.7 сая төг буюу нийт ДНБ-ий 4.7 хувийг үйлдвэрсэн байна. Бүсийн орлого зарлагаасаа 3.9 хувиар их байна. Хүний хөгжлийн индекс 2010 онд 0.702 байна.

### Хангайн бүс

Тус бүс нь хойд өргөрөгийн  $44^{\circ}$ - $50^{\circ}$ , зүүн уртрагийн  $98^{\circ}$ - $104^{\circ}$ -ийн хооронд хойноосоо урагш сунаж тогтсон, далайн түвшнээс дээш 800-2800 метр өндөрт өргөгдсөн, Монгол улсын дунд зэргийн нутаг дэвсгэр бүхий Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд эдгээр 7 аймаг нийт 99 сумтай, 384.3 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 24.6 хувийг эзэлж оршдог. Үүнээс бэлчээр 25212.6 мян.га, тариалан 137.5 мян.га, хадлан 231.3 мян.га талбайг эзэлдэг байна.

Хангайн бүс 2010 оны байдлаар 567.1 мян.хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 268.3 мянга, ажиллагчдын тоо 236.4 мянга бол ажилгүйдлийн түвшин 11.9 хувь байна.

Улсын хэмжээний нийт малын 37.3 хувь буюу 12216.5 мян. толгой нь тус бүс нутагт ногдож байна. Ерөнхий боловсролын 170 сургууль, 172 цэцэрлэгтэй, 4175 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Хангайн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд оны үнээр 1496104.7 сая төг буюу нийт ДНБ-ий 18.1 хувийг үйлвэрлэсэн. Хүний хөгжлийн индекс 2010 онд 0.748 байна. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 0.7 хувиар их байна.

### Төвийн бүс

Тус бүс нь хойд өргөрөгийн 44<sup>0</sup>-50<sup>0</sup>, зүүн уртрагийн 106<sup>0</sup>-108<sup>0</sup>-ийн хооронд хойноосоо урагш сунаж тогтсон, далайн түвшнээс дээш 800-2000 метр өндөрт өргөгдсөн, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрийг хамрах ба дээрх 7 аймаг нийт 95 сумтай, 473.6 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 30.3 хувийг эзэлж оршдог. Үүнээс бэлчээр 35504.3 мян.га, тариалан 583.5 мян.га, хадлан 200.9 мян.га талбайг эзэлдэг.

Төвийн бүс 2010 оны байдлаар 459.7 мян.хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 215.4 мянга, ажиллагчдын тоо 195.4 мянга байна. Ажилгүйдлийн түвшин 9.3 хувь байна.

Улсын хэмжээний нийт малын 23.1 хувь буюу 7558.0 мян.толгой нь тус бүс нутагт ногдож байна. Ерөнхий боловсролын 155 сургууль, 160 цэцэрлэгтэй, 4832 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Төвийн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд оны үнээр 915132.7 сая төг буюу нийт ДНБ-ий 11.1 хувийг үйлдвэрлэсэн байна. Хүний хөгжлийн индекс 0.743 байна. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 2.2 хувиар их байна.

### Зүүн бүс

Тус бүс нь хойд өргөрөгийн 44<sup>0</sup>-50<sup>0</sup>, зүүн уртрагийн 110<sup>0</sup>-118<sup>0</sup>-ийн хооронд хойноосоо урагш сунаж тогтсон, далайн түвшнээс дээш 600-1800 метр өндөрт өргөгдсөн, Монгол улсын дунд зэргийн нутаг дэвсгэр бүхий Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийг хамрах ба дээрх 3 аймаг нийт 44 сумтай, 286.6 мян.км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 18.3 хувийг эзэлж оршдог. Үүнээс бэлчээр 21459.5 мян.га, тариалан 147.5 мян.га, хадлан 1221.3 мян.га талбайг эзэлдэг байна.

Зүүн бүс 2010 оны байдлаар 200.4 мян.хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 80.4 мянга, ажиллагчдын тоо 72.0 мянга бол ажилгүйдлийн түвшин 10.5 хувь байна.

Улсын хэмжээний нийт малын 16.1 хувь буюу 5273.8 мян.толгой нь тус бүсэд ногдож байна. Ерөнхий боловсролын 67 сургууль, 77 цэцэрлэгтэй, 1669 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Зүүн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд оны үнээр 280750.7 сая төгрөг буюу нийт ДНБ-ий 3.4 хувийг үйлдвэрлэсэн. Хүний хөгжлийн индекс 0.709 байна. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 1.01 хувиар бага байна.

#### Улаанбаатарын бүс

Улаанбаатар хот нийт 9 дүүрэгтэй, 132 хороотой бөгөөд 470.4 мян.км<sup>2</sup> буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлдэг. Үүнээс 245.9 мян.га нь бэлчээр, 6.0 мян.га хадлан, 5.6 мян.га талбай тариалан байна.

Улаанбаатар хот 2010 оны байдлаар 1151.5 мян.хүн амтай. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 395.1 мянга, ажиллагчдын тоо 360.9 мянга бол ажилгүйдлийн түвшин 8.7 хувь байна.


Улсын хэмжээний нийт малын 0.8 хувь буюу 262.9 мян.толгой нь тус бүсэд ногдож байна. Ерөнхий боловсролын сургуулийн Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн 65.6 хувь буюу 26851 нь Улаанбаатар хотод байна.

Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 онд оны үнээр 5174108.4 сая буюу нийт ДНБ-ий 62.7 хувийг үйлдвэрлэсэн. Хүний хөгжлийн индекс 0.790 байна. Бүсийн төсвийн орлого зарлагаасаа 3.2 хувиар их байна.

#### Бүс нутгуудын хүн ам, нийгмийн үндсэн үзүүлэлтийн чиг хандлага

Монгол улсын суурин хүн амын тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 3,131,6 мянга болж, 2012 оныхоос 321.9 мянгаар буюу жилд дунджаар 1.6 хувиар өссөн байна. Хүн амын жилийн дундаж өсөлтийг бүс нутгаар авч үзвэл: Улаанбаатар болон Хангайн бүсийн хүн амын тоо 2012-2017 онд жилд дунджаар 3.6 болон 0.5 хувиар өссөн байна. Баруун болон Зүүн бүсийн хүн амын тоо 2012-2017 онд буурсан бол бусад бүсэд өссөн байна.

Бүс хоорондын хүн амын тархалтын бүтцэд огцом өөрчлөлт ороогүй боловч 2017 оныг 2012 онтой харьцуулахад Улаанбаатарын бүсийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь 8.7 пунктээр өссөнийг баруун бүсийн 2.9 пункт, хангайн бүсийн 2.6 пункт, төвийн бүсийн 2.0 пункт, зүүн бүсийн 1.2 пунктийн бууралтаар тайлбарлаж болох юм ( $2.9+2.6+2.0+1.2=8.7$  пункт). Энэ нь бүсүүдийн шилжих хөдөлгөөн нь Улаанбаатарын бүс рүү чиглэж ирсэн болохыг илэрхийлж байна.



2017 оны дүнгээр улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 8.8 хувьд хүрч 2012 оноос 06 пунктээр өссөн бол бол хамгийн өндөр нь Хангайн бүсэд 8.3-аас 9.8 хувь, хамгийн бага нь Улаанбаатарт 7.1-ээс 7.5 хувь байна. Ажилгүйдлийн түвшин 2012-2017 онд Зүүн бүсээс бусад бүсэд өссөн хандлага байна. Хангайн, Төвийн болон Улаанбаатарын бүсүүдийн ажилгүйдлийн түвшний өсөлтийг эдгээр бүсэд хүн ам ихээр шилжин ирсэнээр, Зүүн бүсийн шилжих хөдөлгөөн саарч, Баруун бүсэд хүн амын ердийн өсөлт ихтэй байсан зэргээр тайлбарлаж болох ба ажлын байр нийт бүсэд дутагдсан хэвээр, ямар нэг чанарын бүс, тоон өөрчлөлтийн үр дүн болсон гэж үзэж байна.

Бүс нутгуудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн чиг хандлага

**ДНБ-ий салбарын бүтэц, бүсээр /2010 - 2017 оны дундажаар/**

	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр	Уул уурхай	Боловсруулах	Барилга	Үйлчилгээ	Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр	Уул уурхай	Боловсруулах	Барилга	Үйлчилгээ
Бүгд	22.1	33.2	23.5	6.4	3.0	41.7	18.1	35.4	24.8	7.3	1.5	45.1
Баруун бүс	71.0	1.1	0.4	0.1	1.4	5	58.4	6.4	0.3	2.1	8	3
Хангайн бүс	33.5	3	6	1.8	0.9	2	31.4	5	3	1.1	3	7
Төвийн бүс	53.0	1	5	4.9	1.6	3	51.0	8	5	5.5	3	9
Зүүн бүс	65.9	9.4	7.3	0.0	1.1	5	53.4	5	3	1.1	4	7
Улаанбаатар	0.8	7	7	1	4.5	1	0.8	3	6	8	2	6

ДНБ-д хөдөө аж ахуй, барилгын салбарын эзлэх хувь 2010-2017 онд буурч, үйлчилгээ, аж үйлвэрийн салбарын эзлэх хувь өссөн байна. Үүнийг бүс нутгаар авч үзвэл:

Баруун бүсийн ДНБ-д ХАА-н салбарын хувийн жин 2005 онд 71.0 хувь байсан бол 2010 онд 58.4 хувь болж, 12.6 пунктээр буурсан байна. Аж үйлдвэрийн салбарын хувийн жин 2005 онд 1.1 хувь байсан бол 2010 онд 6.4 хувь болж, 5.3 пунктээр нэмэгдсэн. Харин үйлчилгээний салбарын хувийн жин 2005 онд 26.5 хувь байсан бол 2010 онд 34.3 хувь болж, 7.8 пунктээр нэмэгдсэн байна.

Хангайн бүсийн ДНБ-д ХАА-н салбарын хувийн жин 2005 онд 33.5 хувь байсан бол 2010 онд 31.4 хувь болж, 2.1 пунктээр буурахад Булган аймагт 0.3 пункт, Орхон аймагт 0.5 пунктээр нэмэгдсэн боловч бусад аймагт 3.7-11.8 пунктээр буурсан нь нөлөөлжээ. Аж үйлдвэрийн салбарын хувийн жин 2005 онд 55.3 хувь байсан бол 2010 онд 52.5 хувь болж, 0.7 пунктээр буурахад Орхон аймагт 1.3 пункт, Баянхонгор 5.1 пункт, 3.1 пунктээр буурсан нь нөлөөлжээ. Харин үйлчилгээний салбарын хувийн жин 2005 онд 12.2 хувь байсан бол 2010 онд 15.7 хувь болж, 3.5 пунктээр өссөн байна.

Төвийн бүсийн ДНБ-д ХАА-н салбарын хувийн жин 2005 онд 53.0 хувь байсан бол 2010 онд 51.0 хувь болж, 2.0 пунктээр буурахад Сэлэнгэ аймагт 15.1 пункт, Төв аймагт 8.0 пункт, Дархан-уул аймагт 7.1 пунктээр нэмэгдсэн боловч бусад аймагт 10.6-22.4 пунктээр буурсан нь нөлөөлжээ. Аж үйлдвэрийн салбарын хувийн жин 2005 онд 20.1 хувь байсан бол 2010 онд 24.8 хувь болж, 4.7 пунктээр нэмэгдсэн байна. Харин үйлчилгээний салбарын хувийн жин 2005 онд 25.3 хувь байсан бол 2010 онд 23.9 хувь болж, 1.4 пунктээр буурсан байна.

Зүүн бүсийн ДНБ-д ХАА-н салбарын хувийн жин 2005 онд 65.9 хувь байсан бол 2010 онд 53.4 хувь болж, 12.5 пунктээр буурчээ. Аж үйлдвэрийн салбарын хувийн жин 2005 онд 9.4 хувь байсан бол 2010 онд 19.5 хувь болж, 10.1 пунктээр нэмэгдэхэд Сүхбаатар аймагт 23.2 пунктээр нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин үйлчилгээний салбарын хувийн жин 2005 онд 23.5 хувь байсан бол 2010 онд 26.7 хувь болж, 3.2 пунктээр өссөн байна.

Улаанбаатарын ДНБ-д аж үйлдвэрийн салбарын хувийн жин 2005 онд 33.7 хувь байсан бол 2010 онд 35.3 хувь болж, 1.6 пунктээр нэмэгджээ. Барилгын салбарын хувийн жин 2005 онд 4.5 хувь байсан бол 2010 онд 2.2 хувь болж, 2.3 пунктээр буурсан байна. Харин үйлчилгээний салбарын хувийн жин 2005 онд 61.1 хувь байсан бол 2010 онд 61.6 хувь болж, 0.5 пунктээр нэмэгдсэн байна.

Нийт ДНБ-ий 50-аас дээш хувийг Улаанбаатар бүрдүүлж байна. ДНБ-д бүсүүдийн хувийн жингийн хандлагаас үзэхэд 2008-2010 онд Улаанбаатар, Төвийн бүсээс бусад бүсүүдийн хувийн жин буурсан байна. ДНБ-ий дийлэнх хувийг Улаанбаатар бүрдүүлж байгаа нь хүн амын нягтшил өндөр, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн 60-аас дээш хувь нь төвлөрсөн байгаагаар тайлбарлаж болно.

ДНБ-д Улаанбаатар 2010 онд 62.7 хувь болж, 2005 оныхоос 4.3 пунктээр нэмэгдсэн байна. Орхон аймгийн ДНБ-д эзлэх хувийн жин 2008 онд 12.6 хувь, 2009 онд 10.3 хувь, харин 2010 онд 10.5 болсон байна.

Бүс, аймгийн ДНБ-ий (оны үнээрх) 2010 оны гүйцэтгэлийг 2009 оныхтой харьцуулж авч үзвэл баруун бүсийнх 3.1 хувиар, хангайн бүсийнх 15.2 хувиар, төвийн бүсийнх 24.3 хувиар, зүүн бүсийнх 6.2 хувиар, Улаанбаатар хотынх 32.2 хувиар нэмэгдсэн байна.

Улаанбаатараас бусад бүсүүдийн ДНБ-ий хэмжээ буурсан нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ ханш буурсантай шууд холбоотой, түүнчлэн сүүлийн жилүүдэд хангайн болон зүүн бүсийн ДНБ-д эзлэх хувь буурч байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн бууралттай холбоотой байна. Улаанбаатараас бусад бүсийн бууралт нь 2007-2010 онуудад бүх нутгуудыг хамарсан зудын уршгаар манай улсын голлох салбар болох хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг буурсантай холбоотой.

ДНБ-ийг салбараар нь авч үзье. Манай улсын ДНБ-ий ... гаруй хувийг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, уул уурхай олборлох үйлдвэр, тээвэр агуулахын аж ахуй холбоо, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ салбарууд эзэлж байна.

Өөрөөр хэлбэл манай орны эдийн засгийн хөгжил мал аж ахуйн салбар (сүүлийн 5 жилийн дунджаар хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ихэнх хувийг мал аж ахуй эзэлж байна), бөөний болон жижиглэнгийн худалдаа, тээврийн салбарын хөгжлөөс хамаарч байна.

1999-2003 оны динамикаар авч үзэхэд, хөдөө аж ахуйн хувийн жин жилд дунджаар 3.4 пунктээр буурч, уул уурхай олборлох үйлдвэрийн салбар 0.8 пунктээр, жижиглэн, бөөний худалдааны салбар 1.2 пунктээр, тээврийн салбар 0.9 пунктээр тус тус өсч байна. Энэ нь манай үйлдвэрлэлийн бүтцэд багахан өөрчлөлт орж байгааг илэрхийлж байна.

### Хөдөө аж ахуй

Хөдөө аж ахуйгаас бусад бүх салбаруудын нэмэгдэл өртгийн 41-99 хувийг зөвхөн Улаанбаатарын бүс эзэлж байна. Энэ нь Улаанбаатарын бүс нь бусад эдийн засгийн бүсүүдээс эрс ялгаатай болохыг харуулж байна. Иймд судалгааны энэхүү хэсэгт Улаанбаатарын бүсийг оруулах шаардлагагүй хэмээн үзэж хаслаа.

Хөдөө аж ахуй ан агнуур, ойн аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн 25.4 хувийг Төвийн бүсэд, 24.6 хувийг Баруун бүсэд, 22.8 хувийг Хангайн бүсэд, 17.6 хувийг Зүүн бүсэд, 2.3 хувийг Улаанбаатарын бүсэд үйлдвэрлэсэн байна. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн зонхилох хэсэг нь мал аж ахуйн секторт үйлдвэрлэгддэг.

Малын тоо 1999-2002 онуудад бүх бүс нутгуудаар буурсан байна. 1999-2002 онуудад нэг аймгийн малын тоо жилд дунджаар 8.3



хувиар буурсан байна. Энэхүү бууралтын бүс нутгаар авч үзвэл, баруун бүсэд хамгийн их буюу жилд дунджаар 11.6 хувиар, хангайн бүсэд 11.4 хувиар, төвийн бүс 8.3 хувиар тус тус буурч харин зүүн бүсэд жилд дунджаар 0.1 хувиар өсч байв.

Энэ малын тооны өөрчлөлт нь аймгийн цаашилбал бүсийн ДНБ-ий өөрчлөлтийн чиглэлтэй ижил байна. Өөрөөр хэлбэл бүсүүдийн ДНБ-ий бууралт нь МАА-н салбарын үйлдвэрлэл буурсантай шууд холбоотой болохыг харуулж байна. Уул уурхай олборох үйлдвэрийн салбарын 54 хувийг Хангайн бүсийн Орхон аймагт, 41 хувийг Улаанбаатарт, бусад бүсүүдэд 0.2-4 хувийг бүрдүүлж байна.

### Бөөний болон жижиглэн худалдаа

Бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөгт Төвийн бүс 7.5 хувь, Хангайн бүс 7 хувь, Зүүн бүс 2.7 хувь, Баруун бүсэд 2.6 хувийн хувь нэмрийг оруулжээ. Үлдсэн буюу 80 хувийг Улаанбаатарт үйлдвэрлэсэн байна.

### Тээвэр, холбоо

Тээвэр холбооны салбарийн нэмэгдэл өртгийн 4.9 хувийг Төвийн бүсэд, 4.4 хувийг Хангайн бүсэд, 3.5 хувийг Баруун бүсэд, 1.6 хувийг Зүүн бүсүүдэд үйлдвэрлэжээ.

Улаанбаатараас бусад бүсүүдийг харьцуулан үзэхэд Хангайн болон Төвийн бүсүүдэд эдийн засгийн салбаруудын нэмэгдэл өртгийн 70-95 хувийг үйлдвэрлэж байна. Мөн Хангайн болон Төвийн бүсүүд нь эдийн засгийн бүтэц, хөгжил, чадавхиараа ойролцоо болох нь харагдаж байна.

Дээрх үзүүлэлтүүдийг бүсүүдээр авч үзвэл, Баруун бүсийн ДНБ-ий 2/3 (65%)-ийг хөдөө аж ахуйн салбарт, 15 хувийг тээвэр худалдааны салбарт үйлдвэрлэж байна. Хангайн бүсийн ДНБ-ий 83 хувь нь хөдөө аж ахуй (34%), уул уурхай олборох (38%), худалдааны (11%) салбаруудад ногдож байна.

Төвийн бүсийн ДНБ-ий 70 хувийг хөдөө аж ахуйн (46%), тээврийн (6%), худалдааны (18%) салбаруудад үйлдвэрлэж байна.

Зүүн бүсийн хувьд хөдөө аж ахуйн салбарт ДНБ-ий 65%-ийг, 13%-ийг худалдааны салбарт, тээвэр холбооны салбарт 4 хувийг буюу нийтдээ 80 гаруй хувийг дээрх 3-н салбарт үйлдвэрлэж байна.

Харин Улаанбаатарын ДНБ-ий 37 хувийг худалдааны, 20 хувийг тээврийн, 18 хувийг боловсруулах уул уурхай олборлох салбар эзэлж байна.

#### Бүсүүдийн доторх аймгуудын үйлдвэрлэлийн чадавх

**Баруун бүс:** Баруун бүсийн аймгуудын бүсийн ДНБ-д оруулсан хувь ижил тэнцүү байна (Говь-Алтай аймгаас бусад). Тус бүсийн голлох салбар болох хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөгт мөн л тэнцүү хувь нэмэр оруулдаг бол худалдааны салбарт Баян-Өлгий, Увс аймгууд голлох үүрэг гүйцэтгэдэг байна.

**Хангайн бүс:** Тус бүсийн голлох салбар болох уул уурхай олборлох үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг Орхон аймаг бүрдүүлж байна. Мал аж ахуйн нэмэгдэл өртөгт Хөвсгөл, Өвөрхангай, Булган аймгууд голлох нөлөөг үзүүлжээ. Мөн худалдааны салбарын нэмэгдэл өртгийн хувьд Орхон аймаг давамгайлж байна.

**Төвийн бүс:** Төвийн бүсийн голлох салбар болон мал аж ахуй салбарын нэмэгдэл өртгийн 80-аад хувийг Сэлэнгэ, Дундговь, Төв аймгуудад үйлдвэрлэжээ. Худалдааны салбарын нэмэгдэл өртөгт Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгууд, тээвэр холбооны салбарт Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь аймаг зонхилж байна. Онцлон тэмдэглэхэд, Дархан-уул аймаг цахилгаан дулаан үйлдвэрлэлээрээ Улаанбаатарын дараа орж байна.

#### Бүс нутгуудын амьжиргааны түвшин, ядуурлын байдал

Манай орон нь газар зүйн ялгаатай шинж бүхий бүс нутагтай, бүс нутгууд нь цаг уур, ургамал, амьтны аймгийн хувьд өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Эдгээр нь эдийн засгийн хөгжлийн байдал, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлоход чухал нөлөөтэй. Ядуурлын байдал бүс нутгуудад ихээхэн ялгаатай байна.

Хүснэгт

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, бүсээр, 2002/2003, 2010 оноор


хувь

Бүс	2002/2003			2010		
	Ядуурлын	Ядуурлын гүнзгийрэлт	Ядуурлын мэдрэмж	Ядуурлын	Ядуурлын гүнзгийрэлт	Ядуурлын мэдрэмж
	хамралтын хүрээ			хамралтын хүрээ		
<b>Улсын</b>						
<b>дундаж</b>	36.1	11.0	4.7	39.2	11.3	4.6
<b>Баруун бүс</b>	51.1	14.6	5.7	51.1	16.0	6.7
<b>Хангайн бүс</b>	38.7	12.3	5.2	51.9	16.0	6.7
<b>Төвийн бүс</b>	34.4	10.1	4.3	29.3	7.7	2.9
<b>Зүүн бүс</b>	34.5	12.4	6.6	40.6	12.3	5.2
<b>Улаанбаатар</b>	27.3	8.1	3.3	29.8	7.7	2.8

\*Амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнгээр

Ядуурлын түвшин улсын дунджаар 2010 онд 39.2 хувь болж, 2002/2003 оныхоос 3.1 пунктээр нэмэгдсэн байна. Энэ үзүүлэлтийг бүсээр авч үзвэл Хангайн бүсэд 13.2 пункт, Зүүн бүсэд 6.1 пункт, Улаанбаатарт 2.5 пунктээр өссөн бол төвийн бүсэд 5.1 пунктээр буурсан байна. Улсын хэмжээнд 2010 оны байдлаар ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын

шугамнаас 11.3 хувиар доогуур байгаа бол Баруун, Хангайн бүсүүдэд энэ үзүүлэлт 2002/2003 оныхоос өсч, бусад бүсэд буурсан хандлагатай байна.




\*Амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнгээр


Амьжиргааны түвшний түүвэр судалгаа болон Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс үзвэл улсын хэмжээнд ядуурлын түвшин 2006-2010 онд өссөн хандлагатай байна.

Судалгааны дүнгээр нутгийн төвийн хэсэг ядууралд бага өртөж байгаа бөгөөд 2006-2010 онд ядуурлын түвшин буурах хандлага ажиглагдаж байна. Хангайн болон Баруун бүсэд талаас илүү хувь нь ядуу байна. Хангайн бүсэд ядуурлын түвшин 2006-2010 онд ажмаар өссөн хандлагатай байна. Зүүн бүсийн хүн амын тавны хоёр хувь нь ядуу байгаа

боловч 2007-2010 онд тус бүс нутгийн ядуурлын түвшин буурсан хандлагатай байна. Улаанбаатар хотын хувьд бусад бүсүүдтэй харьцуулахад ядуурлын түвшин бага байгаа боловч 2006-2010 өссөн хандлагатай байна.



Хүний хөгжлийн индекс нь хүний чадавхийн хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлнэ. Улсын хэмжээгээр 2010 онд хүний хөгжлийн индекс 0.763 болж, 2000 оноос 0.096-аар нэмэгдсэн байна. Хүний хөгжлийн индексийг бүсээр авч үзвэл: Улаанбаатар болон Төвийн бүс 2005-2010 онд өссөн хандлагатай байгаа нь бусад бүстэй харьцуулахад худалдан авах паритетаар илэрхийлсэн нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ тогтмол өссөнтэй холбоотой.



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 2014 оноос эхлэн тогтвортой хөгжлийн олон талын үзүүлэлтээр аймгуудыг байгаа нөөц чадавхиа хэрхэн ашиглаж байгааг судалж, орон зайн хөгжлийн ямар боломж хаана байгааг нийгэмд ил тод таниулж, Бүсчилсэн уулзалт зохион байгуулж, үр дүнг олон нийтээр хэлэлцүүлж байгаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг сайжруулахад чухал ач холбогдолтой ажил болж байна. Өрсөлдөх чадварын талаарх ойлголт нь ЭЗБӨЧСТ-өөс гаргасан аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны 2017 оны тайланд үндэслэн бүсүүдийн хөгжлийн өнөөгийн байдлын талаар бидний хийж байгаа дээрх үнэлгээ, дүгнэлтийг давахар баталсан зарим ерөнхий үзүүлэлтийг энд дурдаж байна.

Аймгуудын хөгжлийн ерөнхий түвшний зарим илтгэлцүүрийг харьцуулж үзээд тэдгээрийг 3 бүлэг болгон ангилан хувааж, эрэмбэлэн харуулах оролдлого хийлээ /их дунд бага хувилбараар/. Үүнд:

Нэг хүнд ногдох ДНБ-	Дундаж	Хүн ам	Аймгийн ДНБ-д
----------------------	--------	--------	---------------

	ийн 2008-2010 оны дундаж, төг	наслалт	зүйн ачаалал	төсвийн зардлын эзлэх хувь	Үнэлгээ
I БҮЛЭГ	Их	Их	Бага	Бага	ИХ
II БҮЛЭГ	Дунд	Бага	Дунд	Дунд	ДУНД
III БҮЛЭГ	Бага	Дунд	Их	Их	БАГА

I бүлэгт: Архангай, Булган, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Говьсүмбэр аймаг;

II бүлэгт: Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг;

III бүлэгт: Баян-Өлгий, Дорноговь, Өвөрхангай аймаг орж байна. Энэ бүлэглэлтийн дүнд бүлэг доторх аймгууд бие биетэйгээ хамгийн ойр (ижил төсөөтэй), харин бүлгүүд нь хоорондоо хамгийн их ялгаатай байхаар хувиарласан болно. Энд хүн амын дундаж наслалтыг бас нэг илтгэлцүүр болгон ашиглав.

Дундаж наслалт нь хүн амын эрүүл мэнд, ажиллаж, бүтээх чадварыг тодорхойлогч хөгжлийн чадавхийн нэг гол



үзүүлэлт гэж бусад улсад тооцдог ажээ.

Улсын хэмжээнд төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2017 онд 69.89 жил байсан бол Дундговь аймаг хамгийн их буюу 70.23 жил, Хөвсгөл аймаг хамгийн бага буюу 63.63 жил байна. Хүн амын дундаж наслалт 2012-2017 онд дунджаар 0.75 хувиар өссөн бол Баянхонгор аймаг хамгийн их буюу 0.99 хувь, Баян-Өлгий аймаг хамгийн бага буюу 0.51 хувиар өссөн байна. Энд мөн хүн амын ачаалал/ хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ/ болон хүн амын хөгжлийн индекс/ хүний чадавхийн хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул



байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлнэ/-ийг ҮСХ-ны тооцоогоор харууллаа.

### Хүн амын хөгжлийн индекс ба хүн амын ачаалал

Дээр дурдсан судалгаа, тооцооноос үндэслэн, аймгуудын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь аймгийн ДНБ-д төсвийн зардлын эзлэх хувь, хүн ам зүйн ачаалалтай урвуу, дундаж наслалтын түвшинтэй шууд хамааралтай байнх гэж үзээд, энэ нь, тухайн аймгийн нэг хүнд ногдох ДНБ өндөр байх тутам ДНБ-д төсвийн зардлын эзлэх хувь болон хүн ам зүйн ачаалал бага, дундаж наслалт өндөр байна гэсэн ерөнхий хамаарал байж болохыг харуулахыг хичээлээ. БХҮБ батлагдсанаас хойш 2003 -2010 он хүртэл гарсан дээрх хөгжлийн хандлагыг 2017 он хүртэлх хугацаагаар үргэлжлүүлэн хураангуйлж үзье. Тэгвэл,

- Эдийн засгийн хөгжлийн түвшин, үр өгөөжийг илэрхийлэгч нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт Баруун, Хангайн бүсэд 2013 он хүртэл өсөөд 2016 он хүртэл буурч ирсэн,УБ, Төв ба Зүүн бүсэд аажмаар өсч буй хандлага (УБ-аас бусад нь улсын дундажаас доогуур)
- Нэг хүнд ногдох ДНБ-ий (улс=100) Баруун бүс хамгийн доогуур (46,9%), Хангайн бүс, Төвийн бүс дундаж (60 гаруй %), Зүүн бүс ба (80,8%) Улаанбаатарын бүс (46,3%)-эд өндөр, хүн амын амьдралын түвшин ялгаатай, тэгш бус байдал 2010 оноос нэмэгдэх хандлагатай болжээ.
- Хүн амын ажил эрхлэлтийн түвшин Баруун бүсэд буурах, Хангайн ба Зүүн бүсэд өсөх, Төв ба УБ-ын бүсэд тогтворжих хандлагатай байна.
- Хүн амын ажилгүйдлийн түвшин Баруун ба Төв, Зүүн бүсэд буурсан нь, хүн ам шилжин явсан Улаанбаатар, Хангай (Эрдэнэт)-н бүсэд өссөн нь хүн ам олноор шилжин ирсэнтэй холбоотой байна.
- Ядуурлын түвшин: Хамралтын (20-36%) хүрээгээр бүх бүсэд нэмэгдсэн, хамгийн их нь Баруун, Зүүн бүсэд гарчээ. Ядуурлын гүнзгийрэлт мөн ийм дүр төрхтэй (30-45) УБ, Төвийн бүсэд харьцангуй бага. Одоогоор ядуу хүн (орлогоор) УБ (343,1 м), Хангай (189 м), Баруун бүсэд (150,1 м) их,

- Хөгжлийн түвшний ерөнхий индекс улсын дундаж 0339, Баруун, Зүүн бүсэд хамгийн доогуур (0177 – 0182), Хангайн, Төвийн бүсэд дундаж (0251 - 0307), УБ-ын бүсэд 0521 өндөр байх жишээтэй.
- Бүс нутгийн хүн амын бүтээмж (бизнесийн ЭЗБӨЧСТ) Төвийн бүсийн Дархан, Өмнөговь, Баруун бүсийн Увс, БӨ, Зүүн бүсийн Дорнод, Хангайн бүсийн Орхон, Хөвсгөл аймгууд харьцангуй өндөр 70 – 100%, бусад аймгууд 40 – 60%-ийн зэргэмжтэй эрэмбэлэгджээ.
- Монголын эдийн засгийн орон зай үндсэндээ бэлчээрин мал аж ахуйн байршилт зонхилсон хэвээр байна. /УБ-аас бусад бүсэд ХАА-ын салбар ДНБ-ний 35-аас 45 хувийг эзэлж байна./
- Төв ба Хангайн бүсээс бусад бүсэд ХАА-н дараа худалдаа, үйлчилгээний салбар орж байна. Боловсруулах үйлдвэр бага хөгжсөн.
- Эдийн засгийн орон зай дахь байгаль, бэлчээрийн үр өгөөж тун бага. Жишээ нь: бэлчээрийн рент буюу ашиг 1 га-д 2 ам.доллар;
- Байгалийн капиталд бэлчээр өндөр хувьтай байдаг Ирланд /77/-542, Уругвай /60/-64, Гүрж /45/-103 байна. Гэтэл байгалийн орон зайн капиталд бэлчээрийн газар 60%-ийг эзэлдэг;
- Бүс хоорондын хүн амын тархалтад Төвийн бүс буюу Өмнөт Говийн бүсэд шилжсэн мэдэгдэхүйц өөрчлөлт орсон. УБ-аас бусад бүсэд хүн амын өсөлт (1,5 – 3%) буурах хандлагад орсон. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо мөн 2010 оноос хойш УБ, Төв (Дархан, Өмнөговь), Хангайн бүс (Орхон)-ээс бусад бүс аймагт буурч байна. Энэ бүхэн хүн ам Төв рүү буюу УБ, Дархан, Эрдэнэт чиглэн шилжиж буйг харуулж байна. Хөдөө орон нутаг эзгүйрч болзошгүй байна гэсэн иргэдийн болгоомжлол үнэний хувьтай болж байна
- Бүс нутгийн аж ахуйн бөөгнөрөл, төрөлжилтийн индекс (1-ээс их бол төрөлжсөн)-ийг УБ, Дархан, Эрдэнэтийг хасч, ойролцоогоор тооцвол бүх бүсэд мал аж ахуй, худалдаа үйлчилгээгээр төрөлжсөн гэж үзэхээр байна. Гэхдээ эдгээр салбарын таваарлаг чанар буюу нэмэгдсэн өртөг доогуур (0,5-аас бага) зөвхөн аймгуудаас Улаанбаатар руу, эргээд УБ-аас аймгууд (Дархан, Эрдэнэт) руу бараа түүхий эдийн солилцоо явагдаж буй учир “Бүсүүд төрөлжөөгүй”, эдийн засгийн адил төстэй бүтэцтэй байна.

Ерөнхий дүр зураг нь Монгол улсад хөдөлмөрийн нутаг дэвсгэрийн хуваарь, бүс нутгийн хоршилт хөгжлийн анхдагч түвшинд буюу УБ, Дархан, Эрдэнэт, Өмнөговь тэдгээрийг холбосон улсын гол тэнхлэг рүү татагдсан орон зайн бүтэц, зохион байгуулалт хэвээр байна. Хөгжлийн түвшний индекс УБ, Төвийн бүсээс бусад бүсэд ихээхэн доогуур байгаа ч хөгжлийн нөөцийн индекс (байгалийн эрдсийн баялаг, мал аж ахуйн түүхий эд) бүс бүсэд өндөр байна. /Улсын дундаж 0,500 гэвэл, УБ-аас бусад бүсэд 0,650 - 0,700 гаруй/. Гэхдээ эдийн засгийн орон зайн бүтэцийг бүсчлэн зохицуулж, сайжруулах потенциал боломж их байна.

#### **3.4. Эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн чадавх, гарц /SWOT үнэлгээ/**

## ЭДИЙН ЗАСГИЙН БҮСҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ЧАДАВХ, ГАРЦ /SWOT үнэлгээ/

### БАРУУН БҮС:

#### Давуу тал буюу БОЛОМЖ

- Нутгийн цэвэр угшлын эрүүл мал сүрэг
- Ажиллах хүчний нөөц (иргэд нь ажилсаг)
- Гадаад харилцаа, худалдааг хөгжүүлэх газарзүйн боломж (ОХУ, БНХАУ, Казахстан)
- Иргэдийн боловсролын түвшин өндөр
- Газар нутгийн унаган төрхөө алдаагүй, байгалийн баялаг ихтэй.



#### Сул тал буюу АСУУДАЛ

- Дэд бүтцийн хөгжил сул (зам, цахилгаан, дулаан)
- Үйлдвэр хөгжөөгүй (уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл)
- Бус нутгийг дэмжсэн бүсчилсэн болон төсөв санхүүгийн бодлогын хэрэгжилт хангалтгүй.
- Шатахуун болон суурь бүтээгдэхүүний үнэ өндөр
- Газар тариаланг ихээр хөгжүүлэх боломжгүй (усжуулалт муу) эрдэм шинжилгээ, судалгааны ажил хангалтгүй

**Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:**

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Дэд бүтцийн хөгжил сул (зам, цахилгаан, дулаан)	- Төвөөс алслагдсан байдал - Дэд бүтцийг хөгжүүлэхэд өртөг өндөр.	- Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. - ГШХО-ыг нэмэгдүүлэх бүсийн нэгдсэн бодлоготой болох.	- Бараа бүтээгдэхүүний үнэ буурч, амьжиргааны түвшин дээшилнэ.
2 Үйлдвэрлэл хөгжөөгүй (уул уурхай, боловсруулах)	- Бүс нутгийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй. - Зах зээлийн багтаамж муу.	- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг сайжруулах. - Үйлдвэрлэлийг дэмжсэн эрх зүйн болон хөрөнгө оруулалтын орчин бий болгох.	- Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэж ажилгүйдэл буурна.
3 Бүс нутгийг дэмжсэн төсөв санхүүгийн бодлогогүй.	- Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн бодлогыг удирдах бүтэц засгийн газарт байдаггүй, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, бодлогогүй.	- Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн хууль гаргах.	- Тогтвортой хөгжлийн суурь үзүүлэлт сайжирна.
4 Шатахуун болон суурь бүтээгдэхүүний үнэ өндөр.	- Тээврийн зардал өндөр. - Төрийн зохицуулалтгүй.	- Монгол Улсын хэмжээнд нэг үнийн системд шилжих. - Бүсийн татварын хөнгөлөлт бий болгох.	- Суурь бүтээгдэхүүний үнэ тогтворжиж ард иргэдийн орлого нэмэгдэнэ.
5 Газар тариаланг их хэмжээгээр хөгжүүлэх боломжгүй (усжуулалт муу)	- Үржил шимт хөрстэй газар бага. - Гадаргын усны нөөц бага - Цаг уурын эрс тэс уур амьсгалтай	- Байгаль цаг уурт тохирсон технологи, сорт, үр бий болгох. - Усжуулалтыг сайжруулах	- Бүс нутгийн хэрэгцээг хангана - Үйлдвэрлэлийг нэмэгдүүлж ажлын байрыг бий болгоно.

#### **Баруун бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:**

- Транзит тээвэр-Логистикийн төв
- Аялал жуулчлал
- Уул уурхай
- МАН-н боловсруулах үйлдвэр (мах, түүхий эд)
- Эрчим хүчний үйлдвэрлэл (сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй хосолсон)
- Шинжлэх ухааны болон үйлдвэр технологийн парк
- Байршлын давуу тал (гадаад худалдаа)
- Чөлөөт бүс
- Тэжээл үйлдвэрлэл

#### **Баруун бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:**

### **МАЛЫН ТҮҮХИЙ ЭД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР**

#### **Өнөөгийн нөхцөл байдал:**

- Баруун бүсэд 12 сая толгой мал байна.
- Одоогоор малын түүхий эд боловсруулах үйлдвэр байхгүй байна.
- Эдийн засгийн үр ашиг бага байна.

#### **Цаашид тулхуу хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:**

- Үйлдвэр технологийн парк, кластер байгуулах.
- Бүсийн хэмжээний төлөвлөлт хийж нөөцийг тогтооно.
- Үйлдвэрийн дэд бүтцийг байгуулах (агуулах, цахилгаан дулаан, ус).
- Түүхий эд цуглуулах сүлжээ байгуулах.

#### **Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:**

- Баруун бүсийн нэмүү өртөг өснө.
- Шинээр ажлын байрууд бий болно.
- Амьжиргаа дээшилнэ.
- Орон нутагт төсвийн орлогын эх үүсвэр бий болно.
- Хүнсний аюулгүй байдлын баталгаа хангагдана.
- Даруун бичил бизнесүүд бий болно.

## ТӨВИЙН БҮС

### Давуу тал буюу БОЛОМЖ

- Газарзүйн байршил. (дэд бүтэц, зам харилцааны хөгжил сайн)
- Газар тариалан, ХАА-н үйлдвэрлэл хосолж, өрхийн үйлдвэрлэл илүү хөгжсөн.
- Мэргэжлийн ажиллах хүч, хүний нөөцийн чадавхи өндөр.
- Байгалийн нөөц баялаг их, газар нь эдийн засгийн эргэлтэнд бүрэн орсон, хот төлөвлөлт сайн.
- Гадаад худалдаа, хил гаалийн өргөн боломжтой, эдийн засгийн чөлөөт бүстэй.



### Сул тал буюу АСУУДАЛ

- Байгаль орчны тэнцвэрт байдал алдагдсан.
- Хүн амын шилжилт хөдөлгөөн, нягтралаас болж гэмт хэргийн гаралт их.
- Олон Улсын авто зам, төмөр замын сүлжээ болон нийслэлтэй ойр зэргээс шалтгаалан үйлдвэрлэл, үйлчилгээний зах зээлээ алдах боломж их.
- Хил залгаа аймаг болон сумд хоорондын хилийн маргаан их.
- Малчин, тариаланчдын хоорондын газрын зөрчил их.

**Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:**

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 <u>Байгаль орчны тэнцвэрт байдал алдагдсан:</u> - <u>Модны хулгай, ой, хээрийн түймэр</u> - <u>Агаарын бохирдол</u> - <u>Хог хаягдал</u>	- <u>Уул уурхайн компаниуд нөхөн сэргээлт хийдэггүй, түүнд тавих төр, иргэний хяналт муу, үйлдвэрлэлийн технологийн хоцрогдол.</u>	- <u>Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх</u> - <u>Хяналтыг сайжруулах</u> - <u>Иргэний хариуцлагыг нэмэгдүүлэх.</u>	- <u>Байгаль орчин нөхөн сэргэж, иогэд эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.</u>
2 <u>Хүн амын шилжилт хөдөлгөөн суурьшлын нягтралаас болж гэмт хэргийн гаралт их.</u>	- <u>Зам тээвэр суурьшлын гол зангилаа учраас.</u>	- <u>Хяналтаа сайжруулахад зориулж хөрөнгө гаргаж, хяналтыг сайжруулж, урьдчилан сэргийлэх.</u>	- <u>Гэмт хэргийн гаралт буурч, хяналтын тогтолцоо сайжирна.</u>
3 <u>Олон Улсын авто зам болон төмөр замын сүлжээ дайран өнгөрдөг, мөн нийслэлтэй ойр 6-8аай үйлдвэрлэл, үйлчилгээний зах зээлээ алдах боломж их.</u>	- <u>Газарзүйн байршил.</u>	- <u>Үйлдвэрлэлийг шинээр бий болгоход санхүүжилтыг нэмэгдүүлэх.</u> - <u>Гадны бүтээгдэхүүн оруулахад хязгаар тавих.</u>	- <u>Бүс нутгийн хэмжээнд өөрийн гэсэн брендтэй болно.</u> - <u>Бүс нутгийн иргэд, бизнес эрхлэгчдийн орлого сайжирна.</u>
4 <u>Хилийн цэсийн маргаантай байдал</u> - <u>Аймаг хооронд</u> - <u>Аймаг дотроо сум хооронд</u>	- <u>Хилийн цэсийн шугам тодорхой бус.</u> - <u>Газар нутгийн дахин хуваарилалт.</u> - <u>Хот төлөвлөлт.</u>	- <u>УИХ-ын түвшинд асуудлыг даруй шийдвэрлэх (Хугацаа их алдаж байна).</u>	- <u>Шинэ төлөвлөлт хийхэд нөлөөлнө.</u> - <u>Газар эдийн засгийн эргэлтэнд орох боломжтой.</u>
5 <u>Малчин тариаланчдын хоорондын зөрчил их</u>	- <u>Газар тариалангийн талбай болон малын бэлчээрийн давхцал.</u> - <u>Малчдын шилжилт хөдөлгөөн их.</u>	- <u>Хариуцлагаа ухамсарлах.</u> - <u>Газар тариалангийн талбайгаа хашаажуулах.</u> - <u>Эрчимжсэн МАА-г төрөөс дэмжих.</u> - <u>ХАА-н шинэ технологи нэвтүүлэх.</u>	- <u>Малчид, тариаланчдын хоорондын маргаан багасна.</u> - <u>Сүү, махны гарц, үр ашиг сайжирч, тогтвортой ажлын байр бий болно.</u>



## **Төвийн бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:**

- Хүнд үйлдвэр (Төмөрлөг, металлурги)
- Барилгын материал
- Хүнсний бүтээгдэхүүн (мах, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн)
- Хөнгөн үйлдвэр, арьс шир, оёмол, сүлжмэл
- Тээвэр, ложистик
- Аялал жуулчлал-гадаад, дотоод
- Газар тариалан
- Эрчимжсэн мал аж ахуй
- Уул уурхай
- Гадаад дотоод худалдаа
- Аж үйлдвэр (технологийн парк)

## **Төвийн бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР: ҮЙЛДВЭРЛЭЛ-БҮХ ТӨРЛИЙН ХҮНД, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ**

### **Өнөөгийн нөхцөл байдал:**

- Төмөрлөг, жонш, МАА-н бүтээгдэхүүн, ноос, сүү, өндөг, нүүрс, цемент, барилгын материал, хүнс гэх мэт үйлдвэрлэлийн салбар хөгжсөн.
- Үйлдвэрлэлийг дэмжих тээвэр, ложистик хөгжсөн.
- Зах зээлийн багтаамж их.

### **Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:**

- Дэвшилт технологийг нэвтрүүлэх.
- Мэргэжлийн боловсон хүчнээр хангах.
- Бизнесийн эрх зүйн орчинг сайжруулах (таатай орчин бүрдүүлэх).
- Бүсийн аймгууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах.

### **Бус нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:**

- Бус нутгийн брендүүд, кластер бий болно.
- Хувийн хэвшлийнхний өрсөлдөх чадвар сайжирна.
- Монгол Улсын экспортыг нэмэгдүүлнэ.

## ГОВИЙН БҮС

### Давуу тал буюу БОЛОМЖ

- Уул уурхай
- Байршил, (Баруун аймгуудтай холбогдох замын сүлжээ)
- Дэд бүтэц (Аж үйлдвэрийн парк, цахилгаан станц, нарны эрчим хүчний станц барих боломжтой)
- Аялал жуулчлал (Дэлхийн энергийн төв зэрэг жуулчдыг татах олон газруудтай мөн нийслэлтэй засмал замаар холбогдсон).
- Говийн амттай мах



### Сул тал буюу АСУУДАЛ

- Цөлжилт
- Байгаль орчны бохирдол
- Хүн ам сийрэг
- Орлогын тэгш бус байдал
- Боловсон хүчин хомс

**Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:**

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БУЙ ХУЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 <u>Цөлжилт</u>	- <u>Хуурайшилт</u> - <u>Тоосжилт</u> - <u>Усны хомсдол</u> - <u>Хариуцлагагүй уул уурхай</u>	- <u>Орхон (Хэрлэн) голоос говийн бус рүү гольдрол үүсгэж шинэ нуур, цөөрмүүд байгуулах</u>	- <u>Цөлжилтийг багасгана.</u> - <u>Байгаль орчныг сэргээнэ.</u> - <u>Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжинэ.</u>
2 <u>Байгаль орчны бохирдол</u>	- <u>Хүний буруутай үйл ажиллагаа</u> - <u>Хариуцлагагүй уул уурхай</u>	- <u>Уул уурхайг дэс дараалалтай ашиглах</u> - <u>Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх</u> - <u>Нөхөн сэргээх</u> - <u>Мод тарих</u>	- <u>Хүн амьдрахад таатай орчин бүрдэнэ.</u> - <u>Экологийн тэнцвэрт байдал хадгалагдана.</u>
3 <u>Хүн ам сийрэг</u>	- <u>Төрөлт багассан</u> - <u>Шилжих хөдөлгөөн</u>	- <u>Нутгийн хишиг олгох.</u> - <u>Говийн нэмэгдэл олгох</u> - <u>Хүн амын өсөлтийг дэмжих.</u> - <u>Бүс нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх.</u>	- <u>Хүн амын тоо өснө.</u> - <u>Ажиллах хүч нэмэгдэж, үйлдвэрлэл хөгжинө.</u>
4 <u>Орлогын тэгш бус байдал</u>	- <u>Хууль, эрх зүй</u> - <u>Монополь орчин</u>	- <u>Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бий болгох.</u> - <u>Хууль эрх зүйн орчинг сайжруулах.</u>	- <u>Иргэдийн амьжиргаанд зэрэг нөлөөлнө.</u>
5 <u>Боловсон хүчний хомсдол</u>	- <u>Их дээд сургууль байхгүй.</u> - <u>Шилжих хөдөлгөөн их.</u>	- <u>Бүс нутгийн тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.</u> - <u>Их дээд сургууль байгуулах.</u> - <u>Залуу боловсон хүчнийг ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх.</u>	- <u>Мэргэжлийн ажиллах хүчин нэмэгдэнэ.</u>

## **Говийн бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:**

- Уул уурхай-Боловсруулах үйлдвэр
- Аялал жуулчлал-Соёлын урлал
- Тээвэр агуулахын аж ахуй
- Барилгын материалын үйлдвэрлэл
- Эрчим хүч, дулаан хангамж
- МАА-Тэмээний аж ахуй

## **Говийн бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:**

# **УУЛ УУРХАЙ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР**

### **Өнөөгийн нөхцөл байдал:**

- Хууль эрх зүйн орчин тогтворгүй.
- Олон улсын зах зээлээс хамааралтай.
- Боловсруулах үйлдвэр байхгүй.

### **Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:**

- Хууль эрх зүйн орчныг сайжруулах, тогтвортой болгох.
- Боловсруулах үйлдвэрүүдийг яаралтай барьж дуусгах.
- Дэд бүтэц олон улсын коридоруудыг нэмэгдүүлэх.
- Уул уурхайн ханган нийлүүлэлтэнд тохирсон ЖДҮ байгуулах шаардлагатай.

### **Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:**

- Ажлын байр нэмэгдэнэ.
- Бүс нутгийн үсрэнгүй хөгжлийг бий болгоно

## ЗҮҮН БҮС

### Давуу тал буюу БОЛОМЖ

- Аялал жуулчлал-(Чингисийн тоонот нутаг, Алтан-овоо, Буйр нуур, Мэнэнгийн тал)
- Нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой-Барилга
- ХАА-н салбар
- МАА-(Хурдан морь)
- Газар тариалан
- Хадлан тэжээл, малын тэжээл
- Уул уурхай
- Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах.
- Олон Улсын онгоцны буудал байгуулах
- Казино байгуулах
- Морин тойруулга (Зүүн хойд Ази)



### Сул тал буюу АСУУДАЛ

- Ажилгүйдэл
- Хүн ам сийрэг
- Хөрөнгө оруулалт, санхүүжилт дутмаг
- Дэд бүтэц
- Аймгаас боомт руу явсан хатуу хучилттай авто зам, төмөр зам байхгүй.
- Шилжих хөдөлгөөн их
- Шилжих хөдөлгөөн ихэссэнээс болж социализмын үед байсан сангийн аж ахуй, үйлдвэрийн газрууд зогссон.

**Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:**

	АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1	<u>Ажилгүйдэл</u>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Үйлдвэрлэл хөгжөөгүй.</u></li> <li>- <u>Чадварлаг боловсон хүчин хомс.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Хөрөнгө оруулалт татах</u></li> <li>- <u>Байгалын нөөцийг ашиглаж, үйлдвэрүүдийг байгуулах.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Ажлын байраар хангагдана.</u></li> <li>- <u>Шилжих хөдөлгөөн буурна.</u></li> </ul>
2	<u>Хөрөнгө санхүү, шинэ технологи хомс.</u>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Дэд бүтэц муу.</u></li> <li>- <u>Гадаад харилцаа сул.</u></li> <li>- <u>Хөрөнгө санхүүг татсан, шинэ технологийг нэвтрүүлэх талаар бодлого муу.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Гадаад харилцааг хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалт, шинэ технологийг татах.</u></li> <li>- <u>ААНОАТ-ийг засаг захиргааны нэгжүүд өөрсдөө авах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Тулгараад буй бэрхшээлүүдийг шийднэ.</u></li> </ul>
3	<u>Дэд бүтэц</u>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Боомтууд засмал замгүй.</u></li> <li>- <u>Төмөр зам хөгжөөгүй.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Гадны болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах.</u></li> <li>- <u>Бонд босгох.</u></li> <li>- <u>Концессын гэрээгээр дэд бүтцийг сайжруулах.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Далайд гарцтай болно.</u></li> <li>- <u>Гадаад худалдаа идэвхижнэ.</u></li> </ul>
4	<u>Хүн ам зүйн асуудал (шилжих хөдөлгөөн).</u>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Ажлын байр хомс.</u></li> <li>- <u>Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар муу.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Ажлын байрыг бий болгох.</u></li> <li>- <u>Амьдрах орчныг сайжруулах.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Хотжилт бий болж, шилжих хөдөлгөөн буурна.</u></li> <li>- <u>Боловсон хүчний нөөц бүрдэнэ.</u></li> </ul>
5	<u>Зах зээлийн багтаамж бага.</u>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Хүн ам цөөн</u></li> <li>- <u>Гадаад худага</u></li> <li>- <u>муу.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Гадаад харилцааг хөгжүүлж, хүн амын суурьшлыг бий болгож, хүн амын өсөлтийг дэмжих.</u></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <u>Зах зээл өргөжиж, үйлдвэрлэл хөгжинө.</u></li> </ul>

### **Зүүн бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:**

- Уул уурхай
- Аялал жуулчлал
- ХАА, МАА
- Үйлдвэрлэл
- Худалдаа үйлчилгээ
- Зам барилга

Зүүн бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:

## **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

### **Өнөөгийн нөхцөл байдал:**

- Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг байхгүй.
- Аялал жуулчлалын нэгдсэн маршрут байхгүй.
- Жуулчдыг амраах орчин нөхцөл муу, гадаад сурталчилгаа хийгддэггүй.
- Гадаад харилцаа сул.
- Аялал жуулчлалын салбарт ажиллах хүний нөөц хомс.

### **Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:**

- Аялал жуулчлалын бодлогын баримт бичиг боловсруулах.
- Гадаад, дотоод хөрөнгө оруулалт татах.
- Дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцөө бэлдэх.
- Гадаадын жуулчдад нийлүүлэх бүтээгдэхүүн бий болгох.
- Чингис хааны цогцолбор байгуулах.
- Аймгийн төвүүдийг хот болгон хөгжүүлэх.
- Зочид буудал, ресторан, бэлэг дурсгалын үйлдвэрлэл, үйлчилгээг өндөр түвшинд хүргэх.
- Аялал жуулчлалын статистик судалгаатай болж мэдээллийн төвтэй болох.

### **Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:**

- Эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгоно.
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Аялал жуулчлалын шинэ маршрут бий болно.

## ХАНГАЙН БҮС

### Давуу тал буюу БОЛОМЖ

- Малын түүхий эдийн чанарын лабораторыг өргөтгөж, цогцоор хөгжүүлэх.
- Аялал жуулчлал, сувилал
- Бүс нутгийн нөөцөд тулгуурласан барилгын материалын үйлдвэрлэл
- Баруун аймгийг Улаанбаатар хоттой холбох ложистикийн төв байгуулах.



### Сул тал буюу АСУУДАЛ

- Малын чанар муу.
- Бэлчээрийн даацын асуудал
- ДЦС-ын тоног төхөөрөмжийн хуучирсан байдал (цахилгаан хүртээмж муу)
- Агаарын бохирдол
- Аялал жуулчлалын баазуудын төвлөрсөн байдал нь нэг нэгнийхээ үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.



**Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:**

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Малын түүхий эдийн чанар муу.	<ul style="list-style-type: none"> <li>- Чанар харгалзахгүй түүхий эдийн урамшуулал олгодог.</li> <li>- Арьс ширний хувьд чанараас хамааран зах зээлийн үнэ адилхан.</li> <li>- Малын удам угшил муудсан. (эрлийжүүлсэн)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрх зүйн орчин (лаборатори байгуулж хяналтын тогтолцоог сайжруулах)</li> <li>- Малын түүхий эдийн урамшууллын зохицуулалтыг эргэж харах.</li> <li>- Тооллогыг чанартай явуулж бодит тоо гаргах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Малын чанар сайжрах нь түүхий эдийн чанар сайжирч нэмүү өртөг бий болгох боломжтой.</li> <li>- Бэлчээрийн даац нэмэгдэнэ.</li> </ul>
2 Бэлчээрийн даац муудсан.	<ul style="list-style-type: none"> <li>- Бэлчээр зохион байгуулалтын ажил дутмаг.</li> <li>- Бог малын зохистой харьцаа алдагдсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бэлчээрийн даацыг зөв зохистой ашиглах.</li> <li>- Малын удам угсааг сайжруулж үр шимийг нэмэгдүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Малын чанар сайжирна</li> <li>- Байгаль экологийн тэнцвэрт байдал хадгалагдана.</li> </ul>
3 ДЦС-ын тоног төхөөрөмжийн хуучирсан байдал.	<ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгө оруулалт шийдвэрлэгдэхгүй байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг шинэчлэх.</li> <li>- Нүүрсний уурхай байгуулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрчим хүчний хүртээмж сайжирна.</li> <li>- ЖДҮ хөгжих боломж нэмэгдэнэ.</li> </ul>
4 Агаарын бохирдол	<ul style="list-style-type: none"> <li>- Нам даралтын зуухууд ихэссэн.</li> <li>- Гэр хорооллыг дэд бүтэцтэй холбоогүй</li> <li>- Хог хаягдлыг шатааж байгаа нь.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДЦС барьж яндангийн тоог цөөлөх.</li> <li>- Эрчих хүчний хэмнэлттэй зуух ашиглах.</li> <li>- Хог хаягдлын менежментийг сайжруулах.</li> <li>- Ногоон байгууламжын тоог нэмэгдүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Агаарын бохирдлыг бууруулна.</li> <li>- Амьдралын таатай орчин бүрдэнэ.</li> </ul>
5 Зах зээлийн багтаамж бага.	<ul style="list-style-type: none"> <li>- Хүн ам цөөн, гадаад худалдаа муу.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаад харилцааг хөгжүүлж, хүн амын суурьшлыг бий болгож, хүн амын өсөлтийг дэмжих.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Зах зээл өргөжиж, үйлдвэрлэл хөгжинө.</li> </ul>

## **Хангайн бүс-1-ийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:**

- Хөдөө аж ахуй
- Аялал жуулчлал
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэл
- Тээвэр, ложистик
- Уул уурхай

Хангайн бүс-ийн хөгжлийн тулгуур САЛБАР:

## **ХӨДӨӨ АЖ АХУЙ**

### **Өнөөгийн нөхцөл байдал:**

- Малын тоогоор тэргүүлж байна.
- ДНБ-ийн 50-60 хувийг мал аж ахуйн салбар дангаараа бүрдүүлдэг.
- Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр ховор.
- Цагаан идээ боловсруулах ЖДҮ-ийг дэмжин бренд бүтээгдэхүүн бий болгоход анхааран ажиллаж байна.
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх атаршсан талбайн нөөцтэй.

### **Цаашид аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:**

- Малын чанарыг сайжруулах.
- Мал сүргийг эрүүлжүүлэх, мал эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах.
- МАН-н бүтээгдэхүүнийг хагас болон бүрэн боловсруулах үйлдвэрүүд байгуулах.
- ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах.
- Өвлийн хүлэмжийн аж ахуйг олноор байгуулах.

9)

### **Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх зэрэг нөлөө:**

- Тогтвортой ажлын байр нэмэгдэнэ.
- ДНБ нэмэгдэнэ.

### **3.5. Монголын эдийн засгийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн арга зүйн шинэлэг хандлагууд**

Монголын газар нутгийн зохион байгуулалтын түүхэн хандлага, эдийн засгийн бүсчлэл, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийн туршлага сургамж, түүнийг дэлхийн бусад орны бүсчилсэн хөгжлийн орчин үеийн нийтлэг хандлагатай харьцуулан судалгаа хийж үзэхэд онол, арга зүй, үзэл баримтлалын чанартай дор дурдсан зүйлсийг зайлшгүй эргэн нягталж, зүгшрүүлэх шаардлагатай байгаа юм. Үүнд:

- 1.) Түүхэн хандлагаас улбаалсан цэрэг – улс төрийн шинжтэй “бүсчлэл” (бүсчилсэн хөгжил) гэсэн ойлголтыг ямар нэг тулгуурыг тойрсон таталцлын хүчийг бий болгох үйл ажиллагаа гэдгээр нь цаашид хэвшүүлж, өнөөгийн эдийн засгийн өсөлтийн төвүүдийг бий болгоход хэрэглэх,
- 2.) Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын орчин өөрчлөгдсөн,
- 3.) Ардчилал, зах зээлийн харилцаа цаашид гүнзгийрэх болсонтой холбогдон даяаршилт, эдийн засгийн бие даасан байдал, интеграцчилал, инноваци, тогтвортой хөгжлийн асуудлууд хурц тавигдаж, эдгээрийг улс гүрнүүдийн орон зайд хэрхэн тархаан, тэнцвэртэй зохион байгуулах арга замыг олох бүс нутгийн чанартай онол арга зүйн олон шинэлэг чиглэлүүд (ногоон хөгжил – экологичлол, үйлдвэржүүлэлт, кластержуулалт, улс, бүс хоорондын эдийн засгийн коридор, хамтарсан чөлөөт бүс, тээвэр – ложистикийн төв, тэнхлэгүүд байгуулах, аялал жуулчлал, мэдлэг – мэдээллийн сүлжээ хөгжүүлэх г.м),
- 4.) Монголын БХҮБ, бодлого хөтөлбөрүүд хангалттай хэрэгжээгүйн нэг учир шалтгаан болж буй бодлого тодорхойлогч, төр, түүнд нөлөөлөгч (улс төрийн намууд), оролцогч талууд (иргэд, ААНБ)-ын байр суурь, үзэл бодол, харилцан ойлголцол, зөвшилцлийн асуудал,
- 5.) БХҮБ, түүнийг практикт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн чөлөөт бүсүүд, аж үйлдвэрлэл технологийн паркууд, тулгуур төв хотууд байгуулах арга технологи, үйл ажиллагаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцээгүй, төвлөрсөн төлөвлөлтийн шинжтэй болсон гэсэн ДБ, АХБ зэрэг олон улсын байгууллагын үнэлэлтүүд,

Энэ бүгдийг нягтлан үзээд, улс орны хөгжлийн цаашдын бодлого, төлөвлөлтөд эдийн засгийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн асуудлыг онол, арга зүйн талаас нь дараах чиглэлүүдээр шинэлэг байдлаар харгалзах нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

- 1.) Эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн 4 том бүсийн аймгуудын бүрэлдэхүүнийг амьдрал дээр нэгэнт үүсээд байгаа Өмнөт Говийн, Хойт гэсэн бүсүүдээр задалж, орон зайн менежментэд гүйцэтгэх үүрэг бүтэц, шалгуурыг нь тодотгон үндэслэх,
- 2.) Монголын хувьд, эдийн засгийн макро (үндэсний хэмжээний), мезо (дэд бүс буюу аймаг дундын), бичил буюу микро бүсчлэлийн харилцан уялдсан нэгдсэн сүлжээ, мөн аж ахуйн нэгжүүдийн нутаг дэвсгэрийн бүтэц, байршилт, зах зээлийн хамрах хүрээг харуулсан салбарын бүсүүд, тусгай зориулалтын бүсүүд (алслагдсан бүс нутгийг дэмжих, онцгой хамгаалалтанд авах г.м)-ийг тогтоож, бүс нутаг, салбар хоорондын хөгжлийн төлөвлөлтөд харгалзах,
- 3.) Хөгжлийг урьдаас байгаль, амьдрах орчинд хал, аюул багатай төлөвлөх, зохицуулах үүднээс экологи – ландшафтын, хэрэглээний уур амьсгалын, газар хөдлөлтийн г.м байгаль орчин – нийгмийн харилцааны хамтын менежментийг бүрдүүлэхэд ашиглах бүсчлэлийн сүлжээг шинэчлэх тогтоох,
- 4.) Улс, бүс хоорондын хамтын ажиллагаа, хоршилтын орон зайн бүтэц, зохион байгуулалтын оновчтой хүрээг тогтоож, стратегийн төлөвлөлтөд харгалзах эдийн засгийн уртрагийн бүсчлэлийн зэрэгцээ, мөн хөгжлийн өргөргийн дагуух хөндлөн зурвас бүсчлэлийг тогтоох,
- 5.) Эдийн засгийн бүсчлэлийг бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын төлөвлөлтөд төдийгүй, үндэсний аюулгүй байдлыг хангах, газар нутгийн эзэмшилт, хамгаалалт, тогтвортой хөгжлийн тэнцвэрийг хангах, нүүдэлчдийн аж ахуй, соёлын уламжлалыг хадгалах зэрэг бусад олон чиг үүрэг зориулалтаар төрийн зохицуулалтын бодлогын хэрэгсэл болгон ашиглах (ОХУ, БНХАУ, Япон зэрэг томоохон оронд бүсчлэлийн энэ функц чухал байна),
- 6.) Бүс нутаг бүрийн эдийн засгийг жигд хөгжүүлэх үзэл хандлагаас эдийн засгийн өсөлтийн туйлууд, хөгжлийн таталцлын тэнхлэгүүдийг үүсгэх, хотжилтын үйл явцыг түлхүү дэмжих, аймаг, хот, бүс нутаг бүрийн хөгжлийг харилцан нэгнээ дэмжсэн, бие биенээ нөхөн хангадаг бүтэц, чиглэлтэй болгох,
- 7.) Аймаг, бүс нутгийг байгаль, түүхий эдэд нь ойртуулан үйлдвэрлэл, үйлчилгээг жигд байршуулах объект буюу талбар болгон төсөөлж ирсэн зарчмаас хүн ам, нийгмийн цогц хөгжлийг хангах субъект болгон үзэж, ЗЗНД-ийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу эдийн засаг, төсөв, санхүүгийн эрх хэмжээг нь өртгөтгөн,

давуу талд нь түшиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хөдөлмөрийн хуваарьт өрсөлдөг оролцдог, улс орны эдийн засгийн харьцангуй бие даасан хэсэг маягаар төрөөс дэмжин зохицуулах,

- 8.) Бүс нутаг бүрийн чадавх, давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний кластерууд (аж үйлдвэрийн, экологи – аялал жуулчлалын, түүх – соёлын, оюуны мэдлэг, мэдээлэл – технологийн г.м)-ыг дэд бүтцийнх нь хамт байгуулах ААНБ-ын санаачилгыг тууштай дэмжиж, тэдгээрийн дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн, нэмүү өртөг, илүүц ашиг хуримтлал бий болгох чадварыг дээшлүүлэх замаар төр, хувийн хэвшлийн ашиг нэгдсэн хамтын сонирхлын бүс нутгуудыг үүсгэн хөгжүүлэх,
- 9.) Тогтвортой хөгжлийн орон зайн өсөлт, тэнцвэрийг хангах мэдээллийн технологи, оюуны болон соёлын үйлдвэрлэл, экосистем – аялал жуулчлалын үйлчилгээний инноваци – чадавхийн төвүүд, паркууд, ногоон хөгжлийн бүс, тэнхлэгүүдийг байгуулах,
- 10.) Геополитик, геоэкономикийн бүсчлэл, олон улсын банк, санхүүгийн байгууллагын хүрээнд хөгжиж байгаа болон хөгжингүй орнууд (хөрш орноос гадна, бүр алслагдсан улс гүрнүүд ороод)-тай худалдаа – эдийн засгийн болон аялал жуулчлал, тээврийн өргөн сүлжээг хөгжүүлж, үндэстэн дамнасан аж ахуйн хоршилт, бизнес – маркетингийн, мөн байгаль хамгаалал, ашиглалтын хамтын менежментийн тогтолцоог бүрдүүлэх,

Монгол орон газар зүйн байрлал, байгаль – уур амьсгалын нөхцөл, нүүдэлчдийн ахуй, соёлын өвөрмөц шинж байдлыг хадгалж байдгийн хувьд, бүсчилсэн хөгжил, зохицуулалтын дээр дурдсан зарим онцлог зарчим, арга зүйн чиглэлийг төр, иргэний нийгмийн бодлогод харгалзах цаг үе ирснийг судалгаа харуулж байна. Бид үүнийг Монголын нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг цаашид шинэчлэх бүсчилсэн хөгжлийн загваруудын систем болох ёстой гэж үзэн дараах байдлаар тодотгон томъёолох оролдлого хийж байна. Үүнд:

#### Нэгдэх загвар нь:

- Монголын эдийн засгийн бүсчилсэн хөгжил – хүн амын байршил, хот байгуулалтын нэгдсэн тогтолцоо;

#### Агуулга нь:

- Хот, хөдөөгийн хүн амын ажил эрхлэлт, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, залуучуудын орон нутгийн бүтээн байгуулалтад оруулах хувь нэмэрийг өндөржүүлэх, хот хөдөөгийн нэгдмэл хөгжлийн үндсийг хангах үйлдвэрлэл,

үйлчилгээний орон зайн зохистой төвлөрөл, бөөгнөрлийг бий болгох, тус орны Баруун, Зүүн жигүүрт Улаанбаатартай адил таталцлын тулгуур төв, тэнхлэгүүдийг байгуулах;

Хоёрдахь загвар нь:

- Монголын газар нутгийг тэлж ашиглах, хамгаалах тогтвортой хөгжлийн бүсчилсэн тогтолцоо;

Агуулга нь:

- Монгол орон нутаг дэвсгэрээ Баруун, Зүүн гар, Төв хэсэг болгон зохион байгуулж ирсэн түүхэн хандлага, нүүдэлчдийн аж ахуй (мал аж ахуй), соёл, ёс зүйн дэвшилтэт өв уламжлалыг хадгалан, тусгай хамгаалалттай газар нутаг, экосистем – аялал жуулчлалын үйлчилгээний сүлжээнд үндэслэн газар нутгаа тэлж ашиглах, хамгаалах хамтын менежментийг бүрдүүлэх;

Гуравдахь загвар нь:

- Монголын эдийн засгийн орон зайг экологичлох, мэдлэгжүүлэх хандлагаар үйлдвэржүүлэх, кластержуулах бүсчилсэн тогтолцоо;

Агуулга нь:

- Байгаль орчинд ээлтэй техник технологи бүхий төр, хувийн хэвшлийн томоохон компанийг ЖДҮҮ-тэй хоршиж, төрөлжсөн хамтын сонирхлын бүс нутгуудыг үүсгэж, тэдгээрийг дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн хөгжих нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлэх;

Дөрөвдэх загвар нь:

- Монголын дотогшоо харсан эдийн засгийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын бүсчилсэн зохицуулалт;

Агуулга нь:

- Газар, түүний баялгийг бүрэн өгөөжтэй ашиглуулах зарчимд тулгуурлан хөгжлингүй орнуудын үндэстэн дамнасан компани, пүүсийн салбарын бүсүүдэд нээж, Монголын аж ахуйн нэгж, байгууллагатай хоршин, өртөг шингэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, дэлхийн зах зээлд борлуулах, Монголын бизнес эрхлэгчид хөрш ба бүс нутгийн орнуудын зах зээлд ажиллаж, гаднаас орох дэвшилтэт технологи, ноу – хау, шилдэг мэдлэг туршлага, хөрөнгө мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх;

Тавдахь загвар нь:

- Монголын гадагшаа чиглэсэн худалдаа – эдийн засгийн хамтын ажиллагааны бүсчилсэн зохицуулалт;

Агуулга нь:

- Монгол Улс гео-улс төр, гео-эдийн засгийн бүсчлэлээ нягтлан тогтоож, Төв Ази, ЗХА, Ази Номхон далайн орнуудын бүсийн болон олон улсын бусад байгууллагатай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн хамт, Зүүн Хойт Азийн бүс нутгийн орнуудтай худалдаа – эдийн засгийн тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлэх улс төр – эрх зүйн нөхцлийг хангах, эдгээр орны хөгжлийн чадавх боломжийг шингээх таталцлын төв, тэнхлэгийг улс орондоо байгуулах;

Эдгээр 5 загварыг үндэсний (гадаад харилцааг оруулаад), бүс нутгийн, салбаруудын хөгжлийн аль ч түвшинд уян хатан харгалзах бүсчилсэн (бодлогын орчин, тавил өөрчлөгдөхөд зохицох чадвар) хөгжлийн тийм эрх зүйн болон ёс зүйн зохицуулалтын үндсийг бүрдүүлж, тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

### **3.6. Бүлгийн дүгнэлт, санал, зөвлөмж**

Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, өнөөгийн бодлогын хэрэгжилтийн явц байдалд хийсэн чиглэл, хэсэг бүрийн үнэлгээ, тайлбарыг нэгтгэж, дараах нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг эхлэлтийн тайланд дэвшүүлсэн болно. Хөндлөнгийн, Засгийн газрын байгууллагын, ОУБ-ын хийсэн үнэлгээнд дэвшүүлсэн дүгнэлт, саналууд үндсэндээ адил төстэй байгаа юм. Үүнд:

1./ Тэмүүжин – Чингис хааны үеэс олон овог аймгийг бүсчлэн нэгтгэж, Монголын эзэнт гүрнийг байгуулсан нь дэлхийд ач холбогдолтой болжээ. Тухайлбал, овог аймгуудыг бүсчлэн нэгтгэсэн энэ бодлогыг Чингис хаан, түүний хамтран зүтгэгчид дэлхийн улс орнуудыг эзэлж, Монголын их эзэнт гүрний хил хязгаарыг тэлэх зорилгодоо ашиглаж ирсэн байна. Энэхүү геополитикийг түүхчид “Алтан аргамжийн бодлого” гэж нэрлэсэн байдаг.

2./ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хууль, тогтоомж 2001 – 2010 он хүртэл харьцангуй тогтвортой хэрэгжиж, төлөвлөлт, зохион байгуулалт, судалгаа, мэдлэг мэдээллийн ахиц өөрчлөлтүүд гарсан байна.

3./ БХҮБ, хууль тогтоомжийн хэрэгжилт 2012 оноос суларч, тасалдаж эхэлсэн хандлага ажиглагдаж байна. Үүнд, төрийн бодлогын залгамж чанар алдагдаж, мөн одоогийн аймаг, сумдын хүрээнд хөгжлийг төлөвлөн зохицуулах чиглэлийг голлон барьсан бодлогын шинжтэй өөрчлөлт нөлөөлсөн байх магадлал их байна.

4./ Хэдийгээр ийм тасалдал гарсан ч БХ-ийн талаар аймаг, нийслэлийн удирдлага, ШУБ, гадаадын судлаачид, ажил хэрэгч хүмүүс оролцсон бүсчилсэн уулзалт, экспертүүдийн зөвлөгөөн, дотоод гадаадын судлаачид, судалгаа – мэдээллийн ажил тасралтгүй хийгдэж иржээ. Энэ нь Монголын нийгэмд “бүсчилсэн хөгжил”-ийн бодлого, үзэл санаа хэрэгтэй, түүнийг үргэлжлүүлэх нь зүйтэйг анхааруулсан, нэг ёсны дохио санамж болж өгсөн байна.

5./ БХҮБ, бодлогыг өнөөгийн шинэ нөхцөлд, зах зээлийн эрэлт, иргэний нийгмийн өргөн оролцоо, түүний дотор шинжлэх ухааны үндсэлэлд тулгуурлан, шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Ингэхдээ:

- бүсчилсэн хөгжлийн асуудал нь үндэсний аюулгүй байдал, орчин үеийн дэлхийн, хөрш ба бүс нутгийн орнуудын геоэдийн засгийн бодлого, чиглэлтэй улам бүр холбогдож байгааг онцлон анхаарах;

- монголын далайд гарцгүй эх газрын газарзүйн байрлал, байгаль цаг уурын өөрчлөлт, экологийн болзошгүй эрсдэлийг урьдаас төсөөлж, “байгаль орчинд дасан зохицох чадвартай орон зайн эдийн засгийн зохион байгуулалт”-ыг бүрдүүлэх;

- бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын нэгдсэн загвар баримтлал боловсруулж, бодлогын шинэчлэлд тусгах, энэ үндсэн дээр, хүн амын нутагшилт, томоохон хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх;

- Бүсийн хөгжлийн тулгуур төв – хотын асуудлыг нутаг дэвсгэрийн тэнцвэр, Баруун, Зүүн хэсгийн таталцах чиглэл, эдийн засгийн, тээвэр – хөгжлийн коридорууд, хөгжлийн бүс, өсөлтийн туйлууд үүсэх хандлагатай холбон (мөн, дээр хэлсэн “агломерац”, хөгжлийн гурвалжин г.м ) дахин нягталж, бодлогод тодотгон тусгах;

- Бүсчилсэн хөгжлийн бодлогын шинэчлэлд БХҮБ-д заасан “улс, бүсийн хэмжээ”-нд “бүс нутаг – хот – хөдөөгийн суурин”-гийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх “хот, хөдөөгийн нэгдмэл хөгжлийн концепц”-ийг төсөөлж тусгах;



- Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт зохицуулалтын удирдлага, зохион байгуулалтын бүх шат, хүрээ, салбарыг хамарсан үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үүднээс “эдийн засгийн макро, мезо, микро бүсчлэл, салбар”-ын болон тусгай чиг үүргийн бүсчлэл (том хотын үүргийн бүсчлэл ороод)-ийн харилцан уялдсан нэгдсэн сүлжээг бүрдүүлэх;

- Бүсчилсэн хөгжлийн нийтлэг стратеги, зорилтуудыг зөвхөн төрөөс дэмжин зохицуулах биш, аж ахуйн нэгж (мэргэжлийн холбоодоор дамжуулан), иргэдийн байгууллагын өргөн оролцоо, дэмжлэгийг хангасан “нийгмийн өргөн зөвшилцөл, харилцан сонирхлын хослол” дээр тулгуурлан шийдэх;

- БХУЗ-ын хуульд тодорхойлсон “Бүсчилсэн хөгжил”-ийн удирдлагын бүтцийн нэгжүүдийг үр нөлөөтэй ажиллуулах, бүсийн хөгжлийг үндэсний болон бүсийн хэмжээнд дэмжих татвар, төсөл, санхүү зээлийн илүү үр дүнтэй хөшүүргийг судлан тогтоож, ашиглах;

- Хууль тогтоомжийг нийгэм, эдийн засгийн болон хот байгуулалт, салбарын харилцааг зохицуулдаг бусад хууль тогтоомжтой сайтар нийцүүлэх;

- Бүсчилсэн хөгжлийн бодлогын шинэчлэл, хэрэгжилтийг үнэлэх ажилд судлаачид, ОУБ, гадаад орны шинжээчдийг байнга оролцуулахын хамт, энэхүү тайланд дурдсан ОУБ-аас өгсөн дүгнэлт, саналыг бусад салбарын судалгааны үр дүнтэй нэгтгэн дүгнэж, бодлогын төлөвлөлтөнд харгалзах;

- Нэгдсэн болон салбарын судалгааны “бодлогын хэрэгжилтэнд хийсэн хөндлөнгийн үнэлгээ”-г ЗГХЭГ, холбогдох яам, газарт танилцуулж, тэдгээрийн албан ёсны хяналт – шинжилгээ (гараагүй бол хийлгэх)-ний дүгнэлт, саналд тусгуулах (нийцүүлэх);

## **ДӨРӨВ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **4.1. Бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудал, шалтгаан, шийдвэрлэх арга замууд**

#### **4.1.1. Тулгамдсан асуудал**

## 1.) Асуудал яагаад чухал болох

- Монгол орны нутаг дэвсгэрийн зохион байгуулалт (газар нутгийн хуваарь)-ын түүхэн хандлага, эдийн засгийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн ололт, сургамжийг бусад орны туршлагатай харьцуулан онцлог ба нийтлэг үзэл баримтлалын талаас нь нэгтгэн судалж дүгнэх ажил үгүйлэгдэж ирсэн. Үүнээс үүдэж нийгэмд энэ асуудлыг хэрхэн үзэх нэгдмэл ойлголт бүрдээгүй, түүнийг хэрэгжүүлэх ажилд нийтээрээ оролцох, үр дүнг нь хүлээн баттай итгэл үнэмшил төрөөгүй явж ирсэн байна.
- Бүсчилсэн хөгжлийн гол мөн чанар болон аймаг, сум, улс үндэстэн дамнасан бүс нутаг хоорондын, салбар хоорондын хамтын ажиллагаа хоршилтын төлөвлөлт, зохицуулалтын үр өгөөж, ач холбогдлыг төр иргэний нийгэм, аж ахуйн нэгж байгууллагын бүх түвшин, хүрээнд зөвшилцөн ойлгож, хэвшүүлэх хэрэгтэй байна. Хэдийгээр хамтарч ажиллах, хорших ёстойг хуульчилж өгсөн боловч нийгмийн орон зайн энэ нэгдмэл цогц асуудлыг олон жилийн турш одоогийн аймаг, сум, багийн хил заагийн дотор, эсвэл нийслэлийн дүүргүүд, дагуул хот, тосгоны хүрээгээр таслан хувааж, тэдгээрийн хязгаарлагдмал нөөц чадавхиар шийдвэрлэхийг эрмэлзэж иржээ.
- Ингэснээр, өөр хоорондоо уялдаа багатай, зөвхөн орон нутгийн явцуу бодлого, төсөв хөрөнгө, эсвэл улсын санхүүгийн дэмжлэг, бизнес эрхлэгчдийн туслалцааг харсан хаагдмал шинжтэй засаг захиргааны олон жижиг нэгжүүд оршин байх үндсийг нөхцөлдүүлж өгсөн байгаа юм.

## 2.) Асуудлын түүхэн шалтгаан

- Монголчууд бүр Хүннү гүрний үеэс нутаг дэвсгэрээ Баруун, Зүүн гар, Төв хэсэг гэж хуваан, газар нутгаа тэлж ашиглах бодлого баримталж байсан нь өнөөг хүртэл, гурван муж, гурван бүсийн хэлбэрээр ямар нэг хэмжээгээр уламжлагдаж ирсэн байна. Үүнийг өнөөдөр ч гэсэн зарим судлаачид Баруун, Зүүн жигүүр, Төв хэсэг, эсвэл муж болгон засаг захиргаа – нутаг дэвсгэрийн том нэгж болгох, тэдгээрийн хүрээнд нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах Улаанбаатараас гадна Баруун, Зүүн хэсэгт хоёр тулгуур төв тэнхлэг бий болгох саналыг дэвшүүлсээр байгааг хэтийн бодлогод харгалзаж болох байна.

- Социализмын үед эдийн засгийн нэгдсэн бүсчлэл болон салбарын бүсчлэл (мужлалт) тогтоож, нутаг дэвсгэрийн нөөц, чадавх, хөгжлийн тэнцвэрт байдлыг ажиглах, улмаар тэдгээрийг үйлдвэрлэх хүчний хөгжил, байршлыг зураглан төсөөлөх, орон зайн хэсгүүдийн нягтрал, багтаамжийг харьцуулах, нутаг дэвсгэрийн цогцолбор төлөвлөгөө зохиох (1970-аад оноос)-од ашиглаж иржээ. Энэ байдлыг зах зээлийн нөхцөлд зохицуулан бүс нутаг, хот байгуулалтын төлөвлөлтөд бүтээлчээр харгалзах боломжтой гэж үзнэ.

### 3.) Асуудлын үр нөлөө, үр дагавар

- БХҮБ, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрүүдийн олонх зорилт, арга хэмжээ хэдийгээр хэрэгжиж чадаагүй ч Монгол орны газарзүйн байрлал, орон зайн зохион байгуулалтын өвөрмөц нөхцөлд төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм, экологи, гадаад харилцааны олон салбарт хамтран ажиллах, хүч хөрөнгөө хоршин ашиглах хэрэгтэй юм байна гэсэн дохио санамжийг нийгэмд өгч, төрийн удирдлагын хүрээнд үндэсний болон бүс нутаг, орон зайн иж бүрэн (цогц) төлөвлөлт, зураг төслийн арга зүй, мэдээллийн ихээхэн баазын бүрдүүлсэн. Бүсчилсэн судалгаа, шинжилгээ хийгдэж, сургалт, сурталчилгааны хөтөлбөрүүд гарч, бүсчилсэн уулзалт, хурал зөвлөгөөн хийдэг дэг журам бий болж, өнөөдөр ч үргэлжилсээр байна.
- Бүсчилсэн хөгжлийн тогтолцоо (бүс нутаг – хот – хөдөөг холбосон)-ны хатуу дэд бүтэц (засмал зам, тээврийн босоо, хэвтээ тэнхлэг, мэдээлэл харилцаа холбоо, цахилгаан дамжуулах, бөөний худалдаа, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ г.м) үндсэндээ бүрдэж, тус улсад ойрын ирээдүйд бий болох нийгмийн орон зайн бүтэц зохион байгуулалтыг зангидах араг яс тодорч байна. Энэ араг ясыг дүүргэх хүн амын нутагшилт, аж ахуйн байршилтууд, тэдгээрийг холбох зах зээлийн уян (зөөлөн) дэд бүтцүүдийг бий болгох шаардлага тулгарч байна. Үүнд бидний дэвшүүлж байгаа асуудлын шийдэл хариулт өгөх учиртай.
- БХҮБ, түүний дагалдан гарсан олон хөтөлбөр, төсөл (бүсүүд, тулгуур төвүүд, үйлдвэрлэл – технологийн паркууд, чөлөөт бүсүүд г.м), удирдлага зохицуулалтын арга хэрэгсэл (БХУЗХ-иар тогтоосон Бүсчилсэн хөгжлийн Хороо, Бүсийн зөвлөл, бүсийн хэлэлцээр, бүсийн хөгжлийг дэмжих сан г.м) цаг тухайдаа хэрэгжээгүйгээс болж бүтээн байгуулалтын болон нийгэм – сэтгэлзүйн чанартай олон таагүй үр дагавар гарч байгаа. Эдгээрээс заримыг нь дурдвал:

- Мянганы хөгжлийн зорилт, бүсүүдийн хөгжлийн стратеги, хөтөлбөрт тодорхойлсон стратегийн ач холбогдол бүхий эрдсийн баялгийн ордуудыг ашиглалтад бэлтгэх ажил хойшлогдсон;
- Бүсүүдийг хооронд нь болон гадаад зах зээлтэй холбох авто болон төмөр замын босоо, хөндлөн тэнхлэгүүдийг барьж байгуулах ажил удааширсан;
- Бүсүүдийн хүрээнд аймгуудын аж ахуйн хоршилтыг хөгжүүлэхээр Засгийн газар, бүсийн зөвлөлүүдийн түвшинд удаа дараа яригдсан мах, ноос, арьс шир боловсруулах, барилгын материалын үйлдвэрүүд барих томоохон төслүүдийг эхлүүлэх, тэдгээрт түшиглэн ЖДҮ-ийг хослон хөгжүүлэх арга хэмжээ удааширсан (зөвхөн Дорноговь аймагт аймаг дундын ач холбогдолтой цементийн үйлдвэр баригдаж, ашиглалтанд орсон);
- Дархан, Сэлэнгэ, Сайншанд, Багануур болон бусад газар үйлдвэрлэл – технологийн паркууд байгуулах ажил зохион байгуулалтын түвшинд эхлээд, урсгал үргүй зардал их гарсан;
- Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсүүдийг байгуулж улс орны эдийн засгийн өсөлт, хуримтлалыг нэмэгдүүлэх стратегийн зорилт удааширч, оруулсан хөрөнгийн үр ашиг хангалтгүй, дотоод, гадаадын ажил хэрэгч хүмүүсийн хүлээлт бий болсон;
- Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр, төсөл амжилттай хэрэгжинэ гэдэгт олон нийтийн итгэл алдарч, сум, багийн иргэд, бизнесийн байгууллагын хамтран ажиллах идэвх суларсан;
- Бүсчилсэн хөгжлийн бодлогын ач холбогдол, үр нөлөө тодорхойгүй болж, иргэд байгууллагын зүгээс зөв зүйтэй, үнэтэй санал, шүүмжлэл олон гарсан боловч, цаг тухайд нь тусган хэрэгжүүлж чадаагүй (жишээ нь: эдийн засгийн 5 бүсийг аймаг, хотын хоршилтод үндэслэн дэд бүсүүдэд хуваах, бүсийн тулгуур төв – хот дээрээс тогтоон шийдэх бус, харин хөгжлийн тэнхлэг, өсөлтийн туйлуудын таталцлын хүрээнд үүсэх нөхцлийг нь дэмжин бүрдүүлэх, бүсчлэлд тулгуурлан олон жилээр тогтнож ирсэн засаг захиргаа – нутаг дэвсгэрийн одоогийн хуваарийг судалж, орон нутгийн эдийн засгийн бие даан хөгжих чадвар, шалгуурт нийцүүлэн өөрчлөх г.м);

#### 4.) Асуудалд нөлөөлсөн хүчин зүйлс:

- Төрийн бодлогын залгамж чанар алдагдсан;
- Монголын болон дэлхийн эдийн засгийн өсөлт саарсан;
- Улсын төсөв санхүүгийн дутагдал, хямралт шинж;

- Бүсчилсэн хөгжлийн бодлого, улсын нэгдсэн төлөвлөлт, төсөв, хөрөнгө оруулалтын уялдаагүй байдал;
- Аймаг, нийслэл, салбаруудын бодлогын уялдаагүй байдал, орон нутаг, салбарын эрх ашгийг урьтал болгодог явцуу үзэл хандлага;
- Иргэд, олон нийт, ААНБ-ын оролцоо, дэмжлэгийг өргөжүүлж чадаагүй;
- Олон улсын төрөлжсөн байгууллагууд (НҮБ, ДБ, АХБ г.м)-ын хийсэн санал дүгнэлтийг тухай бүр харгалзаж, бодлого, үйл ажиллагаанд тусгаагүй г.м;

#### 5.) Асуудал үр нөлөөтэй хэрэгжих боломж

- БХҮБ, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэнд нөлөөлсөн хүчин зүйлсийг иргэний нийгмийн оролцоотой үнэлж, хэрэгжээгүй шалтгааныг нийтэд мэдээлэх;
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг цаашид ямар хувилбараар, ямар хугацаанд хэрэгжүүлэх боломжтой, түүний ач холбогдлыг ялангуяа залуу үед сурталчлах;
- Эдийн засгийн бүсчлэл, төвлөрлийг сааруулах урт хугацааны шинэчилсэн бодлого боловсруулах Засгийн газрын шийдвэрийг Засгийн газрын бүх байгууллага, нийгэмд ойлгуулж, нэгдсэн ойлголт, үзэл баримтлал, мэдээлэл – арга зүйн баазтай болох;
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг үр дүнд чиглүүлэн шинэчлэн төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дотоод, гадаадын эрдэмтэд, судлаачид, ААНБ, ТББ, Монгол дахь ОУБ-ын дэмжлэгийг хангах;
- Бүсчилсэн хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх асуудлыг төв, орон нутагт өргөн хэлэлцүүлж, санал зөвлөмжийг нэгтгэн тусгах;

#### 6.) Асуудлыг хэрэгжүүлэхэд гарах хүндрэл, бэрхшээл:

- Төрийн удирдлагын тогтвортой байдал алдагдах;
- Төрийн бодлогын залгамж чанарт улс төрийн сонгууль, улс төрийн хүчнүүд нөлөөлөх;
- Удирдлагын бүх түвшинд бүс нутаг, хот, салбарын эрх зүйн болон төлөвлөлт зохицуулалтын уялдааг хангах, хуулийн нэгдмэл үйлчлэлийг бий болгох;
- Төр бизнесийн байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан зөвшилцөл, хамтын сонирхлыг хангах явдал удаашрах;
- Улс орон нутгийн төсөв санхүүгийн нөөцийн хомсдол, татвар, төлбөр, шилжүүлэг, зээл тусламж, дэмжлэгийн механизмын зохицоогүй (оновчгүй) байдал г.м;

7.) Асуудлын судалж буй түвшин, бүрэлдэхүүн хэсэг:

- Тавигдсан түвшин:
  - Үндэсний (гадаад харилцаа)
  - Бүсийн (макро, мезо, хотын)
  - Аймаг, нийслэл
- Бүрэлдэхүүн хэсэг:
  - БХҮБ, хууль, удирдлага
  - Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт (хөтөлбөр, төсөл)
  - Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт, үнэлгээ
  - Бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчлэх зураглал, таамаглал
  - Бүсчилсэн хөгжлийн зохицуулалт

8.) Асуудлын мөн чанарын талаарх судлаачийн ойлголт.

Бүсчилсэн хөгжил нь:

- Эдийн засаг, нийгмийн орон зайн харилцааны менежментийг боловсронгуй болгох арга зам;
- Аймаг, хот, бүс, улс дамнасан эдийн засгийн хөгжлийн нийтлэг асуудлыг иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ашиг сонирхол, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын дэмжлэгээр шийдвэрлэх стратегийн төлөвлөлтийн арга хэрэгсэл;
- Тогтвортой хөгжлийн тэнцлийг хангах зорилгод улс үндэстэн, бүс нутаг, салбарын ашиг сонирхлын хослолыг хангах төр, иргэний нийгмийн хамтын зохицуулалтын арга механизм;

9.) Асуудлыг шийдэхэд баримталсан тулгуур зарчим:

- ❖ Улс үндэстэн, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ашиг сонирхлын хослолыг хангах;
- ❖ Монгол нутаг дахь нүүдэлчдийн ахуй – түүх, соёл, ёс суртахууны дэвшилттэй өв уламжлалыг орчин үеийн суурин иргэншлийн ололттой хослуулах;
- ❖ Нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, эдийн засгийн бүсчилсэн төлөвлөлтийн Монголын онцлог тал (байгаль, аж ахуй, соёлоос үүдсэн)-ыг дэлхийн улс орнуудын нийтлэг туршлагатай хослуулах.

#### **4.2. Бодлогын асуудлын зураглал /зохиомж - сценари/**

Монголын нутаг дэвсгэрийн хөгжил, аймаг, орон нутгийн өмнө өнөөдөр тулгамдаж буй нийтлэг асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлох зорилгоор судлаач цаашид баримтлах бодлогын талаар дараах зураглал – зохиомжийг гаргаж байна. Ингэхдээ, хүн амын шилжих хөдөлгөөн, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, удирдлагын төвлөрлийн өнөөгийн бодит байдал, түүний нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх бодит нөөц боломж, энэ талаарх улс төр, нийгмийн зүтгэлтнүүд, улс төрийн хүчнүүдийн байр суурь, төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс, судлаачдын дунд гарч байгаа нийтлэг маягийн үзэл бодол зэргийг иш үндэс болголоо. Үүнд, дор дурдсан 3 янзын зураглал харагдаж байна.

Нэгдүгээрх нь, нийслэл Улаанбаатар, мөн Эрдэнэт, Дархан хот, тэдгээрт шууд таталцсан бүс нутагт бөөгнөрөн суурьшиж амьдрах /хөгжлийн “Алтан гурвалжин” үүсгэж /;

Хоёрдахь нь, нийслэл хотоо Хархоринд шилжүүлж, газар нутгаа тэлж ашиглан, орон нутгаа жигд хөгжүүлэх замаар тархай суурьшиж амьдрах;

Гуравдахь нь, байгалийн чадавх, зах зээлийн газар зүйн байрлал сайтай газарт эдийн засгийн өсөлтийн туйлууд, хөгжлийн таталцлын тэнхлэгүүд буй болгон, олон суурьшлын төвүүдэд амьдрах;

Өнгөцхөн харахад эдгээрийн аль алийг нь зэрэгцүүлж (хослуулан) шийдэх боломжтой, алсдаа ийм л хандлага руу явж байх шиг байна гэж хэлж болох юм. Гэхдээ, эдгээрийн аль нэгийг нь түлхүү барьж, нэн даруй хэрэгжүүлж эхлэхгүй бол, улам олон асуудал, бэрхшээл хуримтлагдаж, их хэмжээний хөрөнгө санхүү шаардагдах болно. Хамгийн гол нь газар нутаг эзэнгүйдэх, ая тухтай орчныг хүлээж байгаа хот, хөдөөгийн хүн амын амьдрал улам дордож, амьдралын үндэс болж ирсэн таван төрлийн малаа өсгөх байгаль, эдийн засгийн боломж хязгаарлагдах нь зайлшгүй.

Дээр дурдсан 3 зураглалын аль алин дээр нь Монгол газар нутагт байхаар байгалиасаа шалгарч ирсэн бэлчээрийн (цаашид хагас бэлчээрийн болгосон ч) мал аж ахуй, манай эдийн засгийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын суурь дэвсгэр болж өгөх нь гарцаагүй. Үүн дээр аль ч бүс нутагт олон ч цөөн ч хүн нутаг усандаа үлдэх учир, бололцоотой газраа ногоо тариагаа эрхлэх, ашигт малтмалаа орлогоо нэмэгдүүлэх эх үүсвэр болгож ашиглах, дотоод, гадаад аялал жуулчлал, худалдаа наймаа хөгжүүлэх болно. Гагцхүү орон зайн зохион байгуулалтын энэ анхдагч дэвсгэр дээр эдийн засгийн өсөлт, хөгжлийг түргэтгэхээр гуравт зурагласан зохиомжийг хэрэгжүүлэх тухай өнөөдөр голлон ярьж байна гэж ойлгож байна.

Ингэж үзвэл, эн түрүүнд гуравдахь зураглалын зохиомжийг байгаа дотоод, гадаад нөөцөө дайчлан дэс дараатай хэрэгжүүлэх явдлыг ойрын 10 жилийн бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам болгох нь зүйтэй байна. Энэхүү зураглалын гол агуулга нь нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийн хангах /зарим тохиолдолд нийгмийн жигд хөгжил гэж ярьж ирсэн/ зохиомжоос илүү үйлдвэрлэл, технологийн паркууд, уул уурхайн болон хөнгөн хүнс, соёл – аялал жуулчлалын кластерууд, тээвэр – хөгжлийн коридор байгуулах үйл ажиллагааг төрөөс дэмжиж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн одоогийн хуваарийг өөрчлөх, нийслэлийн чиг үүрэг, бүтцийг шинэчлэх, шинэ хот, тосгон байгуулах, хөдөөд хотожсон амьдралын хэв маягийн бүрдүүлж эхлэх юм. Ингэснээр, газар, түүний баялгийг ашигласны үр өгөөж нэмэгдэж, хүн ам нутаг усандаа ая тухтай амьдрах боломж бүрдэнэ. Нөгөө талаас, бэлчээрийн мал аж ахуй, нүүдэлчдийн ахуй соёлын уламжлалыг орчин үеийн суурин иргэншлийн ололттой хосолсон орон зайн боловсронгуй зохион байгуулалт бий болж, хүн амын хөдөлмөр, оюун санааны бүтээлч чадавх дээшлэн, зөвхөн худалдаа наймаа, олборлон бэлтгэх ахуйгаас гадна үйлдвэрлэл, үйлчилгээгээр зах зээлд өрсөлдөн нэмүү ашиг олох хот хөдөөгийн хоорондын нийгмийн харилцаа хөгжих үндэс суурь тавиггдана.



Энэ нь өнөөдрийг хүртэл Монголын хөгжлийн бодлогод голлож ирсэн байршилт, газрын баялаг, авто тээвэр, зам харилцаа, худалдаа, эрчим хүчний сүлжээ зэрэг биет (физик) хүчин зүйлд тулгуурласан харьцангуй давуу талын онол, түүнийг зохицуулдаг эрх зүйн актуудаас өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэж, мэдлэг мэдээллийг дотоод, гадаад зах зээлд солилцох орон зайн зөөлөн дэд бүтэц (банк, санхүү, зээл, даатгал, өмч хөрөнгийн зах зээл г.м)-ийг хөгжүүлэх дэлхийн эдийн засгийн нийтлэг харилцаанд орон шилжилтийн үйл явцаар тодорхойлогдоно. Энэ үйл явц хэр түргэн, хэр эрчимтэй байхыг цаашид явуулах бодлогоо хэрхэн зөв төсөөлж (таамаглаж), түүнийг тасралтгүй мөрдөх арга механизмыг олж хэрэгжүүлэх чадвараас шууд шалтгаална.

Орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулах нь эдийн засаг, нийгэм, экологийн цогц асуудал, улс үндэстэн, аймаг, хот, бүс нутгийн түвшин, төр, иргэн, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлын хослол шаардсан иж бүрэн асуудал учир нэг талыг барьсан өрөөсгөл үзэл бодол (зураглал - зохиомж), бодлогын шулуун чиг шугамаар хэрэгжихэд бэрхшээлтэй болохыг онцлон тэмдэглэж байна. Иймд, асуудлыг шийдвэрлэх таамаглал гаргахдаа бүсчилсэн хөгжил, зохицуулалтын онцлог шинж, түүнд нөлөөлөх олон талын хүчин зүйлсийн орон зай, цаг хугацаанд хувьсан өөрчлөгдөх байдлыг нягтлан үзсэн уян хатан сонголт хийх хэрэгтэй юм.

### 4.3. Бүлгийн дүгнэлт, санал, зөвлөмж

Монголын бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц байдалд хийсэн чиглэл, хэсэг бүрийн үнэлгээ, тайлбарыг нэгтгэж, дараах нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг эхлэлтийн тайланд дэвшүүлсэн болно. Хөндлөнгийн, Засгийн газрын байгууллагын, ОУБ-ын хийсэн үнэлгээнд дэвшүүлсэн дүгнэлт, саналууд үндсэндээ адил төстэй байгаа юм. Үүнд:

1./ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хууль, тогтоомж 2001 – 2010 он хүртэл харьцангуй тогтвортой хэрэгжиж, төлөвлөлт, зохион байгуулалт, судалгаа, мэдлэг мэдээллийн ахиц өөрчлөлтүүд гарсан байна.

2./ БХҮБ, хууль тогтоомжийн хэрэгжилт 2012 оноос суларч, тасалдаж эхэлсэн хандлага ажиглагдаж байна. Үүнд, төрийн бодлогын залгамж чанар алдагдаж, мөн одоогийн аймаг, сумдын хүрээнд хөгжлийг төлөвлөн зохицуулах чиглэлийг голлон барьсан бодлогын шинжтэй өөрчлөлт нөлөөлсөн байх магадлал их байна.

3./ Хэдийгээр ийм тасалдал гарсан ч БХ-ийн талаар аймаг, нийслэлийн удирдлага, ШУБ, гадаадын судлаачид, ажил хэрэгч хүмүүс оролцсон бүсчилсэн уулзалт, экспертүүдийн зөвлөгөөн, дотоод гадаадын судлаачид, судалгаа – мэдээллийн ажил тасралтгүй хийгдэж иржээ. Энэ нь Монголын нийгэмд “бүсчилсэн хөгжил”-ийн бодлого, үзэл санаа хэрэгтэй, түүнийг үргэлжлүүлэх нь зүйтэйг анхааруулсан, нэг ёсны дохио санамж болж өгсөн байна.

4./ БХҮБ, бодлогыг өнөөгийн шинэ нөхцөлд, зах зээлийн эрэлт, иргэний нийгмийн өргөн оролцоо, түүний дотор шинжлэх ухааны үндсэлэлд тулгуурлан, шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Ингэхдээ:

- бүсчилсэн хөгжлийн асуудал нь үндэсний аюулгүй байдал, орчин үеийн дэлхийн, хөрш ба бүс нутгийн орнуудын геоэдийн засгийн бодлого, чиглэлтэй улам бүр холбогдож байгааг онцлон анхаарах;

- монголын далайд гарцгүй эх газрын газарзүйн байрлал, байгаль цаг уурын өөрчлөлт, экологийн болзошгүй эрсдэлийг урьдаас төсөөлж, “байгаль орчинд дасан зохицох чадвартай орон зайн эдийн засгийн зохион байгуулалт”-ыг бүрдүүлэх;

- бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын нэгдсэн загвар баримтлал боловсруулж, бодлогын шинэчлэлд тусгах, энэ үндсэн дээр, хүн амын нутагшилт, томоохон хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх;

- Бүсийн хөгжлийн тулгуур төв – хотын асуудлыг нутаг дэвсгэрийн тэнцвэр, Баруун, Зүүн хэсгийн таталцах чиглэл, эдийн засгийн, тээвэр – хөгжлийн коридорууд, хөгжлийн бүс, өсөлтийн туйлууд үүсэх хандлагатай холбон (мөн, дээр хэлсэн “агломерац”, хөгжлийн гурвалжин г.м ) дахин нягталж, бодлогод тодотгон тусгах;

- Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт зохицуулалтын удирдлага, зохион байгуулалтын бүх шат, хүрээ, салбарыг хамарсан үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үүднээс “эдийн засгийн макро, мезо, микро бүсчлэл, салбар”-ын болон тусгай чиг үүргийн бүсчлэл (том хотын үүргийн бүсчлэл ороод)-ийн харилцан уялдсан нэгдсэн сүлжээг бүрдүүлэх;

- Бүсчилсэн хөгжлийн нийтлэг стратеги, зорилтуудыг зөвхөн төрөөс дэмжин зохицуулах биш, аж ахуйн нэгж (мэргэжлийн холбоодоор дамжуулан), иргэдийн байгууллагын өргөн оролцоо, дэмжлэгийг хангасан “нийгмийн өргөн зөвшилцөл, харилцан сонирхлын хослол” дээр тулгуурлан шийдэх;

- Хууль тогтоомжийг нийгэм, эдийн засгийн болон хот байгуулалт, салбарын харилцааг зохицуулдаг бусад хууль тогтоомжтой сайтар нийцүүлэх;

- Бүсчилсэн хөгжлийн бодлогын шинэчлэл, хэрэгжилтийг үнэлэх ажилд судлаачид, ОУБ, гадаад орны шинжээчдийг байнга оролцуулахын хамт, энэхүү тайланд дурдсан ОУБ-аас өгсөн дүгнэлт, саналыг бусад салбарын судалгааны үр дүнтэй нэгтгэн дүгнэж, бодлогын төлөвлөлтөнд харгалзах;

- Нэгдсэн болон салбарын судалгааны “бодлогын хэрэгжилтэнд хийсэн хөндлөнгийн үнэлгээ”-г ЗГХЭГ, холбогдох яам, газарт танилцуулж, тэдгээрийн албан ёсны хяналт – шинжилгээ (гараагүй бол хийлгэх)-ний дүгнэлт, саналд тусгуулах (нийцүүлэх);

## **ТАВ. МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД**

### **5.1. Монголын бүсчилсэн хөгжлийн бодлого /2030 он хүртэлх/ -ын зорилго, зорилтуудыг тодорхойлох үндэслэл санал**

#### **1. Бүсчилсэн хөгжлийн бодлогын үзэл баримтлалыг шинэчлэх шаардлага, чиглэлүүд**

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ, зах зээлийн өнөөгийн нөхцөл дөх иргэний нийгмийн санаа бодол, төрийн эдийн засгийн зохицуулалт болон тогтвортой хөгжлийн шинээр бий болж байгаа бодлогын орчин, дэлхийн бусад улсын бүсчилсэн хөгжлийн онол, практикийн туршлага, цаашдын чиг хандлагаас үндэслэн Бүсчилсэн хөгжлийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (УИХ-аас 2001 оноос батлан мөрдөж байгаа)–ын зарим үзэл санааг шинэчлэн төгөлдөржүүлэх шаардлага тавигдаж байна. Үүнийг дор дурдсан гурван үндсэн асуудалтай холбон нягтлан судалж, цаашдын бодлогод тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1.) Хавтгайрсан, нэлэнхүйдээ тэгш, буюу жигд хөгжүүлэх үзэл санаанаас татгалзаж улс орны эдийн засгийн өнөөгийн нийтлэг хүндрэл, бэрхшээлийг богино хугацаанд даван туулахын тулд , үндэсний болон аймаг, орон нутгийн төсөв санхүүгийн хязгаарлагдмал хүч нөөцийг эн түрүүнд үр ашгиа өгөх хөгжлийн тэргүүлэх бүс нутаг, аж ахуйн салбарт төвлөрүүлж, үр өгөөжийг зүй зохистой хуваарьлан ашиглах орон зайн зохицуулалтын менежментийг бүрдүүлэх;

2.) Эдийн засгийн бүсүүдэд байгаа стратегийн ач холбогдолтой ашигт малтмал, мөн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ХАА-н түүхий эдийн нөөц, орон

нутгийн хүн амын аж байдал, байгаль орчинд ивээлтэй түүх, соёл, оюуны уугуул чадавх, боломжоо үр өгөөжтэй ашиглах үйлдвэрлэл, үйлчилгээний орчин үеийн цогцолборуудыг үйлдвэрлэл- технологийн болон шинжлэх ухаан –мэдлэг мэдээллийн паркууд, аж үйлдвэрийн болон экологи-соёлын аялал жуулчлалын кластеруудын аль нэг зохистой, ирээдүйтэй чиглэлээр байгуулж, эдийн засгийн өсөлтийн болон зах зээлийн таталцлын төвүүдийг хөгжүүлэх ;

3.) "Зам дагаж хөгждөг" гэсэн үзэл хандлагаас улс хоорондын, бүс хоорондын хөндлөн болон босоо чиглэлийн "эдийн засгийн болон ногоон хөгжлийн коридорууд", төмөр зам, засмал зам, эрчим хүч, цахим/интернет/ - мэдлэг мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, бүх орон зайд адил үйлчлэх дижитал технологи, сансарын хиймэл дагуулын мэдээллийн систем, мөн банк, санхүү, зээл даатгал, хөрөнгийн бирж г.м. зах зээлийн дэд бүтцийн хөгжлийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын хэтийн төлөвийг шинээр тодорхойлох.

## **2. Бүсчилсэн хөгжлийн бодлогын стратегийн зорилго, зорилтууд**

Бодлогын судалгааны эхлэлтийн болон дунд шатны энэхүү тайланд тусгасан Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн хандлага, сургамж, өнөөгийн байдал, бүсчилсэн хөгжлийн талаарх бусад орны туршлага, түүнийг шинэчлэх арга зүйн хандлага, тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх талаар дэвшүүлсэн таамаглал зэргийг багтаасан нөхцөл байдлын дүн шинжилгээний багц үр дүнгүүд нь 2030 он хүртэлх хугацаанд тавих бүсчилсэн хөгжлийн бодлого, түүний стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлох гол үндэслэл шаардлага болж байна. Бодлогын зорилго, зорилтуудыг томъёолохдоо, энэхүү тайлангийн 2.1-д тодорхойлсон "Бүсчилсэн хөгжлийн орон зайн тогтолцооны загвар" (5 чиглэлийн) –уудыг үндэс болголоо.

Загвар тус бүрийн агуулгуудын гол санаа/дээрх 2.1-д тодорхойлсон/ -г нэгтгээд Бүсчилсэн хөгжлийн 2030 он хүртэл бодлогын стратегийн зорилгыг **"Монголын нийгмийн орон зайн бүтэц, байгуулалтын дотоод, гадаад орчныг шинэчлэх эдийн засгийн бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын нэгдмэл тогтолцоо бүрдүүлнэ"** гэж томъёолох саналтай байна. Харин эдгээр загварыг хэрэгжүүлэх явдлыг Бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилгод хүрэх стратегийн зорилтууд буюу цогц зорилтууд гэж үзсэн. Учир нь бодлогын зорилтууд нь бүхэлдээ бүсчилсэн хөгжлийн дээрх загваруудыг босгоход чиглэгдэж баймааж нь бодлогын стратеги хангагдах ёстой болно. Ингээд, бүсчилсэн хөгжлийн 2030 он хүртэлх стратегийн зорилгын хүрээнд хэрэгжүүлэх зорилтуудыг дараах байдлаар томъёолж байна. Үүнд:

- 1/ Монголын эдийн засгийн бүсчилсэн хөгжил, хүн амын байршил, хот байгуулалтын нэгдсэн тогтолцоо
- 2/ Монголын газар нутгийг тэлж ашиглах, хамгаалах тогтвортой хөгжлийн бүсчилсэн тогтолцоо
- 3/ Монголын орон зайг байгаль орчны даацад нийцүүлэн үйлдвэржүүлэх,

кластержуулах бүсчилсэн тогтолцоо

4/ Монголын дотогшоо харсан эдийн засгийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын бүсчилсэн зохицуулалт

5/ Монголын гадагшаа чиглэсэн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсчилсэн зохицуулалт. Эдгээр 5 зорилт нь шинэ тутам бөгөөд иж бүрэн шинжтэй тул 2030 он хүртлэх хугацаанд тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр явуулах үйл ажиллагааны үйл ажиллагааг тус судалгаагаар тодруулах нь бас ач холбогдолтой байж болох юм гэж үзээд дор дурдсанаар томъёлох саналыг тайланд тусгалаа.

Зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг цаашид гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх, мөн нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулах гэсэн хоёр чиглэлээр зааглан авч үзэх боломжтой гэж үзлээ. Үүнд:

#### “Зорилт 1”-ийн хүрээнд:

1.) БХҮБ-ыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх талаар:

- Эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүсийн аймгуудын хуваарийг дунд хэмжээний бүсчлэлийн сүлжээгээр тодотгон өөрчилж, аймаг, бүс нутгийн, салбар хоорондын хоршилт, эдийн засгийн бүтэц, төрөлжилтийг сонгон хөгжүүлэх;
- Хүн амын нутагшилт, ажил эрхлэлтийн нэгдсэн Ерөнхий төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
- Хот байгуулалт, газар эзэмшилт, зохион байгуулалтын нэгдсэн Ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөдөө, орон нутагт залуу хүн тогтвортой амьдрах, шилжин суурьших “Бүсийн хөнгөлөлт – таатай орчин” гэсэн зорилтот хөтөлбөрийг шатлан хэрэгжүүлэх;

2.) Нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх талаар:

- Улаанбаатар – Төв аймгийн агломерацийг бүрдүүлж, нийслэл, Дархан, Эрдэнэт хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрлийг Төвийн бүсийн Хойт, Өмнөт хэсэгт тархаан байршуулж, бусад аймаг, хөдөөгийн хүн амын шилжин суурьших сонирхлыг татах хөгжлийн шинэ бүсүүдийг бий болгох;
- Монголын хүндийн хүчний төвийг тус орны Баруун, Зүүн жигүүрт авчрах хоёр тулгуур хотыг байгуулах үндэс суурийг тавих;
- Ард нийтийн санал асуулгын үндсэн дээр Улаанбаатар хотын нийслэлийн чиг үүргийг бусад хотод шилжүүлэх, эсвэл аймгуудыг томсгон эдийн засгийн хувьд бие даалгах бодлогын сонголтыг судалж шийдвэрлэх;

#### “Зорилт 2”-ын хүрээнд:

1.) БХҮБ-ыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх талаар:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн чадавхид түшиглан нүүдэлчдийн ахуй соёл, спорт – аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах, экосистемийн үйлчлэлээр Монголын зах зээлд өрсөлдөх нөхцлийг хангах;
  - Өргөрөгийн дагуух хөндлөн тэнхлэгийн бүсчлэлийг тогтоон Өрнө, Дорныг холбосон төмөр зам байгуулж, ногоон байгууламж, эко-парк, байгаль – түүх судлалын олон улсын төвүүдийг хөгжүүлэх;
  - Нэг буюу хэд хэдэн аймаг, сумдын нутгийг хамарсан улсын хоорондын буюу хил дамнасан бүсүүдийн ландшафт, биологийн төрөл зүйл, гол мөрний ай савуудын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээгдэх чадавхийг нь зохистой ашиглах байгаль – нийгмийн орон зайн хамаарлын хамт (нэгдсэн)-ын менежментийн тогтолцоох бүрдүүлэх;
- 2.) Нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх талаар:
- Аймаг, сум, багийн экологи – ландшафтын бүсчлэл, аж ахуйн хэв шинжийн уялдаанд тулгуурлан газар ашиглалтын функц, хөрөнгө оруулалтын чадавхийг үнэлж, салбарын байршил, төрөлжилтийн бодлогыг шинэчлэх;
  - Зах хязгаар нутаг, хил орчмын бүсийн тээвэр – газар зүйн байрлал, байгалийн баялаг, түүхий эдийн нөөцийг үнэлж, эн түрүүнд ашиглан эдийн засаг, дэд бүтцийн татах чадварыг дээшлүүлэх, Монголын иргэдийг олноор шилжин суурьших нөхцлийг дэмжин бүрдүүлэх;
  - Хөрш хоёр орны муж оронтой хил залгаа нутагт холбогдох субъектүүдтэй худалдаа – бизнесийн тогтвортой хамтын ажиллагаа, чөлөөт бүс, хил – гаалийн холбоо (бүс нутгийн бусад улс, олон улсын байгууллага оролцсон), шашин, түүх, урлаг соёл, спортын наадам цогцолсон аялал жуулчлалын цогцолбор байгуулах;

### “Зорилт 3”-ын хүрээнд:

#### 1.) БХҮБ-ыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх талаар:

- Эдийн засгийн дунд хэмжээний бүсчлэлийн хүрээнд, аймаг, орон нутгийн байгалийн баялаг, түүхий эдийн нөөцийг төр – хувийн хэвшлийн байгууллага хамтран ашиглаж, “том компани – ЖДҮҮ” хоршиж, төрөлжсөн аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх;
- Аймгуудыг хооронд нь болон улс орны томоохон төвүүдтэй холбосон “Мянганы зам” төслийг хэрэгжүүлж дуусгах, тэнхлэгийн төмөр замуудын бүтээн байгуулалтыг түргэсгэх;
- Стратегийн ордууд, ашигт малтмал ашигласны орлогын 30-аас доошгүй хувийг томсгосон аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, тэдгээрийн эдийн засгийн бие даасан байдлыг тогтвортой дээшлүүлэх;

#### 2.) Эдийн засгийн орон зайн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх талаар:

- Монгол улс 2020 оны наана Сансарын өөрийн хиймэл дагуултай болж, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгийн болзошгүй аюул

эрсдлийн цаг хугацаа, газар зүйн байршилтын нөлөөллийг шуурхай тогтоон, түүнд дасан зохицох ороон зайн менежментийн мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах;

- Эдийн засгийн уртраг, өргөргийн дагуух бүсчлэл, дэд бүтцийн таталцлын босоо, хэвтээ тэнхлэгийн дагуух ашигт малтмалын ордуудыг орчинд ивээлтэй ашиглах зохимжит загварууд, мал аж ахуйн түүхий эдийг татан авах, бүтээгдэхүүнийг нийлүүлэх зах зээлийн сувгуудыг тогтоох үндсэн дээр улс орноо үйлдвэржүүлэх алс хэтийн зураглал, төсөөлөлтэй болох;
- Томоохон компанийн аж ахуйн зах зээлийн харилцааны нутаг дэвсгэрийн зохистой бүтэц, байршилт, төрөлжилтийн чиглэлийг тогтоож, тэр хүрээнд хувийн хэвшилтэй хамтран улс орон, бүс нутгийн эдийн засгийн өсөлт, тэнцвэрийг хангах хамтын сонирхол нийцсэн хөгжлийн бүс нутгууд үүсэх нөхцлийг төрөөс дэмжин зохицуулах;
- Аж үйлдвэржүүлэлтийн зураглал, иж бүрэн төслийн үндсэн дээр тохиромжтой бүс нутагт Монголын онцлогт нийцсэн, эн түрүүнд үр дүнгээ өгөх, тогтвортой хөгжлийн жишиг болох кластеруудыг мал аж ахуй – хөнгөн хүнсний, шинжлэх ухаан – үйлдвэрлэлийн, оюуны боловсрол – соёлын чиглэлээр сонгон авч, хатуу, зөөлөн дэд бүтцийг нь хамтад нь цогцлоон байгуулах;

#### “Зорилт 4”-ийн хүрээнд:

1.) БХҮБ-ыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх талаар:

- Эдийн засгийн дунд түвшин (эсвэл томсгосон аймгууд)-ий бүсчлэлийн хүрээнд хөрөнгийн бирж, үнэт цаас, банк, санхүү, зээл, даатгалын зөөлөн дэд бүтцийн сүлжээг бүрдүүлж, бүс нутгийн зах зээлийн чадамжийг дээшлүүлэх;
- Эдийн засгийн өсөлтийн төвүүд, улс хоорондын тээвэр – хөгжлийн тэнхлэгүүдийн таталцлын орон зайд бүс нутгийн хөгжлийг дэмжсэн дотоод, гадаадын хоршиж, төрөлжсөн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг татвар, газрын төлбөр, зээлийн бодлогоор дэмжих;

2.) Эдийн засгийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх талаар:

- Тухайн улсын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу Монголын сул хөгжилтэй бүс нутагт хөгжингүй орны компани пүүсүүд салбараа нээж, хоршин ажилласан нөхцөлд байгалийн баялгийг концессоор, газрыг урт хугацааны түрээсээр ашиглуулах асуудлыг судалж шийдвэрлэх;
- Хөрш болон хөгжиж буй орны шилдэг туршлага, хөрөнгө оруулагчдын оролцоонд тулгуурласан Монголын бүсүүдэд чөлөөт худалдаа, аялал жуулчлал, хил гаалийн бүс, үйлдвэрлэл – технологийн парк, кластерыг хүмүүсийн бизнесийн мэдлэг чадвар, эдийн засгийн өсөлтийг хангах шалгуураар шинэчлэх байгуулж ажиллуулах;

#### “Зорилт 5”-ын хүрээнд:

1.) БХҮБ-ыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх талаар:

- Монголын Баруун, Төв, Хойт, Зүүн бүсийн чиглэлээр ОХУ, БНХАУ-ын хил зэргэлдээ муж, БН улс, өөртөө засах орон, Казахстан улстай тогтоосон худалдаа – эдийн засаг, хил гааль, аялан зорчих, суралцах, мэдлэг мэдээлэл солилцох, багйаль орчноо хамтран хамгаалах хэлхээ холбоог өргөжүүлж, төрөлжүүлэхийн хамт аль боломжтой тал, салбарт хоршиж, төрөлжсөн үйлдвэрлэл, үйлчилгээний газар байгуулахыг дэмжих;
- Монголд ажиллаж буй НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, олон улсын төржлсөн байгууллага (ДБ, АХБ г.м) болон гадаад орны хамтын ажиллагааны байгууллагууд (ЖАЙКА, КОИКА, ГХАН, Швейцарийн хөгжлийн агентлаг г.м)-ын Монголын хот, хөдөөгийн хүүхэд залуусыг дотоод, гадаадад сургах, ажил мэргэжлийн баримжаа олгох, орон нутгийн эдийн засаг, засаглал, хот суурин байгуулалт, бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн талаар явуулж байгаа үйл ажиллагаа, зөвлөмжийг төр, нийгмийн бодлогод тусган хэрэгжүүлэх удирдлага, хяналт, шинжилгээний тогтолцоог сайжруулах;

2.) Эдийн засгийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх талаар:

- Монголын газар зүйн байршлын онцлог, чадавхийн дагуу орчин үеийн даяаршил, интеграцчилал, хөрш орнуудын геополитикийн өөрчлөгдөж байгаа чиг хандлагыг тусгасан гео-эдийн засгийн бүсчлэлт, нийгмийн орон зайн бүтэц, байршилыг тогтоож, үндэсний аюулгүй байдлын болон гадаад харилцааны бодлогод тусган хэрэгжүүлэх;
- Ази – Европ, Өрнө, Дорныг холбосон төмөр ба авто зам, мэдээлэл харилцаа холбоо, худалдаа – аялал жуулчлалын сүлжээг сайжруулж, Монгол – Орос – Хятад гурван улсын хамтарсан эдийн засгийн коридор байгуулах үйл явцад түлхэц үзүүлж, Монголын орон зайн бүтцийг сайжруулах алсын хараа болгож ашиглах;
- Зүүн Хойт Азийн орнуудын уулзалтыг яриа, хэлцлийн түвшнээс улс төр – эдийн засгийн бодит үйл ажиллагааны талбар болгоход түлхэц өгч, эдгээр оронтой чөлөөт худалдаа, эрчим хүч, зам тээвэр, байгалийн хий дамжуулах, спорт – соёлын аялал жуулчлал хөгжүүлэх мэргэжилтэн сургаж бэлтгэх зэргээр стратегийн байнгын түншлэл тогтоох

## **5.2. Бодлогын хувилбаруудын SWOT шинжилгээ**

Энэхүү судалгаанд, “Хөгжлийн бодлогын бримт бичиг боловсруулах нийтлэг журам /Засгийн газрын 2016 оны 249-р тогтоолын хавсралт/-ын 9/13 –д заасны дагуу бүсчилсэн хөгжлийн одоо ба цаашдын төлөвийн нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр Бүсчилсэн хөгжлийн 2030 он хүртэлх



стратегийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх бодлогын дор дурдсан 3 үндсэн хувилбар /буюу сонголтууд/ -ыг энэхүү судалгаанд харьцуулан авч үзсэн болно. Үүнд:

**“А” хувилбар:** Засаг захиргаа – нутаг дэвсгэрийн одоогийн хуваарь, түүнд түшиглэсэн төрийн удирдлагын босоо тогтолцоог хэвээр хадгалах;

**“Б” хувилбар:** Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн нэгжүүдийг нэгтгэн томсгож, эрх хэмжээг нь өргөтгөн, төрийн удирдлага зохицуулалтын босоо, хэвтээ хосолсон тогтолцоог ашиглах;

**“В” хувилбар:** Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хэвтээ тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх.

Арга зам: Бүх чиглэл, түвшинд төвлөрлийг сааруулж, аймаг, сум, хот, хөдөө, салбар хоорондын уялдаа, хоршилтыг сайжруулах, улсын болон бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн өсөлт, тэнцвэрийг хангах чиглэлээр боловсруулахаар товлосон **“эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах”** бодлогын баримт бичигт тавих зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд дор дурдсан гурван үндсэн хувилбарыг авч үзэх боломжтой гэж үзэн, СВОТ шинжилгээ хийж байна.. Үүнд:

**“А” хувилбар:** Засаг захиргаа – нутаг дэвсгэрийн одоогийн хуваарь, түүнд түшиглэсэн төрийн удирдлагын босоо тогтолцоог хадгалах;

**“Б” хувилбар:** Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчилж, төрийн удирдлагын босоо, хэвтээ хосолсон тогтолцоог ашиглах;

**“В” хувилбар:** Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хэвтээ тогтолцоог бүрдүүлэх. Бодлогын хувилбаруудыг хооронд нь харьцуулж, сонгох боломжийг харуулахын тулд 5 баллын үнэлгээний аргыг сонгон авсан болно. Бүсчилсэн хөгжлийн 2030 он хүртэлх ойрын 10 жилийн хугацаанд тавигдах бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх боломж, бэрхшээл, давуу ба сул талын хүчин зүйлсийн нөлөөллийн зэргийг дараах байдлаар оноо өглөө. Үүнд:

- хэрэв хүчин зүйлсийн нөлөө их байгаа бол 4-ээс 5 оноо
- хэрэв нөлөөлөл нь дунд зэрэг байхаар бол 3-аас 4 оноо
- хэрэв үзүүлэх нөлөө нь бага байгаа бол 1-ээс 2 оноос өгч үнэлэв.

Гол шалгуур үзүүлэлтийн асуудал бүрээр өгсөн онооны ердийн арифметик ик дундажийг гаргаж, эцэст нь бүх үзүүлэлтийн оноог нэгтгэн дундачилж, уг бодлогын хувилбарын боломж ба бэрхшээл, давуу ба сул талыг тоймлон дүгнэх оролдлого хийсэн.

## I. БОЛОМЖ БА БЭРХШЭЭЛ:

***А. Засаг захиргаа – нутаг дэвсгэрийн одоогийн хуваарь, төрийн удирдлагын босоо тогтолцоог хадгалах хүрээ***

Гол чиглэл: Одоогийн аймаг, нийслэл, сум, баг, дүүрэг, хороо, хот, тосгон, тэдгээрт түшиглэсэн төрийн удирдлагын тогтолцоог үндсэнд нь хадгалж, энд буй болсон чадавхиар орон зайн харилцааны менежментийг сайжруулах.

1. СВОТ шинжилгээ:


Гол үзүүлэлт	Боломж	Оноо	Бэрхшээл	Оноо
Удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>• УИХ, Засгийн газрын бүс нутгийн хөгжлийг зохицуулах эрх хэмжээг нутгийн удирдлагад шилжүүлэх</li> </ul>	2	<ul style="list-style-type: none"> <li>• УИХ, орон нутгийн сонгуулийн одоогийн систем</li> </ul>	4
	<ul style="list-style-type: none"> <li>• Иргэдийн хурлын эрх хэмжээг өргөжүүлэх</li> </ul>	1	<ul style="list-style-type: none"> <li>• Улстөрийн намуудын нөлөөлөл</li> <li>• Иргэдийн хурлын одоогийн чадамж, байр суурь</li> </ul>	4
	<ul style="list-style-type: none"> <li>• БХУЗ-ын хууль тогтоомжийг бусад хуульд нийцүүлж, эрх зүйн нэгдмэл зохицуулалтыг бий болгох</li> </ul>	2	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөв, татварын нэгдсэн (төвлөрсөн) тогтолцоо</li> </ul>	3

Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Нэгдсэн (макро) болон салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүсчилсэн хөгжлийн асуудлыг тусгах (тусад нь зүйл анги болгох)</li> </ul>	3	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийн талаарх ойлголт бүх түвшинд хангалтгүй</li> <li>• Бүс нутгийн хөгжил, хот байгуулалтын төлөвлөгөө, зураг төслийн уялдаа, зохицуулалт хангалтгүй</li> </ul>	4
	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, сумын хөгжлийн цогц бодлого, хөтөлбөрийг үргэлжлүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн чадавхийг бэхжүүлэх</li> </ul>	3		3
Бодит үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, нийслэлийн хүрээнд сум, дүүрэг, багийн хамтын ажиллагаа, хоршилтыг сайжруулах</li> </ul>	3	<ul style="list-style-type: none"> <li>• Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хоршиж ажиллах санаачилга, оролцоо дутмаг</li> <li>• Төвлөрөл, ялангуяа хүн амын хот руу олноор шилжих хөдөлгөөн</li> </ul>	4
	<ul style="list-style-type: none"> <li>• Бүс нутгийн дэд бүтцийн (хатуу) сүлжээг бэхжүүлэх</li> </ul>	4		4
Зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>• Яам, газар, аж ахуйн нэгж, бүсчилсэн уулзалт, зөвлөлгөөнийг үргэлжлүүлэх</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн бодлогод дэмжлэг үзүүлж ирсэн удирдлага – зохион байгуулалтын бүтэц (БХҮХ, БЗ, БХ, БХС) татан буугдсан</li> <li>• Бүс нутаг, хот төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтэнд хөндлөнгийн</li> </ul>	4
	<ul style="list-style-type: none"> <li>• Төр, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын бүс нутгийн хөгжлийн бодлого, хот суурины төлөвлөгөөний хэрэгжилтийн албан ёсны хяналт, үнэлгээг сайжруулах</li> </ul>	3		3

			үнэлгээ хийдэг журам тогтоогүй	
--	--	--	-----------------------------------	--

**Жишээ нь:** I нийлбэр (2+1+2+3+3+3+4+4+3)=25, II нийлбэр (4+3+4+3+4+4+4+3)=37  
 Ерөнхий дундаж I: 25:9 (асуудлын тоо)=2.7,  
 II: 37:9 (асуудлын тоо) = 3.7

**Бодлого сонгох – Орчны тэнхлэг:**



**Б. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчилж, төрийн удирдлагын босоо, хэвтээ хосолсон тогтолцоог ашиглах хүрээнд**

Гол чиглэл: Эдийн засгийн бүсчлэлд үндэслэн зах зээлийн солилцоо, үйлдвэрлэл үйлчилгээний хоршилт, төрөлжилт, эдийн засгийн бие даасан хөгжлийн шалгуураар аймаг, сумдыг томсгон нэгтгэж, бүс нутгийн удирдлагын тогтолцоонд шилжих

	Гол үзүүлэлт	Боломж	Оноо	Бэрхшээл	Оноо
Босоо чиглэлийн	Удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн удирдлага зохицуулалт (Ерөнхийлөгч, УИХ, ЗГ-ын түвшинд) хөгжлийг бүсчлэн зохицуулах эрх хэмжээг зааглаж, хуульчлан тогтоох</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>Үндсэн хууль хэрхэн өөрчлөгдөх, Монгол улс ямар загвараар хөгжих болон УИХ, Засгийн газрын эрх үүргийн тодорхойгүй байдлууд</li> </ul>	4


	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газар (яам, агентлаг)-ын зарим эрх хэмжээг Аймгийн ЗД-д шилжүүлэх (төсөв, санхүүгийн хамт)</li> <li>• Төр, засгийн оролцоог багасгах</li> </ul>	4 4	<ul style="list-style-type: none"> <li>• УИХ, Засгийн газрын бүтэц, орон тоо өргөжин, төвлөрсөн удирдлагын зардал нэмэгдэж байгаа байдал</li> </ul>	4
Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Улсын (нэгдсэн) төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлого хөтөлбөрт бүсчилсэн хөгжлийн асуудлыг (төсөв санхүүгийн эх үүсвэрийн хамт) тусган батлах</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний хөгжлийн (бүсчилсэн хөгжлийг тусгасан) үзэл баримтлал шинээр тодорхойлогдоогүй</li> <li>• Нэгдсэн улсын төсөв, татварын одоогийн тогтолцоо цаашид хадгалагдах</li> <li>• Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн шинжлэх ухаан – арга зүй, мэдээлэл – технологийн бааз бүрдээгүй</li> </ul>	3 4 3
Бодит үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Томсгосон аймгуудад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын харилцан түншлэл хөгжих</li> <li>• Засгийн газар, томсгосон аймгуудын захиргааны удирдлагын хооронд ажил төрлийн байнгын холбоо тогтох</li> </ul>	4 4	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн оролцоо, зохицуулалтыг цаашид ч хадгалах хүнд суртал</li> <li>• Засгийн газар, гадаадын хөрөнгө оруулагчид, компани (нэгтгэл)-ийн хоорондын харилцан зөвшилцөл хангалтгүй</li> <li>• Аймгуудад бүсчилсэн зохицуулалт хийх мэргэжлийн чадвар туршлага дутмаг</li> </ul>	4 4 4
Зохион байгуулалт, хяналт – шинжилгээ,	<ul style="list-style-type: none"> <li>• Төрөөс дэмжин зохицуулж буй бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын зүгээс томсгосон аймгуудын захиргааг хэрхэн удирдаж,</li> </ul>	4

	үнэлгээ	хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг нь үнэлж тайлагнах Засгийн газар болон томсгосон аймгийн удирдлагын харилцан мэдээлэл, холбоо сайжрах		чиглүүлэх тогтолцоо бүрдээгүй		
Хэвтээ чиглэлийн	Гол үзүүлэлт	Боломж	Оноо	Бэрхшээл	Оноо	
	Удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилэн хөгжлийн асуудлаар аймгууд (тэдгээрийн дотор сумдын)-ын ИТХ-ын эрх хэмжээг хуульчлан өргөтгөх</li> <li>• Бүс нутгийн хөгжилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоо, дэмжлэг нэмэгдэх</li> </ul>	3	<ul style="list-style-type: none"> <li>• Томсгосон аймгууд төрийн нэгдсэн удирдлагаас зайлсхийх, төвөөс зугтах хандлага гаргах</li> <li>• Төрийн төв байгууллагын эрх мэдэл, оролцоо их</li> <li>• Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүсчилсэн хөгжлийг удирдах чадамж сул, аймгийн захирагчтай хэрхэн харилцах хууль, ёс зүйн зарчмыг нарийвчлан тогтоох</li> <li>• Иргэд, ААН байгууллагын оролцоо дэмжлэгийг хангах явдал их урт хугацаа, байнгын зохицуулалт шаардах</li> </ul>	4	4
	Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Томсгосон аймгуудын хүрээнд бүс нутгийн хоршилтыг тусгасан тогтвортой хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгуудад бүс нутаг, хот байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах мэргэжил – арга зүйн чадавхийг шинээр бүрдүүлэх</li> </ul>	4	4

	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгуудын хөгжлийн иж бүрэн төлөвлөлтөнд салбар, салбар хоорондын зорилт арга хэмжээг тусгах</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Салбар яамдын босоо удирдлага, аймгуудын хэвтээ төлөвлөлтийн байнгын уялдааг хангах</li> </ul>	4
Бодит үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Байгаль түүхий эдийн нөөцөд түшиглэсэн бүс нутгийн эдийн засгийн оновчтой бүтэц бүрдэх, тэдгээрийн хоорондын хоршилт, аж ахуйгаа бие даан хөтлөх чадвар дээшлэх</li> <li>• Иргэд, байгууллагын оролцоог хангахад орон нутгийн хөгжлийн сангийн үүрэг ролийг дээшлүүлэх</li> <li>• Аймгууд, дотоод, гадаад зах зээлд үр ашигтай оролцох нэгдсэн сүлжээ бүрдэх</li> </ul>	3  4  4	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, сумдын нутгархаг, үндсэрхэх явцуу үзэл хандлага</li> <li>• Бүс нутгийн хөгжилд иргэд, ААН-ийн хамтын сонирхол, оролцоог хангах</li> <li>• Орон нутгийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх төрийн дэмжлэг, зохицуулалт дутах</li> </ul>	5  4  3
Зохион байгуулалт, хяналт – шинжилгээ, үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>• Томсгосон аймгийн хүрээнд сум, хот, суурингийн удирдлага, иргэд, ААНБ-ын ажил төрлийн байнгын уялдаа зохицуулалтыг хангах ИТХ, ЗД, компанийн удирдлагаас бүрдсэн хамтын зөвшилцлийн механизм бүрдэх</li> <li>• Бүс нутаг, хот байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд мониторинг хийх, үр дүнг үнэлэх тогтолцоо бүрдэх</li> </ul>	3  4	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газар (яамд), аймгуудын захирагч нарын зөвшилцөх ажил төрлийн уялдааг хангах нэмэлт зохицуулалт шаардагдах</li> <li>• Бүс нутаг, салбар хоорондын төлөвлөгөө, төслийн хэрэгжилт, боловсруулалтын уялдааг Засгийн газар, аймгийн түвшинд хангах нэгдсэн арга, мэдээлэл – хяналтын баазыг бүрдүүлэх</li> </ul>	4  3

Ерөнхий дундаж : /боломж/ : 62:16 = 3.8, /бэрхшээл/: 74:20 = 3.7

### Бодлого тодорхойлох –Орчны тэнхлэг.



### В. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хэвтээ тогтолцоог бүрдүүлэх

Гол чиглэл: Нутаг дэвсгэрийн хөгжлийн төрийн удирдлагын босоо чиглэлийн нэгдсэн, шууд тогтолцоог хадгалах

- Монголын газар нутагт тогтвортой хөгжлийн дэвшил, тэнцвэрийг хангах бүсчилсэн зохицуулалтын арга хэрэгсэлийн тогтолцоог бүрдүүлэх


Гол үзүүлэлт	Боломж	Оноо	Бэрхшээл	Оноо
Удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>•Төрийн (ҮАБ-ын зөвлөл, УИХ, ЗГ, аймаг, нийслэл) бүсчилсэн зохицуулалтын эрх зүйн болон ёс зүйн зохицуулалт, зөвшилцлийн механизмыг бүрдүүлэх</li> </ul>	3	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн тогтвортой удирдлага, бодлогын залгамж байдлыг хангах</li> </ul>	4
			<ul style="list-style-type: none"> <li>• Улс төрийн намуудын нөлөөлөл</li> </ul>	4
			<ul style="list-style-type: none"> <li>• БХҮБ сайн хэрэгжээгүйгээс олон</li> </ul>	4



	<ul style="list-style-type: none"> <li>• Мөн ОУБ, харш ба бүс нутгийн орнуудтай улс үндэстэн дамнасан геополитик, геоэкономикийн асуудлыг бүсчилэн зохицуулах гэрээ, хэлцэл байгуулах, хэрэгжих нийтлэг хэм хэмжээг тогтоох</li> </ul>	3	<p>нийтийн үзэл ойлголт, итгэл үнэмшил буурсан</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийн болон дотоодын эдийн засгийн өсөлт, хуримтлалыг хязгаарлагч хүчин зүйлс (байгаль уур амьсгал, хөрөнгө санхүү, хүн хүч, технологи г.м)</li> </ul>	4
Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн макро, мезо, микро бүсчлэлийн хүрээнд хөгжлийн төлөвлөлтийн салбар, бүс нутаг, улс хоорондын уялдааг хангах</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн бодлого, зохицуулалтын арга хэмжээ Улсын хөрөнгө оруулалт, төсөв санхүүгийн төлөвлөгөөний уялдаа хангалтгүй</li> <li>• Бүсчилсэн төлөвлөлт яам, салбар хоорондын, бүс нутаг (аймаг, хот хоорондын) хоорондын уялдааг хангах нэгдсэн зохицуулалт бүрдээгүй</li> <li>• Аймаг, сумдын “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн бүсчилсэн хөгжлийн санхүүжилтийн эх үүсвэр хангалтгүй, үүнийг улсын төсвөөс дэмжих боломж хязгаарлагдмал байгаа (ойрын ирээдүйд ч гэсэн)</li> </ul>	4
	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын асуудлыг улсын хөрөнгө оруулалт, ДХТХМ, төсвийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх стратегийн төлөвлөлтийн шалгуур үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишгийн дагуу тогтоож мөрдөх</li> </ul>	4		4
	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлийн холбоодоор дамжуулан компани, ААНБ-ыг бүс нутгийн хөгжлийн нийтлэг бодлогыг тодорхойлоход оролцуулах</li> </ul>	3		4
	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн бодлогод салбар, аймаг, бүс нутгийн эрэлт, хэрэгцээг тусгах цахим төлөвлөлтийн арга зүй – мэдээллийн баазыг бүрдүүлэх</li> </ul>	4		4
Бодит үйл	• Эдийн засгийн		• Төрийн	



**Бодлого тодорхойлох –Орчны тэнхлэг.**



**II. ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ**

**А. Засаг захиргаа – нутаг дэвсгэрийн одоогийн хуваарь, төрийн удирдлагын босоо тогтолцоог хадгалах хүрээ**


Гол чиглэл: Одоогийн аймаг, нийслэл, сум, баг, дүүрэг, хороо, хот, тосгон, тэдгээрт түшиглэсэн төрийн удирдлагын тогтолцоог үндсэнд нь хадгалж, энд буй болсон чадавхиар орон зайн харилцааны менежментийг сайжруулах.

Гол үзүүлэлт	Давуу тал	Оноо	Сул тал	Оноо
Удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>Бүс нутгийн хөгжлийн талаар төрийн удирдлага, хяналт сайжрах</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн босоо удирдлага, хяналт хүчтэй болж, зах зээлд төрийн оролцоо нэмэгдэнэ.</li> <li>Аймаг, орон нутагт иргэд, ААНБ-ын бүтээлч үүсгэл санаачилга суларна.</li> </ul>	4 5

Төлөвлөлт		• Бүсчилсэн хөгжлийн асуудлаар нэгдсэн (макро) төлөвлөлт (төсөвлөлт)-ийн үүрэг дээшилнэ.	4	• Бүсчилсэн зохицуулалтаар дамжин төвлөрсөн төлөвлөгөөт удирдлага эргэж сэргэх • Засгийн газрын байгууллагуудын төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааны ачаалал төвөгшин нэмэгдэх	3
		• Орон нутгийн төлөвлөлтийн хариуцлага ба хөгжлийн сангийн эх үүсвэр нэмэгдэнэ.	4		4
Бодит ажиллагаа	үйл	• Аймаг, хот, сумдыг холбосон дэд бүтэц (хатуу)-ийн байгууламж цаашид сайжрах • Бүсүүдэд үйлдвэр, үйлчилгээний газруудыг аймаг, сум дундын зориулалтаар барьж байгуулах	5	• Улсын төсвийн санхүүжилтийн ачаалал ихэсч, эдийн засгийн өсөлт саарах, хяналт байдал цаашид үргэлжлэх • Зах зээлийн зохицуулалт алдагдаж, бүс нутагт зөөлөн дэд бүтэц (банк, санхүү, даатгал, бирж г.м) байгуулагдах үйл ажиллагаа удаашрах	4
			3		4
Зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ	–	• Засгийн газар, аймаг, орон нутгийн удирдлагын байнгын уулзалт, зөвлөлгөөн сайжрах • Хяналт – шинжилгээ үнэлгээ хуулийн дагуу тогтмол хийгдэх хариуцлага тооцогдох	4	• Засгийн газрын байгууллагуудын бүтэц, орон тоо нэмэгдэх • Хөгжлийн үр дүнд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх ажил сулрах	4
			4		4

Ерөнхий дундаж /давуу тал/ : 28:7= 4.0 , /сул тал/: 32:8 = 4.0

**Бодлогын сонголт - орчны тэхлэг:**




**Б. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчилж, төрийн удирдлагын босоо, хэвтээ хосолсон тогтолцоог ашиглах хүрээнд**

Гол чиглэл: Эдийн засгийн бүсчлэлд үндэслэн зах зээлийн солилцоо, үйлдвэрлэл үйлчилгээний хоршилт, төрөлжилт, эдийн засгийн бие даасан хөгжлийн шалгуураар аймаг, сумдыг томсгон нэгтгэж, бүс нутгийн удирдлагын тогтолцоонд шилжих

Гол үзүүлэлт	Давуу тал	ОНО	Сул тал	ОНО
Удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн шууд зохицуулалт, хянах үүрэг багасах</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн нэгдсэн удирдлага, түүнийг хүлээн авах шаардлага сулрах</li> </ul>	3
	<ul style="list-style-type: none"> <li>Аймгуудын төв, засаг, төрийн дэмжлэгээс хамаарал багатай бие даан хөгжих хүч чармайлт нэмэгдэх</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>Тогтвортой хөгжлийн орон зайн тэнцлийг хангах, төрөөс шууд нөлөөлөх боломжууд хүндрэх, төвөгтэй болох</li> </ul>	4
	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр, удирдлагын эрх хэмжээ нэмэгдэх</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>Улсын хөрөнгө оруулалт, нэгдсэн төсвийн санхүүжилтийн</li> </ul>	4

			чадавх, хуримтлал багасах	
Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын үйл ажиллагаанд дунд болон урт хугацааны нэгдсэн ба салбарын төлөвлөлт, төсөөллийн чадавх нэмэгдэх</li> <li>• Аймгууд (томоохон)-ын бүс нутаг – хот байгуулалт, салбарын төлөвлөлтийн уялдаа, хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр сайжрах</li> </ul>	4  4	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын төсөв, санхүүгийн зохицуулалтын ачаалал нэмэгдэх</li> <li>• Томсгосон аймгуудын хөгжлийн арга хэмжээний төлөвлөлтийн хэрэгцээ, төсөв санхүүгийн боломжийн тэнцэл хангагдахгүй болох</li> </ul>	3  4
Бодит үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгууд эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаа бие даан шийдвэрлэж эхлэх</li> <li>• Аймгууд хөрш хоёр орны субъектүүдтэй тогтвортой холбоо тогтоож, гадаад зах зээлээ өргөтгөн хөгжүүлэх</li> <li>• Аймгууд сумдаа бүсчлэн хөгжүүлэх, бие даалгах арга хэмжээг дотроо авч хэрэгжүүлэх</li> </ul>	4  4  5	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын байгууллагуудтай тогтоосон босоо чиглэлийн байнгын холбоо сулрах</li> <li>• Бүс нутгийн хөгжлийн асуудлаар аж ахуйн нэгж байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа зөрөх</li> </ul>	4  4
Зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгууд дотоод, гадаад зах зээлд хөгжлийн түншүүдтэй гэрээ хэлцэл байгуулах, ажил төрлийн уулзалт зохион байгуулах асуудлаа бие даан шийдэх</li> <li>• Бүс нутгийн хөгжлийн бодлогод хяналт – шинжилгээ, үнэлгээ өгөх, үр дүнг Засгийн газарт бие даан тайлагнах</li> </ul>	4  4	<ul style="list-style-type: none"> <li>• Төв Засгийн газрын зарим бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй зөрчилдөх</li> <li>• Засгийн газрын бүс нутгийн хөгжилд байнгын хяналт – шинжилгээ, албан ёсны ба хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажил удаашрах (хойшлогдох)</li> </ul>	3  3

Ерөнхий дундаж /давуу тал/: 41:10 = 4.0, /сул тал/: 32:9 =3.5



**В. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хэвтээ тогтолцоог бүрдүүлэх**

Гол чиглэл: Нутаг дэвсгэрийн хөгжлийн төрийн удирдлагын босоо чиглэлийн нэгдсэн, шууд тогтолцоог хадгалах

- Монголын газар нутагт тогтвортой хөгжлийн дэвшил, тэнцвэрийг хангах бүсчилсэн зохицуулалтын арга хэрэгсэлийн тогтолцоог бүрдүүлэх


Гол үзүүлэлт	Давуу тал	Оноо	Сул тал	Оноо
Удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>•Төрийн удирдлагын нэмэлт төсөв зардал шаардахгүй</li> <li>•Төрийн зохицуулалт, хяналтын эрх зүйн үндсийг сайжруулах</li> </ul>	5 4	<ul style="list-style-type: none"> <li>• Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын төв, орон нутгийн байгууллага, улс төр, ОНБ, Мэргэжлийн холбоод, компани, пүүсийн байнгын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэг зохицуулалт шаардах учир аль нэг талд доголдол, тасалдал гарах магадлалтай</li> </ul>	4

			<ul style="list-style-type: none"> <li>• УИХ-д бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөө, төсөв, санхүү, татвар, төлбөрийн тэнцэл, хуваарилалт, шилжүүлгийг зөв шийдэхэд төвөгтэй байдал байнга үүсэх</li> </ul>	4
Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, хот, үндэстэн дамнасан салбар хоорондын, бүс нутаг хоорондын хөгжлийн цогц асуудлыг бодитой шийдэх иж бүрэн шаталж уялдсан (хэвтээ, босоо чиглэлээр) төлөвлөлт (нэгдсэн, бүс нутаг, салбарын хөтөлбөр, төсөл, хэтийн төсөөлөл г.м)-ийн шинжлэх ухаан – арга зүй, мэдээлэл – зохион байгуулалтын нэгдмэл үндэс бүрдэх</li> <li>• Хөгжлийн төлөвлөгөөг төсөв, хөрөнгө оруулалтын нөөц боломжтой уян хатан зохицуулах</li> </ul>	5	<ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бодлого, төлөвлөлтөнд оролцогч талууд (төр, иргэн, ААНБ дотоод, гадаадын ХО)-ын ашиг сонирхлыг бүрэн хангаж нийцүүлэхэд бэрхшээлтэй, аль нэг тал дээр зөрчилдөөн үүсэх</li> <li>• Төр, Засгийн газарт орон нутаг, салбарын явцуу ашиг сонирхлыг нэгтгэх нэмэлт хүндрэл, ачаалал үүсэх</li> </ul>	5
		4		4
Бодит ажиллагаа үйл	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн макро, мезо-, микро бүсчлэл, салбарын бүсүүдийн хүрээнд нийгмийн орон зайн зохион байгуулалтыг шинэчлэх дүр зураг, алсын хараа бүрдэж, макро эдийн засаг тогтворжих хандлагад орох</li> <li>• Бүсүүдийн хүрээнд аймгууд аж ахуйн бүтэц хоорондын хоршилт, төрөлжилтийнхөө чиглэлийг тогтоож,</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Төв, орон нутгийн хөрөнгө, санхүүгийн нөөцийн дайчлалт төрийн бодлогын залгамж чанараас хамаарч бүсчилсэн хөгжлийн нийтлэг арга хэмжээ, цаг хугацаа, орон зайн хувьд тасалдах, удаашрах</li> <li>• Үйл ажиллагаа бүр дээр (ялангуяа байгаль орчны асуудлаар) төр, хувийн хэвшлийн гэрээ, харилцан сонирхлыг</li> </ul>	4
		4		3



	<p>нөөцдөө түшиглэн дэс дараатай, алсын хараатай шийдэх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүсчлэлийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага дотоод, гадаад зах зээлд оролцох чиглэл, үйлдвэрлэл, үйлчилгээгээ байршуулах газраа сонгох, нэмүү өртгийн сүлжээ бүрдүүлэх чиглэлээр бодитой алхам хийх</li> <li>• Бүсүүд чадавхжихийн хэрээр хүн амын суурьшилт тогтворжиж, нийслэлийн хэт төвлөрөл багасах</li> </ul>	4	байнга нийцүүлж, шаардлагатай үед нэмэлт зохицуулалт, тодотгол хийж байх, холбогдох хязгаарлалт буюу удаашрууллын арга хэмжээ авах /алдагдсан боломжийг ашиглах/	
Зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчлэлийн шатлал бүрд уулзалт, ярилцлага хийж, ажил төрлөө уялдуулах зохион байгуулалтын зардал багатай тогтолцоо бүрдэх (алсын зайн сургалт, уулзалт хийх)</li> <li>• Бүсчилсэн хөгжлийн бодлого тодорхойлох, хэрэгжилтийг үнэлж дүгнэх ажилд шинжлэх ухааны ТББ-ыг оролцуулж, тэдний санал зөвлөмжийг тусгаж байх</li> <li>• Бодлогын хэрэгжилтийн хяналт – шинжилгээ, үнэлгээний ажилд цахим төлөвлөлт, мэдээлэл – технологийн зарчим нэвтрүүлэх</li> </ul>	4	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газар, тухайлбал, Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан яам, агентлаг, аймаг, нийслэлийн холбогдох албадын үйл ажиллагааг байнга уялдуулах, мэргэжилтнүүдийг сургах, мэргэшүүлэх урсгал зардал ихээр шаардах</li> </ul>	4

Ердийн дундаж /давуу тал/:  $46:11 = 4.2$ , /сул тал/:  $28: 7 = 4.0$



Ерөнхий дүгнэлт: Дээр дурдсан SWOT үнэлгээний дүнг харьцуулахад, “Б” хувилбарыг хэрэгжүүлэх улс төрийн зоримог шийдвэр гаргавал бүсчилсэн хөгжлийн бодлого, зохицуулалтыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэхээр байгаа юм. Гэвч энэ асуудлыг шийдэхэд төвөгтэй, бөгөөд шинэ хуваарьт орлоо гэхэд их хугацаа, зардал чирэгдэл гарч хэрэгжилт удааширч болзошгүй байна.

### Ашигласан материал

Бодлогын хувилбаруудын гарах үр дүн, шалгуур үзүүлэлтийн хамаарлын үнэлгээ, мөн хувилбар бүрийн давуу ба сул талд хийсэн SWOT шинжилгээнээс үндэслэн, “В” буюу **Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хэвтээ тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх хувилбарыг Бүсчилсэн хөгжлийн 2030 он хүртэлх бодлогын гол сонголт болгон авч үзэх урьдчилсан саналтай байна.** Харин дээр дурдсан журамд, бодлогын 2-иос доошгүй сонголт байж болно гэсний дагуу төр засгийн шийдвэр, иргэний нийгэм, олон нийтийн санаа бодол нэгдэн нийлсэн тохиолдолд “Б” хувилбар дахь “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн одоогийн хуваарийг аймаг, сумдын эдийн засгийн бие даасан байдлыг хангах боломж, шаардлагад нийцүүлэн хэсэгчилэн өөрчлөх” хувилбарыг эдийн засгийн дунд болон бичил бүсэд (мөн салбарын бүсчлэл)-д үндэслэн “В” хувилбартай зэрэгцүүлэн (хослуулан) хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Энд хэрэв “Б” хувилбар ойрын үед улс төр, эдийн засгийн бодит шалтгаанаас үүдээд нааштай өөрчлөлд авчрахааргүй удааширвал “В” шийдлийг давхар хэрэгжүүлж болно гэсэн санаа юм. Бидний дэвшүүлж байгаа таамаглал хоёр үндсэн санааг агуулж байгаа юм. Үүнд:

Нэгдэх нь, БХҮБ-д тусгасан Монголын нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрөл (ялангуяа хот

байгуулалтын)-ийг сааруулах урт хугацааны цогц бодлогоор үндэсний (гадаад орчин ороод), салбарын аймаг, бүс нутгийн бүх түвшинд төлөвлөн тодорхойлж, эдийн засгийн том, дунд (мезо-) ба бичил бүсчлэлийн нэгдсэн сүлжээ, тогтвортой хөгжлийн өсөлт, тэнцвэрийг хангаж чадахуйц таталцлын олон төвүүд (шинжлэх ухаан – технологи – мэдээллийн болон нүүдэлчдийн ахуй – соёлын паркууд, кластерууд бүхий өсөлтийн бүс нутгууд, тээвэр – ложистик, эдийн засгийн коридорууд г.м)-ээр дамжуулан хэрэгжүүлэх;

Хоёрдахь нь, хэрэв нэгдэх хувилбар дээр бодлого зохицуулалтын залгамж, тууштай байдал алдагдах юмуу суларвал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн нэгдэн нийлж, эдийн засгаа бие даан авч явах чадамж, хотуудын төвлөрлийн үр ашиг, таталцлын чадавхийг нэмэгдүүлж, энэ үндсэн дээр бүс нутаг, салбар дундын хоршилт, төрөлжилтийг хөгжүүлэхэд нийгмийн орон зайг сайжруулахад чиглэсэн дэс дараатай өөрчлөлтийг хамтад нь хэрэгжүүлэх;

Энэ хоёр санааны алийг нь ч хэрэгжүүлэхэд удирдлагын босоо, хэвтээ чиглэлийн төлөвлөлт, зохицуулалтын арга механизмыг ашиглах шаардлага тавигдана. Тодруулбал, бодлогын хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй дотоод, гадаад орчны өөрчлөлтийг харгалзан аль нэгийг нь түлхүү ашиглах боломжтой гэж төсөөлж байгаа болно.

### **5.3. Бүлгийн дүгнэлт, санал, зөвлөмж**

#### **5.3.1. Дүгнэлт, санал**

1. Бүсүүдийн хөгжлийн түвшин олонх үзүүлэлтээр доогуур, ялангуяа 2010 оноос байнга буурч ирсэн хандлага ажиглагдаж байна.
2. Хот хөдөөгийн хүн амын амьдралын түвшний ялгаа ихэсч ирсэн хандлага байна.
3. Бүсүүдийн хоорондох эдийн засаг, нийгмийн уялдаа холбоо, тэнцвэрт байдал алдагдаж байна.
4. Аймаг дундын, сум дундын, улс хоорондын болон салбар дундын чанартай шийдвэрлэх олон асуудал хуримтлагдсаар байна. Үүний төвлөрсөн илэрхийлэл нь хүн ам аймаг орон нутгаас УБ, бусад хотруу олноор шилжин суурьшиж, хот хөдөөгүй хүн амын ажилгүйдэл, ядуурлын түвшин нэмэгдэх хандлагатай болж байгаа явдал юм.
5. Хуримтлагдаж байгаа асуудлын шалтгаан нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөрүүд тууштай хэрэгжиж чадаагүй, тасалдсан.
6. Бүсчилсэн хөгжлийн бодлогын залгамж чанар, удирдлагын тогтвортой зохицуулалт алдагдсан.
7. Бодлогыг хэрэгжүүлэхэд иргэний нийгэм (иргэд, ААНБ)-ийн оролцоо, хамтын ажиллагаа үгүйлэгдэж ирсэн.
8. Бүсчилсэн хөгжлийн талаар Монголын нийгэмд нэгдмэл ойлголт, үзэл баримтлал тогтоогүй байгаа нь иргэдийн санаа бодлоос харагдаж байна.
9. Асуудлын шалтгааныг судлахад, Монгол улсын эдийн засгийн орон зайн бүтэц,

зохион байгуулалтыг цаашид сайжруулах талаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар 3 янзын зураглал буюу зохиомжийг хийж болохоор байна. Үүнд: **нэгдэх нь, нийслэл Улаанбаатар, мөн Эрдэнэт, Дархан хот, тэдгээрт шууд таталцсан бүс нутагт бөөгнөрөн суурьшиж амьдрах /хөгжлийн “Алтан гурвалжин” үүсгэх /; хоёрдахь нь, нийслэл хотоо Хархоринд шилжүүлж, газар нутгаа тэлж ашиглан, орон нутгаа жигд хөгжүүлэх замаар тархай суурьшиж амьдрах; гуравдахь нь, байгалийн чадавх, зах зээлийн газар зүйн байрлал сайтай газарт эдийн засгийн өсөлтийн туйлууд, хөгжлийн таталцлын тэнхлэгүүд буй болгон, олон суурьшлын төвүүдэд амьдрах;**

10. Дээр дурдсан 3 янзын зураглал зохиомжийн хүрээнд бүсчилсэн хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх боломжийг нөхцөл байдлын болон бодлогын хувьсагчаар үзээд, асуудлын шалтгааны 3 дахь зохиомж “байгалийн чадавх, зах зээлийн газар зүйн байрлал сайтай газарт эдийн засгийн өсөлтийн туйлууд, хөгжлийн таталцлын тэнхлэгүүд буй болгон, олон суурьшлын төвүүдэд амьдрах” нөхцөлийг бүрдүүлэх үндсэн дээр **“эдийн засаг, нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчилсэн тогтолцоог бүрдүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашигтай, зохистой төвлөрлийг бий болгоно”** гэсэн таамаглалыг Монголын бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг ойрын 10 жилийн хугацаанд цогц шийдвэрлэх арга зам болгон дэвшүүлж байна.

11. Улс орны эдийн засаг, санхүүгийн боломж хязгаарлагдмал байгаа, гадаад хамтын ажиллагааны орчин чиглэл өөрчлөгдөж байгааг харгалзан бүсчилсэн хөгжлийн бодлогын үзэл баримтлалыг дор дурдсан үзэл хандлагаар шинэчлэн төгөлдөржүүлэх хэрэгтэй. Үүнд:

1/ бүс нутгийг жигд, тэнцвэртэй хөгжүүлэх үзэл баримтлалаас эн түрүүнд үр ашгаа өгөх эдийн засгийн өсөлтийн төв, зах зээлийн дотоод, гадаад таталцлын тэнхлэгүүдэд хөрөнгө хүчийг төвлөрүүлэх;

2/ аж үйлдвэрийн кластер, шинжлэх ухаан – үйлдвэрлэл, үйлчилгээний болон мэдлэг, мэдээлэл – технологийн паркууд, нүүдэлчдийн түүх, ахуй соёл, экологийн аялал жуулчлалын бүс нутгийн зохион байгуулалтаар орон зайн менежментийг төгөлдөржүүлэх;

3/ улс хоорондын болон бүс хоорондын хөндлөн болон босоо тэнхлэгийн төмөр ба засмал зам, агаарын зам, тэдгээрт түшиглэсэн эдийн засгийн болон ногоон хөгжлийн коридорууд, эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн сүлжээ хөгжүүлэх, банк, санхүү, зээл, даатгал, хөрөнгийн бирж г.м. зах зээлийн зөөлөн дэд бүтцийн бүс нутгийн харилцан уялдаа, өрсөлдөх чадварыг хангахад гүйцэтгэх үүргийг өндөржүүлэх зэрэг болно.

### **5.3.2. Зөвлөмж**

1/ Монгол Улсын хөгжлийн тухай хуульд заасны дагуу улсын бүсчилсэн хөгжлийн урт хугацааны бодлогыг тодорхойлохдоо, 11-д заасан БХҮБ-ыг шинэчлэх шаардлагыг харгалзахын хамт энэхүү тайлагийн 2.1-д тусгайлан

бичихийг хичээсэн “ **Монголын эдийн засгийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн арга зүйн шинэлэг хандлагууд**” –ыг нягтлан үзэж, хэрэгжүүлж эхлэх цаг үе тохиож байгааг гол зөвлөмж болгон дэвшүүлж байна.

2/ “Эдийн засгийн бүсчлэл, төвлөрлийг сааруулах” гэсэн нэрээр бүсчилсэн хөгжлийн цаашдын бодлогыг шинэчлэхээр тогтсон нөхцөлд хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлоход дээрх 2.1-д заасан дараах 5 загварыг бүрдүүлэхэд онцлон анхаарах шаардлагатай гэж үзлээ:

- Монголын эдийн засгийн бүсчилсэн хөгжил, хүн амын байршил, хот байгуулалтын нэгдсэн тогтолцоо
- Монголын газар нутгийг тэлж ашиглах, хамгаалах тогтвортой хөгжлийн бүсчилсэн тогтолцоо
- Монголын орон зайг байгаль орчны даацад нийцүүлэн үйлдвэржүүлэх, кластержуулах бүсчилсэн тогтолцоо
- Монголын дотогшоо харсан эдийн засгийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын бүсчилсэн зохицуулалт
- Монголын гадагшаа чиглэсэн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсчилсэн зохицуулалт

3/ Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах асуудлын мөн чанарыг дараах байдлаар ойлгож төлөвлөх боломжтойг зөвлөж байна. Үүнд, Бүсчилсэн хөгжил, зохицуулалт нь:

- Эдийн засгийн орон зайн харилцааны менежментийг боловсронгуй болгох арга хэрэгсэл;
- Аймаг, хот, бүс, улс дамнасан хоршилт, төрөлжилт, дагналтын асуудлыг төр, иргэд, ААНБ ашиг сонирхлын хослол, хамтын оролцоогоор шийдвэрлэх стратегийн төлөвлөлт зохицуулалт (ЗЗНД-ийн одоогийн хуваарийн дотор шийдэх боломжгүй);
- Монголын өргөн уудам орон зайд тогтвортой хөгжлийн өсөлт, тэнцлийг хангах төр, иргэний нийгмийн үйл ажиллагааны удирдлагын босоо, хэвтээ чиглэл хосолсон зохицуулалт болох учраас тулгамдсан асуудлыг шийдэхэд дор дурдсан 3 зарчмыг баримтлах нь зүйтэй. Үүнд:
  - үндэстэн, иргэн, ААНБ-ын хамтын ашиг сонирхлын хослолыг хангах;
  - Монголын газар нутаг дээр нүүдэлчдийн ахуй, түүх, соёлын дэвшилтэт өв уламжлалыг орчин үеийн суурин иргэншилтэй хослуулах;
  - Нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийн Монголын онцлог арга зарчмыг дэлхийн улс орнуудын шилдэг туршлагатай хослуулах;

4/ Бодлого тодорхойлоход бүсчилсэн хөгжлийн дараах онцлог шинжүүдийг харгалзах. Энэ нь аймаг, хот, салбар хоорондын уялдааг хангах урт хугацааны, шаталсан цогц үйл явц гэдгийг анхаарч:

- бодлогын дотоод, гадаад орчин өөрчлөгдөхөд уян хатан зохицуулах

боломжтой бодлогын хэд хэдэн хувилбар, шийдлийг сонгох;

- төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ашиг, сонирхлын хослолыг хангах, оролцогч талуудын санал бодлыг тухай бүр харгалзах ил тод, нээлттэй зөвшилцөх, тохиролцох үйл ажиллагааг чухалчлах.

5/ Монголын нийгмийн орон зайн одоогийн бүтэц зохион байгуулалтыг гагцхүү эдийн засгийн шаталсан бүсчлэл, нутагшилт, хот байгуулалт, газрын менежментийн нэгдмэл бодлогоор өөрчлөн сайжруулах. Энэхүү нэгдмэл бодлого нь эдийн засгийн нэгдсэн (том, дунд, бичил масштабын) болон салбарын байршилт, хоршилтын зах зээлийн бүсчлэл, өсөлтийн тэнхлэгүүд, газар зүйн кластер, эдийн засгийн коридоруудын системд суурилан хэрэгжүүлэх;

6/ Асуудлыг шийдвэрлэх таамаглалд нөлөөлж байгаа болзошгүй нөхцөл байдлын болон бодлогын хувьсагчдын хэрэгжих бодит боломжоос үзэхэд дээр үзүүлсэн гурван зохиомжийг тухайн үеийн улсын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн өсөлт, хуримтлал, санхүүгийн чадавхаас хамааруулан зэрэгцүүлэн /хослуулан/ уян хатан хэрэгжүүлэх шаардлага тавигдаж болзошгүй байгааг анхаарах

7/ Бүсчилсэн хөгжлийн 2030 он хүртэлх бодлогын зорилго, зорилтуудыг томъёолохдоо, энэ бодлого нь 2001 оноос эхэлсэн БХҮБ, түүнийг дагалдан гарсан олон тооны хөгжлийн болон хууль тогтоомжийн баримт бичгүүдийг шинэ нөхцөлд тодотгон үргэлжлүүлж байгаа, иргэний нийгмийн оролцоог ханган хэрэгжилтийн үр дүнг нь сайжруулахад чиглэж байгааг нийгэмд ойлгуулах нэгдмэл үзэл баримтлалтай болоход анхаарах.

8/ 7-д тэмдгэлсэнтэй уялдуулан бүсчилсэн хөгжлийн бодлогын стратегийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо, тэдгээрийн агуулга, гарах үр дүнг чухалчилж, 2030 он хүртэл хугацаанд явуулах “үндсэн үйл ажиллагаа”-г а/ БХҮБ-ыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх талаар; б/ нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулах талаар гэсэн хоёр чиглэлээр харуулах нь зүйтэй байна. Тайланд, зураглан томъёолсон үйл ажиллагааны чиглэлийг бодлогод харгалзахыг зөвлөж байна.

## **ЗУРГАА. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН НӨЛӨӨЛЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ**

### **6.1. Бүсчилсэн хөгжлийн одоогийн бодлогын тойм**

Бүсчилсэн бүс нутгийн хөгжлийн ойлголт анхан XIX зууныг хүртэл бүс нутгийн тухай ухаан (АНУ-ын Айзорд) эдийн засгийн мужлалтын тухай (Оросын эрдэмтэд) сургаал байдалтай хэрэглэгдэж иржээ. XIX зуунаас эхлэн бүсчлэлийн онол нийгэм-улстөрийн нэр томъёонд орж ирж, нутаг дэвсгэрийн хуваарь (бүс нутгуудын төрөлжилт, хоршилт, дагналт, үйлдвэрлэх хүчнийг байршуулах, хүн амын бөөгнөрөл

г.м)-ийг илэрхийлэх арга хэрэглүүр болж ашиглагдаж байв. Бүсчилсэн бүс нутгийн хөгжлийн асуудлыг байгаль эдийн засаг, үндэстэн угсаатны түүх соёлын дотоод ялгаа ихтэй томоохон нутаг дэвсгэр бүхий Орос, Америк, Герман, Франц Хятад зэрэг улс хөгжлийн энэхүү дотоод ялгааг багасгах, нийгмийн харьцангуй тэнцвэрт, барилцан уялдсан байдлыг хангах зорилгоор төрийн бодлого (удирдлага зохицуулалтын)-ын түвшинд авч үздэг болсон байна.

Бүсчилсэн хөгжлийн үйл явц төвлөрсөн төлөвлөгөөт удирдлага төрийн оролцоотой зах зээлийн зохицуулалтын хоёр үндсэн арга замаар явагдаж байдгийг бид мэднэ. Монгол улс 1990 он хүртэл нэгдэх арга замаар, гол төлөв үйлдвэрлэх хүчнийг төлөвлөгөөтэйгөөр жигд байршуулахыг эрмэлзэж ирсэн ба 90-ээд оноос аймаг орон нутгийн хөгжлийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн дохиог харгалзан төрөөс дэмжин чиглүүлэх аргыг түлхүү баримталж байна. 2001 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн үзэл баримтлал”, түүнийг дагалдаж гарсан бодлогын баримт бичгүүд үндсэндээ дээрх хоёр арга зарчмын аль алинийг нь тусгасан, тэгэхдээ төрийн оролцоог гол болгожээ гэж АХБ-ны МОН 3948 (2004 он) төсөлд дүгнэсэн байдаг.

Бүсчилсэн хөгжүүлэх бодлогын шинжтэй тэдгээр баримт бичгүүдийн олонхийн нь хэрэгжих хугацаа 2016 онд дууссан ба харин үзэл баримтлал хүчинтэй хэвээр байгаа юм. Бидний хийсэн БХИБ, бүсүүдийн хөтөлбөрийн зориулалтуудын хэрэгжилтийг төрийн нэгдсэн бодлогоор дэмжих ажил 2013 оноос идэвхгүй болж, одоо үндсэндээ зогсонги байдалтай болсон байна. Энэхүү тайланд Бүсчилсэн хөгжлийн асуудлын мөн чанарыг төрийн бодлого болох талаас нь тоймлон авч үзэх оролдлого хийж байна. Учир нь энэ асуудал яг бодлого, төлөвлөлтийн зохицуулалт талаасаа тэр бүр сайтар (Ялангуяа) манай орны онцлог нөхцөлд, эн ажил нилээд хугацаанд тасалдсан, нөгөөтэйгүүр эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн асуудлыг арга зүйн хувьд шинээр авч үзэх, одоо байгаа бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн тодоройлж, хэрэгжих боломжийг нь хангах шаардлага тавигдаж байгаа юм.

Тухайлбал, улс орны эдийн засгийг цаашид бүсчлэн хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын мөн чанар, агуулга ач холбогдолыг олон нийтэд, түүний дотор бодлого боловсруулах шийдвэр хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагаанд оролцдог улс төрчид, мэргэжилтэн судлаачдын мэргэжлийн холбоодын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг сайжруулж, нэгдмэл нэг үзэл бодол итгэл үнэмшил шинжлэх ухаан мэдээллийн баазтай болгоход туслах зорилгыг өвөрлөж байна. Энэ зорилгоор бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд дор дурдсан ойлголтыг нэгдмэл үзэл бодлын хүрээнд зүгшрүүлэх шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Монголын бүсчилэн хөгжих үзэл санааны 3 үнэт зүйлийг харгалзах:
  - Хүн ам уламжлалт түүх соёлоо хадгалан уугуул нутагтаа тав тухтай амьдрах
  - Хүн ам айл хотол, аймаг, сумаараа харилцан нэгнээ дэмжин амьдрах (хамтын үзэл санаа)
  - Амьдралын суурь үндэс газар дэлхий, мал аж ахуйгаа дээдлэн амьдрах

2. Бүсчилсэн хөгжлийн бодлого нь дор дурдсан гурван эрх ашгийн хослолыг хангах:
  - Тав тухтай ажиллаж, амьдрах газраа чөлөөтэй сонгох иргэний эрх
  - Газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс үндэстний нэгдмэл байдал эдийн засгийн харьцангуй бие даасан байдал зэрэг үндэсний нийтлэг эрх ашиг
  - Байгаль, түүний эд, соёлын нөөцөөр түшиглэн нэмүү өртөг олж, зах зээлд өрсөлдөх аж ахуйн нэгжүүдийн сонирхол
3. Гео улс төр, гео эдийн засгийн бүсчилсэн бодлогын сүлжээ, газарүйн байрлал, байгаль, түүний ... чадавхи, нүүдэлчдийн түүх соёлын ололтод түшиглэн хөрш ба бүс нутгийн орнууд, дэлхийн улсуудын хэмжээнд хамтын ажиллагаа, харилцан түншлэлийн тогтвортой хөгжлийн үр дүнг бүх талаар дээшлүүлэх
4. Бүсчилсэн хөгжил нь баг, сум, аймаг, хот хоорондын, салбар хоорондын бүс нутаг, улс үндэстэн дамнасан эдийн засгийн хоршилт, төрөлжилт, дагналт, байгаль орчны хамтын менежментийг бүрдүүлэхэд чиглэгдэх
5. Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, газар нутгийн зохион байгуулалт, хүн амын нутагшилт, хот байгуулалтын асуудлыг тогтвортой хөгжлийн орон зай төлөвлөлт, зохицуулалтын нэгдмэл үзэл баримтлалын хүрээнд авч үзэх, харилцан уялдсан цогц шийдвэр гаргаж байх
6. Бүсчилсэн хөгжил нь оюун сэтгэхүйн олон хүрээ, бодлогын олон сүлжээ, олон талын ашиг сонирхолыг хамарсан цогц асуудал учир улс төрийн шийдвэр боловсруулж, гаргах үйл ажиллагаанд төр, иргэний нийгмийн бүх талын оролцоо, харилцан дэмжин, хамтын хариуцлагыг хангах
7. Бүсчилсэн хөгжил нь бүр анхнаас шинжлэх ухааны олон салбар, чиглэлийн сургаал номлол дээр үндэслэн тавигдаж ирсэн учир түүнийг урьдаас нарийн бодож боловсруулсан шинжлэх ухааны иж бүрэн үндэслэл, мэдлэг, мэдээлэл-аргазүй, төсөөлөл зураглалын баазад тулгуурлан боловсруулж, шийдвэрлэх
8. Бүсчилсэн хөгжлийн бодлогын зохицуулалтыг хийхдээ:
  - Төр (орон нутгийн засаглал) нь юу зохицуулах
  - Мэргэжлийн холбоод зохицуулалтад хэрхэн оролцох
  - Зах зээл өөрөө юуг шийдэх зэргийг зааглан тодорхойлох
9. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын эрх зүйн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх:
  - Нийгэм-эдийн засгийн нийтлэг харилцаа (төлөвлөлт, төсөвлөлт, татвар г.м)
  - Салбарын ба бүс нутгийн хоорондын харилцааг зохицуулах
  - Компани (банк, санхүү, зээл, даатгал г.м зөөлөн дэд бүтэц ороод) пүүсийн хоорондын харилцааг зохицуулах г.м
10. Бүсчилсэн хөгжил нь эцсийн дүндээ оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэгээс хамаарах учир “хамтын ёс зүй”-г хэрхэн төлөвшүүлэх эрх зүй, нийгэм-сэтгэлзүйн үйлдлийг бүрдүүлэх
11. Эдийн засгийн бүсчлэлийн нэгдсэн болон салбарын сүлжээнд үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг аймаг орон нутгийн эдийн засгийн бие даах чадвар, хоршилт, төрөлжилтийг бий болгох хандлагаар шинэчлэн өөрчлөх боломжийг судалж шийдвэрлэх



12. БХҮБ-д тодорхойлсон бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжих араг яс бүтэц болох үйлдвэрлэл, шинжлэх ухаан-технологийн кластерууд, чөлөөтэй бүс, эдийн засгийн болон ногоон хөгжлийн талаарх орчин үеийн ойлголт, манай нөхцөлд үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, стратегийн төлөвлөлтийн үндсэн дээр шийдвэрлэж байх
13. Бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжих эсэх нь төрийн удирдлагын тогтвортой, үзэл бодлын нэгдмэл байдлаас шууд хамаарах. Энэ бодлогыг анхнаас нь орон зай, цаг хугацааны хувьд уян хатан өөрчлөлт хийх боломжтой байхаар төлөвлөх
14. Бүсчилсэн хөгжлийн үйл ажиллагааг тасралтгүй төлөвлөлт, тодотгол зохицуулалтын зарчмаар явуулах. Бодлогын хувилбарууд (сонголтууд) нь олон, уян хатан байх (тэгвэл ингэнэ гэсэн арга барилаар)

Дээр дурдсан зарим чиглэлээр 2017 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдын дэргэдэх Үндэсний хөгжлийн газраас тодорхой судалгаа шинжилгээ захиалан хийлгэж, иргэд, мэргэжлийн холбоод, аймаг, улс төрчдийг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлэг, Олон улсын бага хурал зохион байгуулж мэдлэг, мэдээлэл-аргаүйн зохих баазыг бүрдүүлсэн. Эдгээр ажил нь бүсчилсэн хөгжлийн асуудлаар нийгэмд нэгдмэл үзэл бодол бий болгох, улмаар энэ талаар цаашид шинэчилсэн бодлого тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэх эхлэлийг тавьж байгааг сайшаан тэмдэглүүштэй байна.

## **6.2. Бүсчилсэн хөгжлийг дэмжих макро эдийн засгийн бодлогын орчин**

Монголын тогтвортой хөгжил, дэвшлийг эрчийг сааруулагч хүчийн зүйлсийн талаар Дэлхийн банкны хийсэн судалгаа /2005 ба 2016 он/, бидний үнэлгээ, тандалтаас үзэхэд бүсчилсэн хөгжлийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн одоо ба цаашдын хандлага нь дор дурдсан 4 үндсэн нөхцлөөс ихээхэн шалтгаалж байгаа юм. Үүнд: 1./ Макро эдийн засгийн орчин сул, тогтворгүй байгаа 2./ Үндэсний, орон нутгийн салбарын бодлого, хууль тогтоомжийн хоорондын уялдаагүй байдал, энэ нь бизнесийн орчинд тодорхойгүй, тогтворгүй байдал үүсгэж байгаа, 3./ Нийгмийн харилцааны бүх түвшинд хувийн эрх чөлөө, зах зээл бүхнийг зохицуулах үзэл давамгайлснаас үүдсэн төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл ихээхэн суларсан, энэ нь улс үндэсний нийтлэг эрх ашгиас илүү орон нутаг, салбарын ашиг сонирхолыг урьтал болгосон, аминч явцуу үзлийг газар авахуулж байгаа 4./ Хот байгуулалтыг бүтэц, зохистой хэмжээ алдагдаж, хүн ам үйлдвэрлэл, үйлчилгээ нийслэл Улаанбаатарт хэт төвлөрөх болсон зэрэг юм.

Эдгээрийг заримыг нь бодлогоор зохицуулж болох зарим нь хүн ам, залуу үеийн итгэл, үнэмшил, хүмүүжил, ёс суртахуун –эрх зүйн харилцан үйлчлэлийн хэм хэмжээтэй холбоотой байна. Нийгмийн орон зайн менежментийг сайжруулах, бүсчилсэн хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэхийн тулд юуны түрүүнд төр засгийн бодлого зохицуулалтын орчинг сайжруулахад онцлон анхаарах хэрэгтэй байгаа юм. Бид энд БХ-д шууд нөлөө үзүүлж ирсэн, цаашид илүү хүчтэй нөлөөлөх

макро эдийн засгийн бодлогын орчин, түүнийг сайжруулах зарим боломжийн талаар өөрсдийн бодол санааг хуваалцахаар тусгаж байна. Учир нь БХ –ийн асуудал эцсийн дүндээ тус улсын макро эдийн засгийн бодлого, төсөв санхүүгийн дэмжлэг, чадавхиас хамаарс байдгийг олон орны туршлага харуулж байна.

Манай бүс нутгуудад /ялангуяа алслагдсан аймаг, сумдад/ бараа материалын үнэ өртөг өндөр хэвээр байгаа бөгөөд, эдийн засгийн өсөлт ялангуяа 2010 оноос буурч, одоо ч үргэлжилсээр байна. Тогтвортой, орлого сайтай ажил хөдөлмөр эрхлэх орон зай улам бүр хумигдаж, ажилгүйдэл, ядуурлын түвшин хөдөө орон нутагт өндөр хэвээр байна. Төгрөгийн бодит ханш эрчимтэй буурснаар хот, хөдөөгийн хн амын худалдан авах чадвар адилхан багасч ханш хэт өндөр байгаа нь гадагшаа худалдаа хийхэд хүндрэлтэй болж, импортоос улам бүр хамааралтай болж, хямд үнэтэй чанар муу бараа гаднаас авч хэрэглэхэд хүрч байна. Энэ орон нутагт үйлдвэрлэл хөгжихөд саад болж, ЖДҮ эрхлэгчдэд хүндээр тусч байна. Хөдөө орон нутагт гол төлөв худалдаа наймаа, банкны зээлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн аж ахуйнууд хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг зах зээлийн боломжийн ханшаар авч чадахгүй байгаагаас хоорондоо хоршиж, бүсчилсэн хөгжлийг дэмжих орчин бүрдээгүй байгаа бөгөөд мөнгөний бодлого цаашид ийм байвал, энэ асуудал мөддөө хэрэгжихгүй хэвээр үлдэх төлөвтэй байна.

ТБУСХ батлагдсанаас хойш /2003/ төсвийн байгууллага хоорондын санхүүжилтын өөрчлөлтүүдийн дагуу орон нутгийн засаг захиргааны татвар болон орлого бүрдүүлэх эрх мэдлийг багасгаж, захиргаанаас үзүүлэх орон нутгийн үйлчилгээнээс бусад нь салбарын яамдад шилжиж, аймгууд эдийн засгийн бие даасан байдлаа хангах тухай ЗЗНД-ийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан бодлого явуулах боломж хязгаарлагдсан байна. 2012 оноос иргэдийн оролцоотой төсвийн менежментийг хэрэгжүүлэх Засгийн газрын шийдвэрээр “Орон нутгийн хөгжлийн сан”/аймаг, сумдын/- гууд байгуулагдсан нь төсөв санхүүгийн удирдлагын хэт төвлөрлийг багасгах чухал алхам болж хэрэгжиж байгаа юм. Гэвч эдгээр сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх орон нутгийн болон нэгдсэн төсвөөс чадавх боломж бага байгаа учир баг, сум дундын ач холбогдолтой бүс нутгийн нийтлэг асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдмал байгаа юм. 2013 оноос орон нутгийн орлогын гол эх үүсвэр болж байсан ашигт малтмал ашиглуулсны орлогын тодорхой хувийг улсын нэгдсэн төсөвт дахин төвлөрүүлэх болсон нь энэ байдлыг бүр ч лавшруулсан байна. Аймаг, орон нутгийн хөгжил үндсэндээ, төвлөрсөн төсвийн санхүүгийн дэмжлэгээс хамааралтай явж иржээ. Мөн шаардлагатай үед орон нутгийн хөгжлийг дэмжих чадвартай /зээл, хандив авах / ААНБ –ын үйл ажиллагаач чухал үүрэгтэй байв. Бодлогын залгамж байдал зарим талаар алдагдаж байсан явдал үүнд бас нөлөөлсөн тал ажиглагдаж байна.

БНХ-ийг макро түвшинд дэмжих өнөөгийн санхүү, эдийн засгийн бодлого нь нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030 он, Засгийн газрын гурван тулгуурт бодлогоор дамжин ОУВС-ийн удирдлагаар явагдаж байна. Ялангуяа “Гурван

тулгуурт хөгжлийн бодлого”- д БНХ-тэй холбогдсон чухал асуудлууд орсон байна. Гэхдээ эдгээр бодлогын алийг нь төрөөс зохицуулах ямарыг нь зах зээлийн баримтаатай шийдэхээс БХ-ийн асуудал хамаарах юм. Тухайлбал, хөдөө орон нутагт хувийн үйл ажиллагааг дэмжиж, аймаг дундын, бүс, улс хоорондын ач холбогдолтой томоохон үйлдвэр, үйлчилгээний газар байгуулж, бүс нутгийн хоршилт, төрөлжилтийг хөгжүүлэхэд төрийн зүгээс хувийн хэвшлийн компани, пүүстэй хамтарсан зорилтот хөтөлбөр, төслүүдийг түлхүү хэрэгжүүлэх, үүнд гадны хөрөнгө оруулалтыг чиглүүлэх явдал хүлээгдэж байна. Бодлого хэрэгжүүлэх явцад төрийн оролцоо зохицуулалт хэт голловол гаднаас маш их хамааралтай байгаа улс, орон нутгийн хөгжилд дотоодын хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагдын хөрөнгө оруулах сонирхол аль аль нь багасч магадгүй байгаа тул, бодлогыг орон зай, цаг хугацааны хувьд шаардлагатай үед нь өөрчлөх чадвартай уян хатан зохицуулалт хэрэгтэй болно.

Хэдийгээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Засгийн газрын төв, орон нутгийн байгууллагаас ихээхэн хүч чармайлт шаардаж, зарим талаар бодлого зохицуулалтын алдаа, эрсдэл гарах магадлал ихтэй байгаа ч, БНХ-г хөгжүүлэх зорилтыг хойшид тууштай хэрэгжүүлнэ гэж үзвэл илүү идэвхтэй, өсөлтөд чиглэгдсэн бодлогыг ЗГ-аас явуулах хэрэгтэй болж байна.

Өнөөгийн нөхцөлд, БНХ- д чухал гэж макро эдийн засгийн бодлогын орчинг сайжруулах дордурдсан асуудлыг дэвшүүлж байна. Үүнд:

1-рт, эдийн засгийн бодлогыг таван бүсээр тэгш хуваарилах боломжгүй, тэгэхдээ үндэсний эдийн засгийн өсөлтийн төвүүд, хөгжлийн таталцлын тэнхлэгүүдэд чиглэсэн, ялангуяа төсөв, татварын нэгдсэн бодлого байх шаардлагатай болов уу.

2-рт, үндэсний түвшинд , БХ-ийг тасралтгүй дэмжих эдийн засгийн бодлогын тогтвортой зохистой суурь, зохицуулалтын хүрээ, төрлийг боловсруулах нь нэн чухал.

3-рт, Бүс нутгийн хөгжлийн нийтлэг асуудлыг бодитой дэмжих мөнгө санхүү /банк, зээл, даатгал, татвар, төлбөр г.м./ -гийн улс хоорондын бүс нутаг хоорондын урсгал, гуримтлал, төвлөрөл, хуваарьлалтын үйл ажиллагааг урт хугацаанд илүү боловсронгуй болгох, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын богино болон дунд нугацааны оновчтой арга хэмжээнүүдийг хослуулан авч хэрэгжүүлэх шаардлагатай.

4-рт, эдийн засгийн орон зайд хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын бүтэц, байшилтыг сайжруулж, үйлдвэрлэл, үйлчилгээний хоршиж, дагнаж, төрөлжсөн үйл ажиллагааг идэвхтэй дэмжсэн нэгдсэн төсөв, хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг үр дүн өгөх талаас нь сайтар бодож хэрэгжүүлэх нь зүйтэй.

5-рт, өнөөгийн хөгжлийн бодлого, нэгдсэн төлөвлөлт, төсвийн тогтолцоог БНХ-ийг нийтлэг зорилтыг дунд, урт хугацаагаар үргэлжлүүлэн дэмжих байдлаар боловсронгуй болгох боломжтой, гэхдээ 2020 хүртэлх хугацаанд, бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын төлөвлөлт, аймаг, салбар хоорондын цахим мэдээлэл, шинжлэх ухаан- арга зүйн болон бодлого, зохицуулалт/ЭЗБХТС/ - ын институцын чадавхийг буй болгох хэрэгтэй байна. ЭЗБХТС-ийн баримт бичгээр 2030 он хүртэл тодорхойлох олон арван арга хэмжээнүүдийг ДХТХ-ний мэдэгдэл, УХОХ, салбар

яамдын болон аймгуудын бүсчилсэн хөгжлийн асуудлыг тусгасан хөтөлбөрүүд, Мэргэжлийн холбоодоор нэгтгэсэн компани пүүсүүдийн төлөвлөлттэй уялдуулан нягтлан боловсруулж, тэргүүлэх чиглэлүүд, хэрэгжих хугацааг нь тогтоох шаардлагатай юм.

### **6.3. Бүсчилсэн хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг сонгосон үндэслэл /Матриц 1; 2/**

Нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн, БХ –ийн бодлогын хувилбаруудыг сонгохдоо юуны өмнө Монголын БХБ-ын дор дурдсан онцлог шинжийг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- 1.) ЭБХТС нь аймаг, хот хоорондын, салбар, бүс, улс хоорондын олон талын сонирхлыг хосолсон, тухайн үеийн боломж, өөрчлөлтөд нийцсэн уян хатан зохицуулалт, урт хугацааны, байнгын тууштай үйл ажиллагаа шаардаж байж үр дүн нь нааштай гарах нарийн төвөгтэй үйл явц гэдгийг;
- 2.) Нэг аймаг, нэг салбарын зорилт шиг, эхлээд тийм асуудлыг шийднэ, дараа нь түүнд хөрөнгө оруулна гэж дэс дараалал тогтооход хэцүү, нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалт, уялдаа холбоог бүхэлд нь цогцоор шинэчлэх системийн хандлага (нийтлэг арга хэмжээ) шаарддаг болохыг;
- 3.) Ардчилал, зах зээлийн нөхцөлд, бүс нутгийн хөгжлийн цогц асуудлыг дан ганц төрөөс төвлөрүүлэн зохицуулахад боломжгүй бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээний байршилт, хоршилт, төрөлжилтийн асуудлыг иргэд, аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагын эрэлт, хэрэгцээтэй уялдуулах, төрийн оролцоо, дэмжлэгийг хэрэгтэй газар нь хэрэгтэй зүйл дээр нь хангах учиртай (ихэвчлэн тэд өөрсдөө бие даан шийднэ) гэдгийг бодолцох;

Эдгээр нөхцөл, шаардлагыг нарийн харгалзаагүйгээс БХҮБ, бүсүүдийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд тусгагдсан олон асуудал цаг тухайдаа шийдвэрлэгдэж чадаагүй ирсэнийг үнэлгээ харуулж байна. Иймд, бүсчилсэн хөгжлийн ямар асуудлыг төр (төв, орон нутгийн Засгийн газар) зохицуулах, ямрыг нь шийдэхэд иргэний нийгмийн байгууллагууд (иргэн, ААНБ)-ын оролцоо, дэмжлэг шаардагдах вэ гэдгийг бодлогын түвшинд урьдчилан тодорхойлж өгөх нь зүйтэй байна.

ЭБХТС бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх хувилбар гэдгийг энэ судалгаанд “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам” (Засгийн газрын 2016 оны 249-р тогтоолын хавсралт)-ын 9.13-т “Бодлогын хувилбар гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээ (НУҮ)-нд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын 2-оос доошгүй сонголтуудыг ....” хэлнэ гэсэн заалтын дагуу ойлгон ашиглав.

ЭБХТС бодлогын дээр дурдсан онцлог шинжүүд, түүхэн үеэс тогтнож ирсэн отор – бэлчээрийн мал аж ахуйн бүс, бүслүүрийн онцлог, ардчилал, зах зээлийн

шаардлагад нийцсэн нийгмийн орон зайн систем бүрэлдэж чадаагүй (харин ч бүрдэл хэсгүүд нь хоорондоо уялдаагүй, алаг цоог, эрээвэр хураавар байгаа) байгаа, үүнээс шалтгаалж, өмнө тодорхойлсон бүсчилсэн хөгжлийн бодлого бүрэн хэрэгжээгүй, олон таагүй үр дагавар гарсан зэрэг нь бодлогын цаашдын хувилбар (сонголт)-т нөлөөлж буй бодит хүчин зүйлс болж байгаа юм.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын эдгээр онцлог шинжүүд нь асуудлыг шийдэх хувилбаруудыг шууд томъёолох бус нэлээд ул суурьтай авч үзэхийг шаардаж байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, БХТС зорилтыг хэрэгжүүлэхдээ нэлээд алсыг харсан стратегийн шинжтэй, тодорхой онол – арга зүйд үндэслэсэн бодлогын хэд хэдэн сонголтыг хий нь зүйтэй байна. Үүнийг бодлогын сүлжээ гэж нэрлэж болох юм.

Төрийн бодлогын сүлжээ (олон сонголт)-ний тухай үзэл баримтлалын чиглэлийг ХХ зууны 1960-аас 1980-аад онд АНУ-ын эрдэмтэд (Т.Ж.Лови, Х.Хекло нарын) үндэслэж, эдүгээ төрийн удирдлагын ухааны онолын шинэ чиглэл болон олон оронд хөгжиж байгаа юм байна. Энэ онол ёсоор, бодлогын сүлжээг дор дурдсан орчин нөхцөлд хэрэглэх нь илүү үр дүнтэй ажээ. Үүнд:

- Олон талын оролцоо, тэдгээрийн нөөц, боломж, мэдлэг чадварыг хоршин ашиглах;
- Талуудын хооронд нь ил тод, харилцан мэдээллийг шуурхай солилцуулах;
- Тухайн бодлогын сонголт нь талуудын нийтлэг хүсэл сонирхол, эрмэлзэл шаардсан;
- Нэгдмэл байр сууринд хүрч чадах, хүлээцтэй, уян хатан чанар, стратегийн асуудал дээр улс үндэснийхээ нийтлэг эрх ашгийг дээдэлж, зөвшилцөх чадвар зэрэг ёс суртахууны болон бизнесийн соёлын зарчмуудыг хүндэтгэх;
- Удирдлага зохион байгуулалтын түвшнээр авч үзвэл босоо, хэвтээ чиглэлийн зохицуулалтыг оновчтой хийх, цаг үеийн өөрчлөлтийг тусгах чадвар зэрэг болно.

Оросын эрдэмтэн О.В. Михайлова (2014 онд) энэ бүгдийг нэгтгэж, бодлогын сүлжээг төрийн зохион байгуулалттай бүлгүүд бодлогын сонголт, шийдвэр гаргах түвшинд “харилцан нэгнээ дэмжиж хамтран ажиллах эвслийн онол” гэж нэрлэсэн байна. Бидний ойлгож байгаагаар “бодлогын сонголтууд хийх (шинэ парадигм)” буюу төрийн бодлогын энэхүү сүлжээ нь иргэний нийгмийн өмнө Төр засгийн байр суурийг ил тод нээж өгдгөөрөө манайд илүү сургамжтай юм.

Хөгжлийн зорилгод дээр дурдсан олон талын ашиг, сонирхлыг хосолж, хүч нөөцийг нэгтгэн чиглүүлж чадах бодлогын сонголтын хамгийн үр дүнтэй арга бол хамтын ажиллагаа гэдгийг бусад орон, ялангуяа Европын холбооны улсуудын туршлага харуулж байна. Ийм учраас тал талаасаа хамтран ажиллах хүсэл сонирхол нь нийлсэн, харилцан нэгнээ дэмжих улс төр, эдийн засаг, санхүү, нийгэм сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлэх бодлогын тийм сонголт (хувилбар)-ыг хийх нь чухал байна.

ЭЗБХТС тогтвортой хөгжлийн тулгуур асуудлыг хамарсан үйл явц нь төр, иргэний нийгэм, аж ахуйн нэгж, байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын хамтын дэмжлэг, оролцоотой шийдвэрлэгдэх учир өмнө томъёолсон 5 зорилтыг хэрэгжүүлэхэд Талуудын сонирхлыг татаж, хамтран ажиллах таатай орчныг бүрдүүлэх бодлогын зөв сонголт хийх хэрэгтэй байгаа юм.

Ирэх 10 гаруй жилийн хугацаанд тогтвортой байх ёстой эдгээр зорилтыг хэрэгжүүлэх бодлогын стратегийн хувилбар (сонголтууд)-уудыг хөгжлийн үе шатаар тууштай үргэлжилсэн, тэгэхдээ уян хатан өөрчлөлт зохицуулалттай байхаар томъёолох нь зүйтэй. Тэрчлэн БХ-ийн бодлогын сүлжээг нэгд нь, одоо хүчинтэй байгаа улс, аймаг, салбарын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр, хууль тогтоомжийг цаашид тодотгон сайжруулах; хоёрт нь, эдийн засгийн бүсчилсэн зохицуулалтаар дамжуулан Монголын нийгмийн орон зайн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх бодлогын шинэ сонголтууд хийхээр төсөөлөх нь чухал байна.

Нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн, “А”, “Б”, “В” хувилбар бүрээр цаашид гарах боломжтой үр дүнг тооцоолох, мөн тэдгээрийг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг бүсчилсэн хөгжлийн бодлогын мөн чанар, онцлогтой уялдуулан сонгон авахыг хичээлээ. Үүнд,

1/ Бодлогын хувилбаруудын хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд:

- хүн амын бөөгнөрөл багасч, шилжих хөдөлгөөн саарах,
- аймаг, хот, сумдын хоршилт, холбоо сайжрах,
- төр, иргэн, ААНБ-ын хамтын ажиллагаа сайжрах,
- Төв Засгийн газар, орон нутгийн болон компанийн засаглалын уялдаа, эрх мэдлийн хуваарилалт сайжрах,
- нийгэм, соёлын орон зайн хамтын менежментийн тогтолцоо бүрдэх

2/ Бодлогын хувилбарын шалгуур үзүүлэлтэд:

- бодлого хэрэгжих боломж
- бодлогын залгамж чанар хадгалагдах
- бүс нутгуудад аймаг, орон нутаг, ААНБ өрсөлдөн зах зээлд хөгжих тэгш боломж олгох
- бодлогыг уян хатан, сайжруулах боломж
- улс төрийн хүчнүүд хүлээн авах боломж
- иргэний нийгэм (иргэд, ААНБ-ын мэргэжлийн холбоод)-ийн оролцоо, нэгдмэл үзэл хандлага бүрэлдэх зэргийг орууллаа.

Матриц 1. Бодлогын хувилбар, үр дүнгийн хамаарал

Хувилбарын хүрэх үр дүн	Бодлогын хувилбараар		
	Хувилбар “А”	Хувилбар “Б”	Хувилбар “В”
1. Хүн амын бөөгнөрөл багасч, шилжих хөдөлгөөн	Хэвээр хадгалагдана.	Мэдэгдэхүйц саарна.	Аажимдаа саарна.

саарах			
2. Аймаг, хот, сумдын хоршилт, холбоо сайжрах	Аймгийн доторх сум, багийн уялдаа сайжирна.	Томсгосон аймаг доторх хот, тосгон, сум, багийн уялдаа, хоршилт хөгжиж эхэлнэ.	Эдийн засгийн бүсүүд доторх аймаг, сум, хот, хөдөөгийн хоорондын уялдаа, хоршилт хөгжинө.
3. Төр, иргэн, ААНБ-ын хамтын ажиллагаа сайжрах	Төрийн хүчтэй дэмжлэг оролцооны дор аймгуудын доторх орон нутгийн засаг, иргэд, ААНБ-ын уялдаа аажимдаа сайжирна.	Томсгосон аймгийн удирдлагаар орон нутгийн засаглал, иргэний нийгмийн байгууллагын уялдаа мэдэгдэхүйц сайжирна	Эдийн засгийн бүсүүдийн хүрээнд төр, иргэн, ААНБ-ын хамтын сонирхлын бүс нутгууд бий болж, уялдаа аажимдаа сайжирна.
4. Төв Засгийн газар, орон нутгийн болон компанийн засаглалын уялдаа, эрх мэдлийн хуваарилалт сайжрах	Засгийн газар, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай одоогийн хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжихэд хүндрэлтэй.	Томсгосон аймгийн хүрээнд аймгуудын бүс нутгийн хөгжлийг удирдах эрх мэдэл сайжирна. Төв Засгийн газраас хамаарах явдал багасах талтай. Хуулийн нэмэлт зохицуулалт шаардлагатай.	Удирдлагын нүсэр том аппарат, зохицуулалт шаардагдахгүй. Төв, орон нутгийн удирдлагын байгууллагын бүсчилсэн хөгжлийн үүрэг, хариуцлагыг хуульчлан тогтоох, иргэний нийгмийн оролцоо, хяналтыг сайжруулах
5. Нийгэм, соёлын орон зайн хамтын менежментийн тогтолцоо бүрдэх	Аймгуудын доторх сум, баг, хот, тосгоны иргэд, ААНБ хоорондын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэгийг сайжруулах хуулийн шинэлэг зохицуулалт, ёс зүйн дэг журмыг тогтоох шаардлагатай.	Томсгосон аймгийн доторх бүс нутгуудын хүн амын аж ахуй, нийгэм – соёлын уялдааг сайжруулах, төрөөс дэмжин зохицуулах шинэ хууль, бодлого хэрэгтэй.	Эдийн засгийн бүх түвшний бүсчлэл, аймаг, салбар дундын хоршилт, холбооны ачаар иргэд, ААНБ-ын харилцан дэмжлэг, хамтын ажиллагаа сайжрах зохицуулалтын орчин аажмаар бүрэлдэнэ.

Матриц 2. Бодлогын хувилбарын үр дүн, шалгуурын хамаарал

Д/д	Хувилбарын шалгуурууд	Хувилбарын үр дүнгүүд				
		Үр дүн 1	Үр дүн 2	Үр дүн 3	Үр дүн 4	Үр дүн 5
1.	Бодлого хэрэгжих боломж	Бий	Дунд зэрэг	Байгаа	Байгаа	Байгаа
2.	Бодлогын залгамж чанар хадгалагдах	Бий	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг
3.	Бүс нутгуудад аймаг, орон нутаг, ААНБ өрсөлдөн зах зээлд хөгжих тэгш боломж олгох	Дунд зэрэг	Боломжтой	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг
4.	Бодлогыг уян хатан, сайжруулах боломж	Боломжтой /шаардлагатай/	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа
5.	Улс төрийн хүчнүүд хүлээн авах боломж	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа
6.	Иргэний нийгэм (иргэд, ААНБ-ын мэргэжлийн холбоод)-ийн оролцоо, нэгдмэл үзэл хандлага бүрэлдэх	Байгаа	Байгаа	Байгаа	Байгаа	Дунд зэрэг



#### **6.4. Бодлогын хувилбаруудад хийсэн нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээ /PEST анализ/**

Энэхүү үнэлгээг хийхдээ, нөхцөл байдлын дүн шинжилгээгээр бидний дээр урьдчилан үзүүлсэн бодлогын “В” сонголтыг тусад нь авч үзэж, түүнийг сонгон хэрэгжүүлэхэд хүрвэл Монголын нийгмийн амьдралын орон зайн бүтэц, зохион байгуулалтад дор дурдсан үндсэн салбар, чиглэлийн хүрээнд эерэг болон сөрөг байдлаар ямархуу харилцан нөлөөлөл үзүүлж болохыг төсөөлөх оролдлого хийж байна. Үүнд:

- эдийн засгийн макро болон микро төлөвлөлтийн нэгдмэл орчин /төсөв, төлөвлөгөө, татвар/
- хүрээлэн буй байгаль орчин, газрын харилцаа
- бизнес эрхлэлтийн орчин
- нүүдэлчдийн түүх, аж ахуй, соёл, оюун сэтгэлгээний дэвшилтэт
- уламжлалыг хадгалан хөгжүүлэх
- төрийн удирдлага, засаглал, улс төрийн намуудын байр суурь
- хууль эрх, ёс зүйн орчин
- хот, хөдөөгийн хүн амын ажил эрхлэлт
- хүн амын нутагшилт, хот байгуулалт
- зам харилцаа, дэд бүтэц
- гадаад харилцаа, геополитик

Бодлогын “В” хувилбарын дээрх 9 салбар, чиглэлээр үзүүлж болзошгүй нөлөөллийг түүний эерэг ба сөрөг хандлагын PEST анализаар харуулахыг хичээлээ/ Хүснэгтийг үз/.

PEST анализийн Хүснэгт:

Бодлогын “В” /Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын хэвтээ тогтолцоог бүх түвшинд шинэчлэн бүрдүүлэх/ хувилбарын нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээний тодорхойлолт

д/д	Нөлөөлөх орчин	Үзүүлж болзошгүй нөлөөлийн чиг хандлага	
		Эерэг хандлага	Сөрөг хандлага
1	Эдийн засгийн макро болон микро төлөвлөлтийн нэгдмэл орчин /төсөв, төлөвлөгөө, татвар/	<ul style="list-style-type: none"> <li>•Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн шинжлэх ухаан - арга зүй, мэдээллийн чадамж дээшлэх</li> <li>•Бүсчилсэн хөгжлийн нийтлэг зорилтыг УХОХ, ТХДМ-д тусгаж, төсөв санхүүгийн нэгдсэн бодлогоор дэмжиж хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх</li> <li>•Бүсчилсэн хөгжлийн санаачлагын хүрээнд аймаг сум, салбар хоорондын төлөвлөлт, мэдээлэллийн уялдаа сайжрах</li> <li>•Бүсчилсэн зохицуулалтын хүрээнд мэргэжлийн холбоо, компаниудын бүсчилсэн хөгжлийн арга хэмжээнд оролцох оролцоо, дэмжлэг нэмэгдэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>•Хөрш болон бүс нутгийн орнуудын зах зээлд газрын тосны үнэ нэмэгдэх, нүүрс эрчим хүчний хэрэглээ багасах</li> <li>•Бүс нутгийн хөгжлийн арга хэмжээг хэрэгжүүлэх макро эдийн зэсгийн зохицуулалт, төсөв санхүүгийн дэмжлэгийн тууштай, тогтвортой байдал алдагдах</li> <li>•Бүс нутгуудад гадаад орон, ОУБ-ын оруулах хөрөнгө санхүүгийн дэмжлэг саарсан хэвээр цаашид үргэлжлэх</li> <li>•Бүс нутгийн хөгжлийг дэмжих зах зээлийн дэд бүтэц(банк, санхүү, зээл, даатгал г.м) бүрдүүлэх ажил удаашрах, зохицоогүй байдал бий болох</li> <li>•Эрх зүйн орчны бүрдэлт удаашрах, хууль тогтоомжийн хэрэгжилт сулрах</li> </ul>
2	Хүрээлэн буй		•Байгаль, нийгмийн

	байгаль орчин, газрын харилцаа	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, сум, баг, бүс, улс дамнасан байгаль хамгаалах, нөөц баялгийг ашиглах нэгдсэн болон хамтын менежментийн тогтолцоо бүрдэх</li> <li>• Хөгжлийг байгаль орчинд хал багатай төлөвлөх, экологийн үнэлгээг урьдаас хийж, бүсчилсэн төлөвлөлтөд харгалздаг болох</li> <li>• Газар нутгаа тэлж, илүү үр өгөөжтэй ашиглах орон зайн бүтэц, зохион байгуулалт сайжрах</li> </ul>	<p>орон зайн уялдааг хангах, орчны бүс нутгийн хамтын менежментийн тогтолцоог дэмжих улс орон нутгийн хүн хүч, хөрөнгө санхүүгийн нөөц дутагдах</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ашигт малтмал ашиглаж буй ААНБ-н байгаль хамгаалах санаачлага дутаж, тэдгээрийг зохицуулах ажил удаашрах</li> <li>• Бэлчээрийн даац хэтрэх болон бусад экологийн ачаалал ихсэх</li> <li>• Цөлжсөн, гамшигт автсан газар нуггийн хүрээ өргөжих, бүсчилсэн зохицуулалт хүндрэх</li> </ul>
3	Бизнес эрхлэлтийн орчин	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн үр дүнд ААНБ-ын нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалт сайжрах</li> <li>• Төр, хувийн хэвшлийн бүс нутгийн хөгжлийг дэмжсэн хамтын ажиллагаа идэвхжих</li> <li>• Мэргэжлийн холбоодоор дамжин компани, ЖДҮҮ-ний хоршилт, холбоо сайжирч, нэмүү өртөгийн сүлжээ бүрдэх эхлэл тавигдах</li> <li>• Нийслэл томоохон хот сууринд байрласан ААНБ-ын бүс нутгийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын байгууллагууд, мэргэжлийн холбоод, компаниудын хооронд байгалийн нөөц ашиглах талаар ашиг сонирхлын зөрчил ужиграх, тэдгээрийг шийдвэрлэх ажил удаашрах, хүч дутах</li> <li>• Бүсчилсэн хөгжлийн үндэс болсон үйлдвэр үйлчилгээний хоршилт /ҮТП, кластер, чөлөөт бүсийн хэлбэрээр/, төрөлжилтийг бий болгох үйл явц удаашрах, гадаад орны хөрөнгө санхүү,</li> </ul>

		дотоод, гадаад зах зээлийг хөгжүүлэх, тэдгээрийн өрсөлдөх чадварыг нэмэглүүлэх санаачлага, оролцоо дээшлэх	техникийн туслалцааны дэмжлэг, оролцоо дутагдах • Засгийн газар, ААНБ-ын хооронд бүсчилсэн хөгжлийг дэмжих, хууль эрх зүйн шинэ орчин шаардагдах, хэрэгжилт нь удаашрах
4	Нүүдэлчдийн түүх, аж ахуй, соёл, оюун сэтгэлгээний дэвшилтэт уламжлалыг хадгалан хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн бодлогоор хүн ам уугуул нутагтаа тогтвортой суурьшин амьдрах нөхцөл дээшлэх</li> <li>• Нүүдэлчдийн аж ахуй, түүх соёл, оюун сэтгэлгээний ололтыг бүс нутгуудад нь хадгалан хөгжүүлэх</li> <li>• Байгалиа дээдэлж ирсэн уламжлал, түүх, археологи, аж ахуй соёлын өвийг ашиглан улс бүс хоорондын аялал жуулчлалын сүлжээг хөгжүүлэх, ТХГН-д түшиглэсэн тогтвортой хөгжил(ногоон хөгжил)-ийг жишиг бүс нутгууд үүсгэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Залуу үед нүүдэлчдийн соёлын ололт, үнэт зүйлсийг сурталчлан ойлгуулах, түүнийг бүтээлчээр уламжлан ашиглах явдал удаашрах /хүмүүжил, ёс зүйн шинэ орчин шаардах/</li> <li>• Байгаль, соёлын бүс нутгийн аялал жуулчлалын сүлжээ бүрдүүлэхэд ихээхэн цаг хугацаа, хөрөнгө шаардах</li> <li>• Аймаг, орон нутаг, компани аж ахуй нэгжийн ашиг сонирхол зөрчилдөж, байгаль хамгаалах, газар, түүний баялгийг ашиглах татвар, төлбөр хураах сөрөг үр дагаварууд гарах</li> </ul>
5	Төрийн удирдлага, засаглал, улс		• Төрийн зохицуулалтад улс төрийн намуудын

	<p>төрийн намуудын байр суурь</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бүсчилсэн зохицуулалт, удирдлагын тогтвортой байдал, бүх шатны, бүх төрлийн бодлогын уялдаа сайжрах</li> <li>• Төв, орон нутгийн засаглалын байгууллагуудын бүс нутгийн хөгжлийн талаарх ажлын уялдаа, мэдээлэл сайжрах</li> <li>• бүс нутгийн асуудлаар төр, иргэний нийгмийн хамтын ажмлагаа, харилцан дэмжлэг сайжирч, үр дүн нь иргэдэд мэдрэгдэж эхлэх</li> </ul>	<p>нөлөөлөл ихсэх, бүсчилсэн хөгжлийн бодлогын залгамж чанар алдагдах</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийг зохицуулах талаар төв орон нутгийн төрийн институцүүдийн хоорондын байнгын уялдаа, эрх мэдлийн хуваарьлалт оновчгүй болох</li> <li>• бүсчилсэн хөгжлийн үр дүнг үнэлэх, түүний төлөө хариуцлага хүлээх этгээд байхгүй байх нутгархах, салбарын эрх ашгийг урьтал болгож ирсэн явцуу, далд үзэл хандлагыг даван туулах явдал удаашрах, бодлогоор зохицуулах боломжгүй болох</li> </ul>
6	<p>Хууль эрх, ёс зүйн орчин</p>	<ul style="list-style-type: none"> <li>• БХУЗ-ын хуулийг нийтийн (ЗЗНДХ-ийн нэгж, хот байгуулалт г.м) ба салбарын бусад хууль тогтоомжид нийцүүлэн бүсчилсэн хөгжлийг дэмжих эрх зүйн зохицуулалтын нэгдмэл үндэс бүрдэх</li> <li>• Бүсчилсэн хөгжлийн зохицуулалтын асуудалд төр, иргэн, аж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн хөгжлийн орон зайн харилцааг бүх түвшний хүрээнд зохицуулах хууль боловсруулах, хэрэглэх ажил удаашрах</li> <li>• Бүсчилсэн хөгжлийг хөтлөгч ёс суртахууны хүч болсон “харилцан нэгнээ дэмжих,</li> </ul>

		<p>ахуй нэгж байгууллагын хамтран хүлээх үүрэг, хариуцлагын талаарх хуулийн механизмыг сайжруулах боломж бий болох</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн зохицуулалт/кастер, ШУТ-ийн парк, нөхөрлөл, хоршоо г.м. –ын аргаар айл өрх, баг, сум, хот, тосгон г.м. бүх түвшинд "хамтдаа өсч хөгжих сэтгэлгээг төлөвшүүлэх" боломжийг судалж нийтэд дэлгэрүүлэхэд хууль, нийгмийн байгууллагууд/сургалт хүмүүжлийн болон сэтгэлзүйн, мэдээллийн/ хамтран ажиллах ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх</li> </ul>	<p>хамтран ажиллах" үйл ажиллагааг зах зээлийн нөхцөлд зохицуулж чадахгүй байх, харин ч нутгархах, ах дүүсэх, аминч үзэл ужиграх</p>
7	Хот, хөдөөгийн хүн амын ажил эрхлэлт	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөө орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт сайжирч, ажлын байр нэмэгдэх</li> <li>• Эдийн засгийн өсөлтийн төвүүд рүү хүн ам (залуучууд ) шилжин суурьших хандлага бий болох</li> <li>• Алслагдсан бүс нутгаас хүн амын гадагш шилжих хөдөлгөөн саарах, уугуул нутагтаа тогтвортой амьдрах сонирхол төрөх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн Баруун, Зүүн, Төвийн бүсэд хүн амыг татах чадвартай хөгжлийн төвүүд, хот байгуулалт удаашрах</li> <li>• УБ, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын бүсэд хүн амын ердийн өсөлт нэмэгдэж, хүн ам, үйлчилгээний бөөгнөрөл, аажилгүйдэл ихсэх</li> <li>• Ирэх 10 жилд хот</li> </ul>

			сууринд олноор түрэн орж ирэх залуучуудыг орлого сайтай ажлаар хангах хэрэгцээ хоцорч, гадаад орон руу гарах үйл явц хэвээр үргэлжлэх
8	Хүн амын нутагшилт, хот байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>• Бүсчилсэн зохицуулалтын хүрээнд газрын менежмент, хот байгуулалтын чиг үүрэг, бүтцийн уялдааг сайжруулах орон зайн төлөвлөлт, мэдээлэл зураг төслийн нэгдмэл тогтолцоо бүрдэж эхлэх</li> <li>• Шинээр байгуулах хот суурингийн чиг үүрэг бүтцийг, тэдгээрийн орчмын бүс нутгийн экологи /усан хангамж, газрын менежмент, зуслан, амралт, ногоон байгууламж г.м./-ландшафт, бичил уур амьсгалын бүсчлэлийн үндсэн дээр алсын хараатай төлөвлөж эхлэх</li> <li>• Эдийн засгийн бүсчилсэн зохицуулалт, ТХГН-ийн менежментийн уялдаа сайжирч, хөгжлийн төвүүд, таталцлын тэнхлэгийн дагуу орчин үеийн тохижсон жижиг суурингууд бий болох эхлэл тавигдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын байгууллагуудын хоорондын ажлын байнгын холбоо, институцийн төлөвлөлтийн чадамж суларч, энэ нь газрын менежмент, хот байгуулалтын уялдаанд зохисгүй нөлөөлөх</li> <li>• Эдийн засгийн өсөлтийн төв, таталцлын тэнхлэгүүд байгуулах хөрөнгө санхүүгийн боломж хязгаарлагдах, төр, хувийн хэвшил/ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдын/ -ийн хамтын ажиллагаа, харилцан зөвшилцөл, санаачлага сулрах зэргээс шалтгаалж хот байгуулах үйл явц бүхэлдээ удаашрах</li> <li>• УБ, Дархан, Эрдэнэт тэдгээрийн хот орчмын бүс нутагт газрын менежмент, хот тосгоны дахин</li> </ul>

			<p>төлөвлөлт, шинэчлэлийн улдаа алдагдаж, экологийн даац, амьдрах орчны чанар цаашид муудах, энэ нь бусад бүс нутагт хөрөнгө оруулах үйл ажиллагааг саатуулах</p>
9	Зам харилцаа, дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> <li>• Алтанбулаг-Улаанбаатар-Замын – Үүдийн чиглэл, түүнд татагдсан улс, бүс хоорондын төмөр ба авто замын ачаа, барааг дамжин өнгөрүүлэх чадвар сайжирах</li> <li>• Баруун ба Зүүн бүс .... тавигдаж буй босоо тэнхлэгийн засмал замыг тавьж дуусгах, хойт ба зүүн бүсийн замыг тавих ажлыг эхлүүлэх</li> <li>• Бүс нутгуудын эдийн засгийн өсөлтийн төвүүдийг хооронд нь болон гадаад зах зээлтэй холбосон зам, тээвэр, эрчим хүч, мэдээлэл харилцаа холбооны сүлжээг сайжруулж, ашиглалтын хүртээмж, чанарыг дээшлүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө санхүүгийн боломж хязгаарлагдсаны улмаас босоо, хөндлөн чиглэлийн замууд, эрчим хүчний станц, улс, бүс хоорондын сүлжээг шинэчлэн байгуулах үйл явц удаашрах</li> <li>• Эдийн засгийн өсөлтийн төвүүд, байгуулах зорилтуудын хэрэгжилт өөрөө удаашрах, дотоод гадаадын бизнес эрхлэгчдийн хооронд хэлэлцээр байгуулах, хөрөнгө оруулах ажлууд сунжирч цаг алдах</li> <li>• Эдийн засгийн бүсүүдэд зах зээлийн зөөлөн дэд бүтэц(банк, санхүү, зээл, даатгал г.м)-ийг бүс нутгийн хөгжлийг дэмжих хэмжээнд шинэчлэн зохион байгуулах, бодлого зохицуулалт удаашрах</li> </ul>



10	Гадаад харилцаа, геополитик	<ul style="list-style-type: none"> <li>• Тус орны газар зүйн байрлалын чадавхийн дагуу хөрш болон бүс нутгийн орнууд, тэдгээрийн субъектүүдтэй үйлдвэрлэл, үйлчилгээг хоршин, хөгжүүлэх дэд бүтцийн орчин сайжрах</li> <li>• Хил зэргэлдээ бүс нутгуудын хоорондын худалдаа хамтын ажиллагааг, эдийн засаг, аялал жуулчлалын хоршилт, холбооны түвшинд гаргаж, харилцан үр өгөөжтэй зохион байгуулах бүсчилсэн зохицуулалтын чадавхи бий болох</li> <li>• Монгол улсын дэлхийн болон бүс нутгийн орнуудын хүрээнд гео - улс төр, гео эдийн засгийн бүсчлэлийн бодлого, чиглэлээ зөв тогтоох алсын хараа бий болох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Европын холбоо, Ази номхон далай, Төв ба Зүүн Ази /хойт ба өмнөт/, Шанхайн хамтын ажиллагаа г.м. байгууллагуудтай Монгол улсын цаашид хамтран ажиллах бодлого чиглэл бүрхэг болж, бүсчилсэн хөгжлийн гадаад зохицуулалтад таагүй нөлөөлөх</li> <li>• Монгол-Орос-Хятад гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил удаашрах</li> <li>• Томоохон гүрнүүдийн тив дэлхий, улс дамнасан гео - улс төрийн бодлого чиглэл өөрчлөгдөж, Монгол улсын гео эдийн засгийн бүсчлэл, орон зайн зохион байгуулалтыг хэрэгжүүлэхэд таагүй нөлөөлөх</li> </ul>
----	-----------------------------	--	---

### 6.5. Бүлгийн зөвлөмжүүд

Бүсчилсэн хөгжлийн бодлогын сонгон авсан “В” хувилбарыг/ хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд.

#### I. Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт :

1/ Монгол улсын нийгмийн орон зайн хөгжлийн онцлогт тулгуурласан нөхцөл байдлийн дүн шинжилгээ, нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээгээр авч үзсэн бодлогын зорилго, зорилтууд тэдгээрийг хэрэгжүүлэх хувилбаруудыг

Монгол улсын аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал , хөгжлийн бодлого , төлөвлөлтийн тухай хууль, Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх үзэл баримтлалтай холбон дахин нягтлан үзэх;

2/ Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (2001 онд батлагдсан) –ыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030, үндэсний хөтөлбөрүүд, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдтэй холбон тодотгон шинэчлэх (одоо хийх гэж буй “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил төвлөрлийг сааруулах бодлого”- ын баримт бичгийн өмнө, эсвэл хойно байх уу гэдгийг нягталж, тогтоох );

3/ ээрх ажлын үндсэн дээр бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт “В” хувилбарыг тусгах, ингэхдээ “А” ба “Б” хувилбаруудын зарим чиглэлүүдтэй хослуулан хамтад нь авч үзэж шийдэх;

4/ Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын нэгдмэл үндсийг бүрдүүлэх, одоо хүчинтэй байгаа “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль”-ийг нийгэм эдийн засгийн нийтлэг харилцааг зохицуулж буй Үндсэн хууль, УИХ-ын тухай, Засгийн газрын тухай хуульд нийцүүлэх, салбаруудын харилцааг зохицуулж буй бусад хууль тогтоомжтой уялдуулах, бүсчилсэн хөгжлийн зохицуулалтыг хот байгуулалт (одоо хэлэлцэж байгаа) газар зохион байгуулалт (төсөл нь гарсан), нийслэлийн болон хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай хамтад нь нийгмийн орон зайн зохион байгуулалтын тухай эрх зүйн нэгдмэл үзэл баримтлалын хэмжээнд авч үзэх;

5/ энэ зөвлөмжийн 2-т дурьдсан БХҮБ-ын шинэчлэлтэй уялдуулан эдийн засгийн одоогийн 5 бүсийн аймгуудын хуваарь, бүрэлдэхүүнийг өөрчлөх , дунд болон бичил масштабын болон салбарын бүсчлэл, зураглалын асуудлыг хамтад нь шийдвэрлэж баталгаажуулах (харин салбарын бүсчлэлийг үндэсний хөтөлбөрүүдэд тусгаж болох юм.);

6/ Эдийн засгийн байгуулалтын бүх түвшин (үндэсний, салбарын, аймаг, бүс, сумын гэх мэт)-д төр ,иргэн, аж ахуй нэгж байгууллагын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэгийг хөгжүүлэх (үйлдвэрлэл,үйлчилгээний хоршилт, төрөлжилтөөр дамжуулан) –эд чиглэгдсэн бүсчилсэн уулзалт, семинар, сургалт зохион байгуулж , оролцогч бүх байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлж, нэгдсэн ойлголт, үзэл бодолтой болгох

## II. УИХ, Засгийн газрын түвшинд анхаарах зүйлс:

1./ Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлогын баримт бичгийн төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ танилцан, хэлэлцэж ямар түвшинд батлан мөрдүүлэхийг шийдэх;

2./ Эдийн засгийн бүсчлэл, хот байгуулалтын бодлогын шинэчлэлтэй уялдуулан тус улсын засаг захиргаа - нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх, орон нутгийн удирдлагын эрх хэмжээг өргөтгөх асуудлыг дахин авч үзэх, шаардлагатай гэж үзвэл нэг мөр юмуу, эсвэл хэсэгчилэн сайжруулалт хийх;

3./ Бүсчилсэн хөгжлийн хүрээнд төр, түүний байгууллагууд байгууллагууд юуг яаж зохицуулах, иргэн, аж ахуй нэгж байгууллага (тухайлан, мэргэжлийн холбоод )-уудын үүрэг оролцоо ямар байхыг тогтоосон эрх зүйн хэм хэмжээг

тогтоох. Тухайлбал Засгийн газар, мэргэжлийн холбоод/ компаниудыг төлөөлж/, бүсүүдийн холбоо буюу зөвлөл (аймаг, хотыг төлөөлж) “Бүсчилсэн хөгжлийн гурван талын гэрээ хэлэлцээр” байгуулах гэх мэт;

4./ Монгол-Орос-Хятад улсын хооронд “ эдийн засгийн коридор” байгуулах хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монголын төр байнга анхаарч, холбогдох төсөл арга хэмжээг санаачлан боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5./ Монголын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах, орон нутгийн засаглалыг бэхжүүлэх талаар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон АХБ, Дэлхийн банк, Японы Жайка, ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Швейцарын хөгжлийн агентлаг зэрэг бусад олон улсын болон гадаад улсын байгууллагаас хийсэн хөгжлийн төсөл үнэлгээний баримт бичгүүдийн тайлантай танилцаж, тэдгээрийн оролцоо, дэмжлэгийг чиглүүлж ажиллах;

6./ Европын холбоо, Ази Номхон далайн орнуудын хамгийн нийгэмлэг, Төв ба Зүүн Ази (хойд ба өмнөд), Шанхайн хамтын ажиллагаа зэрэг олон улсын бүсийн байгууллагууд, тэрчлэн хөрш хоёр орны хил зэргэлдээ муж, өөртөө засах орнуудтай бүсчилсэн хөгжлийн бодлого, зохицуулалтын хүрээнд хамтран ажиллах арга зам, чиглэлүүдийг тогтоон хэрэгжилтийг дэмжих;

7./ Бүсчилсэн хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудлаар улс төрийн талуудын нэгдсэн байр суурь, зөвшилцлийн орчинг бүрдүүлж, төрийн бодлогын залгамж чанарыг хангах арга хэмжээ авах

### **Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө**

	Хийх үндсэн ажлууд	Санаачлагч ба оролцогч талууд
0	1	2
1	Бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах асуудлаар явуулсан нэгдсэн болон салбарын судалгааны тайланг нэгтгэж, үр дүнг Засгийн газарт танилцуулах, салбар яамдын бодлогод тусгуулах	ЗГХЭГ, ҮХГ, яамдын ШУТЗ,ШУА,Их дээд сургууль, мэргэжлийн холбоод, монгол дахь ДБ, АХБ, бусад олон улсын байгууллага, гадаад орны төлөөлөл
2	Төв болон Өмнөговь аймаг, Улаанбаатар хот, мөн бүс нутгийн төлөөлөл болгон Өмнөт Говийн бүсийн жишээгээр бусад аймаг, хот, бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрт тусгах бүсчилсэн хөгжлийн асуудлыг хэлэлцэж, зөвшилцөх уулзалтыг орон нутагт хийх/бүсчлэн/	ЗГХЭГ,ҮХГ, аймаг,нийслэлийн ИТХ, Засаг даргын тамгийн газар, мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөлөл

3	БХҮБ, БХУЗХ-ийг шинэчлэх талаар нэмэлт судалгаа хийж, дүгнэлт гаргах	ЗГХЭГ, Сангийн яам, хууль зүй дотоод хэргийн яам, ҮХГ ба бусад байгууллага
4	Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах асуудлыг хүн амын нутагшил, хот байгуулалтын, газар зохион байгуулалтын төлөвлөлттэй уялдуулах ЗГ-ын ажлын нэгдсэн хэсэг байгуулж, үр дүнг хэлэлцэх	ЗГХЭГ,БХБЯ, ҮХГ, ГХГЗГ болон бүс нутаг, хот төлөвлөлтийн зураг төсөл, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачид
5	Бүсчилсэн хөгжил, хотбайгуулалтын ажлын үр дүнг нийтэд мэдээлж, олон нийтийн санал авах ажлыг зохион байгуулах	ЗГХЭГ, ҮХГ, яамдын ажлын хэсэг, аймаг,нийслэл ЗДТГ

## ДОЛОО. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ СХЕМ, ХАВСРАЛТУУД

### Ашигласан материалын жагсаалт

1. Монгол улсын Үндсэн хууль. УБ. 1992 он. [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn)
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Төрийн мэдээлэл-9. 1994 он.
3. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. 1994 он
4. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого. 1999 он.
5. Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлого. 2000 он.
6. Төрөөс төвлөрлийг сааруулах талаар баримтлах бодлого. Засгийн газрын тогтоол. 2016 он.
7. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого. 2003, 2015он.
8. Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого. УИХ-ын тогтоолын хавсралт. 2015 он
9. Монгол Улсад чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал. 1996 он.
10. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль. 2003он.
11. Чөлөөт бүсийн тухай хууль
12. Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
13. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
14. Хот байгуулалтын тухай хууль
15. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. 2001он
16. Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги.2003 он
17. Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн 2006-2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрүүд. 2006 он

18. Бүсийн тулгуур төв-хотууд/Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуун-мод, Өндөрхаан, Чойбалсан/-ын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө. 2006 он.
19. Баруун бүсийн хөгжлийн төсөл. ЗТБХБ-ын яам. Инженер Геодези ХХК. 2008 он.
20. “Галбын говь” бичил бүс нутаг/Цагаансуврага, Оюутолгой, Тавантолгой/-ийн хөгжлийн төлөвийг тодорхойлох газар зохион байгуулалт-хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө. УБ. 2007 он. БХБЯ. Инженер Геодези ХХК.
21. “Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл”. УИХ-ын 2003 оны 54-р тогтоол.
22. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг. УБ. 2003 он.
23. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн үндэсний илтгэлүүд. УБ.2006 -2017 он. Сангийн яам.
24. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын ХХ-ийн хөтөлбөр. Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл. 2003-2017 онууд
25. Монгол Улсын Их Хурал. Монгол Улсад хүний эрхийг хангах хөтөлбөр. УБ.2003 он
26. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. УБ.2016 он.
27. Монгол Улс Эдийн засгийн өсөлтийн эх сурвалжууд. Эдийн засгийн санамж бичиг. Дэлхийн банк. 2007.07.26.
28. Статистикийн эмхтгэл. 2010 -2016 – 2017 он.
29. Үндэсний статисткийн хорооны мэдээлэл судалгааны төвийн материалууд. 2010 -2017 он
30. Монгол банкны судалгааны төвийн бүс нутгийн талаар судалгаа шинжилгээний материалууд 2010-2017 он
31. УИХ –ын дэргэдэх судалгааны хүрээлэнгийн бүс нутгийн талаарх бодлогын судалгааны материалууд. 2015-2017 он.
32. Монгол Улсын байгаль орчны төлөв байдлын тайлан. 2010 – 2017 он.УБ.
33. Дархан, Эрдэнэт хотуудын эдийн засгийн орон зайн бүтэц, хүрээ. ХБНГУ-ын бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл. УБ. 2009., 2010. 7-р сар. Үйлдвэржүүлэлтийн судалгаа/Дархан, Завхан, Хэнтий аймгийн жишээгээр/. Gtz.-ХБНГУ/-ийн “бүс нутгийн эдийн засгийг дэмжих төсөл. УБ. 2009 он.
34. Монголын Улсын бүс нутгийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх нь. АХБ-ны МОН3948 төслийн материалууд. 2004 он. Сангийн яам, ҮХШХ/хуучнаар/ -ны мэдээллийн сан.
35. Монголын Өмнөт-говийн бүсийн дэд бүтцийн хэтийн төлөв. ЗТБХБЯ, Дэлхийн банкны төслийн тайлан материал. 2006 - 2007 он.
36. Монгол улсын хөгжлийн судалгаа. Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн бүтээлийн эмхэтгэлүүд. 2003-2010 он. Стратеги судлалын Хүрээлэнгийн мэдээллийн сан.
37. Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх арга зүйн асуудал. Г. Баттүвшин., ШУТИС-ийн мэдээллийн сан 2012 он. 38. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн

судалгааны эцсин тайлан. Япон улсын хамтын ажиллагааны байгууллага/ЖАЙКА/. АЛМЕК корпораци. 2016 он.

38. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын онол арга зүйн боловсруулалт. Сангийн яамны захиалгат төсөл. ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн/ бүс нутаг судлаач Т.Энэбиш, Б. Нямаа/. УБ., 2012 он

39. Бүсүүдийн нийгэм, эдийн засгийн хөгжил, нутагшилт, суурьшлын судалгааны аргачлал” боловсруулах зөвлөх үйлчилгээний тайлан. ММСГ ХХК., 2012 он. ҮХШХ/хуучнаар/-ны захиалгат ажил.

40. Монгол улсын хөгжлийн төлөвлөлтийн тухай хууль, холбогдох журам заавар. 2016 он, Сангийн яам.

41. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030. Сангийн яам, ҮХГ. 2016 он

42. Үндэсний хөгжлийн газрын мэдээллийн сангийн холбогдох материалууд

43. Яам, агентлаг, мэргэжлийн холбоодын мэдээллийн сан, вэб сайтууд

44. Улаанбаатар хотын 2020 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага/ii боть/ . 2013 он ., БХБЯ, НЗДТГ.

45. ҮСХ., ЭДИЙН ЗАСГИЙН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА. УБ., 2011

46. ННФ. Г. Жаргал. Орон нутгийн эдийн засгийг бие даан хөгжүүлэх боломж арга зам. УБ. 2006 он.

47. ГУРВАН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО., Засгийн газрын 2018 оны 42 дугаар тогтоолын хавсралт., УБ.2018.

48. АХБ. МОН 3948 ТТ-ны төсөл. Монголын бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь. Бодлогын зөвлөмжийн баримт бичиг № 1-3. УБ., 2004 он.

50. ДБ-ны бодлогын мэдэгдэл. Монгол Улсын бүсчилсэн хөгжил /Зарим асуудал/. УБ 2005 он.

51. Инээмсэглэсэн Монгол. Бүсчилсэн хөгжлийн загвар. Д. ОДХҮҮ., УБ.2014

52. МОНГОЛ УЛС. Аймгуудын өрсөлдөх чадварын Тайлан., 2014-2017 он.Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв.УБ.2016., 2018 он.

Хавсралт 1.

**Монголын Бүсчилсэн хөгжлийн талаарх иргэдийн  
нийтлэл, өгүүллийн жагсаалт (2010 – 2018 он)**

1. Хангайн бүсийн хөгжлийн үүд хаана байгааг эрэлхийлсэн нь. 2017.11.04
2. “Монголын эдийн засгийн чуулган 2018”-ын “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого” сэдэвт салбар хуралдаан. 2018.05.22
3. Бүсчилсэн хөгжлийн онол практикийн асуудал. ОУ-ын бага хурал.
4. С.Батболд. “Хөгжлийн алтан гурвалжин” бодлого.
5. Б.Болор-Эрдэнэ. “Хорин жилийн дараа Монголын малыг хэн маллах вэ?”. Үндэсний шуудан сонин. 2018.05.31
6. Б.Батбаяр. Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтөд суурилан үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй. ЗГ-ын мэдээ. 2017.11.27.
7. Б.Гандолгор. Хөрсөн дээр буюугаагүй бүсчилсэн хөгжлийн бодлого. ЗГМэдээ сонин. 2017.02.07
8. Б.Гандолгор. Хөгжих хүсэл ба бүрхэг бодлогын гацаа. 2017.08.10
9. Кластержуулах процесс: Чацарганы кластерын санаачилгын жишээ. Х.Цэвэлмаа. МУИС. 2017.02.07
10. Нийтлэлч Д.Жаргалсайхан. Бүсчилж хөгжүүлэх бүтээгүй оролдлого. 2018.05.31 <http://jargaldefacto.com>
11. Нийтлэлч Д.Жаргалсайхан. Улаанбаатараа дэлхийн хот болгоё. 2013.10.09. <http://jargaldefacto.com>
12. Нийтлэлч Д.Жаргалсайхан. Нийслэл хот - хөгжлийн чөдөр. 2012.07.25. <http://jargaldefacto.com>

13. Нийтлэлч Д.Жаргалсайхан. Бүсийн хөгжлийн бодлого ба залуучуудын оролцоо. 2016.04.13. <http://jargaldefacto.com>
14. Нийтлэлч Д.Жаргалсайхан. Барилгынхны гацаа ба гарц. 2016.04.27. <http://jargaldefacto.com>
15. Eagle TV. "Бүсчилсэн хөгжлийн асуудлаар" сэдэвт нэвтрүүлэг. "СЭДЭВ 360 Хөтөлбөр". 2012.11.12.
16. Д.Эрдэнэбат. "Хагархай цонх шиг эх орон минь" ном. 2012 он. /Бүсчилсэн хөгжлийн тухай/
17. "Аймгийн болон сумын төвүүдийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалт". АХБ-ны "Төслийн судалгааны танилцуулга". БХБЯ. 2017.10.09.
18. Г.Сонинбаяр. "Бүсчилсэн хөгжлийн замын зураг" нийтлэл. 2018.04.18. [www.medee.mn](http://www.medee.mn)
19. Г.Сонинбаяр. "Бүдэрч бүдгэрсэн бүсийн нэмэгдэл" нийтлэл. 2018.04.17 [eagle.mn](http://eagle.mn)
20. Судлаач Д. Ганхуяг. "Дайчилгааны эдийн засаг" нийтлэл. 2018.02.02 [ganaa.mn](http://ganaa.mn)
21. Судлаач Д. Ганхуяг. "Улсаа яаж хөгжүүлдэг вэ?" нийтлэл. 2015.06.14 [ganaa.mn](http://ganaa.mn)
22. Судлаач Д. Ганхуяг. "Толгой нэхэхийн учир" нийтлэл. 2014.05.25 [ganaa.mn](http://ganaa.mn)
23. Судлаач Д. Ганхуяг. "Зүүн гар" нийтлэл. 2013.05.04 [ganaa.mn](http://ganaa.mn)
24. Нийтлэлч Баярхүү. "Геополитик геоэкономик бүсчлэл" нийтлэл. 2017.11.15. ЗГМэдээ.
25. Б.Энхмандах. "Монголын хөгжлийн загварыг төсөөлөхүй" нийтлэл. 2012. [tsahimurtuu.mn](http://tsahimurtuu.mn)
26. Алберт Туйнхоф. "Монголын Өмнөд Бүс Нутгийн Тогтвортой Хөгжил – Газар доорх усны удирдлагын чухал асуудлууд" судалгааны танилцуулга. Дэлхийн банк. 2010.04.28
27. Э.Адъяасүрэн. "Зүүн бүсийн хөгжлийн гарцыг эрэлхийллээ" зөвлөгөөний тэмдэглэл. МҮХАҮТ-ын <https://www.mongolchamber.mn> вэб сайт. 2017.10.27



28. н. Цогтсайхан. ХААИС, эдийн засаг бизнесийн сургууль. “Баруун бүсийн эдийн засгийн макро түвшний шинжилгээ”. 2014.02.13
29. Г.Нямдаваа. “Баруун бүсийн хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашдын зорилт” илтгэл. <http://www.iltod.gov.mn> . 2011.05.27
30. М.Мөнхтунгалаг. “Баруун бүсийн хөгжлийн гарц юу вэ” нийтлэл. “Нийгмийн толь” сонин. 2012.07.31
31. “НОРТЕРН РЕЙЛВЭЙС” ХХК. “Хойд бүсийн төмөр зам” төслийн танилцуулга. <https://northernrailways.mn> 2013.05
32. Д.Одхүү. “Инээмсэглэсэн монгол”. “Бүсчилсэн хөгжлийн загварын тухай шинэ үзэл баримтлал (Концепц)”. Бизнес таймс сэтгүүлийн нийтлэл. 2013.03.15
33. Г.Жаргал. Удирдлагын академи. ННФорумын вэб сайт. “Аймгийн төвүүдийн үүсэл ба фрактал шинж”. 2005.121.Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын онол арга зүйн боловсруулалт. Суурь судалгааны тайлан., ШУА., Геоэкологийн хүрээлэн. УБ. 2010-2012 он.
34. ҮСХ, ЭДИЙН ЗАСГИЙН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА. УБ., 2011
35. ННФ. Г. Жаргал. Орон нутгийн эдийн засгийг бие даан хөгжүүлэх боломж арга зам. УБ. 2006 он.
36. Д.Санчир. “Дэлхийг авч явах Монголын инструмент-мэдлэг ба мөнгө” нийтлэл. sonin.mn вэб сайт. 2012.03.21
37. Б.Гэрэлжаргал. ШУТИС, ҮТДС. “Монгол Улсын чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх”. 2014.02.12
38. Г.Цэвэлмаа. ШУТИС, КТМС. “Чөлөөт бүсийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломж”. 2014.02.13
39. Х.Цэвэлмаа. “Чацарганы кластерын санаачилга” ШУА-ийн мэдээ. 2017 №1
40. Балгансүрэн. “Нэгдэн нийлж хорших нь өнөөгийн эдийн засгийн хөгжлийн зөв гарц болно”. Зууны мэдээ. 2018.07.20
41. Б.Төгс. “Аймаг эзгүйрч, сумд хумигдах уу.” МНВ. /Интернет/. ШУА-ийн тайлан.
42. Б.Цэрэнчунт. “Монгол улсын жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн индекс”. Харилцаа холбоо. 2009. /интернет/

43. Ш.Ариунболд, Б.Лхам. Эдийн засгийн бүс нутгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтийн харьцуулсан судалгаа. ҮСХ. 2012 он. Интернет.
44. Л.Лувсанжамц. Төсвийн орлогын хуваарилалтыг өөрчлөх арга замууд. PDF file. 2012. Интернет.
45. Ш.Мянган. Хөгжлийн Монгол загвар. /Баруун, Зүүн жигүүр, Төв хэсэг/. Интернет. Erdemt. 2007. 11-р сар
46. Ш.Булган. [www.act.mn](http://www.act.mn) 2018.5.1. [www.zалуу.com](http://www.zалуу.com) Сумын дайтай аймаг, багийн багцаатай сум байлгах уу, баллуурдах уу?
47. Энхзаяа Учрал. SMARTcity. Оюунлаг хотыг хөгжүүлэх онол, арга зүйн судалгаа. Интернет. 2012 он. slideshare.net

## **Бодлогын судалгааны арга зүйн нэгдсэн зөвлөмжийн төсөл**

### **Нэг . Нийтлэг зүйл**

- 1. Зөвлөмжийн зорилго:** БХТС бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, дотоод, гадаадын судалгааны байгууллага, иргэний болон ТББ, Монголын хөгжлийг дэмжигч олон улсын улсын байгууллагын оролцоог хангаж, харилцан зөвшилцлийг бий болгоход оршино. Энэхүү нэгдсэн зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 165 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах / цаашид БХТС гэх / бодлого боловсруулахад шаардагдах судалгааны ажлын жаагсаалт”-д тусгагдсан нэгдсэн болон салбарын хөгжлийн асуудлаар холбогдох судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэд, судлаачид, дотоод, гадаадын төслийн болон ТББ-ын ажилтнууд, бодлогын төсөл боловсруулагч мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоодод зориулж байна.
- 2. Захиалагч:** Үндэсний хөгжлийн газрын салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтэс байна. Эрдэмтэд, судлаачдын баг, яамдын ажлын хэсгүүд арга зүйн энэхүү нэгдсэн загварыг баримтлан судалгааны тодорхой арга хэлбэрийг сонгож, нэгдсэн баримт, мэдээлэлд тулгуурлан, судалгааны зорилго, агуулга, гарсан үр дүнг хоорондоо уялдуулсан нэгдсэн санал, зөвлөмж, тооцоо бүхий бодлогын судалгааны тайлан, тойм бэлтгэж, Үндэсний хөгжлийн газраас тогтоосон хугацаанд ирүүлж, хэлэлцүүлнэ.
- 3. Захиалсан үндсэн сэдэв:** Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын судалгаа
- 4. Тодорхой сэдвүүд :**
  - Макро эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээн дэх БХТС асуудлын зохицуулалтын судалгаа
  - Хүн амын хөгжил, байршил, ажиллах хүчний зах зээлийн судалгаа
    - Аж үйлдвэрийн салбарын нэгдсэн болон салбар бүрийн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа
    - Хөдөө аж ахуйн салбарын нэгдсэн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа

- Барилга , хот байгуулалтын салбарын нэгдсэн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа
- Зам, тээврийн салбарын нэгдсэн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа -Эрчим хүчний салбарын нэгдсэн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа
- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын нэгдсэн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа,
- Аялал жуулчлалын салбарын нэгдсэн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа
- Уул уурхайн салбарын нэгдсэн төлөвлөлт, байршилт, хөгжлийн судалгаа
- Нийгмийн үйлчилгээний салбаруудын нэгдсэн болон балбар бүрийн төлөвлөлт, баршилт, хөгжлийн судалгаа
- Экологийн тогтвортой байдлын судалгаа

##### **5 Бодлогын судалгаа хийхэд харгалзах нийтлэг үндэслэл, шаардлага:**

-Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, байршилт нь эдийн засгийн үр ашгийг тогтвортой нэмэгдүүдэх өсөлтийн хүчин зүйл болж чадаагүй харин ч хүрээлэх орчны даац, чанарыг муутгаж, оршин суугчдын аж байдал, эрүүл мэндэд ноцтой нөлөөлсөн олон тооны сөрөг үр дагаварыг бий болгосоор байна. Өнөөдөр энэ асуудал үндэсний аюулгүй байдлын түвшинд дэвшигдэж байна.

- Тус улсын өргөн уудам газар нутаг, түүний байгалийн баялаг, үзэсгэлэнт газар, түүх соёлын их өв, мал аж ахуйн түүхий эдийн нөөцийг дотоод, гадаад зах зээлд бүрэн, зохистой ашиглаж, үр өгөөжийг нь тэгш шударга хуваарьлаж ирээгүйгээс хүн амын аж байдлын түвшин жигд дээшилж чадаагүй, ажилгүйдэл, ядуурал ихсэж, хүн ам нийслэл, Дархан, Эрдэнэт хот, уул уурхайн цөөн тооны төвүүд рүү шилжин суурьшиж, гадаад оронд гарч ажиллах явдал үргэлжилсээр байна.

- Эдийн засгийн бүсүүд , аймаг, орон нутаг, хот сууринг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах талаар өнөөг хүртэл баримталж ирсэн бодлого, хөтөлбөрүүд, чөлөөт бүсүүд ба хот суурингийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүд өөр хоорондоо болон бүсчилсэн хөгжлийн нэгдсэн үзэл баримтлал, үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, жил бүрийн төсөв санхүүгийн хөөц, хуваарьлалт, аж ахуйн салбарууд, гадаадын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй тухай бүр уялдаж чадаагүйгээс үр дүн нь хангалтгүй байгаа юм. Тэдгээр нь мөн даян дэлхийн болон Монгол улсын тогтвортой хөгжлийн стратеги, байгаль орчны хамгаалах шаардлагыг хангах нийтлэг зорилгод

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн болон хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай, Чөлөөт бүсийн тухай хуулиудын боловсруулалт, хэрэгжилтийн шатны уялдаа хангалтгүй, тэдгээрт тодорхойлогдсон эрх зүйн хэм хэмжээ, заалтууд тус улсын нутаг дэвсгэрийн нийгмийн харилцаа, орон зайн зохион байгуулалтыг оновчтой зохицуулдаг хуулийн нэгдмэл мехаиизм болж үйлчлээгүй, хүмүүсийн нийтээр дагаж мөрддөг ёс зүй, үзэл санаа, дадал,

заншлыг ч бүрэн тусгаж чадаагүй байгаа юм. Үүнээс шалтгаалж, бүс нутгийн үндэсний хэмжээний хөгжлийн нийтлэг асуудлыг гол төлөв орон нутаг – салбарын бодлогоор зохицуулахыг эрмэлзэж ирэв.

- Даяаршлын нөхцөлд, дэлхийн улсууд, түүний дотор манай хөрш хоёр орон ОХУ, БНХАУ –ын геополитик, геоэдийн засгийн чиг хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдөж байна. Тухайлбал, ОХУ Сибир, алс Дорнод руу чиглэсэн хөгжлийн бодлогоо шинэчилж, Зүүн хойт Ази, Номхон далайн оруудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийг зорих боллоо. БНХАУ ч Ази, Европыг холбож байсан торгоны замын худалдаа – эдийн засгийн харилцааг үндэслэн “Нэг бүс – нэг зам” –ын шинэлэг бодлогыг тодорхойлж, энэ чиглэлд татагдаж байсан бүх орон, түүний дотор Хятад-Орос- Монгол гурван улсын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг батламжилж, хэрэгжүүлэхээр тохиролцоод байна.

- Дээр дурдсан дотоод нөхцөл байдал, гадаад орчны өөрчлөлт нь бүс нутгийг хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах талаар өнөөдрийг хүртэл баримталж байгаа үзэл бодлыг нягтлан өөрчилж, амьдралд хэрэгжих боломжтой, ирээдүйг угтан харсан бүсчилсэн хөгжлийн шинэчилсэн бодлогыг тодорхойлоход хүргэж байна. Ийм бодлого тодорхойлж, уялдаатай хэрэгжүүлэх эрх зүйн орчин, бодлогын үндэс тавигдлаа. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай Монгол Улсын хууль батлагдаж, энэ дагуу Монгол Улсын Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх үзэл баримтлалыг боловсруулан мөрдөж байна. Эдгээр бодлого, үзэл баримтлалд эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын мөн чанарыг шинэчлэн ойлгох хуулийн нэр томъёо, түүнийг үндэсний болон орон нутаг, салбарын бодлоготой уялдаатай боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн болон зохион байгуулалтын нийтлэг хэм хэмжээ тусгагдсан болно.

#### **6. Бодлогын судалгааны агуулга, чиглэмж :**

-дээр дурдсан үндсэн болон тодорхой сэдвүүдээр манайд баримталж ирсэн үзэл бодол, судалгааны арга зүйг бусад улс орны судлаачдын орчин үеийн нийтлэг жишигтэй харьцуулан судалж, шинжлэх ухаан -танин мэдэхүйн нэгдмэл ойлголтыг бүрдүүлэх

-бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах шаардлагын үндэслэлийг бодит амьдрал дээр, тодорхой жишээ баримтаар судлан, учир шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийг илрүүлэн гаргах, дээрх сэдвүүдээр хэрэгжүүлсэн болон одоо баримталж байгаа бодлого, хөтөлбөрүүдийн үр дүнд хөндлөн /улс төрөөс ангид/-гийн болон албан ёсны дүгнэлт өгөх

- бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах шаардлагыг харгалзан дээр дурдсан сэдэв бүрийн хүрээнд баримтлах бодлогын үзэл бодлын үндсийг тодорхойлох, зах зээлийн нөхцөлд аймаг, орон нутаг, хот, тосгон, үйлдвэр, үйлчилгээний хөгжил, байршилтын үр өгөөжийг цаашид сайжруулах боломжит хандлага, ирээдүйн зураглалын талаар шинжлэх ухааны таамнал боловсруулж, асуудал шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг дэвшүүлсэн байх

**7. Судалгаанаас гарах үр дүнгийн таамаглал:** Монгол улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал/2030 он хүртэлх/ , Монгол улсын гадаад харилцааны үзэл баримтлалыг үндэс болгон, хүн амэкологи, нийгмийн аюулгүй орчинд ажиллаж,

амьдрах газар нутаг, хот тосгоноо чөлөөтэй сонгон, зохистой хэмжээнд төвлөн суурьшиж, байгаль, мал аж ахуйн баялгийг зах зээлийн нийтлэг зарчмаар бүрэн, үр өгөөжтэй ашиглан, аж байдлаа тогтвортой дээшлүүлэн тав тухтай амьдарч, уламжлалт түүх соёлоо хадгалан, олон талаар боловсрон хөгжих стратегийн зорилгод нийцсэн эдийн засгийн зохицуулалтыг бүсчлэн тогтоосон, үндэсний хэмжээний, урт хугацааны, бүх нийт/аймаг орон нутаг, аж ахуйн салбар нэгж, иргэд г.м/-ийн оролцоо, дэмжлэгээр үр дүнтэй хэрэгжих монгол төрийн өвөрмөц үзэл санааг тодорхойлсон шинжлэх - ухаан танин мэдэхүйн болон олон нийтийн зөвшилцлийн нэс зүйн үндэс, засгийн газрын байгууллагуудын хөгжлийн төлөвлөлт, бодлогын алсын нэгдмэл хараа бүрдсэн байх. **БХТС бодлогын судалгаа, дүн шинжилгээ нь :**

**нэгд**, үндэсний хэмжээнд, эдүүгээ явуулж буй улс төр, эдин засаг, нийгэм, ёс суртахуун, байгаль орчин, гадаад бодлогын бүхий л үйл ажиллагаа нь монгол орны нутаг дэвсгэр, оршин тогтнол, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хамгаалж, газар нутаг, түүний баялгийг амьдрах орчинд хал багатай, зүй зохистой ашиглаж, үр өгөөжийг нь нийт нийгмийн хэрэгцээнд тэнцвэртэй хуваарьлах үндэстний нийтлэг эрх ашгийг хангах, **хоёрт**, амьдрах, газар, ажиллах газраа чөлөөтэй сонгон, бүх талаар боловсрон хөгжиж, бүтээлчээр хөдөлмөрлөн, уугуул нутагтаа тав тухтай амьдрах иргэний эрхийг хэрэгжүүлэх, **гуравт**, хуулиар эзэмшиж, өмчилсэн нөөц, баялгаа зах зээлд өрсөлдөн нэмүү өртөгтэй ашиглаж, эдийн засгийн талаар бие даан хөгжих аймаг, орон нутаг, аж ахуйн нэгжийн ашиг сонирхолыг хослуулах тулгын гурван зарчмыг мөрдлөг болгох, **эцсийн дүндээ**, хот, хөдөөгийн хүн амын ажиллаж амьдрах харьцангуй адил тэгш нөхцлийг хангах үйлдвэрлэл, үйлчилгээний орон зайн бүтэц, зохион байгуулалт, бүс нутаг хоорондын хөдөлмөрийн хуваарь, нийгмийн харилцааны суурь зарчмаар нэгтгэгдэх учиртайг судлаачид анхаарах ёстой. Ингэснээр дээрх хууль тогтоомжид заасан “Нөхцөл, байдлын дүн шинжилгээ”, нөлөөллийн үнэлгээг нэгтгэн боловсруулж, бүсчилсэн хөгжил, төвлөрлийн асуудлаарх хөгжлийн бодлогыг шинэчлэн хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагыг хангаж, тулгамдсан асуудлыг оновчтой тодорхойлох боломж бүрдэнэ.

**8. Судалгаанд баримтлах нэгдсэн ойлголт, ухагдахуун:** БХТС бодлогын судалгаанд *эдийн засгийн бүс, бүсчлэл, бүс нутаг, бүс нутгийн бодлогын талаарх ойлголт, ухагдахууныг* Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал/УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол/ -ын “Гурав. Гол үзэл санаа” гэсэн хэсгийн 3.2.1, 3.2.2, 3.2.3 дахь заалтаар, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль/УИХ, 2015 оны 11 сарын 26 –ны өдөр/ -ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтаар, *төвлөрлийг сааруулах бодлогын үндсэн агуулга, ойлголтыг* засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Төвлөрлийн сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн 3.1.1-ээс 3.1.4 дэх заалтуудаар, *чөлөөт бүс, түүнтэй холбоотой ойлголтыг* Чөлөөт бүсийн тухай хууль/2015 онд шинэчлэн найруулж баталсан/-ийн 3 дугаар зүйлийн заалтуудаар тус тус тодорхойлсон хуулийн нэр томъёоны дагуу тус тус хэрэглэнэ. Үүний зэрэгцээ, дотоод, гадаадын сүүлийн үеийн хэвлэл, мэдээлэлд гарч буй бүсчлэл, төвлөрөлтэй холбоотой дор дурдсан зарим нэр томъёо, шинэ

тутам ойлголтыг бүтээлчээр ашиглан, цаашид судалгаа, бодлогын түвшинд нэг мөр болгон хэвшүүлэх зарчмыг барих нь зүйтэй байна. Үүнд: коридор/эдийн засгийн, тээвэр – хөгжлийн, ногоон хөгжлийн г.м/, босоо/уртраг/ ба хөндлөн/өргөрөг/ тэнхлэгийн бүсчлэл, кластер, хөгжлийн бүс, өсөлтийн төв буюу туйлууд, бүс нутгийн зах зээлийн өрсөлдөөн, бүс нутгийн нийгмийн жигд ба тэнцвэрт хөгжил, удирдлагын буюу эрх хэмжээний төвлөрөл ба үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрөл, хоршилт, төрөлжилт гэх мэт. Эдгээрийг судалгааны тайлан, үр дүнг хэлэлцэх явцад ярилцаж, жигдлэх нь олон нийтийн ойлголтод тустай гэж үзнэ.

**9. Судалгааны түвшин, хамрах хүрээ :** БХТС асуудлыг улс үндэсний /гадаад орон, олон улсын түвшинг оруулаад/ болон бүсийн хэмжээнд / хөрш болон, бүс нутгийн орнуудын хоорондын хамтын ажиллагааны хүрээг хамруулан/, аж ахуйн салбар, түүнтэй харилцан холбоотой бусад салбарууд, аймаг, орон нутгийн түвшинээр харьцуулан судалж, тодорхой аймаг, сум, хот, тосгон, үйлдвэр, үйлчилгээний газрыг жишээ болгон явуулна.

**10. Судалгаанд баримтлах ерөнхий арга зүй:** БХТС талаар бодлогын судалгаанд орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны нэгэн хавсрага салбар болж байгаа төрийн удирдлага, бодлого судлалын арга зүйн зарчмыг баримтална. Ингэдээ, эдийн засаг, нийгэм, байгалийн бүсчлэл, мужлалтын талаар тус оронд болон бусад улсад хийгдэж ирсэн онолын сууь судалгаа/академик гэж нэрлэдэг/- ны үр дүн, туршлагыг ашиглах боловч практикт илүү чиглэсэн байх зарчмыг гол болгоно. Тухайлбал, бодлогын судалгаа”, шинжилгээ нь бодлогын өөрчлөлт хийхэд гарч болох үр нөлөөг таамаглахын зэрэгцээ тодорхой асуудлыг шийдвэрлэх бодлогын хувилбар боловсруулан шийдвэр гаргагч, бодлого боловсрууагчдад танилцуулах шаардлагыг хангасан байх учиртай. Энэ зарчимд үндэслэн БХТС бодлого судлалын ажлыг хоорондоо харилцан уялдаатай *бодлогын судалгаа, бодлогын шинжилгээ* гэсэн хоёр үе шатаар явуулна. Үүнд:

- бодлогын судалгаа нь (бодит байдлын судалгаа) бодлогын хэрэгжилтийн үйл явцад үүссэн, шийдэх шаардлагатай асуудлыг тодорхойлж, нэгдсэн санал, дүгнэлт зөвлөмж гаргах
- бодлогын шинжилгээ нь бодлогын судалгааны үр дүнд үндэслэн, бодлогын боломжит хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн үр ашиг, хэтийн нөлөөллийг тооцоолон, оновчтой гэж үзсэн хувилбаруудыг санал болгох. **Бодлого судлалын** зорилго, агуулга нь дээр өгүүлсэн “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам” –ын дөрөвд заасан “**нөхцөл байдлын дүн шинжилгээ**”/НБДШ/ -г, **бодлогын шинжилгээний** зорилго, агуулга нь журмын тав-д заасан “**нөлөөллийн урьдчилсан үнэлгээ**”/НУҮ/-г бий болгоход тус тус чиглэгдэж байгаа болно. Үүнээс хамаарч эдгээр ажил нь харилцан уялдаатай байх боловч, судалгааны зориулалт, хамрах хүрээ, судалгаа хийх хүмүүс, аргачлал, дизайн, ашиглах мэдээллийн эх үүсвэр, хийгдэх хугацаа, гарах үр дүн нь тус тусдаа өөрийн өвөрмөц онцлогтой

байна.Бодлогын судлал хийх арга аргачлалыг тавьсан ерөнхий болон тодорхой зорилгоос хамааруулансудлаач өөрөө сонгон авна. Ээнэхүү судалгааны туршид шинэ олон аргыг судлан хэрэглэх бүрэн боломжтой юм. Судалгааны тоон болон чанарын олон арга үзүүлэлтийг хослуулан ашиглаж, харьцуулсан дүгнэлт хийнэ.

Статистик ба эконометрик шинжилгээ, бүтцийн, байршилтын, борлуулалтын тээврийн зардлын тооцоо, шаардлагатай үед, салбар хоорондын математик загварчлалын үр дүнг шинжлэх аргуудын зэрэгцээ техник – эдийн засгийн үзүүлэлтүүдийгаймаг бүс нутаг, салбараар харьцуулан/мөн гадаад оронтой/, жишсэн судалгаа, индексчлэх, хамаарлын корреляц, бүсчлэх, зураглах, фокус бүлгийн, кейс судалгааны орчин үеийн аргыг ашиглана. Тодорхой аймаг, салбараар түлхүүр судалгаа хийж жишиг болгон харуулах нь чухал бөгөөд, богино хугацаанд, нийгмийн тодорхой бүлгийн дунд санал асуулга явуулж ч болох юм.

**11.Судалгааны ажлын нэгдсэн ур дун:** Судалгааны ажил нь бодлогын судалгаа, бодлогын дүн

шинжилгээний хувьд тус тусын онлогтой байх боловч эцэстээ БХТС бодлогын үндэслэл болох дор дараах нэгдсэн үр дүнг авахад чиглэгдсэн байна. Үүнд:

- Манай орны эдийн засгийн бүсчлэл/мужлалт/, бүсчилсэн хөгжил, төвлөрөл, бөөгнөрлийн түүхэн хандлага, түүний өнөөгийн үр дагавар, учир учир шалтгааныг регрессийн шинжилгээ, синтезийн аргын тусламжтай тогтоон, тулгамдсан асуудал, шийдвэрлэх боломжийг тодорхойлсон нэгдсэн зөвлөмж боловсруулна.
- БХТ –ийн байдлыг монголын хүн амын нутагшил, соёл, ёс заншлын уламжлал, шинэчлэл, газар нутгийн ашиглалт, хот суурин, үйлдвэр, үйлчилгээний байршилтын орон зайн зохион байгуулалтын онцлог шинж байдал, зах зээлийн өнөөгийн эрэлт хэрэгцээтэй харьцуулан, бусад оронтой жишсэн дүн шинжилгээ хийж, тэдгээрийг нэгдмэл бодлогоор уялдаатай хэрэгжүүлэх талаар нэгдсэндүгнэлт гаргана
- Дээрх нэгдсэн зөвлөмж, дүгнэлтүүдийн үндсэн дээр Монголд ойрын ирээдүйд хэрэгжүүлэх БХТС эдийн засгийн бодлогын хувилбаруудыг боловсруулж, илүү оновчтой байж болох нэгээс хоёр хувилбарыг санал болгоно.
- Санал болгосон хувилбаруудыг хэрэгжүүлэх улс төр, нийгмийн удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо, хууль, ёс зүйн хэм хэмжээ, эдийн засаг, санхүүгийн арга хэрэгсэл, гадаад бодлогын чиглэлийн талаар нэгдсэн зөвлөмж, баримтлал гаргана
- БХТС нэгдсэн бодлогын хүрээнд аймаг бүс нутаг, хот байгуулалт, аж ахуйн салбар, иргэний нийгмийн талаар баримталж ирсэн тодорхой бодлого, тэдгээрийн үр дүн, нөлөөлсөн хүчин зүйлс, ашигласан арга хэрэгслүүдийн өнөөгийн байдлын талаар болон судалгааны явцад ойрын ирээдүйд хэрэгжүүлэхээр дэвшүүлэн тавьж байгаа асуудал, шийдэл, бодлогын хувилбарын хувьд харьцуулсан шинжилгээ хийж, дүн шинжилгээний хураангуй тайланг гаргана.

**Хоёр. Бодлогын судалгаа хийх:**



**12.** Бодлогын судалгааны зориулалт нь дээр дурдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-мын Дөрөвт заасан нөхцөл байдлын дүн шинжилгээг тухайн асуудлын хүрээнд хийлгэхэд оршино. НБДШ –ний дагуу бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах бодлого хангалтгүй хэрэгжиж ирсэн шалтгаан, үр дагавар, үүнд нөлөөлсөн улс төр, эдийн засаг, нийгэм-сэтгэлзүйн хүчин зүйлс, мөн бодлогын алдаа, үзэл бодлын зөрөө зэргийг бодитой үнэлж дүгнэн, бодлогыг шинэчлэх үндэслэл, шаардлага, тулгамдсан асуудлыг оновчтой тодорхойлсон байна.

**12.1.** Бодлогын судалгааг Үндэсний хөгжлийн газраас томилсон эрдэмтэд судлаачдын баг ахалж, шаардлагатай үед судалгааны болон холбогдох их дээд сургууль, судалгааны болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодын хүмүүсийг оролцуулан гүйцэтгэнэ.

**12.2.** Бодлогын судалгааг дараах дэсдарааллаар явуулна. Үүнд:

**1/ Судалгааны асуудлыг тодорхойлох:**дээр дурдсан холбогдох сэдвийн хүрээнд одоо мөрдөж буй бодлогын хэрэгжилтийн явцад үүссэн тулгамдсан асуудлын цар хүрээ, нөхцөл байдал, шалтгааны уялдаа хамаарлыг судлана. Тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн цар хүрээг тодорхойлохын тулд "бодлогын асуудлын зураглал"-ыг гаргаж, судлах асуудал, тавих зорилтоо томъёолон, таамаглал дэвшүүлнэ.

**2/ Таамаглал (гипотез) дэвшүүлэх:**асуудлыг тодорхойлсоны дараа түүний тавигдах болсон шалтгаан, шийдэх арга зам, үр дүнгийн талаар таамаглал дэвшүүлнэ. Энэ нь онолын шинжтэй байх боловч, судлаач энэ зөвлөмжийн 7-д дурдсан ерөнхий таамаглалыг харгалзан нийгмийн эрэлт, захиалагчийн шаардлагын үүднээс тухайн салбарын тулгамдсан асуудлын нөхцөл байдал, шийдвэрлэх арга замыг хэрхэн урьдчилан харж байгаагаа илэрхийлэх юм.

**3/ Судалгааны аргыг сонгох:**сонгосон бодлогын эрх зүйн орчин, тулгамдсан асуудал, хэрэгжилт, хугацаа, үүссэн нөхцөл байдал, мэдээллийн эх сурвалж зэргээс шалтгаалан судалгааг ямар аргаар хийхийг тогтоодог. Ихэвчлэн тоон, чанарын, контент анализ, кейс зэрэг аргуудыг ашиглах ба хэд хэдэн аргыг хослуулан хэрэглэж болно.

**4/ Судалгааны нэгж, түүвэрлэлтийг тогтоох:**бодлогын судалгааны асуудал, зорилго, зорилтоос шалтгаалан нэгж, түүвэрлэлтийн тоог тогтооно. Нэгж нь улс үндэстэн, бүс, бүс нутаг, салбар, үйлдвэрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, арга хэмжээнүүд байна. Эдгээрийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийн байдалд үзүүлж буй хүчин зүйл, нөлөөллийн олонлогоос хамааран нарийвчлан судлах асуудлаа цаг хугацаа, газар зүйн байршил, бүс нутаг, салбарын хөгжлийн шалгууруудын дагуу сонгоно.

**5/ Судалгаа хийх ба дуусгах цаг хугацааг тодорхойлох:**бодлогын судалгаа нь захиалагчийн шаардлагын дагуу тодорхой шийдвэр, шийдэлд хүрэх зорилготой тул цаг хугацааны хязгаарлагдмал /богино/ хүрээнд хийгдэнэ. Үүнийг доор судалгааны ажлын төлөвлөгөөнд үзүүлэв.

**6/ Судалгааны ухагдахуун, зарчмыг тодорхойлох:**Энэхүү зөвлөмжийн 8-д санал болгосон бүсчилсэн хөгжил, төвлөрөлтэй холбоотой үндсэн нэр томъёо, мөрдлөгийг үндэслэн тухайн судалгаанд ашиглах үндсэн ойлголт, зарчимаа тодорхойлно. Ухагдахуун нь хувьсагчаар тодорхойлогдоно. Өөрөөр

хэлбэл шийдвэрлэхээр зорьсон асуудлыг үүсгэж буй олон шалтгааныг бодлогын цаашдын шинэчлэлээр өөрчлөх болон түүнд нөлөөлж болзошгүй хүчин зүйлийг хувьсагчаар тодорхойлно.

**7/ Хувьсагчийг томъёолох:** Хувьсагчийг сайтар боловсруулах нь ухагдахууныг илүү бодитой судлах боломж олгох юм. Хувьсагч нь хэрхэн, яаж гэсэн асуултаар судалгааны шалтгаан, зүй тогтолыг тодорхойлно. Хувьсагчид нь нөхцөл байдал болон бодлогоос хамаарч өөрчлөгдөх хувьсагчдаас бүрдэнэ. БХТС судалгаанд эдгээр хувьсагчийн аль альныг нь ашиглах учир тэдгээрийн хоорондын уялдааг сайтар хангасан байх нь зүйтэй байна. Жишээлбэл:

### БХТС бодлогын судалгааны хувьсагчийн төрөл

Нөхцөл байдлын хувьсагч	Бодлогын хувьсагч
Аймаг, орон нутгийн зах зээлийн багтаамж бага, өрсөлдөх боломж сул үйлдвэрлэл	Төрийналбанхаагчдын цалин,, урамшуулал
Импортыг орлож, нэмүү өртөг бий болгох үйлдвэрлэл хөгжөөгүй	Газрын түрээс, эрдсийн баялгийн олборлолт, боловсруулалт
Техник, технологийн хоцрогдол ихтэй	Улсын хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг
Мэргэшсэн, ур чадвартай ажиллах хүч дутмаг ажил Импортын түүхий эдийн үнэ	Мэргэшилтэй ажиллах хүчний хангамж
Зах зээлийн төвүүдээс алслагдсан, тээврийн зардал их	Гадаадын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа

**12.3.Судалгааны өгөгдөл (мэдээлэл) цуглуулах, боловсруулах:** Өгөгдөлийг ямар эх сурвалжаас цуглуулах, сэдэвтэй холбоотой өөр өгөгдөл мэдээлэл байгаа эсэх, мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл нь юу байхыг тодорхой сонгоно. Мэдээллэл цуглуулалт нь судалгааны үр дүнд шууд нөлөөлдөг чухал үйл явц учир.бловсруулалтын програмуудыг ашиглан мэдээлэлд дүн шинжилгээ хийх нь зүйтэй. Бодлогын судалгааны ажилд анхдагч болон хоёрдогч эх үүсвэрийг аль алийг нь ашиглах боловч судлаач дор дурдсан анхдагч мэдээ, баримтыг

боловсруулахад онцлон анхаарах нь чухал. Учир нь бодлогын судалгааны зорилго нь өнөөдөр бий болсон нөхцөл байдал, тулгарсан асуудал, тэдгээрийн шалтгааныг илрүүлж, анализ хийх явдал юм. Анхдагч судалгааны мэдээлийг дараах эх сурвалжаас цуглуулж болно.

- Тухайн асуудлаар өмнөх судлаачдын хийсэн ажил/ном, өгүүлэл/
- Гадаад орны эрдэмтэд, судлаачдын бүтэл туурвил
- ОУБ /НҮБ, ДБ, АХБ, ННФ ба бусад/ –ын хийсэн судалгааны тайлан мэдээлэл
- Улсын болон аймаг, нийслэлийн статистикийн эмхэтгэл, судалгааны мэдээлэл
- Үндэсний хөгжлийн газрын мэдээллийн сан
- Монгол банкны судалгааны тайлан мэдээ
- Интернет болон бусад боломжтой эх материалууд
- Энэ удаагийн судалгаа нь бодлого боловруулах зорилгоор богино хугацаанд, тодорхой үр дүн гаргах/зөвлөмжийн 11 ийг харах/ - аар хийгдэж байгааг харгалзан, судлаач бүр дор дурдсан асуудлыг өөртөө тавьж, гол төлөв бэлэн байгаа материалыг ашиглан анализ хийж, бодитой дүгнэлт гаргахад анхаарах учиртай. Үүнд:
  - өгөгдлийг ямар бэлэн эх сурвалжуудаас авах вэ?
  - Зарим өгөгдлийг өмнө нь цуглуулчихсан байгууллага, мэдээллийн сан хаана байна вэ
  - Нэмэлт ямар өгөгдөл мэдээлэл хэрэгтэй байна вэ?
  - Энэхүү шаардлагатай өгөгдлийг цуглуулах цаг хугацаа байна уу, захиалагчаас ямар дэмжлэг авах вэ?
  - Зарим аймаг, хот, үйлдвэрийг сонгож, түлхүүр /жишиг/ судалгаа хийх , ярилцлага, санал асуулга авах шаардлага байна уу гэх мэт...

**Жич: цаг хэмнэх үүднээс ярилцлагыг утсаар , судалгааг онлайн эсвэл И-мэйл-ээр хийж болох юм.**

**12.4. Бодлогын судалгааны ажлын онцлог үр дүн, практик ач холбогдол:** БХТС судалгааны ажлуудын гол үр дүн /бүтээгдэхүүн/нь урьд өмнөх бодлогын хэрэгжилтийн явцад хуримтлагдсан асуудал, үр дагаварыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх бодит арга зам , боломжийг дэвшүүлсэн санал, зөвлөмжийг багтаасан тайлан байна. Энэхүү тайланг эрдэмтэд, судлаачид, яам, газрын бодлого төлөвлөгч, мэргэжилтнүүдэд зориулж байгаа тул бусад судалгааны үр дүнтэй хамтруулан, судлаачдын баг, мэргэжлийн хүмүүсийн дунд хэлэлцүүлж, зөвшилцсөн нэгдсэн дүгнэлт гаргана. Энэхүү нэгдсэн үр дүнг **бодлогын дүн шинжилгээ хийх** судалгааны дараагийн ажилд ашиглана. Ингэснээртус нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжил, экологийн тэнцвэрт бус байдал, олонх аймаг бүс нутгийн хөгжлийн хоцрогдол, нийслэл болон зарим хотын хүн ам, үйлдвэрлэлийн хэт төвлөрлийн шалтгаан, үр дагавар, тулгамдсан асуудлыг илрүүлж, БХТС бодлого хөтөлбөрийг цаашид шинэчлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлох боломж бүрдэнэ.

**Гурав. Бодлогын дүн шинжилгээ хийх**

**13.**Бодлогын дүн шинжилгээ/БДШ/ хийхдээ, бодлогын судалгааны үр дүнд дэвшүүлсэн асуудлуудыг цаашид шийдвэрлэхэд түүнд нөлөөлөх орчин хэрхэн өөрчлөгдөх, ямар нөхцөл байдал шинээр үүсэх, үүнтэй уялдан бодлогын ямар хувилбарууд байж болохыг урьдчилан тооцоолох нь зүйтэй юм. Үүний тулд бүс нутгийн хөгжил, төвлөрлийг сааруулах талаар одоо хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, үр дүнг тоймлон судлах шаардлагатай болно.

**13.1** Бодлогын дүн шинжилгээ нь бодлогын судалгааны үр дүнд үндэслэн, БХТС талаар ойрын ирээдүйд баримтлах бодлогын тавил, стратегийн зорилго, зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хувилбаруудын үр ашиг, хэтийн нөлөөллийг тооцоолон илүү оновчтой, хэрэгжих боломжтой хувилбаруудыг гаргах бодлого боловсруулах төслийн эхний үе шатны ажил юм. Иймд, бодлогын дүн шинжилгээг Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан, дээр дурдсан ажлын хэсэг гардан хариуцаж, яам, газрын мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоод, ОУБ –ын шинжээчдийн оролцоотой, богино хугацаанд хэрэгжүүлэх ёстой юм.

**13.2 Бодлогын дүн шинжилгээг** ҮХГ-аас БХТС талаар 2030 он хүртэл баримтлах бодлогын концепц, уг бодлогын хүрээнд шийдвэрлэх асуудлууд, бодлогын баримт бичгийн бүтэц, агуулга, хэрэгжих хугацаа, хүрэх үр дүнг харгалзан хийнэ. БДШ-ний хүрээнд дор дурдсан гурван ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1/ өмнө хийгдсэн нэгдсэн болон салбар бүрийн хөгжил, байршлын бодлогын судалгааны үр дүнг үндэслэн БХТС хэтийн бодлогын хүрээнд шийдвэрлэх зангилаа асуудлаар цаашид тавих бодлогын төсөөлөл, стратегийн зорилго, зорилтыг тодорхойлох

2/ стратегийн зорилго, зорилтыг хөгжлийн үе шатаар хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг төсөөлөх

3/ бодлогын хувилбаруудад нөлөөлийн урьдчилсан үнэлгээ өгч, оновчтойг нь сонгох

**Жич:** БДШ-нд ашиглах БХТС хэтийн бодлогын концепц, шийдвэрлэх асуудал, бодлогын баримт бичгийн бүтэц, агуулгын талаарх урьдчилсан загварыг Үндэсний хөгжлийн газар боловсруулж яамдын ажлын хэсэгт хүргүүлнэ.

### **13.3 Бодлогын дүн шинжилгээ нь дараах зарчимд тулгуурлана:**

- БХТС бодлогын төлөвлөлтийн түвшин, хэрэгжилтийн явц, үр дүнд тодорхойлогдсон цаг үеэс нь шаардлагатай хяналт – шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Энэ талаар явуулж буй өнөөгийн үйл ажиллагааг тоймлон тайлбарласан байх
- Цаашдын бодлогын тавил, зорилго, зорилтыг ойлгомжтой тодорхойлсон байх
- Бодлогын боломжит хувилбаруудыг гаргасан байх
- Хувилбаруудыг үнэлэх багц шалгуурыг томъёолж, сонгосон байх
- Бодлогыг сайжруулах, илүү оновчтой болгоход чиглэсэн тодорхой алхмуудыг санал болгож зөвлөсөн байх

### **13.4. Бодлогын дүн шинжилгээг дараах дэс дарааллаар явуулна. Үүнд:**

**1/ Бодлогын тавил, стратеги/зорилго, зорилтууд/-ийн тодорхойлолт:** бодлогын тавил, алсын хараа, стратегийг аль болох ойлгомжтой, цэгцтэй

томъёолно. Үүнд бодлогын асуудлын мөн чанар, цар хүрээ, нийгэмд хэрхэн нөлөөлөх талаар хийсэн холбогдох судлагааны товч тоймыг оруулах хэрэгтэй. БХТС бодлогын хүрээнд нийт улс үндэстний, иргэний, бүс нутаг, салбарын эрх ашиг, сонирхолыг хэрхэн хослуулж байгааг тодорхойлох нь чухал.

**2/ Өнөөгийн бодлого:** аймаг, хот, бүс нутаг, төвлөрлийг сааруулах талаар одоо хэрэгжүүлж орон нутаг – салбарын хандлага голлосон бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн хоорондын болон нийгмийн бусад бодлоготой уялдаж байгаа зэргийг тоймлон гаргаж өгнө. Үүнд, өнөөгийн бодлогын давуу ба сул талыг тооцож, түүнийг БХТС нэгдсэн бодлогын хүрээнд цаашид сайжруулах боломж, арга зам, энэ талаар улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийн байгууллагуудын байр суурь тодорхойлсон байна.

**3/ Бодлогын хувилбаруудын тодорхойлолт:** бодлогын хувилбарыг дотоодын болон гадаад орны туршлага, үр ашигтай байгаа бусад аймаг/жишээ нь Өмнө –говь/, салбарын бодлогын ололтоос сонгон харж болох юм. Бодлогын төсөлд цаашид сонгох хэд хэдэн хувилбарыг санал болгосон байж болно. Эдгээр хувилбар нь өнөөг хүртэл баримталж ирсэн бодлогодоо бүхэлд нь томоохон өөрчлөлт шинэтгэл хийх үү, эсвэл хэсэгчилсэн, шаталсан алхамуудаар тавьсан стратегидаа хүрэх үү гэдгээс голлон хамаарна. Жишээлбэл, Монгол улсын хувьд БХТС цаашдын бодлогод нь нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийн хангах/зарим тохиолдолд нийгмийн жигд хөгжил ч гэж ярьдаг/стратегийг барих уу, эсвэл, хөгжлийн бүсүүд/үйлдвэрлэл- технологийн паркууд, уул уурхайн болон хөнгөн үйлдвэрийн кластерууд, тээвэр хөгжлийн коридорууд, аялал жуулчлалын цогцолборууд г.м./ суурилсан өсөлтийн концепцийг голлох уу, засаг захиргаа - нутаг дэвсгэрийн нэгжүүдийн одоогийн хуваарийг өөрчлөх үү, нийслэлийн чиг үүрэг, бүтцийг өөрчлөх үү, хотуудын зэрэглэл, статусыг шинэчлэх зэргээс бодлогын хувилбарууд, төлөвлөлтийн загваруудын сонголт шалтгаалж болно.

**4/ Үнэлэх шалгуурын сонголт:** дээрх 3-т заасан нөхцөлтэй уялдуулан хувилбаруудыг тодорхой шалгууруудаар үнэлэн сонгох нь сонголтыг зөв хийхэд чухал. Эдгээр шалгуурт үр ашиг, үр дүн, тэгш байдал, хэрэгжих боломж, уян хатан байдал буюу сайжруулах боломж, улс төрийн хүчнүүдийн хувьд хүлээн авах боломж, иргэний нийгэм болон, мэргэжлийн холбоод ороод сонирхлын гол бүлгүүд хүлээн зөвшөөрөх байдал зэрэг орж болох юм.

**5/Хувилбаруудын үнэлгээ:** дээрх сонгосон шалгууруудыг ашиглан хувилбар бүрийг үнэлэх хэрэгтэй. Хувилбар бүрийн давуу болон сул талыг онцлон харуулна. Хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийж, сонголтоо тодруулна. Тухайлбал энд, эдийн засгийн макро орчны, төрийн байгуулалт, хууль эрх зүйн орчны, улс төрийн, нийгэм-соёлын, хүн амын ажил эрхлэлт, суурьшилт/хот байгуулалтын/-ын, байгалийн баялгийн ашиглалт, байгаль орчны хамгаалалтын, зам тээвэр, дэд бүтэц, техник, технологийн орчны, газар зохион байгуулалтын, олон улсын буюу гадаад орчны г.м олон талын нөлөөллийг урьдчилан тоймлож болох юм. Бодлогын судалгааны явцад хийсэн геополитикийн өөрчлөлтийн, байгалийн гамшгийн

болзошгүй аюулын ,газар зүйн байрлал, байршилтын хүчин зүйлийн судалгааны үр дүнг харгалзана. Мөн улс төр, нийгмийн бүлгүүдийн сонирхлыг ч үнэлэхийг оролдож болох юм.

**6/ Аль нэг хувилбарын сонголт:** үнэлгээний шалгуур болон түүнд нөлөөлөх орчны урьдчилсан үнэлгээнд тулгуурлан тодорхой хувилбарыг дэмжсэн зөвлөмж гаргах хэрэгтэй. Уг сонголтын давуу болон сул талыг тодорхой дурьдсан байна.

**13.5.** Бодлогын хувилбар боловсруулахдаа хувилбар тус бүрээр үр дүнг тооцоолох ба энд доорх матрицыг ашиглаж болох юм.

Матриц 1. Бодлогын хувилбар, үр дүнгийн хамаарал

Бодлогынхувилбар Хувилбарын хүрэх үр дүн

Үр дүн 1 Үр дүн 2 Үр дүн 3 Үр дүн .... Үр дүн n

Хувилбар 1

Хувилбар n...

Энэ матрицад үндэслэн үр дүн бүрээр шалгуур үзүүлэлтийг боловсруулж үнэлнэ.

Матриц 2. Бодлогын хувилбарын үр дүн, шалгуурын хамаарал

Бодлогынхувилбар Хувилбарын шалгуур

Шалгуур 1 Шалгуур 2 Шалгуур 3 Шалгуур .... Шалгуур n

Үр дүн 1

Үр дүн n

**13.6. Бодлогын дүн шинжилгээний мэдээллийг бүрдүүлэх**

**боловсруулах:**Дүн шинжилгээ хийхэд бодлогын судалгааны үр дүнгээс гадна хоёрдогч судалгааны буюу албан ёсны мэдээллүүдийг голлон ашиглана. Эдгээр мэдээллийг Үндэсний Статистикийн хороо, аймаг, нийслэлийн статистикийн газар, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Монголбанк зэрэг байгууллагуудын тайлан, төсөв, төлөвлөгөөнөөс авах боломжтой. Зарим мэдээллийгбусад макро эдийн засгийн үзүүлэлтэд тулгуурлан тооцож гаргана. Мэдээлэл авах сувгууд нь:

- *Үндэсний болон аймаг, нийслэлийн статистикийн газрууд, тэдгээрийн мэдээллийн төвүүдээс боловсруулсан үзүүлэлтүүдийг тооцох аргачлалууд, судалгааны материалууд*
- *Статистикийн жилийн эмхэтгэл*
- *Сангийн яамны төсөв, төлөвлөгөөний материалууд*
- *Үндэсний хөгжлийн газрын мэдээллийн сан*
- *Монголбанкны жилийн тайлан, түүний дэргэдэх судалгааны төвийн материалууд*
- *УИХ-ын тамгын газрын дэргэдэх судалгааны төвийн тайлан мэдээ*
- *ХЗДХ яамны мэдээллийн сайт, хууль, тогтоомжийн эмхэтгэл, бодлогын баримт бичгүүд*
- *Яам, агенлагийн тэдээ, тайлан*
- *НҮБ, ДБ, АХБ, ННФ, Японы ЖАЙКА, БНСУ-ын КОЙКО зэрэг олон улсын байгууллага, гадаад орны судалгааны албан ёсны мэдээ, тайлан гэх мэт.*

Бодлогын судалгаа нийсэн эрдэмтэд судлаачдаас дараах зарим асуудлыг тодруулан асууж болох юм. Үүнд:

- БХТС бодлого арга хэмжээний хэрэгжилтэд нөлөөлсөн хүчин зүйл юу вэ?
- БХТС талаар аймаг, орон нутаг, салбарын хэмжээнд одоо явуулж бодлого арга хэмжээний үр дүн, түүний давуу ба сул талууд юу байна, ямар асуудал тулгамдаж байна вэ ?
- БХТС асуудлыг улс төрийн бодлогын түвшинд цогц байдлаар шийдвэрлэх зайлшгүй шаардлага, үндэслэл зүйлс юу байна вэ?
- БХТС асуудлыг шийдвэрлэхэд төр,иргэн, аж ахуйн хамтын оролцоо, харилцан түншлэлийн бодлогын түвшинд хангах ямар арга хэрэгсэл байж болох вэ?

**13.7. Бодлогын дүн шинжилгээний ажлын үр дүн, ач холбогдол:** энэ ажлын дүнд,*Бодлогын шинжилгээний тойм* гарна. Энэ нь бодлогын судалгааны тайлан болон бусад мэдээллийн эх сурвалжыг ашиглан, бодлогын хувилбаруудыг харьцуулан үнэлсэн баримт бичиг байна.*Бодлогын шинжилгээний тойм нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт зориулагдана.* Иймд, яамдын ажлын хэсэг БДШ-г Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах тухай журмын Тав-д заасан “**Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ**”-ний агуулгад нийцүүлэн богино хугацаанд хийж гүйцэтгэн, үр дүнг нь ҮХГ-тай зөвшилцөн БХТС хөгжлийн бодлогын төсөлд тусгуулах арга хэмжээ авна.

**13.8 . Бодлогын дүн шинжилгээ хийх ажлын төлөвлөгөө**

### **НАЙМ. ШИНЖЛЭХ УХААНЫ ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТ, САНАЛ**

- 6.1. Үндэсний хөгжлийн газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн санал, дүгнэлт
- 6.2. Сангийн яамны дүгнэлт, санал
- 6.3. ШУА-ийн газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн дүгнэлт, санал

**“Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдал,  
цаашдын хандлага” сэдэвт бодлогын судалгааны ажлын тайланд өгөх  
санал**

Үндэсний Хөгжлийн Газрын захиалгаар ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгээс 2018 онд гүйцэтгэж байгаа бүсчилсэн хөгжлийн шинжилгээ, судалгааны ажлын нэг нь бүс нутаг судлаач Т.Энэбишийн хийсэн “Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдал, цаашдын хандлага” сэдэвт бодлогын судалгаа юм. Энэхүү судалгааны нэгдсэн тайлангийн талаар тус хүрээлэнгээс өгсөн нэгдсэн санал, дүгнэлтийг Та бүхэнд үүгээр хүргүүлж байна. Т.Энэбиш нь үүний өмнө, тус хүрээлэнд түшиглэн Монгол Улсын Их Хурлаас 2001 онд баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын онол арга зүйн боловсруулалт” суурь судалгааны ажлыг бас хийж гүйцэтгэн, захиалсан Сангийн яаманд шилжүүлсэн билээ.

Энэ удаагийн ажил нь дээрх суурь судалгааны үр дүнг бодлого боловсруулах практикт ашиглуулахаар хийсэн хавсарга судалгаа болсон гэж үзэж байна. Ингэхдээ, тус үзэл баримтлалыг эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудалтай голлон холбож, арга зүй, практикийн чанартай олон чухал сэдэл, санал, үндэслэлийг дэвшүүлсэн байна. Эдгээрийн дотроос Монгол орны эдийн засгийн болон бүс нутгийн газарзүйн судалгаа, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний байршилт, хоршилт, төрөлжилттэй холбогдох талаас нь дараах үйлсийг тэмдэглэж байна. Үүнд:

1. Байгаль орчиндоо нэн зохицсон, тогтвортой хөгжлийн орон зайн бүтэц, зохион байгуулалтын загварыг тууштай баримтлах, энэ зорилгоор нийгэм, эдийн засгийн бүсчлэлийн асуудлыг эдийн засгийн газар зүй, экологи-ландшафтын мужлалтай холбож, хөгжлийн болон экологийн бүс нутгууд, тэдгээрийн бүтэц, хоршилт, төрөлжилтийг сонгон тогтооход бүсчилсэн хөгжлийн бодлогын үзүүлэх нөлөө, байгаль, нийгмийн үйл явцын харилцан үйлчлэлийг нарийвчлан харгалзаж байх нь зүйтэй гэсэн арга зүйн хандлага, зөвлөмжүүд;
2. Уул уурхайд суурилсан хөгжлийн бүсүүдийн зэрэгцээ, хөдөө аж ахуй, хөнгөн хүнс, аялал жуулчлалын паркууд, кластеруудыг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн саналууд;
3. Экосистемийн нэгдмэл байдал, бүрдэл хэсгүүдийн тогтоц, байршилтын уялдаа, хамаарлыг нарийвчлан судалж, эдийн засаг-экологийн өргөрөгийн дагуух бүсчлэлийг тогтоож, Өрнө-Дорныг



холбосон улс хоорондын тээвэр-хөгжил (төмөр зам)-ийн коридор барьж байгуулах, Монгол орны хойт /Хангайн бүс/ нутгийг аялал жуулчлалын, эрчимжсэн болон бэлчээрийн мал аж ахуйн, дунд хэсгийн тал хээр нутгийг бэлчээрийн мал аж ахуй, түүнд түшиглэсэн хөнгөн, хүнсний үйлдвэрийн, өмнөт хэсгийг уул уурхай, хүнд аж үйлдвэрийн, худалдаа тээврийн, олон улсын аялал жуулчлалын чиглэлээр тус тус хөгжүүлэх бүсчилсэн үнэлгээ, зөвлөмжийг дэвшүүлсэн зэргийг дурдаж байна.

Эдгээр нь бүсчлэн хөгжих үзэл баримтлалыг эдийн засгийн болон бүс нутгийн газарзүй талаас нь цаашид гүнзгийрүүлэн судлах тус хүрээлэнгийн цаашдын судалгааны чиглэлүүдтэй нийцэж байна. Уг судалгааны үр дүнг бүсчлэн хөгжих экологийн загвар, тогтвортой болон ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлт, тооцох аргачлал, мөн бүс нутгийн экологийн үнэлгээ зэрэг орон зайн хөгжлийн хойшид байгаль орчинд аль болох сөрөг нөлөө багатай байхаар урьдаас төлөвлөн зохицуулах асуудалтай холбож, дээр хэлсэн “Аж үйлдвэрийн байршилт, бүсчлэл”, “Орон нутгийн бүсчилсэн хөгжил”, “Байгаль газарзүй, геоэкологийн орчны судалгаа” (ҮХГ-аас захиалж хийлгэсэн)-тай уялдуулж, нэгдсэн үнэлэлт, дүгнэлт гаргахыг судлаачдад санал болгож байна.

“Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдал, цаашдын хандлага” бодлогын судалгааны ажлын завсрын (үе шатны) үр дүнгүүдтэй цаг тухайд нь танилцаж байсан тул энэ судалгаа нь бүхэлдээ Захиалагчаас тавьсан зорилгыг бүрэн хангасан практик үр дүнтэй, бүсчилсэн хөгжлийн эдийн засгийн газарзүй, экологийн бүс нутгийн үнэлгээ, төлөвлөлтөд үндэслэл, материал болгон ашиглаж болохоор арга зүйн олон чухал асуудлыг хөндсөн, бүсчилж хөгжих бодлогод эдийн засаг, экологийн хандлагыг хослуулах шаардлагыг боломжийн тусгасан шинэлэг судалгаа болжээ. Бодлогын энэ судалгааны тайланг хүлээн авч, байгаль орчин, аж ахуйн салбарын бусад судалгааны үр дүнтэй нэгтгэн, хөгжлийн бодлого боловсруулахад харгалзах нь зүйтэй байна.

ШУА-ийн Газарзүй-экологийн хүрээлэнгийн эрдэмтэн

нарийн бичгийн дарга, доктор (Ph.D).....А. Хауленбек

## **“Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдал, цаашдын хандлага” бодлогын судалгааны нэгдсэн тайланд өгөх санал**

Энэхүү судалгааг Үндэсний Хөгжлийн Газрын захиалгаар улсын төлөвлөгөөний комисс, Сангийн яаманд бүс нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар олон жил дагнан ажилласан, манай туршлагатай мэргэжилтний нэг байсан ахмад ажилтан Т.Энэбиш гуай ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэнд түшиглэн гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгаанд Монгол Улсын Их Хурлаас 2001 онд баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал (БХҮБ), бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, бусад баримт бичгийн хэрэгжилтийн байдал, үр дагавар, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс, учир шалтгаанд төрийн бодлого, төлөвлөлтийн талаас нь үнэлгээ, дүгнэлт өгч, өнөөдөр тулгамдаж буй асуудал, тэдгээрийг цаашид шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байна.

Мөн бүсчилсэн хөгжлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, одоогийн бодлого, төлөвлөлтийг цаашид шинэчлэх үндсэн чиглэл, бодлого, зорилтууд, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлсийн талаар тодорхой үзэл бодол, таамаглал, төсөөлөл дэвшүүлсэн нь нэлээд цогц ажил болжээ.

Судлаач энэ үндэсний болон бүс нутгийн гэсэн хоёр түвшинд, судалгааны нэгдсэн арга загвараар, Захиалагчаас баталсан “Ажлын даалгавар”-ыг чанд баримталж хийсэн байна. Бодлогын энэ судалгааны нэгдсэн тайланг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, түүний хэрэгжилт, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын нөхцөл байдлын дүн шинжилгээ (I); Монгол Улсын бүсчлэн хөгжих үзэл баримтлалыг цаашид “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах” Засгийн газрын бодлогын хүрээнд шинэчлэх арга зам, бодлогын хувилбарууд, нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээ (II) гэсэн хоёр үндсэн үе шатны судалгааны үр дүнгээр нэгтгэн бичиж, тодорхой санал, зөвлөмжүүдийг өгсөн нь “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” холбогдох журмын заалтад нийцэж байна.

Тайлангийн судалгааны I хэсэг (Агуулгын Гурав, Дөрөв гэсэн бүлэг)-т БХҮБ, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хоорондын уялдаанд хийсэн үнэлгээ; бүсчилсэн хөгжлийн талаар төр, улс төр, иргэд, олон улс, гадаад орны байгууллагын хийсэн үнэлгээ, санал, бодол, мэдээлэл; Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ; эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн чадавх, гарц /SWOT үнэлгээ/; эдийн засгийн бүсчлэл, бүсчилсэн хөгжлийн арга зүйн шинэлэг хандлагууд; Судалгааны II хэсэг (Тав ба Зургаа гэсэн бүлэг)-т бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудал, шалтгаан, шийдвэрлэх арга замууд; бодлогын асуудлын зураглал /зохиомж - сценари/; асуудлыг шийдвэрлэх таамаглал /бодлогын хувьсагчаар/; бүсчилсэн хөгжлийн бодлого /2030 он хүртэлх/ -ын зорилго, зорилтуудыг тодорхойлох үндэслэл санал; бодлогын хувилбаруудын SWOT шинжилгээ; бүсчилсэн хөгжлийн одоогийн бодлогын тойм; бүсчилсэн хөгжлийг дэмжих макро эдийн

засгийн бодлогын орчин; бүсчилсэн хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг сонгосон үндэслэл; бодлогын хувилбаруудад хийсэн нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээ буюу PEST анализ зэргийг авч үзсэн байна.

Эдгээр нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах шинжлэх ухаан, арга зүйн үндэслэлд нийцэж байна.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдал, цаашдын хандлага” сэдэвт энэхүү судалгааны ажлын ач холбогдлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагаанд дор дурдсан байдлаар харгалзан ашиглах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- 1.) Монголын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын түүхэн хандлага, өнөөгийн байдлын үнэлгээг БХҮБ-ыг цаашид тодотгон сайжруулах, мөн тогтвортой хөгжлийн орон зайн тэнцлийг хангах шалгуураар үйлдвэрлэл, үйлчилгээний байршилт, хоршилт, төрөлжилтийг бүсчлэн зохицуулах шаардлагыг үндэсний, салбар, аймаг, бүс нутгийн хэтийн төлөвлөгөө, төсвийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, тэдгээрийн хоорондын уялдааг хангах ажилд арга зүйн үндэслэл болгон ашиглах;
- 2.) БХҮБ-ын хэрэгжилтийн олон талын үнэлгээ, иргэд, байгууллагын үзэл бодол, санал, зөвлөмж, бүс нутгийн хөгжлийн чадавхийн SWOT шинжилгээний үр дүнг бүсчилсэн хөгжлийн цаашдын стратегийг тодорхойлох, түүнийг макро эдийн засгийн бодлого (төсөв, хөрөнгө оруулалт, татвар)-оор дэмжих, хэрэгжилтийг хянан зохицуулах үйл ажиллагаанд тулгуур мэдээ, материал болгон харгалзах;
- 3.) Бүсчилсэн хөгжлийн нөхцөл байдлын дүн шинжилгээ (тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам г.м), бодлогын зорилго, зорилтууд, тэдгээрийн нөлөөлөх байдлын урьдчилсан үнэлгээний талаар хийсэн дүгнэлт, санал, дэвшүүлсэн үзэл бодол, таамаглал (ялангуяа эдийн засгийн бүх шатны бүсчлэлээр дамжуулан хөгжлийн орон зайд зохицуулах), төсөөллийг “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах” бодлого тодорхойлоход цаашид баримтлах боломжтой нэг хувилбар болгон ашиглах зэрэг болно.

Энэхүү судалгааны явцад гарсан үр дүн, тайланд хийсэн дүгнэлтүүд, ялангуяа бүсчилсэн хөгжлийн үндэсний эдийн засгийн бодлого, төлөвлөгөө, төсөв, татвар, тэдгээрийн уялдааг салбар, бүс нутгийн түвшинд хангах, бүсчлэн хөгжих үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, дотоод, гадаадын байгууллагын хамтын оролцоо, харилцан дэмжлэг, зөвшилцлийг хангах талаар өгсөн санал, зөвлөмж (түүний дотор, Сангийн яаманд өгсөн санал)-ийг хүлээн авах боломжтой гэж үзлээ.

“Монголын бүсчилсэн хөгжлийн түүхэн замнал, өнөөгийн байдал, цаашдын хандлага” нэгдсэн тайлан нь БХҮБ-ын шинжлэл судлал, арга зүйн үндэслэлийг тодорхой болгож, бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг аль болох бүрэн харгалзах боломжийг бүрдүүлэх талаар Захиалагчаас өгсөн ажлын даалгаварыг хангасан ажил болсон байна гэж үзэв.

Иймд, судалгааны энэхүү нэгдсэн тайланг зохих түвшинд баталгаажуулан хүлээн авахыг дэмжиж байна. “Эдийн засгийн бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах” бодлогыг шинэчлэн боловсруулах талаар судлаачаас өгсөн үнэлгээ, санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар танай байгууллага, бусад яам, газартай хамтран ажиллахад бэлэн байна.

Эдийн засгийн бодлогын газрын дарга ..... /...../

Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга .....  
/...../